



ХААН БАНК



# ЖИЛИЙН ТАЙЛАН

Хамтын өсөлт  
**төгөлдөр**

# Агуулга

## 01

### Удиртгал

---

Бидний тухай	7
Бидний үнэт зүйлс	7
ТУЗ-ийн даргын мэндчилгээ	10
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	11
2025 оны онцлох үйл явдал	13
2025 оны амжилтууд	15

## 02

### Компанийн засаглал

---

Засаглалын үйл ажиллагаа	17
Засаглалын тогтолцоо	18
Хувьцаа эзэмшигчид	19
Төлөөлөн удирдах зөвлөл	21
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	22
ТУЗ-ийн хараат бус гишүүд	22
ТУЗ-ийн ердийн гишүүд	23
Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод	25
Дотоод аудит	27
Дотоод аудитын зохион байгуулалт, чиг үүрэг	27
Дотоод аудитын зорилго, үйл ажиллагаа	28
Гүйцэтгэх удирдлага	29

# 03

## Бизнесийн зорилтууд

Бизнесийн зорилтууд	32
Харилцагчийн туршлага	33
Харилцагчийн туршлага ба харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлого	35
Харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлого	36
Харилцагчийн үйлчилгээ	37
Үйлчилгээний нэгдсэн төв	37
“GEN AI” -д суурилсан “Digi” чатбот	37
Гомдол шийдвэрлэх үйл ажиллагаа	38
ХААН саналын систем	38
“Харилцагчийн туршлага 2025” конференц	38
Service Excellence II хөтөлбөр	39
Харилцагчийн сэтгэл ханамжийн судалгаа	39
Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ	40
Картын бүтээгдэхүүн	40
Тогтвортой санхүүжилтийн бүтээгдэхүүн	41
Үйлчилгээ нэвтрүүлэлт	42
Картаар үйлчлэгч байгууллагын үйлчилгээ	42
IBAN нэвтрүүлэлт	43
Шинээр нэвтрүүлсэн хиймэл оюуны хөгжүүлэлт болон бүтээгдэхүүн, үйлчилгээ	44
Бизнесийн өсөлт	45
ХААН приорити	46
ХААН сигначер	47
Байгууллагын банкны үйлчилгээ	48
Жижиг дунд бизнесийн банкны үйлчилгээ	49
Ноолуурын нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээл	50
Үр тарианы нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээл	50
Махны нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээл	51
Сүүний нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээл	51
Факторинг үйлчилгээ	51
Эмэгтэй бизнес эрхлэгчдийн цахим шилжилтийг дэмжих зээл	52
Жижиг дунд бизнесийн академи	52
Хөрөнгө зохицуулалт ба хөрөнгө оруулагчдын харилцаа	53
Төлбөрийн чадвар	53
Мөнгөний зах зээл	54
Валют болон алтны арилжаа	54
Урт хугацаат эх үүсвэр	55
Худалдааны санхүүжилтийн үйлчилгээ	56
Корреспондент банкуудын харилцаа, гадаад төлбөр тооцоо	57
Санхүүгийн голлох үзүүлэлтүүд	58
Санхүүгийн үр дүн	58
Санхүүгийн гүйцэтгэл (аудитлагдсан санхүүгийн тайлангаар)	60
Зах зээл эзлэлт (Монголбанкны тайлагналаар)	60

# 03

## Бизнесийн зорилтууд

---

Эрсдэлийн удирдлага	61
Хүлээн зөвшөөрөх эрсдэл	63
Эрсдэлийн засаглал	63
Өргөтгөсөн хамгаалалтын гурван шугам	65
Зээлийн эрсдэлийн удирдлага	66
Зах зээлийн эрсдэлийн удирдлага	66
Гадаад валютын ханшийн эрсдэл	66
Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага	67
Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага	67
Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага	68
Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлага	69
Хууль эрх зүй	70
Комплаенс	70
Цахим банк	72
Цахим банкны үйлчилгээ	73
Business AI туслах	74
Khan Business аппликэйшн	74
Байгууллагын хөгжил	75
Тогтвортой байдлын засаглал	76
Тогтвортой байдлын бодлого	77
Тогтвортой байдлын стратеги	78
Тэргүүлэх чиглэлүүд ба давхар материаллаг байдал	79
Тогтвортой байдлын онцлох үйл явдал, ажлууд	81
Тогтвортой байдлын замнал	82
Тогтвортой санхүүжилт	84
“Green database” төсөл	85
Монгол Улсын анхны Жендэр бонд	86
Нийгмийн санхүүжилт	87
Хөндлөнгийн аудит - “Ногоон бонд”	87
Ажилтнуудын чадавх бэхжүүлэх	88
Компанийн нийгмийн хариуцлага	89
Хүний нөөцийн удирдлага	89
Хүний нөөцийн бодлого	89
Ажилтны сайн сайхан байдал болон түүнтэй холбоотой ажлууд	90
Чадамжид суурилсан байгууллага	90
Тасралтгүй суралцагч байгууллага	91


# 04

## Санхүүгийн тайлан

---

Хараат бус Аудиторын Тайлан	96
Ерөнхий мэдээлэл	103
Товчилсон үгс	104
Санхүүгийн тайлангууд	
Санхүүгийн байдлын тайлан	105
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	106
Өмчийн өөрчлөлтийн тайлан	107
Мөнгөн гүйлгээний тайлан	108
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	
Танилцуулга	110
Банкны үйл ажиллагааны орчин	110
Тайлан бэлтгэх үндэслэл	111
Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой тооцоолол, дүгнэлт	111
Шинэ буюу нэмэлт өөрчлөлт орсон стандартуудын тайлбар болон хэрэгжилт	116
Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогын мэдэгдэл	116
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	117
Монголбанкинд заавал байлгах нөөц	119
Санхүүгийн хөрөнгө оруулалт	119
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	123
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	125
Бусад хөрөнгө	137
Үндсэн хөрөнгө	138
Биет бус хөрөнгө	140
Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөр	140
Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	141
Репо хэлцэл	141
Харилцагчдын харилцах, хадгаламж	141
Банкнаас гаргасан үнэт цаас	141
Зээлээр авсан санхүүжилт	143
Бусад өр төлбөр	149
Хувьцаат капитал, бусад нөөц ба ногдол ашиг	149
Хүү болон түүнтэй адилтгах орлого	151
Хүү болон түүнтэй адилтгах зардал	152
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	152
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн цэвэр олз	153
Зээлжих эрсдэлийн сан	153
Үйл ажиллагааны зардал	153
Орлогын албан татвар	154
Нэгж хувьцаанд ногдох ашиг	156
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулга	157
Сегментийн шинжилгээ	158
Болзошгүй өр төлбөр ба үүрэг	162
Санхүүгийн эрсдэлийн удирдлага	170
Санхүүгийн хөрөнгүүд болон Санхүүгийн өр төлбөрүүдийн цэвэршүүлэлт	188
Бодит үнэ цэнийн тодруулга	189
Холбоотой талын тодруулга	195
Хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээ	198
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	200
Тайлант хугацааны дараах үйл явдал	200

# Удиртгал



# БИДНИЙ ТУХАЙ

ХААН Банк нь 1991 оноос хойш 34 жилийн турш харилцагчдынхаа санхүүгийн аяллын алхам бүрд хамт байж, өсөж хөгжихөд нь тууштай дэмжлэг үзүүлж, санхүүгийн цогц үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хурдан шуурхай хүргэн ажиллаж байна.

Монгол Улсын тэргүүлэгч банкны хувьд бид бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ бүхий л түвшинд технологийн дэвшил, хиймэл оюунд суурилсан хөгжүүлэлтийг тууштай хэрэгжүүлж, автоматжуулалт, хэрэглээний хялбар шийдлүүдийг нэвтрүүлснээр харилцагчдадаа илүү ухаалаг, хүртээмжтэй, үр ашигтай санхүүгийн үйлчилгээг тасралтгүй санал болгон ажиллаж байна.

2025 оны хувьд ч мөн дэвшилтэт техник, технологийн инновацид суурилсан, олон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлсний зэрэгцээ дотоодын хөрөнгийн зах зээлд Монголын анхны Жендэр бонд гарган санхүүгийн салбар дахь манлайллаа улам бүр бататгалаа.



## Алсын хараа

Харилцагчидтайгаа хамт эгнэгт өсөж хөгждөг, итгэл төгөлдөр банк байна.



## Эрхэм зорилго

Бид харилцагчдынхаа санхүүгийн аяллын алхам бүрд хамгийн шилдэг, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэнэ.



## Уриа үг

Хамтын өсөлт төгөлдөр



## Бидний үнэт зүйлс

Хөгжил цэцэглэлтийн түүчээлэгч

Бидний үүрэг банкны үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ харилцагчид, ажилтнууд, хувьцаа эзэмшигчдээ өсөлт хөгжлийн замд хөтлөхөд чиглэнэ.

Тогтвортой хөгжилд манлайлагч

Бид нэг байрандаа зогсдоггүй. Тогтвортой бизнесийг бүтээхийн төлөө тасралтгүй суралцаж, дасан зохицож, улам сайжирдаг учраас харилцагчдаа зорьж буй ирээдүйд нь хүргэх ажлаа улам төгөлдөржүүлнэ.


Шилдэг цахим бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэгч

Харилцагч бүр шилдгийг хүлээн авах учиртай. Тиймээс бид ирээдүйн сайн сайханд хөтлөх санхүүгийн ухаалаг арга хэрэгсэл, бүтээгдэхүүн үйлчилгээгээр түүчээлнэ.

Итгэлт зөвлөгч

Харилцагчид маань хэдэн арваны турш санхүүгээ бидэнд даатгаж ирсэн билээ. Энэхүү хүндтэй үйлсийг бид бахархалтайгаар үргэлжлүүлж, найдвартай зөвлөх, итгэлтэй түнш байж, үргэлж сайны төлөө зүтгэх болно.

## Үйл ажиллагааны чиглэл




ХААН Банк нь нийгмийн бүх бүлэгт хүрч ажилладаг бөгөөд харилцагч бүрийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, шийдлийг дараах төрөлжсөн дэд үйлчилгээг санал болгож байна.

Үүнд:

### Corporate


Талбартаа цойлох өрнүүн ажлын тань замналд санхүүгийн найдвартай түшиг болж, амжилт бүтээлээр дүүрэн өсөлтийг хамтдаа бүтээе.



Хөгжлийг хурдасгах үйлс төгөлдөр

### Business


Санхүүгийн цогц үйлчилгээ, шилдэг бүтээгдэхүүнээр бизнесийн тань хөшүүрэг болж, үр шимтэй өсөлтийг хамтдаа бүтээе.



Амжилт төгөлдөр

### Priority


Хамгаас үнэтэй цаг хугацааг тань эрхэмлэж, санхүүгийн аяллын алхам бүрд итгэл нэмж, тав тухыг мэдрүүлэх үйлчилгээг танд зориулан урлав.



Итгэл төгөлдөр

### Signature

Бид оргилд хүрэх аяллын тань алхам бүрд урам зориг төрүүлж, өсөлтийг хамтдаа урлана.



Тэмүүлэл төгөлдөр

# ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



**Т.ДАРБУМ**

“ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн дарга

## Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ,

2025 онд дэлхий дахинд худалдаа, геополитик, технологийн салбарт сорилт ихтэй байсан хэдий ч ХААН Банк дунд хугацааны стратегийн зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа улам бэхжүүлсний үр дүнд банкны нийт актив 23.9 их наяд төгрөгт хүрч, тогтвортой өсөлтөө хадгалан, банкны салбар төдийгүй хөрөнгийн зах зээл дэх манлайллаа дахин бататгалаа.

Тайлант онд банк 695 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх онтой харьцуулахад 8.8 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд ногдол ашгийн хэмжээг 9.5 хувиар нэмэгдүүлснээр нийт 409 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлээд байна. Өсөлтийн энэхүү таатай нөхцөл байдалд тулгуурлан, Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн зүгээс 2026 онд ч банкны үйл ажиллагаа улам өргөжин тэлнэ гэдэгт итгэл төгс байна.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн зүгээс банкны дунд хугацааны стратегийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, эрсдэлийн удирдлага, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, дотоод хяналт болон мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад онцгойлон анхаарч ажиллалаа. ХААН Банкны стратегийн тэргүүлэх чиглэлүүд нь цахим шилжилтийг эрчимжүүлэх, машин сургалт болон хиймэл оюунд суурилсан шийдлээр харилцагчийн туршлагыг сайжруулах, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, мөн ноос, ноолуур, газар тариалан, сүү, махны чиглэлийн кластерийн хөгжлийг дэмжих замаар тогтвортой хөдөө аж ахуйн хөгжилд хувь нэмрээ оруулахаар зорьж байна.

ТУЗ-өөс 2025 онд “Тогтвортой хөгжлийн стратеги 2030”-ийг баталснаар ажилтнууд, харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон түнш байгууллагуудынхаа өмнө 2030 он хүртэл хэрэгжүүлэх тодорхой зорилтууд, хариуцлагатай үүрэг амлалтыг тодорхойлсноо дуулгахад таатай байна.

Мөн өнгөрсөн жил бид удирдах түвшний ажилтнуудаа чадавхжуулахад онцгой анхаарч, эрсдэлийн удирдлага тэр дундаа цахим эрсдэл болон хиймэл оюун, засаглалын чиглэлээр сургалт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүллээ. Цаашид ч хиймэл оюун ухааны засаглал нь ТУЗ-ийн гол анхаарах асуудал хэвээр байх болно.

Хиймэл оюуны хөгжил дэлхий даяар сүүлийн жил гаруйн хугацаанд эрчимжсэн бол ХААН Банкны хувьд энэхүү технологид суурилсан шийдлүүдийг олон жилийн турш хөгжүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээндээ тасралтгүй нэвтрүүлж ирсэн арвин туршлагатай билээ. Тиймээс ТУЗ-ийн зүгээс хиймэл оюуны хариуцлагатай засаглалыг төлөвшүүлж, харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагыг илүү таньж мэдэх, харилцагчийн үйлчилгээний чанарыг сайжруулах, мөн ажилтнуудаа чадавхжуулахад чиглэсэн инновацлаг санаачилга, хүчин чармайлтуудыг дэмжин ажиллаж байна.

Гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа тэргүүтэй удирдлагын баг банкныг өөрчлөлт, шинэчлэлтэд удирдан чиглүүлж, стратегийн зорилтууддаа хүрч, харилцагчид, олон нийтийн өмнө хүлээсэн банкны найдвартай, тогтвортой байдлыг ханган ажиллаж чадна гэдэгт ТУЗ бүрэн итгэлтэй байдаг билээ.

Харилцагчдынхаа санхүүгийн аяллын алхам бүрд хамтдаа өсөж хөгжих эрхэм зорилгын төлөө тууштай ажиллаж буй банкны нийт ажилтнуудын хичээл зүтгэл, мэргэжлийн үр чадвараар чин сэтгэлээсээ бахархаж буйгаа энэ ташрамд илэрхийлье.

Мөн эрхэм хувьцаа эзэмшигч та бүхний итгэл, дэмжлэгт гүн талархал илэрхийлье. Та бүхний дэмжлэгтэйгээр ХААН Банк цаашид ч харилцагчид, ажилтнууд төдийгүй нийгмийн сайн сайхны төлөө тасралтгүй өсөн дэвжиж, шинийг эрэлхийлэн, тогтвортой үнэ цэнийг бүтээсээр байх болно.

**Хүндэтгэсэн,**

**ТҮДЭВ ОВОГТОЙ ДАРЬБУМ**



# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



**Р.МӨНХТУЯА**  
ХААН Банкны Гүйцэтгэх захирал

## Эрхэм танд энэ өдрийн мэнд хүргэе!

Харилцагч, хамтрагч түншүүд та бүхэндээ ХААН Банкны ололт амжилтаар дүүрэн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж буйдаа баяртай байна. Өнгөрөгч он манай банкны хувьд олон улсын зах зээлд итгэл, нэр хүндээ бататгасан, харилцагчидтайгаа хамтдаа өсөж хөгжсөн онцгой жил байлаа.

Банкны 2024-2026 оны дунд хугацааны стратегийн хүрээнд бид тогтвортой бизнес, дижитал шилжилт, харилцагчийн туршлага, байгууллагын чадавхыг бэхжүүлэх гэсэн дөрвөн үндсэн чиглэлд төвлөрч, технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны сайжруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Үүний үр дүнд банкны санхүүгийн гүйцэтгэл тогтвортой өсөлт үзүүлж, бид салбартаа тэргүүлэх байр сууриа бататгаж чадлаа. Банкны нийт актив 23.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 17.9 хувиар өссөн нь банкны системийн активын 31.1 хувийг дангаар бүрдүүлж байна.

Зээлийн багц 14.4 их наяд, татан төвлөрүүлсэн хөрөнгө 20.8 их наяд, өөрийн хөрөнгө 2.8 их наяд төгрөгт тус тус хүрснээс гадна 694.8 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгийн өгөөж 17.5 хувьд хүрээд байна. Монголбанк болон олон улсын банк санхүүгийн байгууллагуудын зохистой харьцаа үзүүлэлтүүдийг бид бүрэн ханган ажиллаж буй.

2025 онд стратегийн тэргүүлэх чиглэл болох тогтвортой санхүүжилтийн хүрээнд олон улсын хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллагуудаас 523 сая ам.долларын урт хугацаат эх үүсвэр татан төвлөрүүлж, харилцагчдад очих ногоон болон нийгмийн хариуцлагатай санхүүжилтийг бодитоор тэллээ. Мөн тайлант онд бид Монголын хөрөнгийн зах зээлд анхдагч Жендэр бондыг амжилттай гаргаж, жендэрийн тэгш байдал, зохистой хөдөлмөр, ажлын байрыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг дэмжих төслүүдийг санхүүжүүлээд байна.

Харилцагч төвтэй дижитал банк болох зорилгын хүрээнд үйлчилгээний хүртээмж, хурд, хялбар байдлыг тасралтгүй сайжруулж, өнөөдөр манай банкаар дамжиж буй нийт гүйлгээний 99.6 хувь нь онлайнгаар хийгдэж байна. Зээлийн бүтээгдэхүүнүүдийг цахим сувагт үе шаттай шилжүүлснээр нийт хэрэглээний зээлийн 88 хувийг онлайнгаар олгож буй бол бизнес эрхлэгчид 200 сая төгрөг хүртэлх зээлийг цахимаар авах бололцоотой болсон.

Харилцагчийн туршлагын олон улсын IDCXS2022:02 стандартыг манай банк гурав дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж, хөндлөнгийн үнэлгээгээр 98 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн.

Мөн 2025 онд хиймэл оюунд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээгээ улам сайжруулан Business AI туслах болон Khan Business аппликэйшн зэрэг шинэ үйлчилгээг нэвтрүүлж, харилцагч байгууллагуудад бизнесээ ухаалгаар өсгөх боломжийг бүрдүүлээд байна.

ХААН Банк нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, байгаль орчин, соёл урлагийг дэмжих чиглэлд нийгмийн хариуцлагын ажлуудыг ХААН Банк сангаараа дамжуулан хэрэгжүүлж ирсэн. Өнгөрөгч оны хувьд онцлох томоохон ажил нь алслагдсан бүс нутагт 4 байршилд “Багийн бага сургууль”-ийг байгуулж өгч, боловсролын хүртээмж, суралцах орчныг сайжруулахад бодит хөрөнгө оруулалт хийлээ.

Манай хамт олны мэргэжлийн ур чадвар, хичээл зүтгэл, тогтвортой засаглал, технологийн манлайллыг дотооддоо төдийгүй олон улсад өндрөөр үнэлж, “Монгол Улсын шилдэг банк”, “Цахимаар тэргүүлэгч банк”-аар шалгаруулсан нь бидний үйл ажиллагаанд өгсөн бодит үнэлгээ гэж үзэж байна. Үүний зэрэгцээ ХААН Банк Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE Russell-ийн индекст багтсан Монголын анхны компани болж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл, олон улсын хөрөнгийн зах зээл дэх нэр хүндээ шинэ шатанд гаргалаа.

2025 оны амжилтын түүхийг хамтдаа бичилцсэн нийт ажилтнууд, бидэнд итгэл хүлээлгэдэг харилцагч, хувьцаа эзэмшигчид та бүхэнд талархал илэрхийлье.

2026 онд ХААН Банк үүсэн байгуулагдсаны 35 жилийн ой тохиож буй бөгөөд банкны системийн анхдагчдын нэгийн хувьд 2.9 сая харилцагч, 34 мянга гаруй хувьцаа эзэмшигчдэдээ үр өгөөжтэй, хамтдаа өсөж урагшилсан олон ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж буйг дуулгахдаа таатай байна. Та бүхэнд сайн сайхныг хүсье!

**Хүндэтгэсэн,**

**РЭНЦЭНБАТ ОВОГТОЙ МӨНХТУЯА**

# 2025 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ


Монгол Улсын анхны Жендэр бондыг амжилттай гаргалаа.



Нийт 530 сая ам.долларын урт хугацаат эх үүсвэрийг олон улсын зах зээлээс болон дотоодын хөрөнгийн зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэв.



Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE Russel-ийн индекст багтсан Монголын анхны компани боллоо.



Хиймэл оюунд суурилсан Business AI туслахыг нэвтрүүлэв.

Хиймэл оюунд суурилсан Khan Business аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлэв.



Багийн бага сургуулиудыг алслагдсан бүс нутагт үе шаттайгаар байгуулж, 2025 онд 3 сургууль хүлээлгэж өглөө.



 BANK OF THE YEAR  
AWARDS 2025  
Mongolia  
Khan Bank



## 2025 оны амжилтууд

### Олон улсын шагналууд



#### THE BANKER СЭТГҮҮЛ

“Монгол Улсын шилдэг банк”



#### EUROMONEY EXCELLENCE AWARDS 2025

“Монгол Улсын шилдэг банк”  
“Монгол Улсын шилдэг  
цахим банк”



#### FINANCE ASIA 2025 СЭТГҮҮЛ

“Тогтвортой хөгжлөөр  
тэргүүлэгч банк”  
“Шилдэг арилжааны банк”  
“Хамгийн шилдэг инновац  
технологитой банк”



#### ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК (EBRD)

“Хамгийн идэвхтэй аккредитив  
нээгч банк”  
“Харилцагчдад зориулсан шилдэг  
чатбот нэвтрүүлэгч байгууллага”  
“Цахим харилцагчийн туршлагын  
шилдэг стратегитай байгууллага”



#### “THE DIGITAL BANKER” СЭТГҮҮЛИЙН DIGITAL CX AWARDS 2025

“Харилцагчийн туршлагаар  
тэргүүлэгч цахим банк”  
“Шилдэг чатботыг  
нэвтрүүлсэн банк”



#### COURSERA

“Бүс нутгийн ялагч”

### Дотоодын шагналууд



#### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МҮХАҮТ

“ТОП-100 ААН”-ийн 4-рт  
эрэмбэлсэн.




#### МҮХАҮТ, “ЭНТРЕПРЕНЕР-2025”

“Оны онцлох ААН”  
мөнгөн Меркури цом  
“Банкны салбарын онцлох  
энтрепренер”,  
хүрэл Меркури цом



#### ТОС ХОЛБОО

“Жендэрийн манлай  
байгууллага”



#### МОНГОЛ ДАХЬ АМЕРИКИЙН ХУДАЛДААНЫ ТАНХИМ

Нийгмийн хариуцлагыг  
хэрэгжүүлэгч шилдэг  
байгууллага



#### МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

Шилдэг татвар төлөгч байгууллага



#### МУЦАЭХ, “GRAND BULL AWARDS 2025”

“Шилдэг нээлттэй  
хувьцаат компани”  
“Онцлох бүтээгдэхүүн”

# Компанийн Засаглал



# ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн засаглал нь компанийн зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоох, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг чиглүүлэх, хянах цогц тогтолцоо юм. Компанийн засаглалын бүтэц, түүний үйл ажиллагаа тогтвортой, сайн байх нь шийдвэр гаргалт, удирдлагын залгамж халааг оновчтой төлөвлөх, цаашид компани бие даасан, хараат бус байж, ирээдүйн хөгжилд тууштай анхаарах нөхцөлийг бүрдүүлж, олон эерэг үр дүн бий болгох давуу талтай.

Банк нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”, Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ” гэх )-ноос баталсан “Компанийн засаглалын кодекс”, Монголын хөрөнгийн бирж (“МХБ”, “Бирж” гэх)-ээс баталсан “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”, ХААН Банкны дүрэм, Компанийн засаглалын кодекс болон бусад холбогдох хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог. Энэ хүрээнд жил бүр Монголбанк болон СЗХ-нд засаглалын хэрэгжилтийн тайлан хүргүүлж, зохих үнэлгээ авдаг.

ХААН Банкны “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн тайланг 2025 оны эхний хагас жилийн байдлаар СЗХ хянан баталгаажуулж, 98.6 оноо буюу засаглал сайн, эрсдэлгүй гэж үнэлэн хувьцаат компаниудын дунд 1 дүгээр байранд эрэмбэлсэн. Энэхүү үнэлгээ нь компанийн засаглалын чанар, хяналт, удирдлагын тогтолцоог бид үр дүнтэй хэрэгжүүлж буйг илэрхийлж байна. Цаашид компанийн засаглалын тогтолцоог улам сайжруулах, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах чиглэлээр тасралтгүй анхаарч ажиллахаар зорьж байна.

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллагуудын санаачилгаар хөрөнгийн зах зээлийн шилдгүүдийг тодруулан өргөмжилдөг “Grand Bull Awards 2025” арга хэмжээний хүрээнд ХААН Банк нь тайлагналын ил тод байдал, сайн засаглал, ТУЗ-ийн хараат бус бодлого, хувьцааны хөрвөх чадвар зэрэг шалгуур үзүүлэлтүүдээр өндөр үнэлгээ авч, хөрөнгийн зах зээлийн “Шилдэг хувьцаат компани”-иар шалгарч, сайн засаглалын бодит үр дүнг харууллаа.

# ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

“ХААН Банк” ХК (Банк, ХААН Банк гэх) нь компанийн засаглалтай холбоотой Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, сайн туршлагуудыг дотооддоо нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд анхаарч ажилладаг.

Ингэснээр олон улсын үнэлгээний агентлагуудын дунд компанийн үнэлгээг өсгөх, Монголдоо системийн нөлөө бүхий тэргүүлэгч банкны нэр хүндийг хадгалахаас гадна өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэр татах, урт хугацаанд тогтвортой хөгжихөд ач холбогдолтой юм. Банкны компанийн засаглалын 4 үндсэн зарчим:

## Хариуцлагатай байдал

Банк хууль ёсныхоо эрх ашгийн хүрээнд өөрт олгогдсон хэрэгжүүлж буй эрх мэдэл болон үүргээ бүрэн хариуцах хариуцлагатай байх

## Ил тод байдал


Мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй, тодорхой байдлыг хангаж, оролцогч талуудад шийдвэр, үйл ажиллагааг ойлгож, итгэх боломжийг олгох

## Тайлагнал

Банкны бүх оролцогч /сонирхогч талуудад албан ёсны баримт бичиг, мэдэгдэл, харилцаагаар дамжуулан мэдээллийг тодорхой зохион байгуулалттайгаар хүргэх

## Шударга байдал

Банкны бүх оролцогч болон сонирхогч талуудад шударга, тэгш, ялгаваргүй хандах




# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Нийт **3,000,000,000** ширхэг зарласан хувьцаатай бөгөөд үүнээс **1,912,198,000** ширхэг гаргасан хувьцааг **34,601** хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн өргөн оролцоо нь банкиг хувьцаат компаниудын дунд жижиг

хувьцаа эзэмшигчийн тоогоороо харьцангуй өндөр байр суурь эзэлж байгааг илтгэхийн зэрэгцээ Банкны засаглалын ил тод байдал, хөрөнгө оруулагчдын итгэлийг харуулж байна.

Компанийн гаргасан хувьцааг дараах хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Үүнд:



■ **40.99%**

"Эйч Эс Холдингс" ХК

■ **8.78%**

"Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед" ХХК

■ **22.78%**

"Таван Богд Холдингс" ХХК

■ **13.22%**

Д.Хулан

■ **14.23%**

Олон нийт

## "ЭЙЧ ЭС ХОЛДИНГС" ХК

"Эйч Эс Холдингс" ХК нь 1958 онд анх үүсэн байгуулагдсан бөгөөд хувьцаагаа олон нийтэд арилжаалдаг (Токиогийн хөрөнгийн биржийн бүртгэлийн дугаар: 8699) нээлттэй хувьцаат компани юм. Тус компани нь гол төлөв үнэт цаасны арилжаа, зуучлал, хоёрдогч бүтээгдэхүүнээс гадна компаниудад үнэт цаас гаргаж, тэдгээрийг бусдад санал болгох, арилжих үйлчилгээ, мөн банк, үл хөдлөх хөрөнгө, шинээр үйл ажиллагаагаа эхэлж буй компаниудад хөрөнгө оруулах зэрэг санхүүгийн олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг. Харилцан хамаарал бүхий нийт 9 компанитай.

## "ЭЙЧ ЭС ИНТЕРНЭЙШНЛ (АЗИ)" ХХК

"Эйч Эс Интернэйшнл (Ази)" ХХК нь "Эйч Эс Холдингс" ХК-ийн Хонконг дахь охин компани юм. Тус компани нь Хятад болон Ази тивийн эдийн засгийн өсөлт дээр тулгуурлан Ази дахь стратегийг хэрэгжүүлж, бүс нутгийн улс орнуудын зах зээлийн судалгаа хийхээс гадна Хонконгийн зах зээлд бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг.

## “ТАВАН БОГД ХОЛДИНГС” ХХК

“Таван Богд Холдингс” ХХК нь “Таван Богд” группийн толгой компани ба группийн бодлого стратеги, менежментийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан. “Таван Богд” групп нь худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, аялал жуулчлал болон зочид буудал, уул уурхайн тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэлт, банк санхүү зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг. “Таван богд” групп “Toyota”, “Geely”, “Xerox” зэрэг брэндийн албан ёсны дистрибьютер бөгөөд “KFC”, “Pizza Hut”, “Subway” брэндийн сүлжээ ресторануудын Монгол Улс дахь албан ёсны франчайз эрхийг эзэмшдэг.

## Д.ХУЛАН

Монгол Улсын иргэн Д.Хулан нь “Таван Богд” группийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч бөгөөд одоо “Таван Богд” группийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Д.Хулан нь банкны ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэд дарга бөгөөд 2010 оноос бие даасан хувьцаа эзэмшигч болсон.

## ОЛОН НИЙТ

ХААН Банк нь Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2023 оны 4-р сарын 13-ны өдөр анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулж, нийт хувьцааныхаа 10 хувийг олон нийтэд санал болгосон нь Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн өндөр дүнтэй, хамгийн олон захиалга авсан, хамгийн олон хөрөнгө оруулагч хамрагдсан арилжаа болсон. Мөн “Банкны ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөр”-ийн хүрээнд 4,136 ажилтны эзэмшиж байсан хувьцааны тусгаарлалтын хугацаа 2023 онд дууссантай холбогдуулан хувьцааг үнэт цаасны данс руу шилжүүлснээр олон нийтэд хамаарах хувьцааны хэмжээ 272,068,550 ширхэг буюу нийт хувьцааны 14.23 хувьд хүрсэн.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.1-д заасны дагуу банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. ХААН Банкны хувьцаа эзэмшигчид нь ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах замаар банкнийг удирдах ба хувьцаа эзэмшигчид нь хуралд өөрсдийн эзэмшиж буй хувьцааны тоогоор саналын эрхтэй оролцоно. Банкны хувьцааг эзэмшиж буй хүн бүр Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй.

ХААН Банк нь холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулдаг бөгөөд 2025 оны ээлжит хурлыг 4-р сарын 24-ний өдөр танхим болон цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулж, дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1. “ХААН Банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.
2. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлав.
3. “ХААН Банк” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-ний төслийг батлав.

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, мэдээлэл, тайлбартай танилцан, асуулт, хариулт болон санал хүсэлтээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгч батлав.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн тухай хуулийн 75.1, “ХААН Банк” ХК-ийн дүрмийн 9.1-т заасны дагуу Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. ТУЗ нь Банкны тухай хуулийн 31.3-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

ТУЗ нь байгууллагын бүх шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалын зарчмыг хэрэгжүүлж, Банкны стратеги, алсын харааг тодорхойлон, Банкны үйл ажиллагааг үр ашигтай, тогтвортой байлгах зорилгоор шийдвэр гаргалт, удирдлагын процессыг чиглүүлж, дэмжин ажилладаг. Банкны ТУЗ нь Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, үүний дотор Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголбанк, СЗХ, Монголын хөрөнгийн биржийн холбогдох дүрэм, журам, заавар, ХААН Банкны дүрэм, Компанийн засаглалын кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох эрх зүйн бичиг баримтыг мөрдөн компанийн зохистой засаглалыг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулдаг. ТУЗ-ийн ээлжит хурал нь жилд дөрвөөс доошгүй удаа хуралддаг бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулдаг.

Тайлант хугацаанд ТУЗ нийт 7 удаа бүх гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, 43 тогтоол баталсан байна. Өөрийн чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх удирдлагын багт санал, зөвлөмж, үүрэг даалгавар өгч, тэдгээрийн хэрэгжилтэд тогтмол, нягт хяналт тавин ажилласан.

Түүнчлэн 2024 оны эцэст баталсан бизнес төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх удирдлагаас сар бүр хүргүүлсэн санхүү болон гүйцэтгэлийн тайланг үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, удирдлагын багийг зорилгод нийцүүлэн оновчтой чиглүүлэн ажиллалаа.

Банкны ТУЗ нь банк, санхүү, эрсдэлийн удирдлага, компанийн засаглал, хууль эрх зүй, зохицуулалтын орчин болон стратегийн төлөвлөлт зэрэг олон чиглэлээр өргөн хүрээний мэдлэг, туршлагатай, нэр хүндтэй мэргэжилтнүүдээс бүрддэг бөгөөд хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болон хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгон шалгаруулдаг. 2023 оны 6-р сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар одоогийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаатай томилсон.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

## ТУЗ-ийн хараат бус гишүүд



**Т.ДАРЬБУМ**  
ТУЗ-ийн дарга

Хатагтай Т.Дарьбум 2020 оны 8-р сараас ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр Монгол Улс болон Хойд Америкт бизнесийн удирдлага, банк санхүүгийн чиглэлээр 30 гаруй жил ажилласан, өндөр ур чадвартай мэргэшсэн хүн юм. Хойд Америкийн зургаа дахь, Канад Улсын хоёр дахь том банк болох "ТиДи банк" группт 10 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд АНУ-ын Сиаттлын их сургуульд санхүүгийн шинжлэх ухааны магистрын зэрэг хамгаалсан. Канадын мэргэшсэн нягтлан бодогч (CPA) зэрэгтэй.



**А.ТАМИР**  
Хараат бус гишүүн

Монголын мэргэшсэн татварын зөвлөх, Монголын мэргэшсэн нягтлан бодогч (CPA) ноён А.Тамир нь 2020 оны 7-р сараас Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр аудит, нягтлан бодох бүртгэл, татварын болон санхүүгийн тайлан, дүн шинжилгээ, бизнес төлөвлөлт гэх зэргээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын "Пи Кэй Эф Интернэйшнл" компанийн Монгол дахь гишүүн компани болох "Пи Кэй Эф - Ай Эф Эс Монголиа" ХХК-ийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэдэг.



**ХАНС ААРТ  
ЙОНГЕЯНС**  
Хараат бус гишүүн

Ноён Ханс Аарт Йонгеянс нь 2020 оны 7-р сараас банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр банк санхүүгийн салбарын эрсдэлийн удирдлагын чиглэлээр 50 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд Нидерландын Вант улсын Банк санхүүгийн институтийг амжилттай дүүргэн Эй Би Эн АМРО банк (Нидерланд), Би Эн Пи Парибас банк (Франц) болон Австрали, Тайланд, Бельги, Саудын Араб, Бахрейн зэрэг улсын банк санхүүгийн байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан.

## ТУЗ-ийн ердийн гишүүд



**Д.ХУЛАН**  
ТУЗ-ийн дэд дарга

Хатагтай Д.Хулан нь банкны бие даасан хувьцаа эзэмшигч бөгөөд ТУЗ-ийн гишүүнээр 2003 оны 3-р сараас ажиллаж байна. Тэрээр “Таван Богд” группийг үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд ТУЗ-ийн даргын албан тушаалыг хашдаг. Д.Хулан нь ОХУ-ын Москва хотын Санхүүгийн их сургуулийг олон улсын эдийн засгийн бакалавр зэрэгтэй төгссөн, мөн Япон улсад мэргэжил дээшлүүлсэн. Түүнчлэн Монгол Улсын Сангийн яам, Худалдаа хөгжлийн банк зэрэг байгууллагад ажиллаж байсан, банк санхүүгийн салбарын арвин мэдлэг, туршлагатай.



**КИСАБҮРО ИШИЙ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Ноён Иший Кисабүро нь “Эйч Эс Холдингс” ХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд тус компанийн хараат бус захирлаар ажиллаж байна. Тэрээр Токиогийн их сургуулийг эрх зүйн бакалаврын зэрэгтэй төгссөн. Япон улсын Газар, дэд бүтэц, тээврийн яамнаас ажлын гараагаа эхлүүлж, Хотын захиргааны ерөнхий захирлаас дэд сайдын албан тушаал хүртэл дэвшин ажилласан. Түүнчлэн Япон улсаас Румын улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын албан тушаалыг хашиж байсан туршлагатай.



**Ц.БААТАРСАЙХАН**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Ноён Ц.Баатарсайхан нь “Таван Богд Холдингс” ХХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн гишүүн юм. Тэрээр ТУЗ-ийн ердийн гишүүнээр 2009 оны 3-р сараас томилогдон ажиллаж байна. “Таван Богд” группийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашдаг. Ц.Баатарсайхан нь Монгол Улсын Политехникийн их сургууль болон Япон улсын Токио хотын Цахилгаан холбооны их сургуулийг тус тус дүүргэсэн. Монгол-Японы хамтарсан “Алтай” ХХК-ийн захирал болон МИАТ ХК-ийн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай.

## ТУЗ-ийн ердийн гишүүд



**ХАРАДА ЯСҮНАРИ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Ноён Харада Ясүнари нь “Эйч Эс Интернэйшнл (Ази)” компанийг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд “Эйч Эс Холдингс” ХК-ийн Ерөнхийлөгч, Төлөөлөгч захирлын албан тушаалыг хашиж байна. Тэрээр Япон улсын Кьюшү их сургуулийг Эрх зүйн бакалаврын зэрэгтэй төгссөн. Ажлын гараагаа Япон улсын Аж үйлдвэрийн банкнаас эхлүүлж, Морган Стэнли, Би Эн Пи Парибас, Социэтэ Женерале зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын Япон Улс дахь салбаруудад ажиллаж, туршлага хуримтлуулсан.



**ЖОН ЛО**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Ноён Жон Ло нь байгууллагын банк болон хөрөнгө оруулалтын банкны чиглэлд 30 гаруй жил ажилласан арвин туршлагатай нэгэн. Өмнө нь ОУСК-ийн Олон улсын санхүүгийн зах зээлийн газарт банкны мэргэжилтнээр ажиллаж байсны дээр Ситибанк болон Жи.Пи Морган зэрэг банкуудад Ази, Номхон далайн бүс хариуцсан удирдах түвшний албан тушаал хашиж байсан туршлагатай. Тэрээр АНУ-ын Индиана мужийн Блүүмингтон хот дахь Индианагийн их сургуульд Бизнесийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан. 2016 оноос ХААН Банкны ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



**Б.АМАРСАНАА**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор, профессор Батболдын Амарсанаа нь банкны ТУЗ-ийн ердийн гишүүн юм. Тэрээр өмнө нь Арбитрын шүүхийн арбитрч, шүүн таслах бүрэлдэхүүний даргаар олон хэрэг дээр ажиллаж байсан төдийгүй Хонконгийн Олон улсын арбитрын төв, Олон улсын худалдааны танхимын арбитрын шүүх дээр Монгол Улсын хууль эрх зүйн мэргэжилтнээр ажиллаж маргаан шийдвэрлэж байсан туршлагатай. Үүнээс гадна Хууль зүйн зөвлөлийн үндсэн гишүүний хувьд Монгол Улсын томоохон хуулиудын төслийг бэлтгэх чиглэлээр ажилласан өргөн туршлагатай хүн юм.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Компанийн тухай хуулийн 81-р зүйлд заасны дагуу банкны ТУЗ нь тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороодыг байгуулан ажиллуулдаг. ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүрийн чиг үүрэг, үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийн эрх үүрэг, тэдгээрт тавигдах шаардлага зэрэг бусад асуудлыг хороодын дүрэм, Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулдаг. Холбогдох журам, зааврын зохистой байдлыг хадгалах үүднээс хороод нь өөрсдийн дүрмийг хянаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах саналыг ТУЗ-д хүргүүлдэг.

Банкны 2024 оны 3-р сарын 13-ны өдрийн ТУЗ-ийн 7 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсан.

Банкны чухал үйл ажиллагааны чиглэлүүдэд хяналт, шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор ХААН Банкны ТУЗ нь дэргэдээ дөрвөн байнгын хороотой ажиллаж байна. Эдгээр хороо нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, зохицуулагч байгууллагуудаас баталсан холбогдох дүрэм, журам, зааварт нийцүүлэн боловсруулж өөрсдийн үйл ажиллагааны дүрмийг мөрдөн ажилладаг бөгөөд уг дүрмээр хороодын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан.

ТУЗ-ийн дэргэдэх хороод	Хорооны дарга	Хорооны гишүүд
Аудитын хороо	А. Тамир (Хараат бус гишүүн)	Ханс Аарт Йонгеганс (Хараат бус гишүүн) Иший Кисабүро (Ердийн гишүүн)
Эрсдэлийн хороо	Т.Дарьбум (Хараат бус гишүүн)	Ц.Баатарсайхан (Ердийн гишүүн) Ханс Аарт Йонгеганс (Хараат бус гишүүн)
Засаглал, цалин урамшууллын хороо	А.Тамир (Хараат бус гишүүн)	Харада Ясүнари (Ердийн гишүүн) Т.Дарьбум (Хараат бус гишүүн)
Нэр дэвшүүлэх, хүний нөөцийн хороо	Ханс Аарт Йонгеганс (Хараат бус гишүүн)	А.Тамир (Хараат бус гишүүн) Д.Хулан (Ердийн гишүүн)

## АУДИТЫН ХОРОО

ТУЗ-ийн Аудитын хороо нь Банкны санхүүгийн тайлан, тайлагналын үнэн бодит байдал, нягтлан бодох бүртгэлийн үр дүнтэй системийг хангах болон дотоод хяналтыг тогтолцоо, хэрэгжилтийг үнэлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Мөн банкны хөндлөнгийн аудит болон дотоод аудитын мэргэжлийн, хараат бус байдал болон ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг.

## ЭРСДЭЛИЙН ХОРОО

ТУЗ-ийн Эрсдэлийн хороо нь Банкны эрсдэлийг зохистой удирдах, эрсдэлийн хяналтын системд үнэлэлт өгч, Банкны эрсдэлийн бодлогуудыг хянан батлах, учирч болзошгүй эрсдэлийн өсөлт, хязгаарын тоон үзүүлэлт дээр үндэслэн зээл, зах зээл, хөрвөх чадвар, үйл ажиллагаа, комплаенс, нэр хүнд болон бусад эрсдэлд хяналт тавих, санал зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Түүнчлэн БОНЗ, тогтвортой хөгжил болон уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг үнэлэх, хянах, тодорхойлох, удирдах, тэдгээрийг банкны нийт эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нэгтгэн бодитой хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих зэрэг чиг үүрэгтэй.

## ЗАСАГЛАЛ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ-ийн Засаглал, цалин урамшууллын хороо нь компанийн засаглалын цогц зарчим, ёс зүйн дүрэм, компанийн засаглалын стратеги, гүйцэтгэл, тайлагналд хяналт тавих, банкны урамшууллын системийн зорилгыг тодорхойлох, ТУЗ болон ТУЗ-өөс томилогддог эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан олгох хүрээнд ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Түүнчлэн нь банкны байгаль орчин, нийгмийн хариуцлагын стратеги, хөтөлбөр, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чухал чиг үүрэгтэй. Энэ хүрээнд тус хороо нь банкны Тогтвортой хөгжлийн хороотой хамтран ажиллаж, байгаль орчны болон нийгмийн арга хэмжээний гүйцэтгэлийг хагас жил тутамд үнэлж, дүгнэлт гарган, хяналт тавьдаг.

## НЭР ДЭВШҮҮЛЭХ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХОРОО

ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, хүний нөөцийн хороо нь Банкны хүний нөөцийн стратеги, төлөвлөгөө, үндсэн бодлого, залгамж халаа, удирдлагын гэнэтийн бэлэн байдлыг удирдах, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-өөс томилогддог эрх бүхий албан тушаалтныг нэр дэвшүүлэх, томилох, үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөхөд ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

# ДОТООД АУДИТ

## Дотоод аудитын зохион байгуулалт, чиг үүрэг

ХААН Банкны дотоод аудит нь зохистой засаглалын зарчмын дагуу банкны гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны шууд удирдлагад харьяалагдан ТУЗ-ийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Дотоод аудит нь банкны эрсдэлийн удирдлагын хамгаалалтын III шугамын чиг үүргийн хүрээнд Гүйцэтгэх удирдлагаас бий болгосон эрсдэлийн удирдлагын тогтолцоо, хамгаалалтын I болон II шугамын үр дүнтэй байдалд үнэлгээ хийж, зөвлөмж мэдээллээр хангаж байна.

ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Ерөнхий аудиторын томилгоо, Дотоод аудитын дүрэм, стратеги болон жилийн төсөв төлөвлөгөөг батлах, аудитын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавих байдлаар Дотоод аудитын бие даасан, хараат бус байдлын статусыг хангадаг. Ерөнхий аудитор нь Дотоод аудитын дүрмээр тодорхойлогдсон эрх хэмжээний хүрээнд Салбарын аудитын газар, Төв банкны аудитын газар, Мэдээлэл технологийн аудитын газар гэсэн бүтэцтэйгээр банкны стратегид чиглэн, эрсдэлд суурилсан арга аргачлалаар үйл ажиллагаагаа зохион байгуулж, төлөвлөн хэрэгжүүлж байна.

Дотоод аудит нь үйл ажиллагаандаа Олон улсын дотоод аудиторчуудын институт (ОУДАИ)-ээс гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (цаашид ОУМПХ гэх)-ний стандартуудыг мөрдөж ажилладаг бөгөөд 2023 онд олон улсын нэр хүнд бүхий байгууллагаар Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийлгэж “бүрэн нийцсэн” гэж үнэлэгдсэн. 2024 онд шинэчлэгдэн батлагдсан ОУМПХ-ний стандартууд болон сэдэвчилсэн шаардлагуудын хүрээнд 2025 онд дотоод аудитын дүрэм болон дагалдах баримт бичгүүдээ шинэчилж, стандартын нийцтэй байдалд жил бүр дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээ хийж сайжруулдаг.

Дотоод аудит нь тодорхойлсон зорилго, стратеги, түүнийг хэрэгжүүлэх засаглалын зохистой зохион байгуулалтаараа банкны бизнесийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагааны зорилгыг дэмжих, хамгаалахад чиглэн ажиллаж байна.

## Дотоод аудитын зорилго, үйл ажиллагаа

ХААН Банкны дотоод аудит нь засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоонд бодитой байх зарчимд тулгуурласан хараат бус аудитын үйлчилгээ үзүүлэх замаар банкны үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулдаг.

2025 онд бид үйл ажиллагаагаа олон улсын жишигт нийцүүлэх, дэвшилтэт технологи ашиглан чанарын үр дүнг тогтмол сайжруулах үүднээс “Дунд хугацааны стратеги 2025-2027”-г шинэчлэн боловсруулж, дотоод аудитын үйл ажиллагааны стандартын нийцлийг хадгалж, мэргэжлийн үр чадварыг сайжруулан, аудитын үйл ажиллагаанд тэргүүлэх арга аргачлалыг нэвтрүүлж, автоматжуулалтыг сайжруулах замаар дижитал хөгжлийн дараагийн түвшинд хүрсэн, үнэ цэнийг нэмэгдүүлэгч стратегийн түнш болох зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Энэхүү стратегийн суурь болох мэргэжлийн үр чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дотоод аудиторудаа тогтмол сургаж, хөгжүүлэхэд анхаарч ажилласны үр дүнд 2025 оны байдлаар CIA, CISA, ESG аудитор, ISO/IEC 27001:2022 lead, Cobit 2019 design and Implementation, AML & CTF foundation level зэрэг нийт аудиторт эзлэх санхүү, дотоод аудит, БОНЗ, мэдээлэл технологийн чиглэлд олон улсын мэргэжлийн сертификаттай аудиторудын тоо 20%, мөн ММНБ, ТМЗ, ҮЦЗЗ-д мэргэжлийн үйлчилгээ эрхлэх, Компанийн засаглалын зэрэг дотоодын мэргэжлийн сертификаттай аудиторын тоо нийт аудиторт 35% -ийг эзэлж байна.

Тайлант хугацаанд “Дотоод аудитын төлөвлөлтийн бодлого”-ын дагуу банкны стратеги, зорилтууд, эрсдэлийн үнэлгээнд суурилсан аудитын төлөвлөгөөг боловсруулан банкны тогтвортой бизнес стратеги, түүний 4 үндсэн чиглэлд хамаарах гол зорилтуудын хэрэгжилт, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд баталгаажуулалт хийж, бизнесийн болон процессийн үр ашигт байдалд чиглэн ажилласан.

Монголбанкнаас боловсруулсан “Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-өөр тодорхойлсон “Банкны хяналт шалгалт зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх”, “МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, ФАТФ-ын дараагийн үнэлгээнд бэлтгэх зорилтуудын хүрээнд банкны эрсдэлийн удирдлагын үйл явцад томоохон өөрчлөлтүүд хийгдэж байна. Ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг таньж мэдэх, удирдах чиглэлээр эдгээр өөрчлөлтийг хийж байгаа бөгөөд болзошгүй эрсдэлийн магадлал, үр нөлөө, хүчин зүйлийн оновчтой тооцоололд аудитын баталгаажуулалт хийх шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан. Банкны дижитал стратегийн хүрээнд хэрэгжүүлж байгаа цахим бүтээгдэхүүн үйлчилгээ, процессийн автоматжуулалтын чиглэлд мэдээлэл технологийн болон мэдээллийн аюулгүй байдал, өгөгдөл тайлагналын эрсдэлд чиглэсэн аудитуудыг гүйцэтгэж баталгаажуулав.

# ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



**Р.МӨНХТУЯА**  
Гүйцэтгэх захирал



**Б.ЭРДЭНЭДЭЛГЭР**  
Гүйцэтгэх захирлын  
тэргүүн орлогч



**САЧИН НАИР**  
Технологи, үйл ажиллагаа  
хариуцсан Гүйцэтгэх  
захирлын орлогч



**Г.МӨНХБАЯР**  
Эрсдэл хариуцсан  
Гүйцэтгэх захирлын орлогч




**Д.ДУГАРБААТАР**  
Ерөнхий аудитор




**В.ЯНЖИНЛХАМ**  
ТУЗ-ийн нарийн  
бичгийн дарга



**Ш.ГАНБЯМБА**  
Хүний нөөц хариуцсан  
дэд захирал



**Д.АРИУНБАТ**  
Байгууллагын банк  
хариуцсан дэд захирал




**Т.УУГАНБАЯР**  
Үйл ажиллагаа хариуцсан  
дэд захирал



**Ш.ӨЛЗИЙ-АЮУШ**  
Санхүү хариуцсан  
дэд захирал



**Ж.ТОВУУДОРЖ**  
Жижиг дунд бизнесийн банк  
хариуцсан дэд захирал




**Б.АРИУНБОЛД**  
Мэдээллийн технологи  
хариуцсан дэд захирал




**Ч.ЧИНБОЛД**  
Иргэдийн банк хариуцсан  
дэд захирал



**Ю.ТӨРМӨНХ**  
Стратеги хариуцсан  
дэд захирал



**Д.ӨЛЗИЙЖАРГАЛ**  
Санхүүгийн эрсдэл  
хариуцсан дэд захирал



**С.ЭНХ-ИРЭЭДҮЙ**  
Бизнес хөгжил хариуцсан  
дэд захирал




**О.АРИУНТУЛГА**  
Байгууллагын эрсдэл,  
комплеэнс хариуцсан  
дэд захирал



**Г.ХУЯГБААТАР**  
Мэдээллийн технологийн  
тасралтгүй ажиллагааны  
захирал



**Э.НЯМЦЭНД**  
Цахим банкны захирал



**Д.ДАВААЖАРГАЛ**  
Аюулгүй байдлын захирал



**Р.ИЧИННОРОВ**  
Орон нутгийн иргэдийн  
банкны захирал



Монгол Улсын Компанийн тухай хууль болон Банкны тухай хуулийн дагуу Банкны гүйцэтгэх удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд, Монголбанкны зөвшөөрлөөр томилдог. Гүйцэтгэх удирдлага нь Банкны тухай хуульд заасан шаардлагыг ханган ажиллах үүрэг хүлээж, үйл ажиллагааныхаа талаар ТУЗ-д тогтмол тайлагнана.

Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавин ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-өөс гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ХААН Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12-р сарын 24-ний өдрийн 18 тоот тогтоолоор хатагтай Р.Мөнхтуяаг ХААН Банкны Гүйцэтгэх захирлаар томилсон бөгөөд тус банкны гүйцэтгэх удирдлагын баг дээрх бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



# Бизнесийн зорилтууд



# БИЗНЕСИЙН ЗОРИЛТУУД

ХААН Банк нь салбартаа манлайлагчийн байр сууриа улам бэхжүүлж, дэвшилтэт инновац, дижитал шилжилтэд суурилсан 2024-2026 оны дунд хугацааны тогтвортой бизнесийн стратегийг хэрэгжүүлж, банкны хөгжлийг дараагийн шинэ шатанд хүрэх зорилтыг түүштай ханган ажиллаж байна.

Энэхүү стратеги нь Харилцагчийн туршлага, Цахим банк, Бизнесийн өсөлт ба эрсдэлийн удирдлага, Байгууллагын хөгжил гэсэн дөрвөн тулгуур чиглэлд төвлөрөн, урт хугацаанд үнэ цэн бий болгоход чиглэж байна.



# ХАРИЛЦАГЧИЙН ТУРШЛАГА

ХААН Банк нь Монгол  
Улсын нийт хүн амын

**83%** буюу 2.9 сая гаруй  
харилцагчид

цогц үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.



Өргөн цар хүрээтэй дижитал үйл ажиллагааг аюулгүй, найдвартай, чанартай, олон улсын түвшинд хэрэгжүүлэхийн тулд ХААН Банк нь олон улсын жишигт нийцсэн стандарт, удирдлагын тогтолцоонуудыг үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэвтрүүлж, харилцагчийн туршлага, үйл ажиллагааны чанарыг тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

ХААН Банк нь харилцагчийн ялгаатай зан төлөв, нарийвчилсан микросегментүүдийг тодорхойлж, тус модельд үндэслэн харилцагчид тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчийн утасны

дугаарт мессеж илгээх, ХААН Банк аппликэйшн болон Digi Pay хэтэвчний мэдэгдлээр /Push notification/ автоматаар санал болгох боломж бүхий Digi Brain системийг нэвтрүүлсэн. Үүний хүрээнд, 11.7 сая удаа бүтээгдэхүүн санал болгож, 712 мянга гаруй харилцагчид банкны бүтээгдэхүүн борлуулсан байна.

ХААН Банк харилцагчдадаа чанартай үйлчилгээ үзүүлэх үүднээс олон улсын жишигт нийцсэн стандартуудыг нэвтрүүлэн түүнийг тасралтгүй сайжруулан ажилладаг билээ. Үүний хүрээнд дараах стандартуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Банкны цахим сувгуудаар хийгддэг  
нийт санхүүгийн гүйлгээний эзлэх хувь

**99.6%**

хувьд хүрсэн.

Монгол Улсад цахим сувгаар  
дамжин хийгдэж буй нийт гүйлгээний

**75%**

дангаараа бүрдүүлж байна.

### IDCXS 2022:02 СТАНДАРТ - ХАРИЛЦАГЧИЙН ТУРШЛАГА:

ХААН Банк нь цахим сувгаар хүргэж буй үйлчилгээний чанарыг сайжруулах, харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн дижитал хэрэглээг нэмэгдүүлэх, харилцагчийн туршлагыг олон улсын түвшинд хүргэх зорилгоор 2023 онд Олон улсын хэрэглэгчийн туршлагын институтын IDCXS 2022:02 стандартыг нэвтрүүлсэн. Энэхүү стандартыг гурав дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж, 2025 онд "British Standards Institution" (BSI) байгууллагын аудитын дүнгээр олон улсын төгөлдөршил буюу "International Excellence" түвшинд 98 хувийн гүйцэтгэл үзүүлснээр олон улсын жишигт нийцсэн амжилтаа дахин бататгалаа.

(BSI) байгууллагын аудитын дүнгээр  
"International Excellence" түвшинд

98%

### ISO9001:2015 СТАНДАРТ - ЧАНАРЫН УДИРДЛАГА:

Банкны хэмжээнд чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд ISO 9001:2015 "Олон улсын чанарын менежментийн тогтолцоо"-ны стандартыг 2025 оноос үе шаттайгаар нэвтрүүлж, банкны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч газар, нэгжүүдэд чанарын дотоод аудитыг амжилттай зохион байгууллаа. Үүний үр дүнд бүтээгдэхүүн, үйлчилгээний процессууд сайжирч, үйл ажиллагааны үр ашиг бодитоор нэмэгдэж цаашид тус стандартыг бүрэн хэрэгжүүлснээр банкны төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, тасралтгүй сайжруулалтын бүх үе шатанд чанарыг системтэй удирдах боломж бүрдэж байна.

### SWIFT ISO 20022 СТАНДАРТ - ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР ТООЦОО:

SWIFT ISO 20022 стандартыг амжилттай нэвтрүүлснээр дэлхий дахинд өрнөж буй санхүүгийн дижитал шилжилтийн чиг хандлагатай бүрэн нийцсэн төдийгүй өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, ухаалаг автоматжуулалт, цаашдын дэвшилтэт финтек интеграцын суурийг тавьж, банкны технологийн хөгжлийг дараагийн түвшинд хүргэх стратегийн ач холбогдолтой юм. Мөн олон улсын санхүүгийн зах зээлийн шаардлагад бүрэн нийцсэн, орчин үеийн төлбөр тооцооны дэд бүтэцтэй болж, дэлхийн тэргүүлэгч банкуудтай ижил түвшинд "SWIFT ISO Migration"-ийг хэрэгжүүлсэн нь "Pure Digital Bank" болох стратегийн зорилтыг бодитоор хэрэгжүүлэх чухал алхам боллоо. SWIFT ISO 20022 стандарт нь XML бүтэцтэй, өгөгдөл баялаг мессежийн формат тул банк дотоод үндсэн системүүдээ олон улсын стандарттай уялдуулан шинэчилж, автомат боловсруулалт, шууд холболт, интеграцид суурилсан шийдлүүдийг анх удаа бүрэн хэмжээнд нэвтрүүллээ. Энэ нь банкны үйл ажиллагааг илүү ухаалаг, үр ашигтай болгохын зэрэгцээ дотоод инновацийн чадавхийг бодитоор нэмэгдүүлж байна. Энэхүү стандартын хэрэгжилт, инновацид суурилсан дижитал шийдлүүд, харилцагч төвтэй стратегийн бодит үр дүнг олон улсын түвшинд үнэлэн, "The Digital Banker" сэтгүүлээс зохион байгуулдаг "Digital CX Awards 2025"-аас ХААН Банкныг:

- "Харилцагчийн туршлагаар тэргүүлэгч цахим банк"
- "Харилцагчдад зориулсан шилдэг чатбот нэвтрүүлэгч байгууллага"
- "Цахим харилцагчийн туршлагын шилдэг стратегитай байгууллага"

гэсэн гурван төрөлд тус тус шалгаруулсан нь банкны цахимжилт болон инновац, харилцагчийн туршлагаар манлайлж буйг олон улсын хэмжээнд баталгаажуулсан чухал үнэлгээ болсон юм.

## Харилцагчийн туршлага ба харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлого

Хамтын өсөлтийг эрхэм болгосон ХААН Банк Монгол орны өнцөг булан бүрд байрлах салбар, тооцооны төвүүд болон цахим сувгуудаараа дамжуулан харилцагчдынхаа санхүүгийн аяллын алхам бүрд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхдээ “Харилцагчийн туршлагын бодлого” болон “Харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлого”-ын зургаан зарчмыг баримтлан ажилладаг. Энэхүү бодлогын хүрээнд мэдээллийг ил тод хүртээмжтэй хүргэх үүргийн дагуу харилцагчид, олон нийтэд нээлттэй байршуулдгаараа онцлог юм.

Харилцагчийн туршлага, чанарын бодлого:

2025 онд харилцагчийн туршлагыг байгууллагын түвшинд илүү үр дүнтэй удирдах зорилгоор “Харилцагчийн туршлагын бодлого”-ыг шинэчлэн “ХАРИЛЦАГЧИЙН ТУРШЛАГА, ЧАНАРЫН БОДЛОГО” болгон баталлаа. Иймд бид дараах туршлагыг бий болгохоор зорьж байна.

Зорилтот туршлага	Харилцагчид өгөх амлалт
Энгийн хялбар	Харилцагчид бүхий л сувгаар хүргэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь ашиглахад энгийн, хялбар байна.
Харилцагч бүрийн хэрэгцээ онцлогт нийцсэн	Харилцагчийн өнцгөөс харж, одоогийн болон ирээдүйн хэрэгцээ хүлээлтийг нарийвчлан тодорхойлж, түүнд үндэслэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг загварчилж хүргэнэ.
Найдвартай бүтээгдэхүүн үйлчилгээ	Банк бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан харилцагчийн санхүүгийн найдвартай түнш, итгэлт зөвлөх нь байж, бүтээгдэхүүн үйлчилгээний найдвартай байдлыг тогтмол хангана.
Чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ	Банк бүтээгдэхүүн үйлчилгээний чанарт тогтмол анхаарч, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, харилцагчид хүргэх бүхий л үе шатанд чанарыг сайжруулах нь бүх ажилтны үүрэг байна. Банк үйл ажиллагаандаа хамаарах хууль, тогтоомж болон хүлээсэн үүрэг, хариуцлагаар тогтоосон бүхий л шаардлагуудад тогтмол нийцэж ажиллана.

## Харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлого

ХААН Банк харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлогыг үйл ажиллагааныхаа үндсэн зарчим гэж тодорхойлж, дараах чиглэлээр системтэй ажиллаж байна. Энэхүү бодлогынхоо хүрээнд дараах зүйлсийг хэрэгжүүлж байна.

- Харилцагчтай холбогдох бүх үйл ажиллагаанд шударга, ил тод байдлыг хангах
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, хураамж, шимтгэлийн талаарх мэдээллийг ойлгомжтой, бүрэн, үнэн зөв өгөх
- Харилцагчийн шийдвэр гаргахад нөлөөлөх мэдээллийг нууцлалын шаардлага хангасан нөхцөлд ил тод тайлбарлах
- Зохистой засаглалыг дэмжиж, харилцагчийн туршлага төвтэй байгууллагын соёлыг төлөвшүүлэх зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### Харилцагчийн эрх ашгийг хамгаалах 6 зарчим

<b>Зарчим 1</b>	Шударга харилцах	Харилцагчдад шударга, хүндэтгэлтэй үйлчилж, харилцагчийн банканд итгэх итгэлийг бататгах
<b>Зарчим 2</b>	Хэрэгцээнд нийцэх	Харилцагчийн хэрэгцээнд тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлсон сегментээр үзүүлэх
<b>Зарчим 3</b>	Ил тод, хүртээмжтэй байх	Бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээлэл, сурталчилгаа, тайлбар зөвлөгөөг үнэн зөв, шуурхай, хүртээмжтэй байдлаар хүргэх, харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх
<b>Зарчим 4</b>	Нууцлалыг хангах	Харилцагчийн мэдээллийг хамгаалж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах
<b>Зарчим 5</b>	Гомдол саналыг үнэн зөвөөр шийдвэрлэх	Харилцагчийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, зөрчлийн хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлэх
<b>Зарчим 6</b>	Чанартай үйлчилгээ үзүүлэх	Бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдлэг туршлагатай ажилтныг бэлтгэх

# ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2025 онд ХААН Банк харилцагчийн үйлчилгээг цахим шилжилт, хиймэл оюунд суурилсан шийдэл, үйлчилгээний чанарын стандартчлал, ажилтны чадавхжуулалт гэсэн дөрвөн тулгуур чиглэлийн

хүрээнд хөгжүүлэн үйлчилгээний хүртээмж, үр ашиг, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн ажиллалаа. Харилцагчийн үйлчилгээний чиглэлд тайлант онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

## Үйлчилгээний нэгдсэн төв

2025 онд

**3** сая гаруй  
дуудлагад

амжилттай үйлчилсэн.

Автомат хариулагч болон  
Digi чатботоор дамжуулан

**2.5** сая гаруй  
асуудлыг

шуурхай шийдвэрлэсэн.

Үйлчилгээний нэгдсэн төв (ҮНТ) нь банкны цахим шилжилтийг дэмжих хүрээнд 2025 онд 3 сая гаруй дуудлагад амжилттай үйлчилж, автомат хариулагч болон Digi чатботоор дамжуулан 2.5 сая гаруй асуудлыг шуурхай шийдвэрлэснээр дуудлагын төвийн ачааллыг бодитой бууруулан цахим сувгийн ашиглалтыг эрс нэмэгдүүлэв.

Үүнтэй зэрэгцэн тусгай хэрэгцээт харилцагчдад зориулсан дохионы хэлтэй видео теллерийн үйлчилгээг нэвтрүүлж үйлчилгээний тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор 24/7 горимоор ажиллах боломжтой лавлах төвийг Дархан хотод ашиглалтад оруулаад байна.

## “GEN AI” -д суурилсан “Digi” чатбот

Харилцагчийн асуултад уялдаа холбоотой, оновчтой хариу өгөх чадвартай, латин ба кирилл үсэг төдийгүй англи хэлээр харилцах боломжтой “GEN AI”-д суурилсан Digi чатботыг ХААН Банк 2024 онд амжилттай нэвтрүүлсэн билээ.

2025 онд Digi чатботоор нийт 377,000 гаруй харилцагчид үйлчилж, тэдгээрийн 88% нь бүрэн, шаардлагатай мэдээллээ авсан бөгөөд чатботын гүйцэтгэлийг бодитой, нарийвчлалтай хэмжих автомат үнэлгээний системийг нэвтрүүлснээр асуултыг ойлгох чадвар, хариултын зөв байдал, үйлчилгээний шуурхай байдлыг тасралтгүй сайжруулаад байна.

2025 онд Digi чатботоор нийт 377,000  
гаруй харилцагчид үйлчилж, тэдгээрийн

**88%**

бүрэн, шаардлагатай  
мэдээллээ авсан.

Чатботоор мэдээлэл авч буй харилцагчийн тоо өмнөх онтой харьцуулахад 44 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## Гомдол шийдвэрлэх үйл ажиллагаа

Тайлант онд 1.4 тэрбум санхүүгийн гүйлгээний ердөө 0.01 хувьтай тэнцэхүйц гомдлыг хүлээн авч, түүний 95%-ийг хяналтын хугацаанд, 30%-ийг анхны хандалтаар шийдвэрлэж, өндөр гүйцэтгэлтэй ажиллалаа. Бүтээгдэхүүн, үйлчилгээний доголдолтой холбоотой гомдол 22.5 хувиар буурсан нь банкны хэмжээнд чанарын удирдлагын системийг амжилттай хэрэгжүүлсний бодит үр дүн байв.

## ХААН саналын систем

ХААН Банк ажилтнуудынхаа дуу хоолойг тогтмол сонсож, идэвх оролцоог нэмэгдүүлэх, гар ажиллагааг бууруулах, автоматжуулалтыг дэмжих зорилгоор дотоод санал, санаачилгыг хүлээн авах тогтолцоог амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү платформоор дамжуулан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ болон дотоод процессийг тасралтгүй сайжруулах шинэ санаачилгуудыг нээлттэй хүлээн авч, шуурхай шийдвэрлэсээр байна.

Мөн ХААН Банк нь “Монгол Улсын Банкны үйлчилгээний кодекс”-т тулгуурлан банк хоорондын маргаантай гүйлгээг хамтран шийдвэрлэх зааварчилгаа боловсруулж, нэгдсэн зааварчилгааг салбарын хэмжээнд нэвтрүүлснээр гомдол шийдвэрлэх ил тод байдал, шуурхай ажиллагааг шинэ түвшинд хүргэв.

2025 онд бид “ХААН санал” платформыг хиймэл оюун ухаанд суурилсан автомат хуваарилалт, саналын давхардлыг илрүүлэх шийдэлтэй болгож автоматжуулсан нь байгууллагын дотоод харилцааг ил тод, уян хатан болгож, ажилтнуудын оролцоо болон сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чухал алхам боллоо.

## “Харилцагчийн туршлага 2025 конференс”

ХААН Банк нь харилцагчийн туршлага (CX)-аар салбартаа манлайлагчийн хувьд шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх, салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “CX Conference 2025” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд харилцагчийн туршлагад стратегийн түвшинд анхаарах нь байгууллагын гүйцэтгэл, өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөө, мөн лавлах төвийн үйл ажиллагаа, процессийг

дэвшилтэт технологийн шийдлүүдээр хэрхэн оновчилж, үр ашгийг нэмэгдүүлж буй туршлагын талаар мэргэжилтнүүдийн илтгэл, хэлэлцүүлгүүд өрнөв. Арга хэмжээнд Монголын болон Япон улсын харилцагчийн туршлагаараа тэргүүлэгч экспертүүд оролцож, бодит кейс, шилдэг туршлагаа хуваалцсан нь салбарын хэмжээнд мэдлэг солилцоо, хамтын хөгжлийг дэмжсэн өндөр ач холбогдолтой арга хэмжээ болж өндөрлөсөн юм.

## Service Excellence II хөтөлбөр

Харилцагчийн үйлчилгээг ахисан түвшинд хүргэх, үйлчилгээний ялгарлыг бий болгох, мөн харилцагчийн туршлагыг үргэлж эерэг байлгах зорилгоор ХААН Банк "Axiom Inc" байгууллагатай хамтран дотоодын сургагч багш нарыг 2024 оноос бэлтгэж, тооцооны төвийн ажилтнуудыг хамруулж ирсэн. Тайлант онд "Service Excellence II" ахисан шатны харилцааны стандартын сургалтыг интерактив хэлбэрээр (66 академик цагийн сургалт) Орон нутгийн иргэдийн банкны

1,998, Улаанбаатарын иргэдийн банкны 168, Төв банкны харилцагчтай биечлэн болон зайнаас харилцдаг 43 ажилтанд тус тус амжилттай зохион байгуулаад байна.

Харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр ХААН Банкны салбарын үйлчилгээний ажилтанд өгсөн харилцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ өнгөрсөн оноос 4.81 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

## Харилцагчийн сэтгэл ханамжийн судалгаа

ХААН Банк нь биечлэн болон цахим сувгаар үйлчлүүлж буй харилцагчдын санал, дуу хоолойг бүх сувгаар тогтмол хүлээн авч, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулан ажилладаг. 2025 онд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлтийн явцад харилцагчдыг урьдчилсан тестийн шатанд идэвхтэй оролцуулж,

тэдний санал, туршлагыг шууд шийдэлд тусган UX/UI болон бүтээгдэхүүний чанарыг оновчтой болгосон. Үүний үр дүнд Net Promoter Score (NPS) өнгөрсөн оноос +6 пунктээр өсөж, харилцагчийн туршлагыг сайжруулах банкны стратегийн чиглэлд амжилттай хэрэгжиж байна.



# ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант онд ХААН Банк нь дунд хугацааны стратегидээ тодорхойлсон “Харилцагчийн туршлага”, “Бизнесийн тогтвортой өсөлт ба эрсдэлийн удирдлага”, “Цахим шилжилт” гэсэн үндсэн зорилтуудын хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээний инновац, технологийн шинэчлэлийг цогцоор нь хэрэгжүүллээ. Энэхүү зорилгын хүрээнд бид бүтээгдэхүүн хөгжүүлэлт, системийн архитектур, хиймэл оюунд суурилсан дэвшилтэт шийдлүүдийг уялдаа холбоотойгоор нэвтрүүлж,


банкны үндсэн үйл ажиллагааны үр ашиг, харилцагчийн хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулаад байна. Түүнчлэн “Visa International” байгууллагын 2025 оны хоёрдугаар хагасын тайланд ХААН Банкнаас гаргасан “Visa” картууд Монгол Улсын бусад карт гаргагч банкуудаас олон улсын амжилттай гүйлгээний үзүүлэлтээр тэргүүлсэн нь картын бизнесийн гүйцэтгэл, олон улсын зах зээл дэх өрсөлдөх чадвар, үйлчилгээний чанарыг илтгэн харуулж байна.


## Картын бүтээгдэхүүн

2025 онд шинээр нэвтрүүлсэн картын бүтээгдэхүүнүүд нь тус бүр өөрийн гэсэн ялгарах онцлог, үнэ цэн бүхий шийдлүүдийг агуулж, харилцагчдын хэрэгцээ шаардлага, амьдралын хэв маягт нийцсэн олон давуу боломжийг бүрдүүлснээрээ онцлогтой юм.

2025 оны 1-р сард Гламур кредит картыг анхилам цэцгийн үнэр, шинэлэг дизайн, зээлжих эрхийн сонголт, жилийн хураамжийн ялгаатай байдлыг


тогтоож, харилцагчийн хүртээмжийг нэмэгдүүлэн зах зээлд нэвтрүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд энгийн болон премиум 2 төрлийн Гламур кредит картыг харилцагчид санал болгож байна. Энэхүү картаа Digi Pay апп-д холбон И-мартаас худалдан авалт хийхэд байнгын 10 хувийн буцаан олголттой. Гламур премиум карттай харилцагч “Мандал даатгал” ХК-ийн 3 сая төгрөг хүртэл нөхөн төлбөртэй дотоодын гэнэтийн ослын даатгалд хамрагддаг онцлогтой.





Монгол Улсаас гадаад улсад аялах иргэдийн тоо 2022 - 2024 оны хооронд 3 дахин нэмэгдсэнтэй холбоотойгоор харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцүүлсэн "Young Premium" аяллын кредит картыг 2025 оны 4-р сард нэвтрүүлсэн. Тус кредит картын зээлжих эрхийн хэмжээ онлайн кредит картын стандарт зээлжих эрхээс 2 дахин өндөр бөгөөд олон улсын нисэх онгоцны буудлын лоунжаар үйлчлүүлэх Приорити пасс карттай, Блюскай миль оноо, Блюскай лоунжаар хөнгөлөлттэй үйлчлүүлэх эрх, гадаад гүйлгээний шимтгэлгүй, гадаадад АТМ-аас бэлэн зарлага хийхэд шимтгэлгүй зэрэг давуу талтай юм.

Аяллын кредит карттай харилцагч нь "Мандал даатгал" ХК-ийн 20 мянган ам.доллар хүртэл нөхөн төлбөртэй гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгалд хамрагддаг.



Картын пластик, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэж, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор харилцагч интернэт банк, аппликэйшнээр захиалах боломжтой Виртуал кредит картын шинэ бүтээгдэхүүнийг 2025 оны 11-р сард нэвтрүүлээд байна.

## Тогтвортой санхүүжилтийн бүтээгдэхүүн




Тогтвортой хөгжлийн стратегитай уялдсан 93 хувийн дахин боловсруулсан пластикаар бүх төрлийн энгийн дебит болон бизнес дебит картуудыг шинэчлэн 2025 оны 9-11-р саруудад зах зээлд нэвтрүүлээд байна.

Хувиараа бизнес эрхлэгч иргэд болон байгууллагын харилцагчдад зориулсан үг

бүтээгдэхүүн нь БНСУ-тай худалдаа, наймаа эрхэлдэг харилцагчид Visa-гийн GTPP системээр дамжуулан бараа, үйлчилгээний төлбөрөө БНСУ руу хурдан, хялбар, найдвартай гүйцэтгэх боломжийг бүрдүүлж, хил дамнасан төлбөр тооцооны үр ашгийг нэмэгдүүлээ.

## Үйлчилгээ нэвтрүүлэлт



Харилцагчийн картын мэдээлэлд үндэслэн худалдан авалтын төлбөрийн баримтыг автоматаар үүсгэж, И-баримт системд бүртгэх процессийг бүрэн автоматжуулсан “И-баримт хялбар бүртгэл” үйлчилгээг ЦХИХХЯ-тай хамтран 10-р сард зах зээлд нэвтрүүлснээр харилцагчдын цаг хугацаа, үйл ажиллагааны зардлыг хэмнэж, картын хэрэглээний үнэ цэнийг нэмэгдүүлээ.



Тайлант оны 3-р сард хүүхдэд зориулсан Teen картын багц харилцах данс нээх болон хугацаа сунгах үйлчилгээг онлайн болгосноор Teen картын захиалга 100 хувь цахим суваг руу шилжлээ. Нийт борлуулсан картын 70 хувь нь цахимаар захиалагдсан нь картын борлуулалтын үр ашиг, харилцагчийн хүртээмжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байна.

## Картаар үйлчлэгч байгууллагын үйлчилгээ

ХААН Банкны харилцагч болон бизнес эрхлэгчдэд зориулан картаар төлбөр тооцоо гүйцэтгэх дэд бүтцийг бүрдүүлэх, бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор ПОС төхөөрөмжийг санал болгон ажилладаг. 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар картаар үйлчлэгч 84 мянган байгууллагатай хамтран ажиллаж, 87.9 мянган ПОС зах зээлд байршуулж Alipay+ үйлчилгээний 1067 мерчанттай болоод байна. Эдгээр ПОС төхөөрөмж дээр дотоодын болон олон улсын туузан, EMV чиптэй болон контактлес бүх төрлийн картыг хүлээн авахаас гадна ХААН Банкны Digi Pay цахим хэтэвч, PASS цахим хэтэвч, Google Pay, Apple Pay-ээр хийсэн төлбөр тооцоог хүлээн авч гүйцэтгэдэг.

Түүнчлэн онлайн худалдаа эрчимтэй нэмэгдэж буй энэ үед дотоодын банкуудын гаргасан бүх төрлийн карт болон гадаадын банкны гаргасан Виза картыг И-коммерс буюу цахим худалдаанд хүлээн авах үйлчилгээг мөн санал болгон ажиллаж байна. 2025 оны 6-р сард харилцагчтай байгуулж буй КҮБ-ын онлайн гэрээнд сайжруулалт хийж, харилцагчийн хүсэлтийг 100% онлайнгаар шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг нэвтрүүлсэн. Шинэ хувилбар нэвтэрснээр хүсэлт шийдвэрлэлт автоматжиж харилцагчид хурдан шуурхай үйлчлэх боломж нэмэгдээд байна. Тайлант хугацаанд Digi Pay үйлчилгээнд хамрагдах мерчантын тоог нэмж өргөжүүлснээр дижитал сувгийн зах зээлийн хамрах хүрээг тэлэх ажил бүрэн хэрэгжлээ.

## IBAN нэвтрүүлэлт

**ХААН БАНК**

# IBAN ДАНСНЫ ДУГААРЛАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Улсын код<sup>1</sup>    Хяналтын орон<sup>2</sup>    Банкны дугаар<sup>3</sup>    Дансны дугаар<sup>4</sup>

**MN**    **12**    **0005**    **00XXXXXXXXXX**

1. Монгол Улсын хувьд **MN**
2. Тухайн данс зөв эсэхийг шалгах орон тул данс бүрийн хувьд ялгаатай байна.
3. Банк бүр өөр дугаартай ба ХААН Банкны хувьд **0005** байна.
4. Дугаарлалт нь 12 оронтой байх шаардлагатай тул ХААН Банкны 10 оронтой дансны дугаарын өмнө **00** нэмэн **12 орон** болгон дүүргэсэн утга.

Монголбанкнаас хэрэгжүүлж буй Үндэсний төлбөрийн системийн шинэчлэлтийн хүрээнд зохицуулагч байгууллагын шаардлагыг бүрэн хангаж, "IBAN" дансны дугаарлалтын стандартыг банк дотор болон банк хоорондын гүйлгээнд амжилттай нэвтрүүллээ. "IBAN" нэвтрүүлснээр банк хоорондын гүйлгээний хурд сайжирч, гүйлгээний саатал, буцаалтын тоо эрс буурсан. Мөн "IBAN лавлах цэс"-ийг нэвтрүүлснээр харилцагчид төлбөр тооцоогоо саадгүй гүйцэтгэх боломжтой болж, санхүүгийн үйлчилгээг харилцагчдад илүү ээлтэй, ойлгомжтой хэлбэрт шилжүүлсэн. Үүнтэй зэрэгцэн утасны дугаар, и-мэйл хаягаар гүйлгээ хийх хялбар шийдлийг сайжруулж нэвтрүүлсэн нь дижитал үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

IBAN нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн дансны дугаарлалтын стандарт бөгөөд үүнийг банк дотор болон банк хоорондын гүйлгээнд нутагшуулснаар төлбөрийн мэдээллийн ил тод, найдвартай байдал, алдаагүй гүйлгээний шинэ соёл бүрэлдэн тогтлоо. Өнөөдрийн байдлаар 5.5 сая данс IBAN дугаарлалтад бүрэн шилжсэн байна.

Эдгээр шинэчлэл, сайжруулалтууд нь банкны үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэхийн зэрэгцээ, харилцагч төвтэй, уян хатан, өгөгдөл суурилсан санхүүгийн байгууллага болох стратегийн зорилгыг бодит ажил болгоход чиглэж буй.

# ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН ХИЙМЭЛ ОЮУНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Банк нь тогтвортой, урт хугацааны үнэ цэнийг бий болгоход чиглэсэн дэвшилтэт технологи, өгөгдөлд суурилсан шийдлээр бизнесийн өсөлтийг дэмжих инновацийн бодлого, үйл ажиллагаагаа системтэйгээр хөгжүүлж ирсэн. 2025 онд энэхүү бодлогыг банкны дунд хугацааны стратеги төлөвлөлттэй уялдуулан шинэчилж, инновацийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй, хэмжигдэхүйц болгоход чиглэсэн цогц ажлуудыг хэрэгжүүлээ. Инновацийн процесс моделийг банкны төсөл хэрэгжүүлэх аргачлалд нийцүүлэн загварчилж, үе шат бүрийн зорилго, гүйцэтгэх үйл ажиллагаа, гарах үр дүн, хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлсон нь инновацийг зөвхөн технологийн туршилт бус, бизнесийн бодит үнэ цэнийг бий болгодог тогтолцоо болгон төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн олон улсын шилдэг туршлагад тулгуурлан IDCX болон COBIT аудитын зөвлөмжийг хэрэгжүүлснээр санаачилгуудыг стратегийн зорилт, бизнесийн үнэ цэн, эрсдэлийн удирдлага, засаглалтай уялдуулах нөхцөл бүрдэж, инновацийн үйл ажиллагааны тогтвортой байдал сайжирсан нь аливаа өөрчлөлтөд дасан зохицох хурдыг нэмэгдүүлэв.

Уг бодлогыг банкны дунд хугацааны стратеги төлөвлөлттэй уялдуулан “Business AI Assistant” төслийг амжилттай нэвтрүүлж, хиймэл оюун ухаан болон машин сургалтын загваруудыг нэгтгэсэн цогц системийг хөгжүүлэв. Энэ систем нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн тулгуур салбар болох хөдөө аж ахуй (газар тариалан, сүү, мах, ноолуур), худалдаа, үйлчилгээ, барилгын салбарын мэдлэгт суурилсан банкны бүх бүтээгдэхүүн, үйлчилгээнд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэхээс гадна Ногоон санхүүжилт болон БОНЗ-ын зарчмыг дэмжих үйл ажиллагаанд технологийн хөрөнгө оруулалт хийж, тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлээд байна.

Харилцагчийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд харилцагчийн өгөгдөл, зан төлөвт суурилсан шинжилгээ, “Digi Brain” систем зэрэг машин сургалтын загваруудыг нэгдсэн архитектурт уялдуулан хөгжүүлсэн бөгөөд энэ нь Microsegment, Customer Segmentation Model, Merchant Recommender Model, Debt-to-Credit Model болон 213 шүүлтүүрийг ашиглан харилцагч бүрд тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг автоматаар санал болгох боломжийг бүрдүүллээ. Ингэснээр кампанит ажлуудыг илүү нарийвчлалтай төлөвлөх, харилцагчид өөрт тохирсон бүтээгдэхүүнээ тохиромжтой сувгаар, зөв цагт санал болгох нөхцөл бүрдэж, үр ашиг сайжирсан байна.

Business AI туслахыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр нийт 20,426 асуултад хариулт өгч, 7,998 харилцан яриа үүсгэж, 716 танилцуулга автоматаар бэлтгэж, бизнесийн менежментийн оношилгооны 30 тайлан гаргасан бөгөөд ажилтнуудын ажлын бүтээмж нэмэгдэж, мэдээлэл хайх хугацаа 85%-иар (15-30 минутаас 1-5 минут), танилцуулга бэлтгэх хугацаа 90%-иар (2-8 цагаас 5-30 минут) буурсан нь ажлын үр ашгийг эрс нэмэгдүүллээ. Мөн зээлийн бүтээгдэхүүн санал болгосон харилцагчдын зээл олголт 1.78 их наяд төгрөг буюу банкны нийт цахим зээл олголтын 23.45%-ийг бүрдүүлсэн нь системийн үр нөлөөг тодорхой харуулж байна. Ингэснээр хиймэл оюун ухаан, машин сургалтын загварууд нь харилцагчид тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг алдалгүй санал болгох, ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх, банкны бизнесийн үр ашиг, тогтвортой өсөлтийг дэмжих чухал суурийг тавьсан юм.

# БИЗНЕСИЙН ӨСӨЛТ

ХААН Банк 2025 онд дижитал шилжилт, сегментчилсэн бүтээгдэхүүний хөгжүүлэлт, зорилтот санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлснээр бизнесийн тогтвортой өсөлтийг хангаж, зээлийн багц болон активын хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүллээ. Харилцагчийн туршлагыг сайжруулж, үйлчилгээг бүрэн цахимжуулсны үр дүнд нийт гүйлгээний 99.6% нь онлайнар хийгдэж, хэрэглээний зээлийн 88%-ийг цахимаар олгосон нь борлуулалт, хүртээмжийг эрс нэмэгдүүлэв. Микросегментэд суурилсан Digi Brain системээр 11.7 сая санал хүргэж, 712 мянга гаруй харилцагчийг бүтээгдэхүүнд амжилттай холбосон нь өгөгдөлд суурилсан борлуулалтын үр ашгийг баталгаажууллаа.

Бизнесийн зээлийн багц 7,655 тэрбум төгрөгт хүрч 25%-иар өссөн бол Засгийн газрын хөтөлбөрийн зээл 48%-иар нэмэгдэв. Хэрэглээний зээлийн багц 6,670 тэрбум төгрөгт хүрч, үүнээс онлайн зээл 4,329 тэрбум төгрөг буюу нийт багцын 31%-ийг бүрдүүлж, дижитал суваг өсөлтийн гол хөшүүрэг болов.

Жижиг дунд бизнес, эмэгтэй бизнес эрхлэгчид, ногоон болон ХАА-н кластеруудад чиглэсэн тусгай бүтээгдэхүүнүүд болон 200 сая төгрөг хүртэлх бизнесийн зээлийг цахимаар авах шийдэл нэвтрүүлсэн нь зах зээлийн хамрах хүрээг тэллээ.

Khan Business аппликэйшн болон "Business AI" туслахыг нэвтрүүлснээр ЖДБ-ийн чадавхжуулалт, зөвлөх үйлчилгээ, харилцааны менежментийг автоматжуулж, 800 гаруй танилцуулга, 23,000+ асуулт, хариултыг системээр боловсруулан үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэв. Үүний зэрэгцээ банк дотоод процесс автоматжуулалтаар 170,765 цагийн гар ажиллагааг хэмнэж, бүтээмжийг өсгөсөн нь өртгийн бүтэц сайжрахад чухал нөлөө үзүүлээд байна. Эх үүсвэрийн хүрээнд 522.5 сая ам.долларын санхүүжилт татан төвлөрүүлж, ногоон болон жендэрт ээлтэй санхүүжилтийг тэлсэн бөгөөд Монгол Улсын анхны Жендэр бондыг амжилттай гаргасан нь тогтвортой өсөлтийн санхүүгийн суурийг бэхжүүлж, банкны нийт актив 23,942 тэрбум төгрөгт хүрч 17.9%-иар өсөж, активын өгөөж 3.3%-д хадгалагдахад хувь нэмрээ орууллаа.



## Хувийн банкны үйлчилгээ

ХААН Банк нь санхүүгийн цогц хүртээмжтэй үйлчилгээг харилцагчдадаа санал болгон

ажилладаг бөгөөд дараах дэд бүлгүүдэд үйл ажиллагаагаа явуулж байна.

## ХААН приорити

Бид “ХААН приорити” банкны үйлчилгээгээр дамжуулан харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцсэн санхүүгийн цогц бүтээгдэхүүн, үйлчилгээг үр чадвартай мэргэшсэн ажилтнуудаараа дамжуулан өндөр түвшинд, түргэн шуурхай, найдвартай хүргэн ажиллаж байна.

Тайлант жилд харилцагчдад хүрч үйлчлэх хувийн банкны биет салбарыг хотын шинэ суурьшлын хэсэгт шинээр нээж, салбарын тоог нэмэгдүүлж харилцагчийн үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарч ажиллалаа.

Мөн бид жил бүр уламжлал болгон приорити карт эзэмшигчдэдээ зориулсан хөнгөлөлт урамшууллын аяныг тогтмол зохион байгуулдаг. 2025 онд нийт 12 удаагийн томоохон аян, хөтөлбөрийг хэрэгжүүлж, 50 хүртэлх хувийн бодит хөнгөлөлтийг газар дээр нь эдлэх боломжийг харилцагчдадаа бүрдүүлсэн. Үүнээс гадна бүтэн жилийн туршид Улаанбаатар хот болон орон нутгийн худалдаа, үйлчилгээний байгууллагууд, БНСУ-ын эмнэлгүүдийг хамарсан

нийт 140 гаруй гэрээт байгууллагад 35 хүртэлх хувийн хөнгөлөлттэй үйлчлүүлж, лоялти урамшуулалд тогтмол хамрагдах боломжийг санал болгов.

Бид харилцагчдынхаа хүсэл сонирхолд нийцүүлэн, приорити харилцагчдад зориулсан арга хэмжээний нэр төрлийг нэмэгдүүлэн өргөжүүлээд байна. Шинэ шинэлэг арга хэмжээний төрлүүдээс дурдвал харилцагчдын хүүхдийн боловсролд зориулсан арга хэмжээ, харилцагчийн эрүүл мэнд тэр дундаа нүдний чиглэлээр БНСУ-ын мэргэшсэн эмч нарын бүрэлдэхүүнтэй үзлэг, зөвлөмж мэдээлэл өгөх өдөрлөг болон өв залгамжлалтай холбоотой хуулийн мэдлэг мэдээлэл олгох арга хэмжээнүүдийг зохион байгуулсан нь онцлох үйл явдал байв. “ХААН приорити” үйлчилгээний хүрээнд харилцагч бүрийн санхүүгийн зорилго, амьдралын үе шат бүрд нийцсэн шийдэл, үнэ цэнийг бий болгож, харилцагчтайгаа хамт өсөж хөгжих зарчмыг баримтлан үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулсаар байна.



## ХААН сигначер

ХААН Банк амжилт өөд тэмүүлэгч, салбартаа тэргүүлэгч манлайлагч залууст зориулан “ХААН сигначер” үйлчилгээг 2017 онд амжилттай нэвтрүүлэн 8 дахь жилдээ харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон ажиллаж байна. ХААН Банк зөвхөн санхүүгийн үйлчилгээ үзүүлээд зогсохгүй, харилцагчдынхаа бизнест бүх талаар дэмжлэг үзүүлж, бодит хувь нэмэр оруулахыг зорьдог. ХААН сигначер бол үргэлж сайн сайхан руу тэмүүлж, шинийг эрэлхийлдэг, бүтээмж өндөр манлайлагч залуусын хэрэгцээ шаардлагад нийцсэн шуурхай үйлчилгээ төдийгүй хүсэл зорилгынх нь “нэрийн хуудас” билээ. Карт, хөнгөлөлт урамшуулал бүхий ХААН сигначер үйлчилгээг сонгосноор харилцагчдад дараах давуу талуудыг олгодог. Үүнд:

- Сигначер цалингийн зээл
- Сигначер орон сууцны зээл
- Сигначер амины орон сууц худалдан авах болон барихад зориулсан зээлийн бүтээгдэхүүнээр санхүүгийн хэрэгцээгээ шийдэх боломжтой.

Түүнчлэн зөвхөн сигначер харилцагчдад санал болгодог Сигначер дебит болон кредит картаар дотоодын худалдаа үйлчилгээний 80 гаруй байгууллагаар үйлчлүүлэхдээ хөнгөлөлт урамшуулалд хамрагдах давуу талтай. Мөн банкнаас зохион байгуулж буй боловсрол, спорт, соёл урлагийн олон төрлийн арга хэмжээ, сургалт семинарт уригдан оролцож, нийгэмд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхийн зэрэгцээ банкнаас хэрэгжүүлж буй сайн үйлсийн аянд нэгдэн нийгэмд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах боломжийг бүрдүүлсэн нь энэ үйлчилгээний бас нэг онцлог юм.

Түүнчлэн дэвшилтэт технологи бүхий шинэлэг загварыг хослуулсан бүх төрлийн хадгаламж, даатгалын бүтээгдэхүүн болон цаг зав хэмнэсэн цахим банкны цогц үйлчилгээг авах боломжтой.



## Байгууллагын банкны үйлчилгээ

Байгууллагын банк нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн хэрэгцээг цогцоор нь хангаж, уул уурхай, худалдаа үйлчилгээ, барилга бүтээн байгуулалт, боловсруулах үйлдвэрлэл, эрчим хүч зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбаруудад найдвартай, урт хугацааны санхүүгийн түнш байсаар ирлээ. Тайлант онд тогтвортой хөгжлийн бодлого, зорилтын хүрээнд ногоон санхүүжилтийг эрчимжүүлж, нийт 247.9 тэрбум төгрөгийн ногоон зээлийг шинээр олгосон бөгөөд үүний 184.6 тэрбум төгрөгийг эрчим хүчний хэмнэлтэй ногоон барилгын төслүүдийг санхүүжүүллээ. Энэ нь байгаль орчинд ээлтэй, урт хугацаанд эдийн засгийн үр өгөөжтэй бүтээн байгуулалтыг дэмжсэн бодит хөрөнгө оруулалт боллоо.

Мөн Монгол Улсын эрчим хүчний салбарт тулгамдаж буй сорилтыг даван туулахад дэмжлэг үзүүлж, 150 тэрбум төгрөгийн санхүүжилт олгон, эрчим хүчний найдвартай байдал, үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг бэхжүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан юм. Харилцагч байгууллагуудын бэлтгэн нийлүүлэгчдэд зориулсан факторингийн үйлчилгээг идэвхжүүлснээр богино хугацаанд, уян хатан нөхцөлөөр санхүүжилт авах боломжийг бүрдүүлж, нийлүүлэлтийн сүлжээний тасралтгүй ажиллагаа, бизнесийн харилцааг дэмжсэн санхүүгийн гүүр болж ажиллав. Зээлийн багцыг салбаруудын хувьд тэнцвэртэй бүтэцтэйгээр бүрдүүлж, төвлөрлийн эрсдэлийг бууруулан, ашигт ажиллагаа болон тогтвортой өсөлтийг зэрэг хангаж чадсан нь тайлант жилийн онцлох үр дүн байлаа.



## Жижиг дунд бизнесийн банкны үйлчилгээ

ХААН Банк нь санхүүгийн цогц үйлчилгээ, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнээр дамжуулан бизнес эрхлэгчдийн найдвартай түнш байж, тогтвортой бөгөөд үр шимтэй өсөлтийг хамтдаа бүтээхийг эрхэм зорилгоо болгон ажилладаг. Энэ хүрээнд бид жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагчдаа санхүүжилт олгохоос гадна зөвлөх үйлчилгээ, мэргэжлийн сургалт, мэдээллээр тасралтгүй хангаж, дараагийн шатны өсөлт, хөгжлийг дэмжин ажиллаж байна.

2025 оны байдлаар банк санхүүгийн үйлчилгээ болон дэмжих хөтөлбөрүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод 17, орон нутагт 24, нийт 41 “Бизнес төв”-өөр дамжуулан бизнес эрхлэгчдэд мэргэшсэн, шуурхай үйлчилгээг хүргэж байна. Засгийн


газрын хөгжлийн бодлого, алсын хараатай уялдуулан стратегийн ач холбогдол бүхий хөдөө аж ахуйн салбарыг тэргүүлэх чиглэл болгон, үр тариа, ноос ноолуур, мах, сүүний кластерийн оролцогчдод зориулсан тогтвортой санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүллээ. “Цагаан алт” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 209.1 тэрбум төгрөг, “Атар-4” аяны хүрээнд 106.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг жижиг, дунд бизнесүүдэд олгож, салбарын өсөлт, тогтвортой хөгжилд бодит хувь нэмэр оруулсан.

Түүнчлэн зөгийн аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй, махны экспортын чиглэлд шинэ төрлийн санхүүгийн шийдлүүдийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган, агро бизнесийн экосистемийн урт хугацааны хөгжлийг дэмжихээр ажиллаж байна.



## Ноолуурын нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээл

2025 онд ХААН Банк нь тогтвортой ноос, ноолуурын нийлүүлэлтийг дэмжих зорилгоор ногоон зээлийн санхүүжилтийг хэрэгжүүлж, ноос, ноолуур бэлтгэн нийлүүлэх процесс болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг санхүүгээр дэмжин ажиллалаа. Энэ хүрээнд дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ноолуур бэлтгэн нийлүүлдэг 24 хоршоонд нийт 10.7 тэрбум төгрөгийн зээл олгосон. Мөн ноос, ноолуурын салбарын бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 4 үйлдвэрт 2025 онд нийт 8 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний лимитийг тус тус олгож, салбарын санхүүгийн эргэлт, тогтвортой өсөлтийг дэмжсэн.



## Үр тарианы нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээл



Хөдөө аж ахуйн кластерийг дэмжих чиглэлд Үр тарианы нэмүү өртгийн сүлжээг дэмжих багц зээлүүдийг харилцагчдадаа өмнө нь санал болгож байсан. Тэгвэл цаашид одоо байгаа бүтээгдэхүүнүүдийг тухайлсан кластерийн чиглэлээр бус, бүх кластерт ашиглаж болохоор зээлийн зориулалт дээр үндэслэн бүтээгдэхүүний нэршлийг “Хөдөө аж ахуйн кластерийг дэмжих зээл” болгон 2025 оны 6-р сарын 12-ны өдрөөс өөрчилсөн. Тухайлбал, “ХАА-н кластерийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээл, ХАА-н кластерийг дэмжих хөрөнгө оруулалтын зээл, ХАА-н кластерийг дэмжих техникийн хөрөнгө оруулалтын зээл зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлээ.

## Махны нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээл

Махны салбарын бэлтгэн нийлүүлэх процесс, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн ба дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор оролцогч талуудын богино хугацааны санхүүжилтийг шийдвэрлэхэд зориулан мах боловсруулах чиглэлийн 14 бизнес эрхлэгчид 2025 онд 8.9 тэрбум төгрөгийн Факторингийн үйлчилгээний лимит олгосон байна.



## Сүүний нэмүү өртгийн сүлжээг дэмжих зээл



Сүүний эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, сүү, сүүн бүтээгдэхүүнээр дотоодын зах зээлийг хангах зорилгоор сүүний ферм, тэжээлийн үйлдвэр, сүү боловсруулах үйлдвэрүүдийн богино хугацааны санхүүжилтийг шийдвэрлэхэд зориулан сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 4 бизнес эрхлэгчид 2025 онд 1.5 тэрбум төгрөгийн факторингийн лимит олгосон.

## Факторинг үйлчилгээ


Жижиг, дунд бизнес эрхлэгч нартаа зориулж тэдний хэрэгцээ, шаардлагад нийцсэн Факторингийн үйлчилгээг 2023 онд зах зээлд анхлан нэвтрүүлсэн бөгөөд 2025 онд нийт 52 анкор, бэлтгэн нийлүүлэгч 73 байгууллагыг холбож нийт 25.5 тэрбум төгрөгийн авлагын нэхэмжлэл санхүүжүүлсэн.



## Эмэгтэй бизнес эрхлэгчдийн цахим шилжилтийг дэмжих зээл

Европын сэргээн босголт хөгжлийн банкны “Төв Азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд” хөтөлбөрийн хүрээнд ХААН Банк нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг цахимжуулахад чиглэсэн урамшуулалт санхүүжилтийг хэрэгжүүлж байна. Уг санхүүжилтийн хүрээнд эмэгтэй бизнес эрхлэгчид байгууллагын хэрэгцээндээ ERP систем, AI чатбот, компьютер, гар утас, таблет, принтер зэрэг програм хангамж, техник хангамжийн шийдлүүдийг худалдан авч амжилттай суурилуулснаар худалдан авалтын үнийн дүнгийн НӨАТ хассан 10 хүртэлх хувийг буцаан авах боломжтой бөгөөд энэ нь тус зээлийн бүтээгдэхүүний онцлог давуу тал юм.

Түүнчлэн энэхүү зээл нь ЕСБХБ-ны хөгжүүлсэн Digital Technology Selector (DTS) вэб хуудсанд бүртгэлтэй эсвэл зөвлөх багаас баталгаажуулсан програм хангамж, техник хангамжийн шийдлүүдийг санхүүжүүлэх зориулалттай. 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар уг зээлд нийт 55 эмэгтэй бизнес эрхлэгч хамрагдан, 12.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.



Тайлант онд жижиг дунд бизнесийн банкны хүрээнд технологид суурилсан инновац бүхий шийдлүүдийг бизнес эрхлэгчид болон ажилчдаа санал болгон нэвтрүүлээд байна.

## Жижиг дунд бизнесийн академи



Жижиг, дунд бизнесийн академи нь бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, менежментийн болон бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа өргөжүүлэн явуулж байна. Академи харилцагчдыг сургалт, хөтөлбөр, зөвлөх үйлчилгээнд хамруулж, бизнесээ амжилттай удирдан, дараагийн түвшинд гаргахад нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд харилцан түншлэлийг бэхжүүлэх арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг. Үйл ажиллагааны цар хүрээгээ тэлснээр академи жил бүр дунджаар 2,000-3,000 харилцагчид хүрч ажиллах болсон. 2025 онд нийт 9 төрлийн сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлж 3,900 харилцагчийг сургаж хөгжүүлсэн бол, 20 компанид санхүү, бизнес стратегийн зөвлөх үйлчилгээг амжилттай үзүүлжээ.

# ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ХАРИЛЦАА



## Төлбөрийн чадвар

Банк нь өдөр тутмын үйл ажиллагаандаа зохицуулагч байгууллага, олон улсын зээлдүүлэгч байгууллагууд болон өөрийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн хүрээнд төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтүүдийг ханган ажилладаг.

Тайлант хугацааны турш Монголбанкнаас тогтоосон төгрөгийн заавал байлгах нөөц 13%, гадаад валютын заавал байлгах нөөц 18%-ийн харьцаа үзүүлэлтийг тогтмол ханган ажиллалаа.

Мөн Монголбанкнаас тогтоосон хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийг ТУЗ-өөс тогтоосон хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн хүрээнд хамгийн багадаа 5 хувиар илүү буюу 30 хувиас дээш тогтмол хадгаллаа. Банк нь олон улсын зээлдүүлэгч байгууллагуудаас тавьсан шаардлагын дагуу Базел III стандартад заасан хөрвөх чадварын харьцаанууд болох эх үүсвэрийн тогтвортой байдлын харьцаа (NSFR) болон богино хугацааны төлбөрийн чадварыг хангах харьцаа (LCR)-г зохистой түвшнээс тогтмол дээгүүр ханган ажиллалаа.

## Мөнгөний зах зээл

Банк нь сул чөлөөт мөнгөн хөрөнгөө эрсдэл багатай хөрвөх чадвар өндөртэй, хүүгийн орлого олох активуудад байршуулах замаар хөрөнгө оруулалтын орлогоо нэмэгдүүлдэг. Гадаад болон дотоод суурь хүү өндөр түвшинд хадгалагдсан бөгөөд Төв банкны үнэт цаас, Монгол Улсын Засгийн газрын гадаад бондуудад банк хөрөнгө оруулалт хийхээс гадна төв банк болон банк санхүүгийн байгууллагуудад богино хугацаатай хадгаламж байршуулан хөрвөх чадварын удирдлагыг оновчтой хэрэгжүүллээ. Тайлант онд ХААН Банк нь дотоодын Мөнгөний зах зээлд тэргүүлэгч байр сууриа тогтвортой хадгаллаа.

## Валют болон алтны арилжаа

ХААН Банк нь дотоодын валют арилжааны зах зээлд тэргүүлэгч байр сууриа бэхжүүлж, дижитал шилжилт, банкны өргөн сүлжээ, салбар, тооцооны төвүүдээр дамжуулан харилцагчдын валют арилжааны эрэлт хэрэгцээг хурдан шуурхай, уян хатан нөхцөлөөр ханган ажиллалаа.

2025 оны эхний хагаст гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр дотоодын валютын зах зээлд эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр алдагдаж, төгрөгийн ханш ам.долларын эсрэг богино хугацаанд эрчимтэй суларсан. Гэсэн хэдий ч банкны хувьд харилцагчдын гадаад валютын эрэлт хэрэгцээг хангахын зэрэгцээ гадаад валютын позицын удирдлагыг оновчтой хэрэгжүүлэн ажиллалаа.

Тухайлбал, Монголбанкны гаргасан нийт үнэт цаасны 38.9 хувийг анхдагч зах зээлээс худалдан авсан ба хоёрдогч зах зээлийн арилжааг идэвхжүүлэн ажиллалаа. Монгол Улсын Засгийн газрын зүгээс 2017 онд зогсоогоод байсан Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)-ны арилжааг 2025 оны II улирлаас эхлүүлсэн ба дотоодын зах зээлд хуваарийн дагуу үнэт цаасны анхдагч захын арилжааг явуулж байна. ХААН Банк нь ЗГДҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаанд идэвхтэй оролцож, дотоодын эрсдэлгүй өгөөжийн муруйг тогтоох, зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллав.

Улмаар Монголбанкны нэгж валютын (15%) болон нийт валютын (30%) гадаад валютын нээлттэй позицын харьцаа үзүүлэлт тогтмол хэвийн түвшинд хадгалагдлаа. Тайлант онд банк нь валют арилжааны хэлцлийн үйлчилгээг бүрэн цахимжуулах ажлыг шат дараатайгаар амжилттай хэрэгжүүлэн ажиллав. Үүний хүрээнд валют арилжааны платформиг интернэт банкны үйлчилгээнд нэвтрүүлсэн нь дотоодын зах зээлд анхдагч бүтээгдэхүүн, үйлчилгээ болсон ба үүний үр дүнд харилцагчдын валют арилжааны хэлцлийн үйлчилгээ бүрэн цахимжлаа. Мөн Улаанбаатар хот, Дархан хот болон Баянхонгор аймагт буй алт худалдан авах цэгээр дамжуулан ААНБ болон иргэдээс биет алт худалдан авах үйл ажиллагааг тасралтгүй явууллаа.



## Урт хугацаат эх үүсвэр

ХААН Банк харилцагчдынхаа урт хугацаат санхүүжилтийн хэрэгцээг хангах, банкны тогтвортой эх үүсвэрийн төрлийг нэмэгдүүлэх, олон улсын стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагааг дэмжих хүрээнд олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд болон хөрөнгө оруулалтын сангуудтай урт хугацаат түншлэлийн харилцааг хөгжүүлэн хамтран ажилласаар ирсэн.

2025 онд нийт 530 сая ам.долларын урт хугацаат эх үүсвэрийг олон улсын зах зээлээс болон дотоодын хөрөнгийн зах зээлээс амжилттай татан төвлөрүүлсэн нь өмнөх оныхоос 60 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр эх үүсвэрүүдийг банкны тогтвортой санхүүжилтийг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөө үзүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг тусгайлан дэмжин, санхүүжүүлэх зорилгоор голчлон татан төвлөрүүлсэн байна.

Нийт татан төвлөрүүлсэн урт хугацаат эх үүсвэрүүдийн 25 орчим хувь нь байгаль орчинд ээлтэй, ногоон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зориулалттай ногоон санхүүжилт, 23 хувь нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжихэд

чиглэсэн хөрөнгө оруулалтууд байгаа бол 52 орчим хувийг бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчид, тэр дундаа залуу бизнес эрхлэгчид, хөдөө аж ахуй салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч харилцагчдынхаа санхүүжилтийг тусгайлан дэмжихэд зориулж байгаа юм. Нийт шинээр татсан эх үүсвэрийн 90 сая ам доллар нь тогтвортой хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа, аж ахуйн нэгжүүдийг тусгайлан дэмжих зориулалттай бөгөөд ХААН Банкны хувьд хөдөө орон нутгийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Монгол Улсын хөдөө аж ахуй болон мал аж ахуйн үнэ цэнийн сүлжээг бэхжүүлэх тусгай зориулалттай хөрөнгө оруулалтыг анх удаа олон улсын зах зээлээс төвлөрүүлж байгаа нь энэ оны онцлох санхүүжилт болж байна.

2025 оны эцсийн байдлаар ХААН Банк нь олон улсын банк, санхүүгийн 20 гаруй байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компани болон тэдгээрийн удирддаг хөрөнгө оруулалтын 40 орчим сантай хамтран ажиллаж, 2-7 жилийн хугацаатай, нийт 1.2 тэрбум ам.долларын урт хугацаат санхүүжилтийн үлдэгдэлтэй байна.

## Худалдааны санхүүжилтийн үйлчилгээ

ХААН Банк нь гадаад худалдаа эрхлэгч харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн, холбогдох худалдааны эрсдэлээ удирдахад нь дэмжлэг болох худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг цогц хэлбэрээр санал болгон ажиллаж байна. Олон улсын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гаргадаг UCP, URDG, ISP, Incoterms зэрэг нийтлэг дүрмийг баримтлан нээгддэг аккредитив, банкны баталгаа, батлан даалтын аккредитив зэрэг төлбөрийн хэрэгслүүдийг ашиглан импорт, экспортын эргэлтээ нэмэгдүүлэх мөн хамгийн өртөг багатай санхүүжилтээр санхүүгийн хэрэгцээгээ шийдэх боломжуудыг харилцагч нартаа бий болгон ажилладаг.

ХААН Банк нь Азийн хөгжлийн банк (АХБ), Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ), Олон улсын санхүүгийн корпорацын (ОУСК) “Худалдааны санхүүжилтийг дэмжих хөтөлбөр”-ийн идэвхтэй гишүүн банк бөгөөд эдгээр хөтөлбөрийн хүрээнд олон улсад нэр хүнд бүхий 800 гаруй шилдэг банктэй худалдааны санхүүжилтийн чиглэлээр хамтран ажиллаж, ЕСБХБ-наас “Монгол Улсын хамгийн идэвхтэй аккредитив нээгч банк” шагналыг 15 дахь удаагаа, АХБ-наас “Монгол дахь шилдэг хамтрагч банк” шагналыг 7 дахь удаагаа тус тус хүртэж, амжилтаа бататгалаа.

2023 оноос ХААН Банк нь ЕСБХБ-тай хамтран ам.долларын худалдааны зээлийн эх үүсвэрийг

багц санхүүжилт хэлбэрээр татан харилцагч нартаа хямд эх үүсвэртэй зээл олгож байсан бол 2025 онд ЕСБХБ-тай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн худалдааны зээлийн эх үүсвэрийг төгрөгөөр татах гэрээг амжилттай байгууллаа. Уг гэрээний хүрээнд 2025 оны туршид 24.5 тэрбум төгрөгийн болон 22.3 сая ам.долларын худалдааны зээлийн эх үүсвэрийг багцаар татан гадаад худалдаа эрхлэгч харилцагч нарынхаа санхүүжилтийн хэрэгцээг хямд эх үүсвэрээр хангаж ажиллалаа.

Түүнчлэн тайлант онд Азийн хөгжлийн банктэй хамтран ам.долларын худалдааны зээлийн эх үүсвэрийг багцаар татах боломжийг бий болгосноос гадна ногоон худалдааны зээлд зориулсан хямд эх үүсвэртэй зээлийн бүтээгдэхүүн шинээр бий болголоо. 2025 оны туршид АХБ-наас нийт 16.6 сая ам.долларын эх үүсвэрийг багцаар амжилттай татан гадаад худалдаа эрхлэгч харилцагчдаа дэмжин ажилласан байна.

ХААН Банкны худалдааны санхүүжилтийн нийт эргэлт жил бүр тогтмол өсөж тайлант оны жилийн эцсийн байдлаар 288.2 сая ам.доллар буюу 1.03 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь өмнөх оны үеэс 56% өссөн үзүүлэлт юм. Нийт эргэлтийн 97%-ийг харилцагч нарт олгосон худалдааны зээл, үлдсэн хувийг худалдаа санхүүжилтийн төлбөрийн хэрэгслүүд эзэлж байна.



## Корреспондент банкуудын харилцаа, гадаад төлбөр тооцоо

ХААН Банк нь олон улсад нэр хүнд бүхий 200 гаруй банк санхүүгийн байгууллагатай олон чиглэлээр хамтран ажилладаг бөгөөд корреспондент банкны харилцаатай 13 улсын 28 банкна дахь 12 төрлийн валютаарх 44 гадаад ностро дансаараа дамжуулан харилцагчдынхаа гадаад төлбөр тооцоог найдвартай, хурдан шуурхай гүйцэтгэж байна.

2025 оны эцсийн байдлаар ХААН Банкны SWIFT сүлжээгээр хүлээн авсан гадаад гүйлгээний нийт дүн 3.2 тэрбум ам.доллар, илгээсэн гадаад гүйлгээний нийт дүн 2.7 тэрбум ам.долларт тус тус хүрч зах зээлд II байр эзэлсэн байна. Нийт гүйвуулгыг улс орноор нь ангилан үзвэл нийт илгээсэн болон хүлээн авсан гүйлгээний тоогоор БНХАУ (34%) тэргүүлж байгаа бол Япон (22%), Өмнөд Солонгос (21%), АНУ (16%) тус тус удаах байрыг эзэлсэн байна.

ХААН Банк нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын дүрэм, журам болон Монголын Улсын хууль, дотоод бодлого, журмын хэрэгжилтийг ханган ажилладгаас гадна 2025 онд харилцагч нартаа уг хууль, дүрмийн ойлголтыг өгөх олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж ажиллалаа.

АНУ-ын нэр хүнд бүхий The Bank of New York банканд ам. долларын ностро данстай болсноор ХААН Банкны хоёр сая гаруй харилцагчид дэлхийн өнцөг булан бүрд гадаад гүйлгээг хямд зардлаар түргэн шуурхай хийх боломж бүрдэж, 2025 онд уг банктай хамтын ажиллагааг улам өргөжүүлэн, харилцааг өндөр түвшинд амжилттай хадгалан ажиллалаа.

# САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Санхүүгийн үр дүн

НИЙТ АКТИВ

**23.9** их наяд  
төгрөг

+17.9% ▲

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт актив 23.9 их наяд төгрөгт хүрч, 2024 оны эцэстэй харьцуулахад 17.9 хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд энэ нь нийт банкны системийн хэмжээнд тэргүүлж, 28.0 хувийг эзэлж байна.

Активын өгөөж 3.3 хувьд, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 42.5 хувьд хүрсэн бөгөөд зохистой харьцаа 25 хувиас дээш байх шалгуурыг бүрэн хангаж ажиллалаа.

НИЙТ ЗЭЭЛ

**14.4** их наяд  
төгрөг

+20.5% ▲

Өмнөх оны эцэстэй харьцуулахад 2025 оны 12-р сарын байдлаар нийт зээл 2,441.8 тэрбум төгрөг буюу 20.5 хувиар өсөж, 14.4 их наяд төгрөгт хүрлээ.

2025 онд хоёр үе шат бүхий бизнесийн зээлийн өсөлтийн аян зарлаж, бизнесийн зээлийн багцаа нэмэгдүүлсэн, мөн онлайн зээлийн өсөлт өндөр байгаа нь нийт зээлийн багцын өсөлтийг дэмжлээ.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН  
ХӨРӨНГӨ

**20.9** их наяд  
төгрөг

+18.4% ▲

ХААН Банкны нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 18.4 хувь буюу 3.2 их наяд төгрөгөөр өсөж, 20.9 их наяд төгрөгт хүрлээ. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 76 хувийг харилцагчаас татсан эх үүсвэр, 24 хувийг банк, санхүүгийн байгууллагаас татсан зээллэг болон бусад эх үүсвэр бүрдүүлж байна.

2025 онд нийт 172.9 сая ам.доллар олон улсын санхүүгийн байгууллагаас авсан зээллэгийг хуваарийн дагуу төлж, шинээр нийт 529.9 сая ам.долларын бага хүүтэй, урт хугацаатай зээллэгүүдийг амжилттай татан эх үүсвэрээ нэмэгдүүллээ.

## НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

# 2.8

их наяд төгрөг

+14.6% ▲

Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны эцсээс 14.6 хувь буюу 360.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Тайлант жилд нийт 694.8 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. ХААН Банк хувьцаа эзэмшигчдэдээ 2024 оны хуримтлагдсан ашгаас 373.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгов.

2025 оны 12-р сарын байдлаар 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 17.5 хувьд хүрч Монголбанкны 13 хувиас дээш байх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллалаа.

## АШИГТ АЖИЛЛАГАА

# 694.8

тэрбум төгрөг

+8.8% ▲

2025 онд ХААН Банк 694.8 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. Үүнээс хүүгийн цэвэр орлого 1,381.7 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 122.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүллээ. Мөн түүнчлэн ХААН Банк нь нийт 184 тэрбум төгрөгийн ААНОАТ-ыг улсын төсөвт бүрдүүлж хувь нэмрээ оруулаад байна.


		2022	2023	2024	2025
<b>Ашигт ажиллагаа</b>	Өөрийн хөрөнгийн өгөөж	29.4%	31.7%	28.9%	27.1%
	Активын өгөөж	3.4%	3.5%	3.4%	3.3%
	Цэвэр хүүний маржин	6.7%	6.9%	6.7%	6.6%
	Зардал орлогын харьцаа	38.1%	40.2%	40.9%	44.4%
<b>Зээлийн чанар</b>	Чанаргүй зээлийн харьцаа	5.3%	5.3%	4.3%	4.3%
	Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа	135.1%	127.9%	142.3%	135.8%
<b>Монголбанкны шалгуур</b>	Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (>12%)	16.7%	18.6%	17.8%	17.5%
	1-р зэрэглэл өөрийн хөрөнгийн харьцаа (>10%)	16.7%	18.6%	17.8%	17.5%
	Хөрвөх чадварын харьцаа (>25%)	46.0%	46.5%	44.5%	42.5%
	Нэгж гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+-15%)	2.8%	-6.3%	-2.8%	-2.6%
	Нийт гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+-30%)	3.0%	-6.5%	-3.1%	-2.7%
	Хамгийн том зээлдэгчийн харьцаа (<20%)	7.8%	8.2%	13.9%	9.3%
	Хамгийн том холбоотой этгээдийн харьцаа (<5%)	3.3%	3.9%	3.8%	4.2%

## Санхүүгийн гүйцэтгэл (Аудитлагдсан санхүүгийн тайлангаар)

### Нийт актив

(тэрбум төгрөг)

13,463 14,953 17,351 20,303 **23,942**




2021 2022 2023 2024 **2025**

### Нийт зээл

(тэрбум төгрөг)

7,018 7,978 9,669 11,931 **14,373**




2021 2022 2023 2024 **2025**

### Татан төвлөрүүлсэн хөрөнгө

(тэрбум төгрөг)

12,060 13,266 15,012 17,623 **20,870**




2021 2022 2023 2024 **2025**

### Өөрийн хөрөнгө


(тэрбум төгрөг)

1,285 1,515 2,092 2,465 **2,825**



2021 2022 2023 2024 **2025**

## Зах зээл эзлэлт (Монголбанкны тайлагналаар)



# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ХААН Банк нь эрсдэлийн хүчирхэг соёл болон нэгдсэн удирдлагыг банкны үйл ажиллагааны салшгүй хэсэг гэж үздэг бөгөөд банкны бизнес загвар, стратегийн зорилтууд болон тогтвортой байдлын бодлого, чиглэлтэй уялдуулан Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлдэг. Түүнчлэн банк нь Монгол Улсын хууль, тогтоомж, зохицуулалтуудын шаардлагуудыг дагаж мөрдөхийн зэрэгцээ олон улсын шилдэг туршлага, стандартад нийцүүлэн эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулдаг.

ХААН Банк нь хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (risk appetite statement)-ийн хүрээнд банкны стратеги, зорилтуудад нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах, хянах, тайлагнах замаар эрсдэлийг үр дүнтэй удирдахыг зорьж ажилладаг. Үүнд:

- Хүлээн зөвшөөрөх эрсдэл (risk appetite)-ийн хүрээнд эрсдэл, өгөөжийн харьцааг хамгийн оновчтой байлгах;
- Банкны эрсдэлийн зохистой засаглалын бүтцийг бий болгох;
- Эрсдэлийн хүчирхэг соёлыг нийт ажилтнуудад төлөвшүүлэх;
- Банкны материаллаг гэж үзсэн эрсдэлүүдийг илрүүлэх, үр дүнтэй удирдах;
- Эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо тогтмол хугацаанд эргэн хянах, шаардлагатай өөрчлөлт сайжруулалтыг олон улсын стандарт, зөвлөмж, шилдэг туршлагад нийцүүлэн хийх;

Банк нь дунд хугацааны стратеги зорилтын хүрээнд зохистой засаглалын зарчим, банкны эрсдэлийн удирдлагын үйл явц, арга хэрэгслийг олон улсын сайн жишигт нийцүүлэх замаар өөрийн эрсдэл даах чадварыг бэхжүүлэх, санхүүгийн урт хугацааны тогтвортой болон хүртээмжтэй байдлаас

хадгалах зорилгоор Базелийн стандартын “Бүлэг 2”-ын “Өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх (ICLAAP) аргачлал”-ыг нэвтрүүлэн үе шаттай хэрэгжүүлж байна. Түүнчлэн Монголбанкнаас банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх талаар зорилтуудыг мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийн баримт бичгүүдэд тодорхойлсон нь банкны дунд хугацааны стратегийн зорилттой хавсарсан зохицуулалтын шаардлагын үндэслэл болсон.

Энэхүү аргачлалыг нэвтрүүлснээр банк нь өөрийн үйл ажиллагаанд материаллаг гэж үзсэн голлох эрсдэлүүдийг бие даан тодорхойлж, удирдах, уг эрсдэлүүдийг даахад шаардлагатай өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварыг дотооддоо үнэлж, удирдах, өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол мөрдөх, улмаар банкны салбарт тогтвортой өсөлтийг бий болгоход хувь нэмрээ оруулах зэрэг чухал ач холбогдолтой юм. Бид энэхүү эрсдэлийн тэргүүлэх зорилтын хүрээнд банкны ICLAAP бодлогыг шинээр боловсруулан 2024 онд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон ТУЗ-өөр тус тус хэлэлцүүлэн батлуулсан. Түүнчлэн, ICLAAP үйл явцыг банкны үйл ажиллагааны салшгүй хэсэг байхаар холбогдох дотоод журмын төслийг батлах, хэрэгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, шаардлагатай дэд бүтцийг бий болгох зэрэг ажлуудыг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 2025 оны байдлаар банк нь ICAAP болон ILAAP-ын тайлангуудыг 3 дахь жилдээ туршилтын байдлаар боловсруулан Монголбанканд хүргүүлэн ажиллалаа.

Банк нь 2025 онд эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийн хүрээнд дараах гол ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцооны (ERMF) төлөвшлийн түвшин болон стратегийн зураглалыг тодорхойлох үнэлгээг хөндлөнгийн аудитын байгууллага “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-иар хийлгэлээ. Тус үнэлгээг эрсдэлийн засаглал, эрсдэлийн стратеги ба хүлээн зөвшөөрөх түвшин, эрсдэлийн соёл, эрсдэлийн үнэлгээ ба хэмжилт, эрсдэлийн удирдлага ба хяналт, эрсдэлийн тайлагнал ба дүн шинжилгээ, өгөгдөл ба систем гэсэн хамрах хүрээнд хийлгэж үнэлгээний үр дүн болон 2029 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө бүхий стратегийн замын зураглалыг хүлээн авлаа.
- Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлогыг шинэчлэн боловсруулж, ХААН Банкны Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлого болгон шинэчилж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан ба тус бодлогын хавсралтаар “Эрсдэлийн ангилал зүй” болон “Байгууллагын эрсдэлийн соёлын стратеги” баримт бичгүүдийг шинээр боловсруулж батлуулсан. Мөн ХААН Банкны дотоод хяналтын бодлогод нэмэлт өөрчлөлт оруулж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд тус бодлогын сайжруулалтын хүрээнд “Өргөтгөсөн хамгаалалтын гурван шугам”-ын загварыг нэвтрүүлж, эрсдэлийн удирдлага болон хяналтын үүрэг, хариуцлагын хуваарилалтыг илүү нарийвчлан тодорхойлсон.
- Банк нь эрсдэлийг үр дүнтэй хянаж, удирдах зорилгоор 2025 онд “Internal Process, Risk Monitoring System” (IPRMS) системийг шинээр нэвтрүүлсэн бөгөөд энэхүү системээр эрсдэлийг тодорхойлж бүртгэх, үнэлэх, арга хэмжээ авах, хянах, тайлагнахтай холбоотой Эрсдэлийн

самбарын үйл явц болон эрсдэлийн хороодын шийдвэр гаргалтын үйл явцыг автоматжуулсан. Цаашид энэ систем нь эрсдэлийн тайлагналын ил тод байдлыг нэмэгдүүлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх ач холбогдолтой юм.

- ХААН Банк нь цахим шилжилт болон банкны бизнесийн загварын өөрчлөлт, стратегитай уялдуулан шинэ төрлийн эрсдэлүүд болох Технологийн эрсдэл, Уур амьсгалын нөлөөллийн эрсдэлүүдийг анхааран үзэж, байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хүрээнд үр дүнтэй удирдаж, хянах үе шаттай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд ногоон эдийн засгийг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний зорилтод хувь нэмэр оруулах бодлого, чиглэлийн дагуу банк нь 2024 онд Олон улсын санхүүгийн корпорацийн (“ОУСК”) Төслийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, уг гэрээний хүрээнд уур амьсгалын эрсдэлийн удирдлагын механизмыг бүрдүүлэх ажлыг үе шаттай эхлүүлсэн.
- Энэхүү ажлын хүрээнд банкны одоогийн уур амьсгалын стратегид шинжилгээ хийх, түүнийг олон улсын стандарттай нийцүүлэх зөвлөмжүүдийг авах, банкны зээлийн багцын уур амьсгалын биет эрсдэлийн өртөлтийг үнэлэх, санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, мөн уур амьсгалын эрсдэлийн удирдлагын үйл явцыг Банкны нэгдсэн эрсдэлийн удирдлагын үйл явцад нэгтгэх зэрэг голлох ажлууд хийгдэж дууссан. Цаашид банк нь тус ажлын үр дүнд үндэслэн уур амьсгалын шилжилтийн стратегиа тодорхойлох бөгөөд ОУСК-ийн зөвлөмж, үнэлгээний үр дүнд суурилсан арга хэмжээ, бодлого, үйл явцыг дараагийн үе шатуудад шат дараатайгаар боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

## Хүлээн зөвшөөрөх эрсдэл

Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн тогтолцоонд баримтлах зарчим, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл, мэдэгдлийн шаардлагууд болон оролцогчдын үүрэг хариуцлагыг ТУЗ-өөс баталсан бодлогын баримт бичгээр тодорхойлсон байдаг.

Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл нь Банкны нийт харилцагчид, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон ажилтнуудынхаа эрх ашгийг хамгаалах, мөн түүнчлэн бизнес төлөвлөгөө, зорилтууддаа хүрэх, оролцогч талуудын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, итгэлцэл болон хамтын ажиллагаагаа өндөр түвшинд хэвээр хадгалахын тулд банк хүлээж болох эрсдэлийн төрөл болон хэмжээг тодорхойлдог.

## Эрсдэлийн засаглал


ХААН Банк эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавих үүднээс дараах эрсдэлийн засаглалыг бүрдүүлэн ажиллаж байна. Банк эрсдэлийн засаглалыг бизнесийн цар хүрээ, стратеги төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан шинэчлэн сайжруулдаг. ТУЗ нь банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн засаглал болон эрсдэлийн соёлыг бүрдүүлэхэд ерөнхий чиг үүргээр хангадаг.

Банк нь Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийг банкны стратеги, бизнес төлөвлөгөөтэй уялдуулан шинэчилдэг бөгөөд ТУЗ-өөс хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийг жил бүр хянаж, батлан Гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлдэг. Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийг үр дүнтэй хэрэгжүүлж, хянах үүднээс гол эрсдэлүүдэд дотоод лимитийг тогтоож, Байгууллагын эрсдэлийн удирдлагын хороо (БНЭУХ) болон ТУЗ-д сар бүр тогтмол тайлагнаж, хяналт тавьж ажилладаг.

Мөн түүнчлэн Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлого, Байгууллагын эрсдэлийн соёлын стратеги, Эрсдэлийн ангилал зүй, Дотоод хяналтын бодлого болон Залилангийн хөтөлбөр, Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл зэрэг эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлого, стратегийг ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороо болон ТУЗ нь тус тус хэлэлцэн баталдаг.



## ХААН Банкны эрсдэлийн удирдлагын бүтэц



## Өргөтгөсөн хамгаалалтын гурван шугам

Банк нь уламжлалт хамгаалалтын гурван шугамын загварыг банкны бизнесийн цар хүрээ, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, нарийн төвөгтэй байдалд нийцүүлэн өргөтгөж, хамгаалалтын 1-р шугамыг 1А болон 1В болгон илүү нарийвчлан хуваасан. Ингэснээр эрсдэлийн удирдлага, хяналтын чиг үүрэг, хариуцлагыг шугам бүрт илүү тодорхой ялгаж, хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулан хэрэгжүүлэх боломж бүрдсэн.

- **Хамгаалалтын 1-р шугам (1А шугам)** нь эрсдэл хариуцагч буюу бизнесийн нэгжүүд бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлийг таньж, илрүүлж, бууруулах арга хэмжээг шууд хэрэгжүүлнэ. Энэ нь хамгаалалтын анхны түвшин бөгөөд эрсдэлийг хамгийн эхэнд илрүүлэх, хариу арга хэмжээ авах үндсэн үүрэгтэй front-line буюу үйл ажиллагааны түвшний хамгаалалтын шугам юм.
- **Хамгаалалтын 1-р шугам (1В шугам)** нь тусгай чиг үүргийн нэгжүүд бөгөөд бизнесийн нэгжүүдэд аргачлал, зөвлөмж, заавраар дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ давхар хяналтыг хэрэгжүүлнэ. Энэхүү шугам нь анхан шатны хэрэгжилт дээр нэмэлт хяналт, арга зүйн чиглэл өгөх, ерөнхий хяналт хийх back-line буюу дундын хамгаалалтын шугам юм.
- **Хамгаалалтын 2-р шугам** нь эрсдэлийн удирдлагын газар нэгжүүд бөгөөд Банкны хэмжээнд эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого, стратеги, арга аргачлалыг боловсруулан хэрэгжүүлэх, мөн хамгаалалтын 1-р шугамын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй байна.
- **Хамгаалалтын 3-р шугам** нь дотоод аудитын функцүүд бөгөөд банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхийг хараат бусаар баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд сайжруулах санал, зөвлөмж өгөх чиг үүрэгтэй байна.



## Зээлийн эрсдэлийн удирдлага

ХААН Банк нь зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаад, дотоод хүчин зүйлсийг цаг тухайд нь тодорхойлон зээлийн багцад үзүүлэх нөлөөллийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор стресс тестийн тооцооллыг гүйцэтгэн, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах оновчтой арга хэмжээнүүдийг тухай бүр хэрэгжүүлж ажилласан. Тайлант оны зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд 2025 оны макро эдийн засгийн хүндрэлтэй орчинд тогтвортой байсан нь эрсдэлийн удирдлагын арга хэмжээнүүд оновчтой байсныг илэрхийлж байна.

Зээлдэгчийн эрсдэлийг тооцоолох тоон аргачлал болон эрсдэлийн үнэлгээний загварыг олон улсын байгууллагуудтай хамтран тогтмол хөгжүүлж, зээлийн болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр системийн сайжруулалт, хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Банкны барьцаа хөрөнгийн үнэлгээний аргачлалыг эрсдэлийн удирдлагын жишиг үнэлгээгээр үнэлэх хөрөнгийн төрлүүдийг нэмэгдүүлэн илүү боловсронгуй болгосон. Барьцаа хөрөнгийн үнэлгээний дата мэдээллийн чанарыг сайжруулан, хамрах хүрээг өргөжүүлж үл хөдлөх хөрөнгө барьцаалсан онлайн бизнесийн зээлийн бүтээгдэхүүний үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

## Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Банк нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хүү, гадаад валютын ханш болон үнийн өөрчлөлт зэрэг зах зээлийн хувьсагчдын өөрчлөлтөөс шалтгаалан банкны эзэмшиж буй

санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн, ирээдүйн мөнгөн урсгалын хэлбэлзлээс хүлээж болзошгүй алдагдлыг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинд удирдаж ажиллалаа.

## Гадаад валютын ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг тэдгээрийн эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор Монголбанкнаас тогтоосон тухайн нэг болон нийт гадаад валютын нээлттэй позицын хязгаарлалуудыг хангахын зэрэгцээ хамгийн их эрсдэлийн /VAR/, мэдрэмтгий байдал, стресс тестийн шинжилгээ зэрэг аргачлалуудыг ашиглан эрсдэлээ өдөр тутам хэмжин, удирдаж ажилладаг.

Банкны гадаад валютын эрсдэлийн үнэлгээний "VaR" програм хангамж нь гадаад валютын нээлттэй позицоос хүлээх ханшийн эрсдэлийг 99 хувийн итгэх магадлалын түвшинд түүхэн эх үүсвэр, вариаци-ковариаци болон симуляцын аргачлалуудыг ашиглан тооцдог. Мөн удирдлагын мэдээллийн систем болон эрсдэлийн үнэлгээний найдвартай, үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэсэн стандарт тоон ба чанарын шаардлагуудад нийцүүлэн тогтмол хөгжүүлэлтүүдийг хийдэг.

## Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

ХААН Банк нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд Монголбанк болон олон улсын санхүүгийн байгууллагуудын зүгээс тавьсан шалгуур үзүүлэлтүүдийг ханган, нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог мөрдлөг болгон ажиллаж байна. Энэхүү тогтолцооны хүрээнд Актив пассивын удирдлагын хороо тухайн жилд мөрдөгдөх хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн хүрээнд дотоод лимитүүд, стратеги болон бодлогын баримт бичгийг баталснаар холбогдох газар нэгжүүд хамтран хяналт, удирдлагыг өдөр тутамдаа хэрэгжүүлдэг. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд мөнгөний захын хэрэгслүүдийн арилжааны лимитүүдийг 6 сар тутам шинэчлэн баталдаг.

Мөн онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, стресс тест болон мэдрэмтгий байдлын шинжилгээг тодорхой хугацааны давтамжтайгаар тайлагнадаг. Түүнчлэн онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хувилбарууд дээр төсөөллийн туршилт хийж, хэрэгжилтийг нь хэмжин, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, сайжруулалтыг тогтмол хийн ажиллаж байна.

Банк нь хөрвөх чадварын аливаа сөрөг хандлагыг тодорхойлж, нэмэгдэж буй эрсдэл ба эмзэг байдлыг бууруулахын тулд Хөрвөх чадварын эрсдэлийн эрт анхааруулах үзүүлэлтүүдийг тодорхойлон, гүйцэтгэлийг тогтмол хянаж ажилладаг.

## Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Банк үйл ажиллагааны эрсдэлийг үр дүнтэй тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах болон хянах, тайлагнах зорилгоор Эрсдэл ба хяналтын бие даасан үнэлгээ (RCSA), Эрсдэлийн түлхүүр үзүүлэлтийн аргачлал (KRI), Алдагдлын мэдээллийн сан (Loss database), Загварын эрсдэлийн аргачлал (Model risk methodology), Бизнес нөлөөллийн шинжилгээний аргачлал (BIA), Асуудлын удирдлага (Issue management) зэрэг арга хэрэгслүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилладаг.

Банкны үндсэн процессууд, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болон төсөл, өөрчлөлтийн эрсдэл, хяналтыг үр дүнтэй тодорхойлж, үнэлэх зорилгоор Эрсдэл, хяналтын бие даасан үнэлгээ (RCSA)-ний аргачлалыг хэрэгжүүлдэг ба уг үнэлгээнд үндэслэн эрсдэлийг бууруулах, зайлсхийх, шилжүүлэх болон хүлээн зөвшөөрөх гэсэн стратегиудаас хамгийн оновчтойг сонгож хариу арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Мөн түүнчлэн Банк эрсдэлийг шилжүүлэх стратегийн хүрээнд олон улсын “Банкны бүрэн хамгаалалт”-ын даатгалд даатгуулсан байдаг.

Банк нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад GRC (Governance, Risk, Compliance) системийг ашигладаг. Энэхүү системд зорилт, процесс, өөрчлөлт, эрсдэл, хяналтыг бүртгэх, үнэлэх, арга хэмжээний төлөвлөгөө үүсгэх, түүнчлэн алдагдлын мэдээллийн санг удирдах, асуудлын удирдлагыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны эрсдэлийн тайлан мэдээлэл бэлтгэх зэрэг голлох үйл явцуудыг хэрэгжүүлдэг. Банк GRC системийн “M7 SP2” хувилбарыг 2018 оноос үйл ажиллагаандаа ашиглаж байсан бөгөөд 2025 оны 1-р сарын 10-ны өдрөөс “Euphrates I Release” шинэчлэгдсэн хувилбарыг амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. Энэ хүрээнд банкны хэмжээнд алдагдлын үйл явдлыг мэдээлэх, бүртгэх, тайлагнах үйл явцыг бүрэн автоматжуулж, сайжруулсан.

ХААН Банк нь 2025 онд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын чиглэлд дараах баримт бичгүүдийг шинээр болон шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангах замаар үйл ажиллагааны эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэмжээнд удирдахад анхаарч ажиллалаа. Үүнд:

1. Санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын бодлого
2. Залилангийн удирдлагын бодлого
3. Гуравдагч талын эрсдэлийн удирдлагын бодлого
4. Залилангийн удирдлагын журам
5. Асуудлын удирдлагын журам
6. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам
7. Загварын удирдлагын журам
8. RCSA аргачлал
9. Загварын эрсдэлийн аргачлал

Банк нь гадаад болон дотоод залилангаас ангид байж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Залилангийн удирдлагын бодлогын хүрээнд Залилангийн удирдлагын стратегийг боловсруулж 2025 оны туршид амжилттай хэрэгжүүллээ. Энэ хүрээнд харилцагчийг залилангийн эрсдэлээс хамгаалах зорилгоор системийг сайжруулах, ажилтныг чадавхжуулах, харилцагчийн санхүүгийн мэдлэг, мэдээллийг сайжруулах чиглэлд ажиллалаа.

## Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага



ХААН Банк нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хангаж ажиллахдаа олон улсын шилдэг туршлага, арга хэрэгсэл, стандартуудыг мөрдлөг болгодог ба эрсдэлийн удирдлагад оролцогч талуудын үүрэг хариуцлагыг “Хамгаалалтын гурван шугам” загварын дагуу хэрэгжүүлж байна. Дээрх загварын дагуу мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, шинжилгээ хийх, үнэлэх, арга хэмжээ авах болон тайлагнах үйл явцуудад олон улсын ISO/IEC 27005 стандартыг мөрдлөг болгон ажилладаг. Мөн мэдээллийн хөрөнгийн сул талыг ашиглан түүний нууцлал, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдал алдагдсанаар учрах хохирол болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг Аюулгүй байдлын эрсдэлийн дэд хороогоор тогтмол хянан хэлэлцдэг.



## Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлага

ХААН Банк нь мэдээлэл технологийн эрсдэлийг үр дүнтэй удирдах Мэдээлэл технологийн эрсдэлийн дэд хороотой бөгөөд тус хороо нь банкны системүүд болон мэдээлэл технологийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлон арга хэмжээ авч ажилладаг.

Түүнчлэн мэдээллийн технологийн үйлчилгээний хүртээмж, бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс үйл ажиллагаанд гарсан асуудал, зөрчлийн талаар тогтмол дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол цаг тухайд нь арга хэмжээ авч байна.

Эрсдэлийн шинжилгээ, үнэлгээгээр илэрсэн эрсдэлүүдийг холбогдох арга хэмжээнүүдийн хамт мэдээллийн технологийн эрсдэлийн самбарт тусган удирдаж байна. Тайлант жилд мэдээлэл технологийн үйл ажиллагаа, цахим үйлчилгээ, тасралтгүй ажиллагаатай холбоотой эрсдэлүүдэд гол анхаарлаа хандуулж, эрсдэлийн түвшинг бууруулж ажиллалаа.

Банк нь мэдээлэл технологийн хяналт удирдлагадаа COBIT тогтолцоог баримталж, 2 жил тутамд тус тогтолцоонд суурилсан мэдээллийн технологийн хөндлөнгийн аудит хийлгэдэг. 2025 онд энэхүү шалгалтыг хийлгэж, чадамжийн дундаж үнэлгээгээ нэмэгдүүлснээр банкны үйл ажиллагаа нь олон улсын тэргүүлэгч банк санхүүгийн байгууллагатай эн зэрэгцэхүйц түвшинд хүрснийг баталгаажуулсан.

# ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ



Хууль эрх зүйн газар нь банкны үйл ажиллагааг хуульд нийцүүлэх, болзошгүй хуулийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын журам зэрэг эрх зүйн баримт бичигт тухай бүр нийцүүлж, хууль эрх зүйн асуудлаар дэмжлэг үзүүлдэг. Тайлант онд Банкны тухай хууль, Татварын багц хууль болон Зээлийн мэдээллийн тухай хууль зэрэг УИХ-д өргөн мэдүүлэх томоохон хуулийн төслүүдэд санал өгч, холбогдох ажлын хэсэгт орж ажилласан байна.

## КОМПЛАЕНС

ХААН Банк нь комплаенс, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) эрсдэлийн удирдлагын тогтолцоог стратегийн түвшинд тууштай хөгжүүлж, банкны үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын стандарт, сайн туршлага, мөн Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба зэрэг эрх бүхий зохицуулагч байгууллагууд, түүнчлэн корреспондент банкууд болон хөрөнгө оруулагчдын тавьж буй шаардлагад бүрэн нийцүүлэн хэрэгжүүлж ирсэн.

Түүнчлэн Хууль эрх зүйн газар нь банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлагдсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн дагуу эрсдэлийн дотоод лимитийг сар бүр холбогдох үзүүлэлтүүдээр хэмжиж, хяналтыг хэрэгжүүлэх замаар банкны үйл ажиллагаанд гадаад болон дотоод хүчин зүйлээс хамааран үүсэж болзошгүй хуулийн эрсдэлийг удирдан ажиллаж байна.

Улмаар банк нь дотоод бодлого, журам, зохион байгуулалтын бүтэц, хүний нөөцийн чадавх, мэдээллийн технологи, програм хангамжийн шийдлүүдээ үе шаттайгаар сайжруулж, комплаенс болон МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах тогтолцоог тасралтгүй бэхжүүлэн ажиллаж байна. Ийнхүү комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд GRC систем дэх банкны нийт бодлого, журмын нэгдсэн санг шинэчлэн сайжруулах арга хэмжээг удирдан зохион байгуулж, нэгдсэн бүртгэл хөтөлж, тогтмол хяналтыг хэрэгжүүлж эхэлсэн.

2025 онд банк нь МУТСТ бодлого, журмуудаа үе шаттайгаар шинэчлэн баталж, МУТСТ Дотоод хяналтын хөтөлбөрийг хууль эрх зүйн орчны өөрчлөлт, геополитикийн эрсдэлийн нөхцөл байдал, дэвшилтэт техник, технологийн хөгжил, мөн олон улсын шилдэг түршлага, стандарттай уялдуулан шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Түүнчлэн МУТСТ Дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг ТУЗ-өөс томилж, комплаенсийн үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд системтэйгээр, үр дүнтэйгээр хэрэгжүүлэх зорилгоор “Хамгаалалтын гурван шугам”-ын зарчимд суурилсан удирдлага, хяналтын тогтолцоог улам боловсронгуй болголоо. Ингэснээр бизнесийн нэгж, хяналтын чиг үүрэг бүхий нэгжүүд болон дотоод аудитын уялдаа холбоо сайжирч, эрсдэлд суурилсан хяналт, хариуцлагын тогтолцоо илүү тодорхой болсон.

Банк нь мөнгө угаах болон хориг арга хэмжээний эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлд суурилсан автоматжуулсан хяналтуудыг үе шаттайгаар сайжруулан хөгжүүлсэн бөгөөд Монголбанкны газар дээрх МУТСТ иж бүрэн шалгалтад хангалттай үнэлгээ авлаа. Улмаар тусгай хяналтын процессуудыг тогтмол боловсронгуй болгосны үр дүнд сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо өмнөх жилтэй харьцуулахад гурав дахин өсөж, МУТСТ болон комплаенс сэдвийн хүрээнд заавал хамрагдах болон сэдэвчилсэн сургалтуудыг нийт ажилтнуудад хүргэж, 95 хувь нь тогтмол хамрагдсан нь тогтолцооны үр дүнтэй байдлыг харуулж байна.

Мөн банк нь комплаенсийн соёлыг төлөвшүүлэх, салбарын түвшинд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Монголын банкны холбоотой хамтран Монгол Улсын Засгийн газар, эрх бүхий зохицуулагч болон хууль сахиулах байгууллага, төрийн болон олон улсын байгууллагын төлөөллүүд, арилжааны банкуудын ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон комплаенсийн мэргэжилтнүүдийг оролцуулсан “Комплаенс - Цахим шилжилт” сэдэвт 11 дэх удаагийн комплаенсийн форумыг 2025 оны 11-р сарын 27-28-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Форумын хүрээнд комплаенсийн үйл ажиллагаанд дижитал технологи, өгөгдөлд суурилсан хяналтын аргачлал, автоматжуулалт, зохицуулалтын орчны цаашдын чиг хандлага, салбар хоорондын хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэж, гарсан санал, шийдэл, дүгнэлтийг нэгтгэн холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэн, бодлого, зохицуулалтыг сайжруулахад хувь нэмэр оруулсан.

Банкны цахим шилжилтийн хүрээнд комплаенсийн хяналтыг эрсдэлд суурилсан аргачлалаар оновчтой хэрэгжүүлэх зорилгоор Quartz системд машин сургалтын (Machine Learning) алгоритмыг нэвтрүүлж, харилцагчийн баазыг хориг арга хэмжээний жагсаалттай тулгах ажиллагааг автоматжууллаа. Мөн зохицуулагч байгууллагын goAML системийн шинэчлэгдсэн хувилбарт шилжих хөгжүүлэлтийг хугацаанд нь амжилттай гүйцэтгэснээр тайлагналын шаардлагыг бүрэн хангаж ажиллав.

# ЦАХИМ БАНК



ХААН Банк нь Тогтвортой бизнесийн стратегийн хүрээнд харилцагчдадаа зориулан дэлхийн жишигт нийцсэн шинэ технологи, цахим бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхийн зэрэгцээ, банкны үйлчилгээг тасалдалгүй хүргэхийн тулд техник хангамж, системүүдийн бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангахад гол анхаарлаа хандуулан ажиллаж байна. Бид 2025 онд системийн тасралтгүй байдлыг 99.9 хувьтай ханган ажиллаж, банкны арын үйл ажиллагааг автоматжуулах, харилцагчид хүрч буй цахим банкны үйлчилгээг найдвартай, түргэн шуурхай хүргэх зорилгоор мэдээлэл технологийн

сайжруулалтыг хийх, системүүдийг шинэчлэх гэх мэт хөгжүүлэлтүүдийг тасралтгүй тогтмол хийж гүйцэтгэлээ. Цахим банкны стратегийн хүрээнд Харилцагчийн амьдралын хэв маяг, санхүүгийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчид хүргэх зорилгоор өгөгдөлд суурилан машин сургалт болон AI загварууд, анализын үр дүнд үндэслэн хялбар, шуурхай, найдвартай цахим туршлагыг хүргэх үүднээс "DigiBrain" системийг нэвтрүүлж харилцагчид тохирсон цахим сувгаар нь хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон хүргэж байна.

## Цахим банкны үйлчилгээ




Цахим стратегийн хэрэгжилтийг үргэлжлүүлэн эрчимжүүлж, шинэ харилцагчийг цахимаар бүртгэх, зээл, депозит, картын үйлчилгээнүүдийг бүрэн цахимжуулахын зэрэгцээ иргэн болон байгууллагын харилцагчдад зориулсан бүх төрлийн банкны цахим сувгуудыг сайжруулснаар салбар нэгжид биечлэн очиж авдаг байсан санхүүгийн үйлчилгээг цахим орчинд шилжүүлэн, хүртээмжтэй, шуурхай үйлчилгээний стандартыг бүрдүүлээ.

Цахим төлбөр тооцооны экосистемийг хөгжүүлэх хүрээнд DiGi Pay аппликэйшнийг тасралтгүй шинэчилж, харилцагчийн өдөр тутмын хэрэглээнд нийцсэн шинэлэг функцүүдийг нэвтрүүлэв. Мөн Gamification буюу тоглоомчилсон лоялти хөтөлбөрийг 6-р сараас хэрэгжүүлж эхэлснээр төлбөр тооцооны энгийн, сонирхолтой, идэвхжүүлсэн хэрэглээний туршлагыг бий болгож байна.

Тогтвортой бизнесийн стратегийн хүрээнд дэлхийн жишигт нийцсэн шинэ технологи, цахим бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхийн зэрэгцээ банкны үндсэн системийг шинэчилж, өгөгдлийн соёл болон өгөгдлийн засаглалыг бэхжүүлснээр ирээдүйн бүрэн дижитал банкны үйл ажиллагаанд шаардлагатай дэд бүтэц, бэлэн байдлыг хангах томоохон төслүүдийг үе шаттай хэрэгжүүлж байна. Түүнчлэн процесс автоматжуулалтын технологийг ашиглан байгууллагын хэмжээнд үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилт тавьж, 2025 онд газар, нэгжүүдийн процессуудын нэгдсэн сан бүрдүүлэн, нарийвчилсан шинжилгээ, автоматжуулалтыг хэрэгжүүлсний үр дүнд 170,765 цагийн гар ажиллагааг орлож, 85 орчим ажилтны хөдөлмөрийг бүрэн автоматжууллаа.

## Business AI туслах




GenAI технологид суурилсан, 24/7 тасралтгүй ажиллах, өргөтгөх боломжтой “Business AI туслах” системийг хөгжүүлснээр ажилтнууд болон харилцагчид шуурхай, найдвартай, чанартай мэдлэг, мэдээлэл авах нөхцөл бүрдэж, бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт, харилцагчийн туршлагыг сайжруулах инновацлаг шийдэл болсон.

## Khan Business аппликэйшн

ХААН Банк бизнес эрхлэгчдэд зориулсан өөрийн кластерийг бүрдүүлэх, банкны үйлчилгээг цахимаар авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 9-р сард Khan Business аппликэйшн-ийг зах зээлд анхлан нэвтрүүллээ. Хөдөө аж ахуйн кластерийг дэмжих бодлогын хүрээнд хөгжүүлсэн уг аппликэйшнээр дамжуулан харилцагчид кластерийн бүртгэлээ цахимаар үүсгэх, кластерт нэгдэх хүсэлт илгээх, факторингийн үйлчилгээ авах хүсэлт гаргах зэрэг үйлчилгээг хурдан, шуурхай шийдвэрлүүлэх боломж бүрдсэн. Түүнчлэн банкнаас салбарын шинэлэг мэдээ мэдээлэл, сургалт, зөвлөгөөг биет болон цахим сувгаар тогтмол хүргэснээр харилцагчидтайгаа урт хугацааны хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллаж байна.

Тус систем нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлоготой уялдсан хөдөө аж ахуй (газар тариалан, сүү, мах, ноолуур), худалдаа, үйлчилгээ, барилгын салбаруудын мэдлэгт суурилсан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн мэдээллийг агуулж, ногоон санхүүжилт болон ESG зарчмыг дэмжихэд чиглэсэн дэвшилтэт технологийн хөрөнгө оруулалтын чухал суурь болсон.

“Business AI туслах”-ыг нэвтрүүлснээс хойш нийт 1,469 ажилтан системд хандах эрхтэйгээр идэвхтэй ашиглаж, 24,950 асуулт, 9,443 харилцан яриа үүсгэн өдөр тутмын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлээд байна. Мөн Business Maturity Assessment-ийн 38 оношлол хийгдэж, AI-ийн дэмжлэгтэйгээр 860 PowerPoint танилцуулгыг автоматаар үүсгэснээр ажилтнуудын хурд, бүтээмж, мэдлэгт суурилсан соёлыг бодитойгоор нэмэгдүүлсэн бөгөөд уг төсөл нь 2025 оны ХААН Банкны Гранпри төслөөр шалгарсан амжилт үзүүллээ.



# БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ



ХААН Банкны дунд хугацааны стратегийн тулгуур баганы нэг болох байгууллагын хөгжлийн хүрээнд 2025 онд хүний нөөц, соёл, бүтээмж, цахим шилжилт, манлайлал зэрэг чиглэлүүдийг хамарсан олон төсөл, хөтөлбөр, санаачилгыг амжилттай хэрэгжүүлээд байна.

Тухайлбал, ажилтнуудын ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх зорилгоор олон улсын цахим сургалтын платформуудыг нэвтрүүлж, датанд суурилсан шийдвэр гаргалт, дижитал ур чадварыг нэмэгдүүлэх сургалтуудыг түлхүү зохион байгуулсан. Мөн “Тогтвортой байдлын стратеги”-ийг батлаад байгаа юм.


Үүний зэрэгцээ ажилтны туршлагыг сайжруулах, байгууллагын соёлыг бэхжүүлэх зорилгоор дотоод харилцаа, оролцоог нэмэгдүүлэх олон арга хэмжээг зохион байгуулж, уян хатан, хүн төвтэй ажлын орчныг бүрдүүлэхэд анхаарч ажилласан.

Ийнхүү байгууллагын хөгжлийг стратегийн түвшинд системтэйгээр дэмжсэнээр ХААН Банк нь тогтвортой өсөлт, өрсөлдөх чадвараа бэхжүүлэх суурийг улам батжуулан ажиллаж байна.

## Тогтвортой байдлын засаглал

ХААН Банкны Тогтвортой байдлын засаглалын бүтэц жилээс жилд шат дараатайгаар бэхжин сайжирч ирсэн. 2019 онд Тогтвортой хөгжлийн ажлын хэсэг анх байгуулагдаж байсан бол 2025 он гэхэд банкны хэмжээнд Тогтвортой байдлын бодлого, стратеги, зорилт, хэрэгжилтийг

тодорхойлох, хянах, хангах болон тайлагнах цогц засаглалын тогтолцоог бүрдүүлээд байна. 2025 оны 12-р сард “Тогтвортой байдлын бодлого” батлагдсанаар Банкны Тогтвортой байдлын засаглалыг дараах бүтцээр тодорхойлон хэрэгжүүлж байна.



## Тогтвортой байдлын бодлого

ХААН Банк нь “Тогтвортой хөгжлийн бодлого”-оо 2020 онд анх баталж, Тогтвортой хөгжлийн хамрах хүрээ, зарчмуудыг тодорхойлж, тэдгээрийг өдөр тутмын үйл ажиллагаандаа уялдуулан хэрэгжүүлж ирсэн. Жил ирэх тусам олон улсын болон дотоодын шаардлага, чиг хандлага, хөрөнгө оруулагчдаас Байгаль орчин, нийгэм, засаглалд хандах хандлага, Тогтвортой байдалд анхаарал хандуулах байдал улам нэмэгдэж, банк ч үүний жишгээр БОНЗ-ын эрсдэл, боломжийг

системтэйгээр удирдаж, хариуцлагатай үйл ажиллагааг явуулах, зохицуулагч байгууллага болон олон улсын шаардлагыг ханган, санхүүгийн тогтвортой байдлаа хамгаалж, оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлж, урт хугацааны үнэ цэн болон өрсөлдөх чадвараа бий болгох зорилгоор “Тогтвортой байдлын бодлого”-ыг 2025 оны 12-р сард шинэчлэн баталлаа. ХААН Банкны Тогтвортой байдлын бодлогын хамрах хүрээ нь дараах үндсэн чиглэлээс бүрдэж байна. Үүнд:

### Үндэсний амлалтууд

Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт

Тогтвортой санхүүжилтийн үндэсний замын зураг

Алсын хараа 2030

### Бидний амлалтууд



10 зарчим



8 зарчим



7 зарчим



PCAF® Partnership for Carbon Accounting Financials



7 зарчим

## ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БОДЛОГО



БАЙГАЛЬ ОРЧИН



НИЙГЭМ



ЗАСАГЛАЛ



ХАРИУЦЛАГАТАЙ  
БАНК

Тогтвортой байдлын бодлого нь олон улсын болон дотоод бодлогын баримт бичиг, тогтвортой хөгжил ба уур амьсгалын өөрчлөлтийн зорилт, амлалтуудад тулгуурлан боловсруулагдсан. Мөн энэхүү бодлогоор банкны хэмжээнд баримтлан хэрэгжүүлэх Байгаль орчин, Нийгэм, Засаглал болон Хариуцлагатай банк гэсэн дөрвөн үндсэн чиглэлд нийт 33 зарчмыг тодорхойлсон.

Түүнчлэн Тогтвортой байдлын бодлого нь ХААН Банкны ТУЗ-өөр батлагдсанаар бодлогын хэрэгжилт, хяналт бэхжиж, илүү өндөр хариуцлагатайгаар хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдсэн чухал алхам болсон.

## Тогтвортой байдлын стратеги

### Алсын хараа

ХААН Банк “Тогтвортой хөгжилд манлайлагч” үнэт зүйлийнхээ хүрээнд тогтвортой хөгжлийн чиглэлд манлайлж, оролцогч талууддаа урт хугацааны үнэ цэнийг бүтээх болно.

Үүний тулд бид үйл ажиллагаа болон бизнесийнхээ байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлуудыг удирдан чиглүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, түүнд дасан зохицох замаар бодит хувь нэмэр оруулахыг зорино.

### Бидний алхмууд

Банк нь “Тогтвортой хөгжилд манлайлагч” үнэт зүйлийн хүрээнд дараах алхмуудыг хийхээр зорьж байна. Үүнд:

Бүх түвшний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх  
Тогтвортой хөгжлийн зорилгуудыг тодорхойлох;

Стратегийн түвшинд хэмжигдэхүйц амлалт болон зорилтыг тогтоох;

Зорилтуудад хүрэх замыг тодорхойлж, гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтүүд болон аргачлалыг боловсруулах;

Олон улсын стандартад нийцүүлэн гүйцэтгэлийн тухай ил тод тайлагналын процесс, тогтолцоог бэхжүүлэх.

### БИДНИЙ НӨЛӨӨЛӨЛ

#### Тэг ялгаралд шилжих

2030 он гэхэд өөрийн үйл ажиллагааны нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах замаар тэг ялгаралд хүрэх амлалт өгч байна.

#### Оролцоотой, өсөлттэй ажиллах хүчин

Ажилтнуудын шударга, сайн сайхан байдал, нийгмийн оролцоог идэвхжүүлэх замаар хүртээмжтэй ажлын орчин бүрдүүлэх.

#### Нөлөөллийн тогтвортой санхүүжилт

Тогтвортой хөдөө аж ахуй, шилжилтийн санхүүжилтийг дэмжих тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан эерэг нөлөө үзүүлэх.

#### Тогтвортой байдлын зорилтууд болон тогтвортой хөгжлийн зорилтуудад оруулах хувь нэмэр

17 зорилго нь 2030 гэхэд бидний хүрэх тогтвортой байдлын зорилттой уялдаж буй бөгөөд бид үүнээс хамгийн их нөлөө үзүүлэх тогтвортой хөгжлийн дараах 5 зорилгод төвлөрөн ажиллана.



## Тэргүүлэх чиглэлүүд ба давхар материаллаг байдал

ХААН Банк нь Тогтвортой байдлын стратегийг боловсруулах зорилгоор олон улсын шилдэг туршлагаудаас судлан олон улсын байгууллагын зөвлөх үйлчилгээний тусламжтайгаар давхар материаллаг байдлын үнэлгээг банкны бүх оролцогч талуудын оролцоотойгоор гүйцэтгэж, олон улсын стандартад нийцсэн, байгууллагын түвшинд хамаарах БОНЗ-ын 14 давхар материаллаг асуудлыг тодорхойлсон.


Энэхүү үнэлгээ нь байгаль орчин, нийгэм, засаглалтай холбоотой асуудлууд банкны ашигт ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт, тогтвортой үйл ажиллагааг хангахад хэрхэн нөлөөлж буй болон нөгөө талаасаа банк нь эдгээр асуудалд хэрхэн нөлөө үзүүлж буй байдлыг цогцоор нь үнэлэх давхар материаллаг байдлын үнэлгээний аргачлалыг хэлж буй юм.



Давхар материаллаг байдлын үнэлгээний үр дүнд тодорхойлогдсон гол асуудлуудыг ХААН Банк нь стратегийн төлөвлөлт, эрсдэлийн удирдлага, тогтвортой санхүүжилт, дотоод үйл ажиллагаандаа уялдуулан хэрэгжүүлж, Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлт, уур амьсгалд дасан зохицох чадавхыг дэмжихэд бодит хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Эдгээр 14 материаллаг асуудал нь тогтвортой үнэ цэнийг бий болгох стратегийн үндэс суурийг бүрдүүлж буй тэргүүлэх чиглэлүүд бөгөөд 2030 онд гэхэд эдгээр материал асуудлын хүрээнд Тогтвортой байдлын стратегийн 20 зорилтыг Байгаль орчин, Нийгэм, Засаглал болон Хариуцлагатай банк гэх 4 үндсэн тулгуурт хуваан тодорхойлсон. Эдгээр нь банкны хамгийн чухал сорилт, боломжуудыг илэрхийлж, урт хугацааны үнэ цэнийг баталгаажуулах, оролцогч талуудын хүлээлтийг биелүүлэх, нийгэмд эерэг нөлөө үзүүлэхэд чухал ач холбогдолтой.

## ХААН Банкны давхар материаллаг асуудал



## Санхүүгийн материаллаг байдал

## Давхар материаллаг асуудал


- |    |  |                                         |
|----|--|-----------------------------------------|
| 1  |  | Тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээ      |
| 2  |  | Хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ     |
| 3  |  | Уур амьсгалын өөрчлөлт                  |
| 4  |  | Компанийн засаглал                      |
| 5  |  | Нөөцийн хэрэглээ                        |
| 6  |  | Цахимжилт ба инновац                    |
| 7  |  | Цахим ба мэдээллийн аюулгүй байдал      |
| 8  |  | Ажилтны оролцоо, хөгжил                 |
| 9  |  | Бизнесийн ёс зүй                        |
| 10 |  | Харилцагчийн сэтгэл ханамж, хамгаалалт  |
| 11 |  | Эрсдэлийн удирдлага                     |
| 12 |  | Компанийн нийгмийн хариуцлага           |
| 13 |  | Хүний эрх                               |
| 14 |  | Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал |

## Тогтвортой байдлын онцлох үйл явдал, ажлууд

2025 онд ХААН Банкны хувьд тогтвортой байдлын удирдлагыг бэхжүүлэхэд томоохон ажлуудыг төлөвлөн амжилттай хэрэгжүүллээ. Тайлант оны 9-р сард ХААН Банк 2030 он хүртэлх хэрэгжүүлэх “Тогтвортой байдлын стратеги 2030”-ийг боловсруулж, 12-р сард “Тогтвортой хөгжлийн бодлого”-оо шинэчлэн сайжруулж банкны ТУЗ-өөр тус тус батлууллаа. Мөн банкны хэмжээнд Тогтвортой байдлын удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх, шийдвэр гаргах, удирдах, гүйцэтгэх Тогтвортой байдлын засаглалыг шинэчлэн бүрдүүлээд байна. Түүнчлэн ажилтнууд болон удирдлагуудын тогтвортой байдлын мэдлэг,

ойлголтыг гүнзгийрүүлэх, соёлыг бэхжүүлэх арга хэмжээ, аян, сургалт, хөтөлбөрүүд зохион байгуулсан. Үүнээс гадна харилцагч, түнш, бэлтгэн нийлүүлэгч зэрэг гадны оролцогч талуудтай тогтвортой байдлын чиглэлд хамтын ажиллагаа, төслүүдийг амжилттайгаар хэрэгжүүлэв.

*Та бүхэн Тогтвортой байдлын стратеги, засаглал, эрсдэлийн удирдлага болон 2025 оны гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг ХААН Банкны 2025 оны “Тогтвортой байдлын тайлан”-гаас авна уу.*



## Тогтвортой байдлын замнал


	Засаглал	Стратеги, бодлого	Санал, санаачилга болон тогтвортой санхүүжилт	Олон улсын гэрээ, тайлан	Хамтын ажиллагаа, шагнал	Үнэлгээ, зөвлөх үйлчилгээ	Хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол
2007			Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч ХААН Банк санг байгуулав.				
2010				НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд нэгдэв.			
2011	Дотоодын ТоС ажлын хэсгийг байгуулав.	Байгаль орчин, нийгмийн бодлогыг батлав.	Зээлийн хүсэлтэд Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийж эхэлсэн. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хувь нэмэр оруулж эхэлсэн.		Монголын Тогтвортой санхүүжилт (ТоС) хөтөлбөрт нэгдэв.		
2018					Ногоон хөрөнгө оруулалтын зарчимд нэгдсэн.		
2019	Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийг байгуулав.			Тогтвортой хөгжлийн тайланг гаргаж эхлэв.			
2020		Тогтвортой хөгжлийн бодлогыг анх батлав.					
2022	Тогтвортой хөгжлийн газрыг байгуулав. 1 үндсэн, 4 ажлын хэсэг байгуулав.	“Тогтвортой хөгжилд манлайлагч” хэмээн үнэт зүйлээ тодорхойлов.				Moody's агентлагаар БОНЗ-ын үнэлгээг хийлгэв.	
2023		Тогтвортой хөгжлийн бодлогыг шинэчлэн батлав.	Ногоон бонд гаргав.	Зээл, санхүүжилт олгохдоо хүлэмжийн хийг тооцоолох PCAF санаачилгад нэгдэв.	ТоС-ын Манлай банк		
2007	Тогтвортой хөгжлийн хороог байгуулав. ТУЗ-ийн дэргэдэх ЗЦУХ-нд тайлагнадаг болов.		Нийгмийн бонд гаргав.		ТоС-ын Манлай банк Asiamoney -ийн Шилдэг БОНЗ хэрэгжүүлэгч	Тогтвортой байдлын стратеги боловсруулахад ЕҮ-аас зөвлөх үйлчилгээг авав.	
2007	ТУЗ-өөс Тогтвортой байдлын стратеги, бодлогыг батлан хянадаг болов.	Тогтвортой байдлын стратеги болон Тогтвортой байдлын бодлого батлагдв.	Жендэр бонд гаргав.		ТоС-ын Жендэрийн манлай байгууллага	Уур амьсгалын эрсдэлийн зөвлөх үйлчилгээг ОУСК-аас авсан.	Дотоодын үйл ажиллагаанаас ялгаруулсан ХХЯ-ыг хэмжив.

Тогтвортой хөгжилд манлайлагч байх зорилгын хүрээнд 2025 оны 9-р сард банкны Байгаль орчин, Нийгэм, Засаглал, Хариуцлагатай банк гэсэн 4 тулгуур баганы хүрээнд тодорхойлсон “Тогтвортой байдлын стратеги 2030” болон 2025 оны 12-р сард “Тогтвортой байдлын бодлого”-ыг тус тус батлуулаад байна.

Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн “Уур амьсгалын санжүүжилтийн зөвлөх үйлчилгээ”-ний хүрээнд 2024 оны үйл ажиллагаанаас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг тооцож дууссан бөгөөд санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын тооцооллыг гүйцэтгэж байна.

ХААН Банк сангаараа дамжуулан нийгмийн хариуцлагын нийт 13 төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх замаар нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулж, эерэг манлайллыг бий болгон ажиллалаа. Голлох төслөөс дурдвал:

- ХААН Банк нь “ХААН Банкны ой” мод тарих хөтөлбөрийг 2007 оноос хэрэгжүүлж байгаа бөгөөд 2025 онд нийт 500 га газар 1,000,000 мод тарьсан.
- ХААН Банк сангаас НҮБ-ын Хүүхдийн сан болон Боловсролын яамтай хамтран хэрэгжүүлж байгаа “Багийн бага сургууль” төсөл нь сумын алслагдсан багийн хүүхдүүдийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд 2025 онд дараах 4 байршилд сургууль барьж өгч, ашиглалтад хүлээлгэн өглөө.
  - Увс аймгийн Хандгайт багийн Боршоо боомт
  - Ховд аймгийн Үенч сум Хөх үзүүр баг
  - Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг баг
  - Сэлэнгэ аймгийн Мандал сумын Тарни баг



Энэхүү төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл болон ХААН Банк сангийн 2025 онд хэрэгжүүлсэн бусад төсөл, хөтөлбөрүүдтэй танилцахыг хүсвэл Тогтвортой байдлын тайлангийн “Компанийн нийгмийн хариуцлага” хэсгээс уншина уу.

## Тогтвортой санхүүжилт

Монгол Улс Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг ахиулан шинэчилж, 2025 оны 9-р сарын 10-ны өдөр Засгийн газар 91 дүгээр тогтоолоор “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (NDC) 3.0”-ийг баталж, 2035 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 30.3 хувь буюу 24.7 сая тонн CO<sub>2</sub>-эквивалентээр бууруулах зорилт тавьсан .

Энэхүү бодлогын зорилттой уялдуулан ХААН Банк нь ногоон хөгжил, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг түүштай хэрэгжүүлж байна. Банк нь талуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох үндэсний чадавхыг бүх түвшинд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорин, зорилтот ногоон зээлийн бүтээгдэхүүн, төсөл хөтөлбөрүүдийг үе шаттайгаар нэвтрүүллээ.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлд ногоон бизнесийн зээл, агаар орчны бохирдлыг бууруулах ногоон хэрэглээний зээл, цахилгаан тээврийн хэрэгслийн зээл, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц болон амины орон сууцны зээл зэрэг бүтээгдэхүүнийг зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулан харилцагчдад санал болгож, дасан зохицох, даван туулах чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын онцлогт нийцүүлэн хөдөө аж ахуйн салбарын өртгийн сүлжээнд оролцогч талуудыг дэмжих зорилгоор Хариуцлагатай малчны ногоон зээл, Тогтвортой ноос, ноолуурын нийлүүлэлтийг дэмжих ногоон зээлийн бүтээгдэхүүнийг гаргаад байна.

Үүний зэрэгцээ мал аж ахуйн салбарын тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавх, санхүүгийн хүртээмжид суурилсан тогтвортой хөдөө аж ахуйн зээлийн бүтээгдэхүүнийг боловсруулж, зээлийн үр нөлөөг хэмжих, тайлагнах, баталгаажуулж, тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр дотоод, гадаадын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар ХААН Банкны ногоон зээлийн багц 711.95 тэрбум төгрөг байсан бол 2025 оны жилийн эцэст 1,126.7 тэрбум төгрөгт хүрч, 58.3 хувийн өсөлт үзүүлэв. Тайлант хугацаанд арилжааны банкууд нийт 2,334.8 их наяд төгрөгийн ногоон зээлийн багцыг Монголбанканд тайлагнаснаас ХААН Банк дангаар 48 хувийг бүрдүүлж, зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалсан байна.

Ногоон таксономийн ангиллаар задлан үзвэл нийт багцын 69.4 хувь нь эрчим хүчний хэмнэлттэй төсөл, хөтөлбөрүүдэд, 16.15 хувь нь тогтвортой хөдөө аж ахуйд, үлдэх 13.85 хувь нь сэргээгдэх эрчим хүч, ногоон барилга, карбон бага ялгаруулалттай тээврийн ангиллын зээлүүдэд ногдож байна. Мөн тайлант онд стратегийн ач холбогдол бүхий хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хүрээнд үр тариа, ноос, ноолуур, мах, сүүний кластеруудад хамаарах ногоон шалгуур хангасан төсөл, зориулалтуудыг ногоон хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээлээр санхүүжүүлснээр тогтвортой хөдөө аж ахуйн ангиллын багц өмнөх оноос 7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

№	Ногоон таксономи ангилал	Эзлэх хувь
1	Сэргээгдэх эрчим хүч	6.80%
2	Бохирдол багатай эрчим хүч	0.10%
3	Эрчим хүчний хэмнэлт	69.44%
4	Ногоон барилга	2.21%
5	Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа	0.44%
6	Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ	0.25%
7	Тогтвортой ХАА, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал	16.15%
8	Карбон бага ялгаруулдаг тээвэр	4.61%

ХААН Банк 2026 онд ногоон болон нийгмийн зээлийн багцыг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх, ногоон зээлийн багцыг 1.4 их наяд төгрөгт хүргэх зорилт дэвшүүлсэн бөгөөд 2025 оны эхний хагаст анх удаа 1.0 их наяд төгрөгт хүрсэн. Дээрх зорилтын хүрээнд ногоон зээлийн процессийг сайжруулах, цахимжуулах, хиймэл

оюуны тусламжтайгаар ногоон технологийг тодорхойлох, энэ чиглэлд олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах, хамтарсан төслүүдийг нэвтрүүлэх зэргээр сайн арга туршлага, технологийн дэвшлийг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.

## “Green database” төсөл

“Green database” нь Монгол Улсын нэгдсэн ногоон дата экосистемийг бий болгох, платформд суурилсан ногоон санхүүжилтийн цахим үйлчилгээг хөгжүүлэх, бүхий л оролцогч талуудын уур амьсгалын өөрчлөлтөд оруулсан хувь нэмрийн нэгдсэн бүртгэл, тайлагналын систем бий болгох алсын хараатай төсөл юм. Төслийг 2023 оны 9-р сараас эхлүүлж, 2024 оны 11-р сард дээрх алсын хараатай нягт уялдсан Green.khanbank.com платформыг шинээр нэвтрүүлж, ToC форумын үеэр анх удаа олон нийтэд танилцуулсан. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн 3.2 дугаар зүйлд их өгөгдлийн хүрээнд ногоон, тогтвортой санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэхэд энэхүү төсөл бодитой хувь нэмэр оруулж байгаагаараа онцлогтой.

2025 оноос ногоон технологи болон ногоон технологи үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчдийн датаг цуглуулах үндсэн шийдэл буюу бэлтгэн нийлүүлэгчид платформд хандаж ногоон бүтээгдэхүүнээр хамтран ажиллах гэрээг зайнаас байгуулдаг болсон. Үр дүнд нь нийт 160 бэлтгэн нийлүүлэгчийн 690 орчим ногоон бүтээгдэхүүн, технологийн мэдээлэл Green.khanbank.com-д бүртгэгдсэн байна. Түүнчлэн ногоон технологийг таних, шалгуур хангуулах процессийг богино хугацаанд гүйцэтгэх, хүн цагийг хэмнэх зорилго болон банкны цахим шилжилтийн зорилттой уялдуулж, хиймэл оюун ухааны тусламжтайгаар ногоон технологийг баталгаажсан эх сурвалжуудаас шалган баталгаажуулах хөгжүүлэлт хийж байна.

## Монгол Улсын анхны Жендэр бонд



2025 онд Тогтвортой хөгжлийн 5-р зорилт буюу Жендэрийн тэгш байдлыг хангах, 8-р зорилт буюу Зохистой хөдөлмөр болон эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зориулан хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхээр Жендэр бонд гаргасан билээ.

Тус бондын хүрээнд босгосон 30 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг эмэгтэй бизнес эрхлэгчдийн

санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, жендэрийн тэгш байдлыг дэмжих зорилгоор баталгаат ажлын байрыг бий болгох, тэр дундаа эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлт, эдийн засгийн оролцоо, манлайллыг дэмжихэд тусгайлан зарцуулсан бөгөөд нийт 307 эмэгтэй бизнес эрхлэгчид зээл олгосон байна.

## Нийгмийн санхүүжилт

ХААН Банк 2024 онд олон улсын зах зээлээс татсан 130 сая ам.долларын Нийгмийн бондын эх үүсвэрээр Монгол Улсад тулгамдаж буй нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлэх салбарууд буюу хүнсний аюулгүй байдлыг хангах, боловсролын байгууллагын хүртээмж, чанарыг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, орлогод нийцсэн орон сууц, дэд бүтцийн хөгжлийг дэмжих, бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, ажлын байр бий болгох төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлээ.

Нийгмийн бондод ХААН Банкны урт хугацааны түнш ОУСК 100 сая хүртэлх ам.долларын хөрөнгө оруулалт хийсний зэрэгцээ “Нийгмийн бондын санхүүжилтийн хүрээ” (Social Bond Framework “SBF”) баримт бичгийг ОУХЗН (ICMA)-ын “Нийгмийн бондын зарчим”-д уялдуулан боловсруулахад дэмжлэг үзүүлж ажилласан билээ. “Нийгмийн бондын санхүүжилтийн хүрээ”-нд заасны дагуу нийт 1602 зээлдэгчид 442 тэрбум төгрөгийн нийгмийн зээл олгосон бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн зээлийн багц 235 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.


## Хөндлөнгийн аудит – “Ногоон бонд”

ХААН Банк “Ногоон бондын хөтөлбөр”-ийн хүрээнд дотоодын зах зээлд гаргасан 30,000 мянган ам.долларын Ногоон бонд болон олон улсын зах зээлд хаалттай хэлбэрээр, 5 жилийн хугацаатай гаргасан 60 сая ам.долларын Ногоон бондын гүйцэтгэл, “Ногоон бондын санхүүжилтийн хүрээ” (Green Bond Framework)-ний хэрэгжилтийг олон улсын түвшинд баталгаажуулах зорилгоор хөндлөнгийн аудитыг сонгон шалгаруулж, “ПрайсуотерхаусКуперс аудит” ХХК (PWC Audit LLC) хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэж, Ногоон бондын тайланг хүлээн авлаа.

Ногоон бондоор татан төвлөрүүлсэн нийт 311 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчний төслүүд, эрчим хүчний хэмнэлт үүсгэх

бүтээгдэхүүн, үйлчилгээ, төслүүд, ногоон барилгын шийдлүүд, бохирдлоос сэргийлэх бууруулах үйл ажиллагаа, усны менежмент, усны хэмнэлттэй технологи, тогтвортой ХАА, ногоон тээвэр гэсэн 7 чиглэлийн ногоон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулсан. Үүнээс эрчим хүчний хэмнэлт үүсгэх бүтээгдэхүүн, төслүүд 76.9 хувийг, ногоон тээвэр 7.4 хувийг, сэргээгдэх эрчим хүчний төслүүд 5.4 хувийг, тогтвортой ХАА-н төслүүд 3.6 хувийг тус тус бүрдүүлж, үр дүнд нь 120 мянган тонн нүүрсхүчлийн хийг нэг жилд бууруулах боломжтой болсон байна.

*Дэлгэрэнгүй мэдээллийг  
Тогтвортой байдлын тайлан 2025 тайлангаас авна уу.*



## Ажилтнуудын чадавх бэхжүүлэх



ХААН Банк нь тогтвортой санхүүжилтийн чиглэлд ажилтнуудын мэдлэг, үр чадварыг тогтмол сайжруулж, ногоон, нийгмийн, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн цогц үйлчилгээг өндөр түвшинд хүргэхийг зорьдог.

Салбар, нэгж болон төв банкны нийт ажилтнуудаа идэвхжүүлэх, ногоон санхүүжилтийн талаарх мэдлэг ойлголтод нь хувь нэмэр оруулах зорилготой “Green day” өдөрлөгийг “Дулаан шийдэл” төсөл, “Шинэлэг сууц” ХХК, “УБТ гарден” ХХК, “Жи-Пауэр” ХХК, “Леаф центр” ХХК-уудтай хамтран зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үр дүнд ажилтнууд санаачлан ногоон хөгжил, байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөг бий болгох санаачилгуудыг хэрэгжүүлэх зорилго бүхий сайн дурын “Green club”-ийг 110 гишүүнтэйгээр үүсгэн байгууллаа.

ХААН Банкны 21 аймаг, орон нутгийн салбар, бизнес төвийн нийт 500 орчим ажилтандаа зориулан “Тогтвортой хөдөө аж ахуй, ногоон санхүүжилт” сэдвээр 8 долоо хоногийн хугацаатай танхимын сургалтыг Монголын бэлчээр судлалын ногоон алт төв НҮТББ, “Тогтвортой ноос ноолуурын эвсэл” ТББ-тай хамтран зохион байгууллаа.

ОУСК-ын зөвлөх үйлчилгээний хүрээнд банкны 11 хүний бүрэлдэхүүнтэй баг БНХАУ-ын Шанхай хотод ногоон барилгын стандарт, усны хэмнэлт, хаягдал ус цэвэрлэх чиглэлээр туршлага судаллаа.

Тайлант онд эдгээр сургалт, арга хэмжээнээс гадна 21 аймаг, Улаанбаатар хотын салбаруудад ногоон санхүүжилтийн мэргэшсэн нийт 59 “Ногоон амбассадор”-ыг амжилттай бэлтгэлээ. Ингэснээр салбар нэгжийн ногоон зээлийг шийдвэрлүүлэх процесс сайжрах, ногоон төсөл, хөтөлбөрүүдийг урьдчилан тодорхойлж, харилцагчдад оновчтой зээлийн үйлчилгээ санал болгох, аймаг орон нутгийнхаа онцлогт тохирсон байдлаар ногоон санхүүжилтийн үйлчилгээ нэвтрүүлэх зэрэг давуу талуудыг бий болгож байна. Ийнхүү дижитал банкны экосистем, өгөгдөлд суурилсан борлуулалт, зорилтот санхүүжилт, үйл ажиллагааны автоматжуулалт зэрэг стратегийн санаачилгууд нь ХААН Банкны илүү хүртээмжтэй, үр ашигтай, тогтвортой өсөлттэй бизнесийн загварт шилжүүлж, зах зээл дэх манлайллыг бататгав.

## Компанийн нийгмийн хариуцлага

ХААН Банк нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж, ард иргэдийн сайн сайхан амьдралын төлөө бодитой хувь нэмэр оруулахаар нийгмийн хариуцлагын ажлуудыг 2007 оноос хойш ХААН Банк сангаар дамжуулан хэрэгжүүлж, Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хувь нэмрээ оруулсаар байна.

19 жил

536 төсөл

27.7 тэрбум төгрөг

528,000 хүнд хүрсэн

ХААН Банк сан нь ХААН Банкны тогтвортой хөгжлийн бодлогын үндсэн чиглэлийн нэг болох Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалтын хэсэгт багтаж буй нийгмийн хариуцлагын ажлуудыг хэрэгжүүлдэг нэгж юм.

### Тэргүүлэх чиглэл



Хүүхэд залуусын боловсролыг дэмжих



Олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах



Байгаль орчноо хамгаалах



Орон нутгийн хөгжлийг дэмжих



Нийгмийн эмзэг бүлгийг дэмжих



Соёл урлагийг дэмжих

# ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

## Хүний нөөцийн бодлого

ХААН Банк нь 2025 онд Банкны стратегид нийцсэн Хүний нөөцийн стратегийг хэрэгжүүлэхдээ цахим шилжилтийг дэмжсэн өндөр бүтээмжтэй, өөрчлөлтөд бэлэн, хөрвөх чадвартай ажиллах хүчнийг бэлтгэх, ажилтны эерэг туршлагыг бүрдүүлэн хүн төвтэй бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүний нөөцийн бодлого нь байгууллагын хөгжлийг дэмжихийн зэрэгцээ ажилтан бүрийн онцлог, хэрэгцээнд нийцсэн, шинэлэг бодлого, эерэг зөв орчин бүрдүүлэх, байгууллагын зорилго, бизнесийн амжилтад дэмжлэг үзүүлдэг. Дижитал шилжилт, процессийн автоматжуулалтыг эрчимжүүлэх хүрээнд өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтын чадамжийг нэмэгдүүлэхийн сацуу ёс зүй, эрсдэлийн соёлыг бэхжүүлэх, хөдөлмөрийн харилцааны уян хатан

зохицуулалтыг хэрэгжүүлж, ажилтны сайн сайхан байдлыг дэмжих, ажилтны эерэг туршлагыг бэхжүүлэх замаар харилцагчийн туршлагыг сайжруулан бизнесийн өсөлтийг хангахад анхаарч ажиллалаа.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд дараах чиглэлүүдэд төвлөрөн ажиллаж байна. Үүнд:

- Ажилтны эерэг туршлага
- Байгууллагын хөгжил
- Стратегийн түвшний ажиллах хүчний төлөвлөлт
- Цалин урамшуулал
- Талент удирдлага
- Чадамжид суурилсан байгууллага

## Ажилтны сайн сайхан байдал болон түүнтэй холбоотой ажлууд

ХААН Банк ажилтнуудынхаа бие махбод, сэтгэл зүй, нийгмийн сайн сайхан байдлыг дэмжих цогц бодлогыг тогтвортой хэрэгжүүлж байна. Биеийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлийг эрт илрүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг тогтмол зохион байгуулж, 2019 оноос ажилтнуудыг хувийн эрүүл мэндийн даатгалд сайн дурын үндсэн дээр хамруулж байна.

2025 онд 477 ажилтан, 50 гэр бүлийн гишүүн даатгалд хамрагдаж, бүх ажилтныг гэнэтийн ослын даатгалаар хамгааллаа. Мөн бариа заслын үйлчилгээ нэвтрүүлснээр давхардсан тоогоор нийт 6,900 гаруй үйлчилгээ үзүүлсэн байна. Сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлээр 2021 оноос сургалт, зөвлөгөө, ганцаарчилсан болон бүлгийн уулзалтыг тогтмол зохион байгуулж, 2025 онд 309 ажилтан ганцаарчилсан зөвлөгөө авч, орон нутгийн 1,800 гаруй ажилтанд цахим сургалт

хүргэлээ. Эдгээр үйл ажиллагааг хүүхэд асрах чөлөөтэй ажилтнуудад хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлдэг. Ажил-амьдралын тэнцвэрийг дэмжих хүрээнд зайнаас болон уян хатан цагаар ажиллах горимыг хэрэгжүүлж, “ХААН өдөр”, “Төрсөн өдрийн амралт”, “Гэр бүлийн амралт” зэрэг цалинтай нэмэлт амралтуудыг тогтмол олгодог. Гэр бүлд ээлтэй бодлогын хүрээнд хүүхэд харах болон хүүхэд хөхүүлэх өрөө тусгайлан ажиллуулж (2025 онд 60+ хүүхэд), Эх үрсийн баяраар 9,000 гаруй хүүхэд бэлэг гардуулан, ажилтны хүүхдийн тэтгэлэгт хөтөлбөрөөр 101 оюутанд сургалтын дэмжлэг үзүүлэв. Түүнчлэн спорт, сонирхлын 10 гаруй клуб, байгууллагын хэмжээнд 4-5 нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, ажилтнуудын идэвх оролцоо, багийн уур амьсгалыг дэмжин ажиллалаа.

## Чадамжид суурилсан байгууллага

ХААН Банк нь чадамжид суурилсан байгууллага болох зорилгын хүрээнд чадамжийн цогц системд суурилсан сургалт, хөгжлийн тогтолцоог бүрдүүлж, нийт ажилтны ур чадварын зөрүүг арилгах, ур чадвараа ахиулах, нэмэгдүүлэх (reskilling & upskilling) соёлыг эхлүүлж, Монгол Улсад болон дэлхийд өрсөлдөхүйц нарийн мэргэшсэн ажилтнуудыг улам нэмэгдүүлэх замаар Байгууллагын стратегийг хэрэгжүүлэх чадамжтай ажиллах хүчийг бий болгохыг зорин ажиллаж байна.

Банкны нийт ажилтнууд өөрийн карьер хөгжлөө төлөвлөн, шаардлагатай мэдлэг, ур чадвар, зан төлөвийг тасралтгүй сайжруулан хөгжүүлж, карьер хөгжлийнхөө эзэн нь байх боломжтой, нээлттэй карьер хөгжлийн тогтолцоог бий болгохоор бид зорьж байна. Банкны карьер хөгжлийн тогтолцоонд суурилан нийт ажилтнууд, зорилтот

талант сегмент, залгамж ажилтнууд, удирдах ажилтнуудын карьер замналд тохирох сургалт хөгжлийн бодлогыг тодорхойлох, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, тэдний одоогийн чадамжийг хөгжүүлэх, шаардлагатай шинэ чадамжийг эзэмшүүлэх замаар байгууллагын ирээдүйн чадавхыг бий болгох үндсэн зорилготойгоор банкны хэмжээний чадамжийн тогтолцоог бий болгох “Карьер хөгжлийн тогтолцоо бий болгох төсөл”-ийн үндсэн ажлуудыг гүйцэтгэн амжилттай дуусгалаа.

Энэхүү төслийн хүрээнд 2025 онд нийт ажилтны чадамжид суурилсан сургалт хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх суурь болох, “Чадамжийн үнэлгээ” хийх ажлын бэлтгэл ажлын хүрээнд системийн дэд бүтцээ бий болгон нэвтрүүлэв. Ажил үүргийн онцлог болон чадамжийн ялгаатай байдалд үндэслэн борлуулалтын ажилтнууд болон

Төв банкны ажилтнуудын чадамжийн үнэлгээг 86% гүйцэтгэлтэйгээр үнэлж дууслаа.

ХААН Банк тасралтгүй суралцах соёлыг бэхжүүлж, ажилтнуудын мэргэжлийн болон манлайллын чадамжийг системтэйгээр хөгжүүлэхэд анхааран ажиллаж байна. Тайлант онд нийт 9,055 ажилтан гадаад, дотоодын 364 удаагийн сургалтад хамрагдсан бөгөөд сургалтын 62.8% нь ажил мэргэжлийн, 35.6% нь манлайллын, 1.6% нь суурь чадамжийг дэмжсэн агуулгатай байв.

Бид дараах хөтөлбөрүүдийг үе шаттайгаар зохион байгуулж, тасралтгүй сайжруулсаар байгаа билээ.

**Excellence хөтөлбөр:** Уг хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн мэдлэг, үйлчилгээний стандарт, манлайлал, дахин мэргэшил (Data, Automation, IT) болон ажлын байран дахь коучингийг цогцоор нь хэрэгжүүлж, 46 нэгжийн 139 сургагч багш 5,190 ажилтныг хамруулаа. Үүний үр дүнд “суралцахуйн соёл” 6%-иар нэмэгдэж, байгууллагын хоёр дахь том соёл болж төлөвшсөн бөгөөд ажилтны бүтээмжийн индекс (ОPI) 80%-д хүрч, харилцагчийн сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлэв.

**Re-skilling хөтөлбөр:** Энэхүү хөтөлбөр нь технологийн өөрчлөлтөд нийцсэн өгөгдөл, автоматжуулалт, мэдээллийн технологийн үр чадварыг дотоод нөөцөөр бэлтгэж, карьер хөгжлийг дэмжсэн бол коучингийн соёлыг бэхжүүлэх хүрээнд 18 дотоод коуч багш бэлтгэж, 314 ажилтанд коучинг аргачлалаар удирдах үр чадвар олгов. Мөн Executive Coach-тэй хамтран 130 ажилтанд 1,000+ цагийн ганцаарчилсан коучинг хэрэгжүүлж, манлайллын чадамжийг гүнзгийрүүлсэн нь байгууллагын брэнд имиж, шилдэг ажил олгогчийн байр суурийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулав.

**Удирдах ажилтны манлайллын хөтөлбөр:** 939 удирдах ажилтныг 36 удаагийн 275 цагийн сургалтад хамруулж, AI ба автоматжуулалт, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, хүн төвтэй манлайллын чадамжийг хөгжүүлэв.

Түүнчлэн хүүхэд асрах болон урт хугацааны чөлөөнөөс эргэн ажилдаа орж буй ажилтнуудад зориулсан “Welcome Back” хөтөлбөр, дотоодын их, дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрөөр 31 ажилтны мэргэжил боловсролыг дэмжсэн зэрэг ажилтнуудын тогтвортой карьер хөгжлийг бодитоор ханган ажиллаж байна.

## Тасралтгүй суралцагч байгууллага

ХААН Банк нь харилцагчидтайгаа эгнэгт өсөж хөгждөг итгэл төгөлдөр банк байх алсын хараатай ажилладаг. ХААН Банк академи болон дотоодын “KB Academy” цахим платформоор дамжуулан орон зай, цаг хугацаанаас үл хамааран тасралтгүй суралцах боломж бүрдүүлж, 900 орчим цахим сургалтыг ажилтнууддаа хүргэж байна. Сүүлийн нэг жилд 42,206 удаагийн, 2025 оны IV улирлын байдлаар 32,811 удаагийн давхардсан үзэлт бүртгэгдэж, “Заавал үзэх” суурь чадамжийн хөтөлбөр 89.4%-ийн хамрагдалтад хүрсэн нь суралцах дадал байгууллагын өдөр тутмын соёл болсныг илтгэнэ.

2019 оноос дотоодын цахим сургалтаас гадна, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим сургалтын байгууллагууд болох LinkedIn Learning, Coursera, Udemy зэрэг олон улсын сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж ирсэн ба ажилтнуудаа олон улсын шилдэг тэргүүн туршлагаудас суралцах, дэлхийн түвшний мэдлэг боловсролыг эзэмших боломжийг ажилтнууддаа олгосоор байна.

Үүний нэгэн жишээ бол Coursera олон улсын цахим сургалтын байгууллагатай эхлүүлсэн хамтын ажиллагаа юм. ХААН Банк 2024 оноос хойш Coursera-тай хамтран ажиллаж, ажилтнууддаа олон төрлийн сэдвээр курс, зэрэг олгох, сертификатын хөтөлбөрүүдэд цахимаар хамрагдаж, тасралтгүй суралцах, өргөн боломжийг бүрдүүлээд байна.

ХААН Банк нь олон улсын Coursera цахим сургалтын байгууллагаас анх удаа "Talent Transformation" ангилалд анх удаа Бүс нутгийн Ялагч-аар шалгарлаа. Энэхүү шагналыг Coursera платформыг хамгийн үр дүнтэй ашиглан, ажиллах хүчээ шинэ үр чадварт сургаж, бүтээмжийг нэмэгдүүлсэн байгууллагад олгодог бөгөөд шагналыг ХААН Банкны Хүний нөөц хариуцсан дэд захирал Ш.Ганбямба Филиппин улсын нийслэл Манила хотноо зохион байгуулагдсан "Coursera Connect 2025" үйл ажиллагаан дээр гардан авсан. 8 улсын 190 гаруй төлөөлөгч оролцсон тус арга хэмжээнд ХААН Банкны тасралтгүй суралцах соёлын талаарх тэргүүн туршлагуудаа мөн хуваалцсан юм.



ХААН Банк ажилтныхаа сургалт, хөгжилд тасралтгүй анхаарч, шинэ үр чадвар олгох бодлогоор **САЛБАРТАА ТЭРГҮҮЛЖ БАЙНА.**

#### Coursera, LinkedIn, Udemy цахим сургалтын платформын үзүүлэлтүүдээс дурдвал:

- **Coursera:** 150 лицензийн хүрээнд 275 ажилтан 3061 цагийг зарцуулсан бөгөөд хамгийн өндөр үзэлтэй нь бизнес болон дата өгөгдөлтэй холбоотой хичээлүүд байна.
- **LinkedIn:** 300 лицензийн хүрээнд 427 ажилтан 2164 цагийг зарцуулсан бөгөөд хамгийн өндөр үзэлтэй нь "Цагийн менежмент", "Microsoft Excel", "Хувь хүний хөгжил" зэрэг хичээлүүд байна.
- **Udemy:** Нийт 105 идэвхтэй суралцагч 413 төрлийн сургалтад 1709 цагийг зарцуулсан байна. Нэг ажилтны дундаж хугацаа 14 цаг 44 минут байна.
- **Erdem:** 2025 онд Erdem.khanbank.com дээр мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн нийт 122 орчим цахим сургалтыг оруулаад байгаа бөгөөд сүүлийн нэг жилийн байдлаар давхардсан тоогоор 5747 удаагийн үзэлтэй байна.

# Санхүүгийн тайлан



Санхүүгийн тайлангууд болон Хараат бус аудиторын тайлан

# ХААН БАНК ХК

2025 оны 12 дугаар сарын 31

# Агуулга

Хараат бус Аудиторын Тайлан  
Ерөнхий мэдээлэл  
Товчилсон үгс

## Санхүүгийн тайлангууд

Санхүүгийн байдлын тайлан  
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй  
орлогын тайлан  
Өмчийн өөрчлөлтийн тайлан  
Мөнгөн гүйлгээний тайлан

## Санхүүгийн тайлангийн тодруулгууд

1. Танилцуулга
2. Банкны үйл ажиллагааны орчин
3. Тайлан бэлтгэх үндэслэл
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой тооцоолол, дүгнэлт
5. Шинэ буюу нэмэлт өөрчлөлт орсон стандартуудын тайлбар болон хэрэгжилт
6. Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогын мэдэгдэл
7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
8. Монголбанкинд заавал байлгах нөөц
9. Санхүүгийн хөрөнгө оруулалт
10. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр
11. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа
12. Бусад хөрөнгө
13. Үндсэн хөрөнгө
14. Биет бус хөрөнгө
15. Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөр
16. Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж
17. Репо хэлцэл
18. Харилцагчдын харилцах, хадгаламж
19. Банкнаас гаргасан үнэт цаас
20. Зээлээр авсан санхүүжилт
21. Бусад өр төлбөр
22. Хувьцаат капитал, бусад нөөц ба ногдол ашиг
23. Хүү болон түүнтэй адилтгах орлого
24. Хүү болон түүнтэй адилтгах зардал
25. Шимтгэл, хураамжийн цэвэр орлого
26. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн цэвэр олз
27. Зээлжих эрсдэлийн сан
28. Үйл ажиллагааны зардал
29. Орлогын албан татвар
30. Нэгж хувьцаанд ногдох ашиг
31. Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулга
32. Сегментийн шинжилгээ
33. Болзошгүй өр төлбөр ба үүрэг
34. Санхүүгийн эрсдэлийн удирдлага
35. Санхүүгийн хөрөнгүүд болон Санхүүгийн өр төлбөрүүдийн цэвэршүүлэлт
36. Бодит үнэ цэнийн тодруулга
37. Холбоотой талын тодруулга
38. Хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээ
39. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ
40. Тайлант хугацааны дараах үйл явдал



## Хараат бус Аудиторын Тайлан

Хаан Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь Хаан Банк ХК (“Банк” гэх)-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Банкны санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

### Бид юунд аудит хийсэн талаар

Банкны санхүүгийн тайлангууд нь дараах хэсгүүдээс бүрдсэн. Үүнд:

- 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд болон бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан санхүүгийн тайлангуудын тодруулгууд.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэж байна.

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Монгол Улс, Улаанбаатар хот  
14200, Сүхбаатар дүүрэг-8, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр,  
6 давхарт 601 тоот, Утас: +976 70009089

## Хараат бус байдал

Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат бус байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (НБЁЗОУСЗ-ийн Дүрэм)-ийн дагуу Банкнаас бид хараат бус болно. Бид НБЁЗОУСЗ-ийн дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

## Аудитын арга барил

### Хураангуй

<b>Материаллаг байдлын түвшин</b>	Банкны материаллаг байдлын ерөнхий түвшин: 43,950,000 мянган төгрөг нь тайлант жилийн татварын өмнөх ашгийн 5%-тай ойролцоо байна.
<b>Аудитын гол асуудлууд</b>	Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын сангийн тооцоолол

Аудитын төлөвлөлтийн хүрээнд бид энэхүү материаллаг байдлын түвшинг тодорхойлж, санхүүгийн тайлангуудад материаллаг буруу илэрхийлэл байх эрсдэлийг тооцоолсон. Ялангуяа тодорхой бус ирээдүйн үйл явдлын талаарх таамаглалыг агуулсан нягтлан бодох бүртгэлийн тооцоолол зэрэг удирдлагын хийсэн томоохон үнэлэлт, дүгнэлтийг харгалзан үзсэн. Бид аудитын бүх үе шатанд бусад асуудлаас гадна гүйцэтгэх удирдлагын эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих болон залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг батлах нотолгоо байгаа эсэхийг анхаарч үзсэн.

Бид Банкны бүтэц, нягтлан бодох бүртгэл хөтлөлт ба хяналт болон үйл ажиллагаа эрхэлдэг салбар зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр санхүүгийн тайлангуудыг бүхэлд нь дүгнэхэд хангалттай нотолгоо өгөхүйц байдлаар аудитын цар хүрээгээ тодорхойлсон.

### Материаллаг байдал

Бидний аудитын цар хүрээнд материаллаг байдлын түвшин нөлөөлдөг. Аудит нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд үндэслэлтэй баталгаа олж авахад зориулагдсан. Буруу тайлагнал нь алдаа эсвэл залилангаас үүсч болно. Санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц бол тэдгээрийг материаллаг гэж үзнэ.

Бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжинд тулгуурлан Банкны санхүүгийн тайлангуудад бүхэлд нь хамаарах материаллаг байдлын тодорхой тоон босго үзүүлэлтийг тогтоосныг доорх хүснэгтэнд харуулав. Эдгээрийг чанарын хүчин зүйлсийн хамт харгалзаж үзсэнээр бид аудитын хамрах хүрээ, гүйцэтгэх горимуудын шинж чанар, хугацаа, хэмжээг тогтоож буруу илэрхийлэл байгаа бол тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайлангуудад бүхэлдээ хэрхэн нөлөөлж буйг тодорхойлоход тусалдаг.

<b>Банкны материаллаг байдлын ерөнхий түвшин</b>	43,950,000 мянган төгрөг
<b>Бид хэрхэн тодорхойлсон талаар</b>	2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн татварын өмнөх ашгийн ойролцоогоор 5%
<b>Материаллаг байдлын түвшинг тооцсон үндэслэл</b>	Татварын өмнөх ашгийг бид жишиг үзүүлэлт болгон сонгосон, учир нь бидний үзэж байгаагаар энэ нь хэрэглэгчдийн хувьд Банкны үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмждэг хамгийн түгээмэл жишиг үзүүлэлт бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн жишиг үзүүлэлт юм. Бид материаллаг байдлын түвшинг татварын өмнөх ашгийн 5%-аар тогтоосон нь энэ салбарын ашиг олох зорилготой байгууллагуудад ашиглагддаг материаллаг байдлын тоон босго үзүүлэлттэй нийцэж байна.

### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их ач холбогдолтой байсан гэж бидний мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг бид санхүүгийн тайлангийн аудитынхаа хүрээнд бүхэлд нь авч үзэн дүгнэлтээ гаргасан бөгөөд тус бүрчлэн дүгнэлт гаргадаггүй болно.

## Аудитын гол асуудал

### Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын сангийн тооцоолол.

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9, Санхүүгийн хэрэглүүр (СТОУС 9)-ийн дагуу ХБЭА-ын санг тодорхойлох нь нарийн төвөгтэй бөгөөд нилээдгүй мэргэжлийн үнэлэмж шаарддаг болон харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа нь их хэмжээний үлдэгдэл дүнтэй тул харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанд тооцсон ХБЭА-ын санг аудитын гол асуудал гэж бид үзсэн. Банк ХБЭА-ын үнэлгээг тооцоолохдоо:

- зээлийн дараах төрлийн хувьд тусгайлсан суурь:
  - (i) Нийт үнийн дүн нь 2,000,000 мянган төгрөгөөс дээш дүнтэй, хугацаа нь 30 хоногоос илүү хугацаа хэтэрсэн эсвэл бүтцийн өөрчлөлт хийгдсэн зээлүүд;
  - (ii) Банкны дотоод үнэлгээний дагуу "Ажиглалтын жагсаалт"-д орсон зээлүүд, болон
- бусад бүх зээлийн хувьд бүлгийн түвшинд: ХБЭА-ыг тооцоолохдоо зээлийн эрсдэлийн ижил үзүүлэлтүүдийг (жишээ нь, чанаргүйдлийн магадлал, алдагдалд хүргэх чанаргүйдэл) зээлийн багцын ижил сегментүүдэд ашигласан.

Үнэлэмж шаардсан гол хэсэг нь:

- СТОУС 9-ийн дагуу харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг шатлалаар ангилсан байдал;
- Чанаргүйдлийн магадлал, алдагдалд хүргэх чанаргүйдэл, чанаргүйдэлд өртөх дүн болон макро эдийн засгийн хэтийн төлөвийн хувилбарууд болон тэдгээрийн магадлалын жинлэгдсэн үзүүлэлт юм.

Тодруулга 4 "Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой тооцоолол, дүгнэлт", Тодруулга 11 "Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа" болон Тодруулга 34 "Санхүүгийн эрсдэлийн удирдлага" зэрэг санхүүгийн тайлангийн тодруулгуудад эрсдэлийн алдагдлын сангийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тодруулсан.

## Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд энэхүү гол асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар

ХБЭА-ын санг үнэлэхдээ бид дараах аудитын горимуудыг хэрэгжүүлсэн: Бүх зээлийн багцтай холбоотойгоор:

- Аудиторын санхүүгийн эрсдэлийн загварчлалын мэргэжилтнүүдийн багийн оролцоотойгоор бид Банкны боловсруулсан ХБЭА-ын сангийн үнэлгээний аргачлал, загварыг СТОУС 9-ийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлсэн. Бидний гүйцэтгэсэн горимууд үндсэндээ дараах зүйлсэд чиглэгдсэн: чанаргүйдлийн тодорхойлолт, зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг тодорхойлох хүчин зүйлс, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг шатлалаар ангилах болон чанаргүйдлийн магадлал, алдагдалд хүргэх чанаргүйдэл болон чанаргүйдэлд өртөх дүн зэргийг багтаасан эрсдэлийн гол үзүүлэлтүүдийн тооцоолол.
- Хугацаа хэтэрсэн зээлүүдийг тодорхойлох хяналтын загвар болон хяналтын үйл ажиллагааны үр дүнг бид түүврийн үндсэн дээр үнэлж, шалгасан.
- Бид түүврийн үндсэн дээр зээлүүдийн сегментчлэл болон зээлүүдийн шатлалын ангиллыг шалгасан.
- Бид макро эдийн засгийн хэтийн төлөв, тэдгээрийн магадлалын жинлэлтийг ХБЭА-ын түвшинд хэрхэн нөлөөлөх талаарх Банкны үнэлгээг ерөнхийд нь шалгаж, тухайлан эдийн засгийн олон хувилбарт жинлэгдсэн үзүүлэлтүүдтэй холбоотой болон таамагласан макро эдийн засгийн хувьсагчдыг (ДНБ, бодлогын хүү, ажилгүйдлийн түвшин, валютын ханшийн өөрчлөлт, болон малчны зээлийн багцын хувьд малын хорогдлын хувь гэх мэт) гадны эх сурвалж дахь мэдээлэлтэй тулган, ашиглагдсан загварын зохистой эсэхийг шалгасан;
- Бид зээлдэгчдийн үйл ажиллагаагаа явуулж буй сегмент болон зээлийн шатлалын хувьд ХБЭА-ын тооцоололд дүн шинжилгээний горимыг гүйцэтгэсэн.

Тусгайлан үнэлсэн зээлийн багцын ХБЭА-ын хувьд:

- Барьцаа хөрөнгөд тулгуурлан тусгайлан үнэлсэн зээлүүдийн хувьд ХБЭА-ын тооцоололд харгалзан үзсэн барьцаа хөрөнгийн үнэлгээг бид түүврийн үндсэн дээр шалгаж үнэлсэн.
  - Мөнгөн урсгалд тулгуурлан тусгайлан үнэлсэн зээлүүдийн хувьд, бид түүвэрт үндэслэн Банкны үндсэн таамаглалын олон хувилбаруудаас тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалаас эргэн төлөгдөх дүнгийн үндэслэлтэй байдлыг үнэлсэн.
  - Бид ашиглагдсан хувилбаруудын хамаарал, тэдгээрийн магадлалыг үнэлж, мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг дахин тооцоолсон. Үүний тулд бид Банкны зээлдэгчдийн үйл ажиллагаа явуулж буй салбар болон эдийн засгийн хандлагыг авч үзсэн.
- Бүлгийн түвшинд үнэлсэн зээлийн багцын ХБЭА-ын хувьд:
- Бид ХБЭА-ын тооцоололд ашигласан түүхэн өгөгдөл (чанаргүйдлийн магадлал, эргэн төлөгдөх хувь) болон тайлагналын өдрөөрх өгөгдөлийн (чанаргүйдэлд өртөх дүн болон зээлийн шатлал) үнэн зөв эсэхийг түүврийн үндсэн дээр шалгасан. Ингэхдээ бид мэдээллийг эх баримттай нь, жишээ нь: зээлийн гэрээ, барьцааны гэрээ болон зээлийн дансны хуулга зэрэгтэй тулгах замаар гүйцэтгэсэн.
  - Бид түүврийн үндсэн дээр ХБЭА-ын математик тооцооллын үнэн зөв байдлыг шалгасан.

Мөн бид Банкны санхүүгийн тайлангуудын тодруулгуудын хангалттай бөгөөд зохистой байдлыг үнэлсэн.

## Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг харуцлагыг хүлээнэ. Энэхүү аудиторын тайланг гаргах өдрөөс хойш бид хүлээн авахаар хүлээгдэж буй бусад мэдээлэл гэдэгт 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны Жилийн тайланг (үүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан хамаарахгүй болно) орно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргахгүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбоотойгоор бидний хүлээх үүрэг хариуцлага нь дээр дурдсан бусад мэдээллийг уншиж танилцах бөгөөд ингэхдээ бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг зөрүүтэй эсвэл ямар нэг байдлаар материаллаг буруу илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж үзэх юм.

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны Жилийн тайланг уншиж танилцах үед хэрэв бид энэхүү бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл засаглах эрх бүхий этгээдэд энэ талаар тайлагнах үүрэгтэй.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Банк үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвартай эсэхийг үнэлэх, шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхтэй холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулах, Банкийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй болсноос бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### **Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах, мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаа гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл бүрийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба эдгээр нь тус бүртгээ эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхүйц байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх явцдаа бид мэргэжлийн үнэлэмжүүдийг гаргадаг ба аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас ханддаг. Мөн бид:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэл байх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон эрх мэдлээ ашиглан дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдийг агуулсан байдаг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр нөлөөг дүгнэх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой мөрдсөн эсэх, мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн, үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх Банкны чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэсэн үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэдэг. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулгыг хангалтгүй гэж үзвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлага гардаг. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоондоо үндэслэн бид дүгнэлт өгдөг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Банк тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болоход хүргэж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг үнэлдэг ба холбогдох ажил гүйлгээ болон үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид төлөвлөсөн аудитын ажлын хамрах хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдол болон бусад асуудлуудыг багтаагаад аудитын томоохон илрүүлэлтийн талаар засаглах эрх бүхий этгээдтэй харилцдаг.

Бид мөн хараат бус байдалд тавигдах ёс зүйн хэм хэмжээнд хэрхэн нийцэж ажилласан, хараат бус байдал алдагдах үндэслэлтэй эргэлзээ төрүүлэхүйц бүхий л харилцаа болон бусад бүхий л хүчин зүйлсийн талаар, шаардлагатай нөхцөлд тэдгээрээс хараат бус байдлыг хэрхэн хамгаалах арга хэмжээг авч ажилласан мэдэгдлийг засаглах эрх бүхий этгээдэд гаргаж өгдөг.

Засаглах эрх бүхий этгээдтэй харилцсан асуудал дотроос тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудлуудыг тодруулж, тэдгээрийг аудитын гол асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж, дүрэм журамд аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл аудиторын тайланд тухайн асуудлыг мэдээлснээр үүсэх сөрөг үр дагавар нь түүнийг мэдээлснээр олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү гэж үзэх нэн ховор тохиолдлоос бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тусгадаг.

Энэхүү хараат бус аудиторын тайланг гаргаж буй аудитын гэрээт ажлын партнер нь Айгуль Ахметова болно.

Баталсан:

Айгуль Ахметова

Партнер

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Гарын үсэг зурсан:



ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот

2026 оны 3 сарын 10-ны өдөр

# Ерөнхий мэдээлэл

## ТУЗ-ийн гишүүд

---

Түдэвийн Дарьбум  
Дашдаваагийн Хулан  
Харада Ясүнари  
Цагаачийн Баатарсайхан  
Кисабүро Иший  
Жон Ло  
Батболдын Амарсанаа  
Ханс Аарт Йонгеганс  
Амарбаясгалангийн Тамир

## Нарийн бичгийн дарга

---

Ванчиндоржийн Янжинлхам

## Албан ёсны хаяг

---

ХААН Банк Цамхаг  
Чингисийн өргөн чөлөө 6,  
Стадион Оргил - 1, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот - 17010,  
Монгол Улс

## Аудиторууд

---

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

# Товчилсон үгс


Энэхүү Санхүүгийн тайланд товчилсон үгсийн дараах хэв маягийг ашигласан болно:

ХӨ	Хорогдуулсан өртөг
МБ	Монголбанк
ХБЭА	Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал
ҮАХА	Үр ашигт хүүгийн аргачлал
ЧӨД	Чанаргүйдэлд өртөх магадлал
БДОБҮЦ	Бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх бодит үнэ цэнэ
ААБҮЦ	Ашиг, алдагдлаар бүртгэгдэх бодит үнэ цэнэ
БҮЦ	Бодит үнэ цэнэ
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ЖЗХШ	Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл
АХЧ	Алдагдалд хүргэх чанаргүйдэл
НХХБЭА	Нийт хугацааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал
МИК	Монголын ипотекийн корпораци
ТӨГ	Монгол Төгрөг
БДО	Бусад дэлгэрэнгүй орлого
ЧМ	Чанаргүйдлийн магадлал
ХАҮҮЦБ	Худалдаж авсан болон үүссэн үнэ цэнийн бууралт
ЭХТ	Эрсдэлгүй хүүгийн түвшин
ИЗББ	Ипотекийн зээлээр баталгаажсан бонд
АЭХ	Ашиглах эрхтэй хөрөнгө
НХӨ	Нийт хөрөнгийн өгөөж
ӨХӨ	Өөрийн хөрөнгийн өгөөж
ЗЭМӨ	Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт
ЗҮТХТ	Зөвхөн үндсэн төлбөр ба хүүгийн төлбөр
ҮЦСК	Үнэт цаасны санхүүжилтийн корпорац
12 сарын ХБЭА	12 сарын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал
ОТХБ	Олон талт хөгжлийн банк
КВС	Кросс валютын своп
БЖДҮ	Бичил, жижиг дунд үйлдвэр
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
СЯ	Сангийн яам

## Санхүүгийн Байдлын Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7	6,193,900,379	5,470,343,139
Монголбанкинд заавал байлгах нөөц	8	2,196,500,542	1,635,209,857
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж		269,155	7,004,654
Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	9	1,058,477,421	1,270,284,125
Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	9	6,263,389	4,509,664
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	10	84,410,715	29,950,355
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	11	13,534,112,172	11,195,929,984
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт		168,976	168,976
Орлогын албан татварын урьдчилгаа	29	37,769,243	-
Бусад хөрөнгө	12	249,954,249	180,965,856
Биет бус хөрөнгө	14	37,582,954	34,377,217
Ашиглах эрхтэй хөрөнгө	15	12,946,570	14,096,706
Үндсэн хөрөнгө	13	529,527,885	459,469,587
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		425,627	414,488
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>23,942,309,277</b>	<b>20,302,724,608</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	16	340,306,601	88,910,731
Репө хэлцэл	17	65,803,113	87,791,865
Харилцагчдын харилцах, хадгаламж	18	15,767,774,030	14,202,469,957
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	10	19,497,207	-
Банкнаас гаргасан үнэт цаас	19	787,972,774	758,617,294
Зээлээр авсан санхүүжилт	20	3,908,079,003	2,485,410,252
Орлогын албан татварын өглөг	29	-	8,915,881
Хойшлогдсон татварын өр төлбөр	29	35,084,051	10,898,887
Түрээсийн өр төлбөр	15	14,318,036	15,219,265
Бусад өр төлбөр	21	178,634,654	179,832,227
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>21,117,469,469</b>	<b>17,838,066,359</b>
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>			
Энгийн хувьцаа	22	191,219,800	191,219,800
Нэмж төлөгдсөн капитал	22	164,257,808	164,257,808
Хуримтлагдсан ашиг		2,342,390,788	2,018,390,804
Бусад нөөц	22	126,971,412	90,789,837
<b>НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>2,824,839,808</b>	<b>2,464,658,249</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>23,942,309,277</b>	<b>20,302,724,608</b>

2026 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Банкны удирдлагыг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.

	<p><b>ДАРЬБУМ</b> Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга</p> <p><b>ШӨЛЗИЙ-АЮУШ</b> Санхүү хариуцсан дэд захирал</p>	<p><b>Р.МӨНХТУЯА</b> Гүйцэтгэх захирал</p> <p><b>Н.БААСАНЦЭЭ</b> Санхүүгийн удирдлагын газрын захирал</p>
-------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------

Санхүүгийн тайлангийн 8-106 дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025	2024
Үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолсон хүүгийн орлого	23	2,747,658,818	2,377,864,779
Бусад адилтгах хүүгийн орлого	23	52,854,689	46,615,805
Хүүгийн зардал	24	(1,327,865,920)	(1,124,484,248)
Бусад адилтгах хүүгийн зардал	24	(90,982,736)	(40,328,027)
<b>Хүү болон түүнтэй адилтгах орлогын цэвэр ашиг</b>		<b>1,381,664,851</b>	<b>1,259,668,309</b>
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	27	(92,631,816)	(118,630,102)
<b>Зээлжих эрсдэлийн сангийн зардлын дараах хүү болон түүнтэй адилтгах орлогын цэвэр ашиг</b>		<b>1,289,033,035</b>	<b>1,141,038,207</b>
Хураамж, шимтгэлийн орлого	25	322,615,217	302,874,458
Хураамж, шимтгэлийн зардал	25	(81,140,252)	(72,185,651)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн цэвэр олз/(гарз)	26	1,060,877	(590,113)
Гадаад валютын арилжааны олз		29,063,839	32,034,569
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн гарз		(284,246)	(2,050,213)
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн олз		2,351,901	2,449,196
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн олз		7,140,365	-
Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр олз		4,429,952	3,650,890
Үйл ажиллагааны бусад орлого		1,392,875	6,650,412
Үйл ажиллагааны зардал	28	(691,883,021)	(582,553,152)
Бусад гарз, цэвэр дүнгээр		(4,733,954)	(1,387,119)
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>879,046,588</b>	<b>829,931,484</b>
Орлогын албан татварын зардал	29	(184,199,371)	(191,417,028)
<b>Тайлант жилийн ашиг</b>		<b>694,847,217</b>	<b>638,514,456</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд дахин ангилагдах зүйлс:</i>			
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт:			
Дахин үнэлгээний цэвэр олз		4,593,938	7,261,054
Худалдан борлуулснаас ашиг, алдагдалд дахин ангилсан цэвэр гарз		(2,351,901)	(2,449,196)
Мөнгөн гүйлгээний хейджийн нөөц		(5,532,080)	2,881,367
Бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэгдсэн орлогын татвар		822,511	(1,923,306)
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд дахин ангилагдахгүй зүйлс:</i>			
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнэ хэмжигдэх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний цэвэр гарз			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, татвар хассан цэвэр дүн		41,375,710	-
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>38,882,221</b>	<b>5,424,255</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>733,729,438</b>	<b>643,938,711</b>
<b>Банкны нэгж хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан ашиг</b> (нэгж хувьцааны хувьд төгрөгөөр илэрхийлэгдсэн)	30	363	334

Санхүүгийн тайлангийн 8-106 дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	БДОБҮЦ-ээр хэмжигдэх үнэт цаасны дахин үнэлгээний нөөц	Мөнгөн гүйлгээний хейджийн нөөц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эзэмшигчдийн өмч
<b>2024 оны 1 сарын 1-ний дүн</b>	<b>191,219,800</b>	<b>164,257,808</b>	<b>3,766,689</b>	<b>(2,729,982)</b>	<b>86,182,453</b>	<b>1,649,038,593</b>	<b>2,091,735,361</b>
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	638,514,456	638,514,456
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	3,263,230	2,161,025	-	-	5,424,255
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3,263,230</b>	<b>2,161,025</b>	<b>-</b>	<b>638,514,456</b>	<b>643,938,711</b>
Ногдол ашиг (Тодруулга 22)	-	-	-	-	-	(271,015,823)	(271,015,823)
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	(1,853,578)	1,853,578	-
<b>2024 оны 12 сарын 31-ний дүн</b>	<b>191,219,800</b>	<b>164,257,808</b>	<b>7,029,919</b>	<b>(568,957)</b>	<b>84,328,875</b>	<b>2,018,390,804</b>	<b>2,464,658,249</b>
<b>2025 оны 1 сарын 1-ний дүн</b>	<b>191,219,800</b>	<b>164,257,808</b>	<b>7,029,919</b>	<b>(568,957)</b>	<b>84,328,875</b>	<b>2,018,390,804</b>	<b>2,464,658,249</b>
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	694,847,217	694,847,217
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	1,655,571	(4,149,060)	41,375,710	-	38,882,221
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1,655,571</b>	<b>(4,149,060)</b>	<b>41,375,710</b>	<b>694,847,217</b>	<b>733,729,438</b>
Ногдол ашиг (Тодруулга 22)	-	-	-	-	-	(373,547,879)	(373,547,879)
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	(2,700,646)	2,700,646	-
<b>2025 оны 12 сарын 31-ний дүн</b>	<b>191,219,800</b>	<b>164,257,808</b>	<b>8,685,490</b>	<b>(4,718,017)</b>	<b>123,003,939</b>	<b>2,342,390,788</b>	<b>2,824,839,808</b>

Санхүүгийн тайлангийн 8-106 дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025	2024
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>879,046,588</b>	<b>829,931,484</b>
Татварын өмнөх ашгийн цэвэр мөнгөн урсгалд тохируулагдсан тохируулгууд:			
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	<b>26</b>	(1,060,877)	590,113
Хүлээгдэж буй эрсдэлийн сангийн зардал	<b>27</b>	92,631,816	118,630,102
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтаас үүссэн цэвэр буцаалт		(205,264)	(1,296,402)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	<b>28,13</b>	61,573,808	59,253,010
Биет бус хөрөнгийн хорогдуулалт	<b>28,14</b>	14,181,521	14,947,797
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	<b>28,15</b>	10,516,150	9,834,378
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	<b>13</b>	441,977	405,571
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	<b>14</b>	-	2,027,815
Үндсэн хөрөнгө борлуулсны цэвэр гарз		482,044	7,986
Бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө борлуулсны цэвэр (олз)		(2,351,901)	(2,449,196)
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны цэвэр гарз		-	27,851
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаас борлуулсны олз		(7,140,365)	-
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр олз		(4,429,952)	(3,650,890)
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр гарз		284,246	2,050,213
Хүү болон түүнтэй адилтгах орлого	<b>23</b>	(2,800,513,507)	(2,424,480,584)
Хүү болон түүнтэй адилтгах зардал	<b>24</b>	1,401,849,114	1,164,812,275
<b>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ</b>		<b>(354,694,602)</b>	<b>(229,358,477)</b>
Цэвэр (өсөлт)/бууралт:			
- Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц		(561,510,654)	(559,315,826)
- Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		(2,657,352,262)	(2,328,550,360)
- Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж		6,520,000	6,519,999
- Бусад хөрөнгө		(83,986,994)	(93,298,564)
- Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх өрийн үнэт цаас		216,052,700	99,511,200
Цэвэр өсөлт/(бууралт):			
- Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж		245,579,713	(139,081,070)
- Харилцагчдын харилцах, хадгаламж		1,502,434,034	1,759,431,901
- Бусад өр төлбөр		4,995,405	(18,854,658)
<b>Татвар болон хүүгийн зардлын өмнөх үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(1,681,962,660)</b>	<b>(1,502,995,855)</b>
Хүлээн авсан хүү		2,778,248,615	2,398,608,437
Төлсөн хүү		(1,315,945,965)	(1,080,973,866)
Орлогын албан татварын төлөлт	<b>29.3</b>	(246,869,480)	(209,632,612)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(466,529,490)</b>	<b>(394,993,896)</b>

Санхүүгийн тайлангийн 8-10б дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025	2024
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Өмчийн үнэт цаасны худалдан авалт		(1,788,335)	-
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг борлуулсны орлого		-	86,762
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт	9	(305,340,959)	(528,452,263)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаасны борлуулалтын орлого	9	299,571,106	265,605,748
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт	9	(68,296,190)	(124,917,514)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого	9	392,551,375	731,545,294
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		1,055,277	394,254
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	13	(55,063,174)	(66,837,683)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	14	(17,387,258)	(7,823,535)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>245,301,842</b>	<b>269,601,063</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
РЕПО хэлцлээс орж ирсэн орлого	31	2,528,791,392	839,494,046
РЕПО хэлцлийн эргэн төлөлт	31	(2,553,480,741)	(811,873,401)
Зээлээр авсан санхүүжилтээс орж ирсэн орлого	31	2,254,183,559	894,136,139
Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт	31	(909,382,998)	(535,069,802)
Банкнаас гаргасан өрийн үнэт цаасны орлого	31	56,952,675	526,865,000
Банкнаас гаргасан өрийн үнэт цаасны урьдчилгаа	31	(30,295,543)	-
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт	31	(10,191,318)	(9,437,574)
Төлсөн ногдол ашиг	22	(373,547,879)	(271,015,823)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>963,029,147</b>	<b>633,098,585</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(18,356,443)	5,669,549
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлжих эрсдэлийн сангийн өөрчлөлтийн нөлөө	7	112,184	(759,236)
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт</b>		<b>723,557,240</b>	<b>512,616,065</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7	5,470,343,139	4,957,727,074
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7</b>	<b>6,193,900,379</b>	<b>5,470,343,139</b>

Санхүүгийн тайлангийн 8-106 дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## 1. Танилцуулга

ХААН Банк ХК ("Банк") нь Монголбанк("МБ")-аас олгосон 2 тоот зөвшөөрлийн дагуу Банк, санхүүгийн үндсэн үйлчилгээг 2006 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс хойш үзүүлж байна. Банкны хүчин төгөлдөр дүрмийн дагуу Банкны үндсэн үйл ажиллагаа нь:

- Мөнгөн хадгаламж,
- Төлбөр тооцооны үйлчилгээ;
- Гуравдагч этгээдэд өөрийн нэр дээр баталгаа, батлан даалт гаргах;
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, байршуулах;
- Үнэт металл, үнэт чулуу худалдах, худалдан авах, хадгалах, байршуулах;
- Үнэт зүйл хадгалах;
- Гадаад гуйвуулгын үйлчилгээ;
- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ;
- Зээл болон бусад санхүүгийн хэрэглүүрийг худалдах, худалдан авах;
- Даатгалын зуучлал (борлуулалтын агент)-ын үйлчилгээ;
- Тодорхой үнэт цаасны бүртгэл;
- Кастодиан банкны үйлчилгээ;
- Факторингийн үйлчилгээ болон
- Хууль эрх зүйн хүрээнд зөвшөөрөгдсөн санхүүгийн бусад үйлчилгээ болон Монголбанкны дүрэм журам зэрэг холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн, Монголбанк болон СЗХ-оос зохих ёсоор зөвшөөрөгдсөн санхүүгийн бусад үйлчилгээ.

Банк нь Монгол Улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг. Банк нь Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани юм. Банкны төв байрны албан ёсны хаяг нь ХААН банк цамхаг, Чингисийн өргөн чөлөө 6, Стадион Оргил-1, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот - 17010, Монгол Улс байна.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны том хувьцаа эзэмшигч нь Токиогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Эйч Эс Холдингс Лимитед Компани юм. Таван Богд Холдингс ХХК нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны нийт гаргасан хувьцааны 20%-аас илүү хувийг эзэмшдэг цорын ганц бусад нөлөө бүхий хувьцаа эзэмшигч юм. Тодруулга 22-ыг харна уу.

## 2. Банкны үйл ажиллагааны орчин

Монгол Улс харьцангуй өндөр инфляци, зээлийн хүү зэрэг хөгжиж буй зах зээлийн олон шинж чанарыг агуулдаг. Эдийн засаг нүүрс, зэс голчлон экспорд давамгайлсан хэвээр байгаа бөгөөд энэ нь ашигт малтмалын ихээхэн нөөцтэй, үйлдвэржилт хязгаарлагдмал байгааг илэрхийлнэ. ДНБ-ий өсөлт 6.4% (2024: 4.9%) байсан нь дараалсан хоёр жилийн хүнд өвлийн нөхцөл буюу зудны дараах хөдөө аж ахуйн салбарын сэргэлттэй холбоотой. Хятад улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын бууралтын үр дүнд нүүрсний экспортын орлого буурсан боловч зэсийн экспортын өсөлт энэхүү алдагдлыг хэсэгчлэн нөхсөн.

2025 оны 10 сарын 30-ны өдөр Стандарт энд Пүүрс, эрсдэлийн зэрэглэл тогтоох үнэлгээний байгууллага Монгол Улсын зээлжих зэрэглэлийг урт хугацаат эерэг төлөвтэй "BB-" болгон дээшлүүлсэн. 2025 оны 10 сарын 16-ны өдөр Мүүдис үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг тогтвортой төлөвтэй "B1" болгон дээшлүүлсэн. 2025 оны 9 сарын 1-ний өдөр Фитч үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг тогтвортой төлөвтэй "B+" болгон дээшлүүлсэн.

2025 онд Монголбанк бодлогын хүүгээ 2025 оны 3 сард 10%-аас 12% болгож нэмсэнээс хойш өөрчлөөгүй. (2025 оны 12 дугаар сарын 31: 12%, 2024 оны 12 дугаар сарын 31: 10%).

Инфляцийн түвшин 2025 оны 2 сард 9.6%-д хүрч, хурдацтай өссөн нь голчлон цахилгаан эрчим хүчний үнийн нэмэгдэл болон хүнсний бүтээгдэхүүний үнийн нэмэгдэлтэй холбоотой. Гэвч мөнгөний бодлогыг чангаруулах нөлөө илүү тодорч, эдгээр үнийн өсөлтийн нөлөө аажмаар буурснаар 2025 оны эцэст инфляци 7.5 %-д хүртэл буурсан байна.

Мөн ОХУ-Украин улсын мөргөлдөөн үргэлжилсэн хэвээр байгаа тул Банк нь ОХУ-ын банкуудад байршуулсан хөрөнгө болон ОХУ-ын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд шаардлагатай арга хэмжээг авч, хориг арга хэмжээний жагсаалт, хяналт шалгалтын системийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Тулгарч буй энэхүү байдал үргэлжилсээр байвал энэ нь газрын тос болон бусад түүхий эдийн үнийг нэмэгдүүлж инфляцийн түвшинг өсгөж болзошгүй бөгөөд энэ нь хүүгийн түвшинг өндөр хэвээр байлгах нөхцөл болох ба дэлхий даяарх тодорхойгүй байдал санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж дотоодын мөнгөний ханшийн нөхцөл байдалд нөлөөлж болно.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал ("ХБЭА")-ыг тооцоолоход Банк макро эдийн засгийн хувьсагчдын таамаглалыг багтаасан ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигладаг. Гэхдээ аливаа эдийн засгийн урьдчилсан мэдээний нэгэн адил тэдгээрийн гарах төсөөлөл, магадлал нь тодорхойгүй байдлын өндөр түвшинд байдаг тул бодит үр дүн нь төсөөлж байснаас эрс ялгаатай байж болно. Тодруулга 4 болон 34-д Банк ХБЭА-ын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллийг хэрхэн ашигласан талаар дэлгэрэнгүй толилуулсан.

### 3. Тайлан бэлтгэх үндэслэл

Банк эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн стандарт")-ын дагуу бэлтгэн гаргасан.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр нь анх хүлээн зөвшөөрөх, мөн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ ("ААБҮЦ")-ээр болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ ("БДОБҮЦ")-ээр бүртгэгдэх үндсэн хөрөнгө, санхүүгийн хэрэглүүрийг дахин үнэлэх замаар өөрчилсөн түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг доор толилуулав. Эдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг өөрөөр зааснаас бусад тохиолдолд бүх тайлант жилүүдэд тасралтгүй мөрдөж ирсэн.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь удирдлагын хувьд зөвхөн үндсэн хэрэглэгчдэд чухал гэж үзсэн мэдээллийг тусгахад чиглэсэн. Удирдлагын зүгээс материаллаг бус мэдээллийг материаллаг мэдээллээр халхлан эдгээр санхүүгийн тайлангуудыг ойлгомжтой байдлыг бууруулахгүй байхыг зорьдог. Иймээс зөвхөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын хувьд материаллаг гэж үзсэн нөхцөлд холбогдох тодруулгад тусгана.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Банкны үйл ажиллагааны бүртгэлийн мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр толилуулагдсан бөгөөд өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүд мянгалчлан илэрхийлэгдсэн.

**Санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын дарааллаар танилцуулах.** Банк нь тодорхой тодорхойлсон үйл ажиллагааны мөчлөггүй тул санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг тусад нь толилуулдаггүй. Үүний оронд хөрөнгө, өр төлбөрийг хөрвөх чадварын дарааллаар толилуулдаг. Санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг Тодруулга 34-өөс харна уу. Тодруулга 34-д шинжилгээ хийгдээгүй зүйлсийн хувьд тайлант үеэс өмнөх болон дараах 12 сарын хугацаанд нөхөгдөх буюу барагдуулахаар хүлээгдэж буй төлбөрийн талаарх мэдээллийг Тодруулга 38-аас харна уу.

**Санхүүгийн тайланг гаргасны дараа нэмэлт өөрчлөлт оруулах.** Банкны хувьцаа эзэмшигчид болон удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг гаргасны дараа нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

### 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой тооцоолол, дүгнэлт

Банк санхүүгийн тайлангуудаа бэлтгэн гаргахдаа удирдлагаас орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн тайлагнасан дүн, тэдгээрийн дагалдах тодруулга, түүнчлэн болзошгүй өр төлбөрийн талаарх тодруулгад нөлөөлөхүйц дүгнэлт, тооцоолол, таамаглал хийхийг шаарддаг. Эдгээр таамаглал болон тооцооллын тодорхой бус байдал нь ирээдүйн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулга хийх шаардлагатай үр дүнд хүргэж болзошгүй. Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад удирдлага дараагийн санхүүгийн жилд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулга хийх мэдэгдэхүйц эрсдэл бүхий ирээдүйн болон тайлант өдрийн тооцооллын тодорхой бус байдлын бусад гол эх үүсвэрүүдийн талаар дүгнэлт, таамаглалыг гаргасан. Тодруулга 4.1 болон Тодруулга 4.9-ийг харна уу.

Одоо байгаа нөхцөл байдал болон ирээдүйн хөгжлийн талаарх таамаглал нь Банкны хяналтаас үл хамаарах нөхцөл байдлын улмаас өөрчлөгдөж болох бөгөөд тэдгээр нь тохиолдсон үед таамаглалд тусгагдсан болно. Удирдлагын томоохон дүгнэлт/тооцоолол бүхий санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнд хамгийн их нөлөө үзүүлдэг зүйлсийг холбогдох дүгнэлт/тооцооллын дагуу доор нэгтгэн харууллаа.

#### 4.1. Бизнес загварын үнэлгээ

Банк бизнесийн зорилгодоо хүрэхийн тулд санхүүгийн хөрөнгийг хамгийн үр дүнтэйгээр удирдах түвшинд бизнес загвараа тодорхойлно.

Банкны бизнес загвар нь хэрэглүүрийн түвшинд биш нийлмэл багцын түвшинд хянагддаг ба дараах ажиглагдахуйц хүчин зүйлсээс хамаарна:

- Бизнес загварын үнэлгээ болон тухайн бизнес загварт хамрагдаж буй санхүүгийн хөрөнгийг хэрхэн үнэлэгдэж байгааг Банкны эрх бүхий албан тушаалтнуудад тайлагнадаг
- Бизнес загвар (тухайн бизнес загварт хамрагдах санхүүгийн хөрөнгө)-ын гүйцэтгэлд нөлөөлж буй эрсдэл ба эдгээр эрсдэлийг хэрхэн удирдах аргачлал
- Байгууллагын удирдлагуудад хэрхэн урамшуулал олгодог (жишээ нь, урамшуулал нь хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл гэрээний цуглуулсан мөнгөн урсгалд үндэслэдэг эсэх)

Борлуулалтын хүлээгдэж буй давтамж, үнэ цэнэ ба хугацаа нь Банкны үнэлгээг хийхэд чухал хүчин зүйлс болдог.

Бизнес загварын үнэлгээ нь хамгийн боломжит хувилбарт үндэслэдэг ба 'хамгийн муу' эсвэл 'стресс' нөхцөлүүдийг харгалзан үздэггүй. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах мөнгөн урсгал нь анх таамагласан хүлээлтээс өөр байвал Банк тухайн бизнес загварт хамааралтай санхүүгийн хөрөнгийн ангиллыг солихгүй бөгөөд харин тухайн мэдээллийг шинээр санхүүгийн хөрөнгө худалдаж авах үед үнэлгээндээ оруулан үздэг.

Банкны өрийн үнэт цаасны ойролцоогоор 71%-ийг (2024 оны 12 дугаар сарын 31: 53%) хөрвөх чадвартай багц гэж тодорхойлж, цуглуулах ба борлуулах зорилгоор эзэмшиж байгаа гэж ангилсан бол үлдсэн өрийн үнэт цаасыг хугацаа дуустал эзэмших буюу цуглуулах зориулалттай гэж ангилсан. Эдгээр үнэт цаасыг зөвхөн стресс буюу хямралын үед борлуулна.

Банк нь Монголын Ипотекийн Корпорацид худалдах зээлийн багц болон Үнэт Цаасны Санхүүжилтын Корпорацид зарагдах Жижиг Дунд үйлдвэрийн зээлийн багцаас бусад ашиг, алдагдлаар бүртгэгдэх бодит үнэ цэнэд ангилагддаг бүх төрлийн зээлийн багцаа гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилготой бизнесийн загварт тавигдсан шалгуурт нийцнэ гэж дүгнэсэн.

#### 4.2. Мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрдэж буй эсэх үнэлгээ (ЗҮТХТ)

Санхүүгийн хэрэглүүрийн ангиллын хоёр дахь шат бол Банк ЗҮТХТ-ийн шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөлийг дүгнэдэг. Энэхүү шалгуурын хүрээнд 'Үндсэн' гэдэг нь анхны хүлээн зөвшөөрөх үеийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бөгөөд санхүүгийн хөрөнгийн ашиглах хугацааны туршид өөрчлөгдөж болно (жишээ нь, үндсэн төлбөрийн эргэн төлөлт эсвэл урамшуулал/хөнгөлөлтийн хорогдуулалт).

Зээлийн гэрээн дэх хүүгийн хамгийн гол үзүүлэлт нь мөнгөний өнөөгийн үнэ цэнэ болон зээлийн эрсдэл байдаг. ЗҮТХТ-ийн үнэлгээг хийхийн тулд Банк санхүүгийн хөрөнгийг ямар валютаар илэрхийлсэн, хүүгийн түвшнийг тогтоосон хугацаа гэх мэт холбогдох хүчин зүйлс, үнэлэмжийг авч үздэг.

Нөгөө талаас, эрсдэлийг хариуцах магадлал багатай гэрээний заалт эсвэл үндсэн зээлийн зохицуулалттай холбоогүй гэрээний мөнгөн гүйлгээний тогтворгүй байдал зэрэг нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл дүнгийн гэрээний мөнгөн гүйлгээнд нөлөөлөхгүй. Ийм тохиолдолд санхүүгийн хөрөнгө нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ (ААБҮЦ)-ээр бүртгэгдэнэ.

ЗҮТХТ-ийн шалгуурт тэнцээгүй хэрэглүүрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ (ААБҮЦ)-ээр хэмждэг бөгөөд энэ нь Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд Ипотекийн зээлийн хөтөлбөр болон репо хэлцлийн хүрээнд хэрэгжиж буй санхүүгийн хэрэглүүртэй холбоотой.

#### 4.3. Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ)

Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд Банк тайлант өдрийн эцэст санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацаанд үүсэх эрсдэлийг анх хүлээн зөвшөөрсөн өдрийн эрсдэлтэй харьцуулна. Үнэлгээгээр тайлант үеийн эцэст тодорхой нэг зээлийн эрсдэлийн түвшинд хүрэхээс илүү зээлийн эрсдэлийн харьцангуй өсөлтийг нь авч үздэг. Банк хэт их зардал, хүчин чармайлт гаргалгүйгээр бүхий л боломжит ашиглаж болохуйц бэлэн байгаа ирээдүйд чиглэсэн мэдээллийг авч үздэг.

Банк хугацаа хэтрүүлэхээс өмнөх зээлийн эрсдэлийн өсөлтийг харуулсан төлөв байдлын үзүүлэлтүүдийг тодорхойлж, зээлийн эрсдэлийн үнэлгээнд тусгайлсан болон бүлгийн түвшинд тохирсон ирээдүйн мэдээллийг тусгадаг. Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг тодорхойлохын тулд удирдлага үнэлгээнд үндэслэн тодорхой шалгуурыг авч үздэг. Тэдгээр шалгуур нь:

- Байгууллагын зээлийн хувьд 30 хоногоор хугацаа хэтэрсэн, иргэний зээлийн хувьд 15 хоногоор хугацаа хэтэрсэн
- Чанаргүйдлийн магадлалд орох томоохон өөрчлөлт
- Гэрээний бүтцэд өөрчлөлт орсон зээл
- Монголбанкны “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-ын дагуу зээлийн эрсдэлийн ангилал нь “Анхаарал хандуулах” гэж ангилагдсан
- Зээлийн эрсдэлээс урьдчилан сэрэмжлүүлэх үйл ажиллагааны журмын дагуу “Анхаарах зээл”-д ангилагдсан зээл
- Салбар болон бүс нутгийн төвлөрлийн эрсдэлд өртөх магадлалтай гэж үзсэн эдийн засгийн салбар
- Хэрэв зээлдэгчийн бусад зээл чанаргүйдсэн, онцгой нөхцөл байдлууд эсвэл дээрх ЗЭМӨ шалгуурыг хангасан бол.

Хэрэв харилцагчдад олгосон бүх зээл, урьдчилгаа төлбөрийг нийт хугацааны ХБЭА-ын нөөц сан (шатлал 1-ийн 12 сарын ХБЭА-аар тооцогдсон)-аар тооцох бол хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сан нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 130,196,378 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 119,871,582 мянган төгрөгөөр их байсан)-өөр их байна.

#### 4.4. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт нь аргачлал, загвар болон өгөгдлийн орц зэрэг сонголтыг өөртөө багтаадаг чухал тооцоолол юм. Дараах бүрэлдэхүүн хэсгүүд нь эрсдэлийн алдагдалд ихээхэн нөлөө үзүүлдэг (Тодруулга 34):

- Бизнесийн загвар болон ХБЭА-ын үнэлгээний зорилгоорх санхүүгийн хөрөнгийн сегментчилэл;
- ЗЭМӨ-ийн үнэлгээ;
- Чанаргүйдлийн тодорхойлолт;
- Тусгайлсан болон бүлгийн ХБЭА-ын үнэлгээ;
- Дотоодын зээлийн үнэлгээний загварууд;
- Чанаргүйдлийн магадлал (“ЧМ”)
- Алдагдалд хүргэх чанаргүйдлийн (“АХЧ”) үнэлгээ;
- Макро эдийн засгийн хэтийн төлөв, тэдгээрийн магадлалын жинлэлт.

Банк ХБЭА-ыг хэмжих зорилгоор макро эдийн засгийн таамаглалын загвар зэрэг ирээдүйд чиглэсэн хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдээллийг ашигласан. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХБЭА-ын тооцоололд хамааралтай хамгийн ашиглагдахуйц ирээдүйн таамаглал болон магадлалын жинлэгдсэн хувиудыг дор үзүүлэв:

Өгөгдөл	Хувилбар	Жинлэгдсэн хувь	Таамаглал
ДНБ-ний өсөлт	Дээд	23.1%	8.5%
	Суурь	49.4%	5.4%
	Доод	27.5%	2.4%
Бодлогын хүү	Дээд	23.1%	8.4%
	Суурь	49.4%	10.4%
	Доод	27.5%	12.5%
Ажилгүйдлийн хувь	Дээд	23.1%	5.1%
	Суурь	49.4%	7.0%
	Доод	27.5%	8.9%
Төг/Ам.дол/жилийн өсөлт	Дээд	23.1%	-3.7%
	Суурь	49.4%	5.9%
	Доод	27.5%	15.4%

Сүүлийн жилүүдэд цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаа нь өвөл, хаврын улиралд зудын (өвлийн хүнд нөхцөл) эрсдэлийг нэмэгдүүлж байна. Цаашид цаг уурын өөрчлөлтөөс үүдэн өвөлжилт хүндрэх төлөвтэй байна. Банк тус өөрчлөлтийг малчдын зээлээ төлөх чадварт мэдэгдэхүйц нөлөөлнө гэж үзэж байгаа тул хөдөө аж ахуйн сегмент дэх малчны зээлийн багцын хэтийн төлөвийг тусад нь тооцоолсон.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хөдөө аж ахуйн сегментэд багтсан малчны зээлд дараах таамаглалыг ашигласан болно:

Өгөгдөл	2025 оны 12 сарын 31			2024 оны 12 сарын 31		
	Хувилбар	Жинлэгдсэн хувь	Таамаглал	Жинлэгдсэн хувь	Таамаглал	
Малын хорогдлын түвшин	Дээд	7.7%	5.2%	7.7%	4.5%	
	Суурь	46.2%	13.3%	46.2%	12.5%	
	Доод	46.1%	21.4%	46.1%	31.5%	

Малчны зээлийн багцын ирээдүйд чиглэсэн макро эдийн засгийн суурьт ашигласан жинлэсэн хувийг 10%-аар доод таамаглалд шууд өөрчлөхөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХБЭА-ын нөөц санг 1,090,078 мянган төгрөг (2024 оны 12 сарын 31-ний өдөр: 8,673,259 мянган төгрөг)-өөр нэмэгдүүлэхэд хүргэх болно.

Түүнчлэн банкны удирдлагууд зудын байдал ихээхэн нөлөөлсөн бүс нутгаас нь хамааруулан нийтдээ 192,993,003 мянган төгрөг (2024 оны 12 сарын 31: 354,517,851 мянган төгрөг)-ийн малчны зээлийн багцын зээлийн эрсдэл нэмэгдэж байгаа гэж үнэлсэн учир Банкнаас энэхүү багцыг шатлал 2-т ангилсан. Түүхэн чанаргүйдлийн магадлал (ЧМ) нь одоогийн малчны зээлийн багцын төлөгдөх магадлалыг илэрхийлэхээ больсон гэж Банк үзэж байгаа бөгөөд малын түүхэн хорогдлын түвшин болон чанаргүй зээлийн дансны үнэ хоорондын хамааралд үндэслэн түүхэн ЧМ-ын хувь хэмжээг тохируулсан. Үүний үр дүнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тодорхой бүс нутгийн малчны зээлийн багцын ХБЭА-ыг тооцоход илүү өндөр ЧМ ашигласан ба ХБЭА нь 15,512,387 мянган төгрөг (2024 оны 12 сарын 31: 50,053,567 мянган төгрөг)-өөр өссөн үр дүнг үзүүлсэн байна.

ЧМ-ын 10%-ийн өсөлт нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар малчны зээлийн багцын эрсдэлийн алдагдлын санг 1,754,555 мянган төгрөг (2024 оны 12 сарын 31-ний өдөр: 8,844,891 мянган төгрөг)-өөр нэмэгдүүлэхэд хүргэнэ.

АХЧ-ийн 10%-ийн өсөлт нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар малчны зээлийн багцын эрсдэлийн алдагдлын санг 2,174,795 мянган төгрөг (2024 оны 12 сарын 31-ний өдөр: 9,419,713 мянган төгрөг)-өөр нэмэгдүүлэхэд хүргэнэ.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх таамаглал болон магадлалын хувиудыг дор үзүүлэв:

Өгөгдөл	Хувилбар	Жинлэгдсэн хувь	Таамаглалууд
ДНБ-ний өсөлт	Дээд	25.7%	9.6%
	Суурь	54.3%	6.5%
	Доод	20.0%	3.6%
Бодлогын хүү	Дээд	25.7%	6.1%
	Суурь	54.3%	8.2%
	Доод	20.0%	10.1%
Ажилгүйдлийн хувь	Дээд	25.7%	3.5%
	Суурь	54.3%	5.4%
	Доод	20.0%	7.2%
Төг/Ам.дол/жилийн өсөлт	Дээд	25.7%	-6.5%
	Суурь	54.3%	3.4%
	Доод	20.0%	9.9%

Ирээдүйд чиглэсэн макро эдийн засгийн суурьт ашигласан жинлэсэн хувийг 10%-аар доод таамаглалруу шууд өөрчлөхөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нийт ХБЭА-ын санг 988,185 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 727,313 мянган төгрөгөөр нэмэгдсэн)-өөр нэмэгдүүлэхэд хүргэнэ.

ЧМ-ын 10%-ийн өсөлт нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нийт эрсдэлийн алдагдлын санг 13,471,992 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 12,492,931 мянган төгрөгөөр нэмэгдсэн)-өөр нэмэгдүүлэхэд хүргэнэ.

АХЧ-ийн 10%-ийн өсөлт нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нийт эрсдэлийн алдагдлын санг 43,009,477 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 32,008,361 мянган төгрөгөөр нэмэгдсэн)-өөр нэмэгдүүлэхэд хүргэнэ.

#### **4.5. Засгийн Газар, Монголбанк, төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн эх үүсвэр**

Банк нь Монгол Улсын Засгийн Газрын байгууллагууд (зарим нь олон улсын санхүүгийн байгууллагуудын оролцоотой хөтөлбөрүүд байдаг)-аас санхүүжилтийг хэвийн зээлийн хүүтэй ижил хүүгээр авдаг бөгөөд тус зээлийн хүү нь Банкны бусад зээлдүүлэгчдээс авдаг зээлийн хүүгээс доогуур байж болзошгүй. Ийм санхүүжилтийн үр дүнд Банк эдгээр эх үүсвэрүүдийг зээлдэгчийн тодорхойлсон зорилтот харилцагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлүүлэх боломжтой. Удирдлага эдгээр хэрэглүүрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед олз, гарз үүсэх эсэхийг авч үздэг. Ажил гүйлгээнүүд нь холбоогүй талуудтай хийгддэг тул удирдлагын үнэлэлтээр эдгээр эх үүсвэрүүд болон холбогдох зээл олголтууд нь зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн үед нь олз, гарз үүсэхгүй гэж дүгнэсэн. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Засгийн газрын байгууллагуудаас авсан зээлийн эх үүсвэр 300,345,140 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 407,640,297 мянган төгрөг) байна. Тодруулга 20-иос харна уу.

#### **4.6. Монголын ипотекийн корпораци (МИК)-ийн орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас**

Банк МИК-ийн орон сууцны зээлийн багц худалдаж, үнэт цаасжуулах гүйлгээнд 2013 оноос хойш оролцсон. МИК-ийн Тусгай зориулалттай компани (ТЗК) нь (МИК ОССК)-ийн охин компани ба арилжааны банкуудаас Ипотекийн зээлээр баталгаажсан зээлийн багц худалдан авах Давуу болон Энгийн эрхтэй үнэт цаасыг гаргадаг. Дээрх зээлийн багцыг МИК-ийн тусгай зориулалтын компанид үүрэггүй худалдсан. Давуу эрхтэй бондын үндсэн төлбөрийг бүрэн эргүүлэн төлөгдсөний дараа энгийн бондын үндсэн төлбөрийг авах боломжтой ба давуу эрхтэй бонд эзэмшигчид нь төлбөрийн хувьд давуу эрхтэй байдаг. Банк зарагдсан зээл тус бүрийн хувьд үйлчилгээ үзүүлэгч гэгдэх ба харилцагчаас зээлийн төлбөрийг цуглуулж, үйлчилгээний шимтгэлд цуглуулсан төлбөрөөс 2.5%-ийн шимтгэл авна.

Удирдлага эдгээр зээлүүдийг СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартад зааснаар данснаас хасах шаардлагыг хангасан эсэхэд үнэлгээ хийж үзсэн. Банк хэдийгээр агент шиг зээлийн багцаас мөнгө хүлээн авсан боловч эдгээр орон сууцны зээлийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх шилжүүлснээр бүх эрсдэл болон өгөөжийг давхар шилжүүлсэн гэж Банкны удирдлага дүгнэсэн ба тайлан тэнцэлдээ эдгээр зээлийг хүлээн зөвшөөрөөгүй байна.

#### **4.7. Урт хугацаат үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ**

Банк нь Монголбанктай валют хоорондын урт хугацаат хүүгийн своп хэлцэл хийсэн байна. Үүсмэл хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр бүртгэх бөгөөд энэ нь зөрөг утгатай тохиолдолд хөрөнгөд, сөрөг утгатай тохиолдолд өр төлбөрт тус тус бүртгэдэг. Банк ийм төрлийн своп хэлцлийн бодит үнэ цэнийг үнэлэх үнэлгээний загвар, аргачлалыг боловсруулсан. Энэхүү загвар аргачлал нь бүхэлдээ зах зээлийн ажиглагдахуйц мэдээлэлд үндэслэгддэг. Банк нь ам.долларын форвард хүүний хувийг Блүүмберг терминалын ам.долларын форвард өгөөжийн муруйгаас авдаг. Хэрэв зах зээл дээрх төгрөгөөр илэрхийлсэн форвард ханшийн өгөөжийн муруйн мэдээлэл байхгүйн улмаас Банк төгрөгөөр илэрхийлсэн форвард хүүгийн хувьд Монголбанкаас зарласан зээлийн хүүг ашигладаг.

Хэлцлийн эхэн үед, үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь голчлон төлбөрийг бага хэмжээгээр эсвэл огт шилжүүлэхгүй байх нөхцөл бүхий хоёр талын харилцан хэлэлцээртэй байдаг. Гэвч эдгээр хэрэглүүр нь ихэвчлэн өндөр түвшний хөшүүргийг агуулдаг бөгөөд хэлбэлзэл өндөртэй байдаг. Хөрөнгийн үнэ цэнийн харьцангуй бага хөдөлгөөн, хувь хэмжээ болон үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн индексийн хувь нь Банкны ашиг, алдагдалд нөлөөлж болзошгүй.

#### **4.8. Хейджийн бүртгэл**

Банк 2016 оны 5 сарын 1-ний өдрөөс хейджийн бүртгэлийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2018 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн СТОУС 9-ийг хейджийн бүртгэлд ашиглаж эхэлсэн.

Банк хейджийн үр ашгийг үнэлэхдээ чанар болон тоон аргуудыг ашигладаг. Хейджийн бодлого журамд, хейджийн үр ашиггүй байдал дараах тохиолдолд үүсч болно:

- Хейджийн хэрэглүүр болон хейджээр хамгаалагдсан зүйлийн мөнгөн урсгалын ялгаа;
- Харилцагч талуудын бодит үнэ цэнэд нөлөөлөх зээлийн эрсдэл;
- Хейдж хүчин төгөлдөр болох өдрөөр тохиролцсон форвард ханш болон зах зээлийн форвард ханшийн ялгаа.

#### 4.9 Гүйцэтгэлийн баталгаа

Банк гаргасан гүйцэтгэлийн баталгааны гэрээнүүдийг СТОУС 17-ийн хүрээнд хамаарах даатгалын гэрээний тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг шинжилж үнэлсэн. Гүйцэтгэлийн баталгааны зарим гэрээ нь зээлийн эрсдэл учруулдаг гэж Банк үздэг ба учир нь (1) бүх гэрээнүүд нь баталгаа гаргуулах хүсэлт өгсөн харилцагчаас Банкыг баталгаа гаргагчийн хувьд нөхөн төлбөр төлөх үүргийн хэмжээний барьцаа гаргахыг шаарддаг, (2) банк ийм төрлийн баталгаа эзэмшигчдэд их хэмжээний нэмэлт төлбөр төлөх шаардлагатай арилжааны шинжтэй нөхцөл байдал үүсэх хувилбар байхгүй. Иймээс Банк СТОУС 9-ийн дагуу эдгээр гэрээг зээлийн үүрэгтэй гэрээ гэж тооцдог. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үүрэг болгон бүртгэсэн гүйцэтгэлийн баталгааны нийт дүн 93,593,478 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 85,163,613 мянган төгрөг) бөгөөд санхүүгийн байдлын тайланд тусгагдсан холбогдох өр төлбөрийн дансны үнэ 2,408,703 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 293,696 мянган төгрөг) байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар эдгээр гүйцэтгэлийн баталгаанд хүлээн зөвшөөрсөн шимтгэлийн орлого 177,513 мянган төгрөг (2024: 172,901 мянган төгрөг) байна.

#### 5. Шинэ буюу нэмэлт өөрчлөлт орсон стандартуудын тайлбар болон хэрэгжилт

Дараах стандартын нэмэлт өөрчлөлт 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон:

**НББОУС 21, “Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө”-ийн нэмэлт өөрчлөлтүүд (2023 оны 8 сарын 15-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2025 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болно).** 2023 оны 8 сард НББОУСЗ нь НББОУС 21 стандартад нэмэлт өөрчлөлт оруулж, валют хоорондын солилцооны боломжгүй нөхцөлд байгууллагууд хоёр валютын хоорондын солилцооны боломжийг үнэлэх болон тухайн үеийн спот ханшийг тогтоох аргачлалтай болох боломжийг бүрдүүлсэн. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь тухайн байгууллагад тодорхой зорилгоор хэмжилтийн өдөрт гадаад валютыг өөр валют руу солих боломжгүй гүйлгээ эсвэл үйл ажиллагаа байгаа тохиолдолд хамаарна. НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлт нь тухайн үеийн спот ханшийг хэрхэн тооцоолох талаар нарийвчилсан шаардлагыг тусгаагүй болно. Харин үүний оронд хэмжилтийн өдрийн тухайн үеийн спот ханшийг байгууллага тогтоох боломжтой хүрээг тогтоосон. Шинэ шаардлагыг хэрэгжүүлэхдээ өмнөх харьцуулсан мэдээллийг дахин тооцоолохыг зөвшөөрдөггүй. Харин анх удаа хэрэгжүүлэх өдрийн байдлаар нөлөөлөлд өртсөн дүнг тооцоологдсон тухайн үеийн спот ханшаар хөрвүүлэх шаардлагатай бөгөөд энэ үед зөрүүг хуримтлагдсан ашиг эсвэл хуримтлагдсан хөрвүүлэлтийн зөрүүгийн нөөц санд тохируулан бүртгэнэ.

#### 6. Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогын мэдэгдэл

2026 оны 1 сарын 1-ний өдөр буюу түүнээс хойших буюу түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд заавал дагаж мөрдөх зарим шинэ стандарт, тайлбарууд батлагдсан бөгөөд Банк эдгээр стандартуудыг хугацаанаас нь өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

- СТОУС 9 болон СТОУС 7-д орсон нэмэлт өөрчлөлт - Санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон хэмжилт (2024 оны 5 сарын 30-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2026 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно)
- СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга болон тодруулга (2024 оны 4 сарын 9-ний өдөр батлагдан гарсан бөгөөд 2027 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно). СТОУС 18 нь НББОУС 1-ийг орлох бөгөөд НББОУС 1-д байсан зарчмуудын ихэнх нь хэвээр үлдэх боловч хязгаарлагдмал хүрээний өөрчлөлт орсон.
- СТОУС 18 нь санхүүгийн тайлангийн бүртгэл хөтлөлт болон хэмжилтийн зарчимд нөлөө үзүүлэхгүй, харин тухайн байгууллага ‘үйл ажиллагааны ашиг, алдагдал’-аа яаж тайлагнаснаас хамаарч өөрчлөлт оруулах боломжтой. СТОУС 18 нь 2027 оны 1 сарын 1-ний өдөр буюу түүнээс хойших тайлант хугацаануудад хүчин төгөлдөр бөгөөд харьцуулагдах мэдээлэлд мөн адил хэрэгжинэ.
- СТОУС 19 Олон нийтэд хариуцлага хүлээдэггүй охин компаниуд (2024 оны 5 сарын 9-ний өдөр батлагдан гарсан бөгөөд 2027 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно).
- СТОУС14, Хойшлогдсон дансыг зохицуулах (2014 оны 1 сарын 30-ны өдөр батлагдан гарсан).

- СТОУС 10 болон НББОУС 28-д орсон нэмэлт өөрчлөлт - Хөрөнгө оруулагч болон түүний хараат компани эсвэл хамтарсан компанийн хооронд хөрөнгө худалдах буюу хөрөнгө оруулалт хийх (2014 оны 9 сарын 11-ний өдөр батлагдан гарсан бөгөөд хэрэгжиж эхлэх хугацааг НББОУСЗ-өөс тодорхойлсон өдөр болон түүнээс хойших тайлант жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно).
- СТОУС 9 болон СТОУС 7-д орсон нэмэлт өөрчлөлт - Байгалийн нөхцөлөөс хамааралтай цахилгаан эрчим хүчний иш татсан гэрээнүүд (2024 оны 12 сарын 18-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2026 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно).
- СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын жилийн сайжруулалтууд (2024 оны 7 сард батлагдан гарсан бөгөөд 2026 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант жилийн хугацаануудад хүчин төгөлдөр болно)

Дээр өөрөөр тодруулаггүй бол Банк шинэ стандарт болон өөрчлөлтүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг одоогоор үнэлж байна.

## 7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Бэлэн мөнгө	204,400,108	169,843,089
Монголбанкны харилцах	761,465,618	358,986,761
Монголбанкны үнэт цаас	3,871,989,691	4,341,204,093
Бусад банкууд дахь харилцах хадгаламж - 3 сараас бага хугацаатай	1,357,821,671	602,198,089
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нийт дүн</b>	<b>6,195,677,088</b>	<b>5,472,232,032</b>
Хасах: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эзэлжих эрсдэлийн сан	(1,776,709)	(1,888,893)
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр дүн</b>	<b>6,193,900,379</b>	<b>5,470,343,139</b>

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд тодорхой хэмжээний мөнгө рүү түргэн хөрвөх боломжтой үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлс хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд бусад банкуудад 3 сараас бага анхны хугацаатай байршуулсан репо, урвуу репо хэлцлүүд, банк хооронд байршуулсан бүх мөнгөн хөрөнгө орно. Санхүүгийн байдлын тайланд болон мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор анх 3 сараас их хугацаатайгаар байршуулсан хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд ангилж бүртгэхгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэх ба энэ нь: (1) гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээ нь ЗҮТХТ-ийн дагуу байх, (2) ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөхгүй үед бүртгэдэг.

Мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан төлбөр болон орлого нь Банкны мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн шилжүүлгийг илэрхийлдэг. Банкны харилцагч талуудын харилцах дансанд бүртгэсэн дүнг оролцуулан, зээлийн хүүгийн авлага, харилцагчдын харилцах данснаас суутгасан үндсэн төлбөр, харилцагчдад олгосон зээл ба зээлийн хүүгийн төлөлт зэргийг оролцуулах ба эдгээр төлөлтүүд нь харилцагчдын мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болно.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк ОХУ-ын хоригт ороогүй гурван банкинд 171,567 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 131,607 мянган төгрөг)-ийн харилцах дансыг байршуулсан байсан бөгөөд Банкны зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн гэж үзсэн тул тэдгээрийг "шатлал 2"-т ангилж, нийт хугацааны турш дахь ХБЭА-ыг тооцоолж, нийт 116,014 мянган төгрөг (2024 оны 12 сарын 31: 104,956 мянган төгрөг)-ийг бүртгэсэн. Бусад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг "шатлал 1"-т ангилсан.

Монголбанкны үнэт цаасыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 67,000,000 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 84,840,000 мянган төгрөг)-ийн Репо хэлцлээр барьцаалсан. Барьцаалуулагч эдгээр үнэт цаасыг дахин барьцаалах, худалдах эрхгүй. Бусад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, түүний дотор төв банкинд байгаа үлдэгдэл (заавал байлгах нөөцөөс бусад) барьцаалагдахгүй.

**Бэлэн мөнгөнөөс бусад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан**

Доорх хүснэгтэд Банкны дотоод зээлийн үнэлгээний систем болон жилийн эцсийн байдлаар шатлалын ангилалд үндэслэсэн зээлжилтийн чанар болон зээлийн эрсдэлийн хамгийн дээд хэмжээг харууллаа. Хүснэгтэд тусгасан дүн нь үнэ цэнийн бууралтын хасагдуулгын нийт дүнгээр илэрхийлэгдсэн. Банк зээлийн бус санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд Стандарт болон Пүүрс (S&P)-ийн жил бүр гаргадаг дэлхийн корпорациудын чанаргүйдэл болон зэрэглэл шилжилтийн судалгааг ашигладаг бөгөөд үнэлгээгүй компанийн хувьд таамаглалын зэрэглэлийг ашигладаг. Банкны дотоод үнэлгээний систем болон ХБЭА-ын сангийн тооцооллыг тусгайлсан эсвэл бүлгэд суурилсан үнэлгээгээр тооцоолох эсэх тухай бодлого журмыг Тодруулга 34-т дэлгэрэнгүй тусгасан болно.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотоод үнэлгээний зэрэглэл:

Мянган төгрөгөөр	Монголбанкны харилцах	Монголбанкны үнэт цаас	Бусад банкууд дахь харилцах, хадгаламж-3 сараас бага	Нийт дүн
AA- аас AA+ зэрэгтэй	-	-	17,283,740	17,283,740
A- аас A+ зэрэгтэй	-	-	199,479,191	199,479,191
BBB- ээс BBB+ зэрэгтэй	-	-	6,376,415	6,376,415
BB- ээс BB+ зэрэгтэй	-	-	6,692,695	6,692,695
B- ээс B+ зэрэгтэй	761,465,618	3,871,989,691	1,113,923,144	5,747,378,453
C ээс CCC+ зэрэгтэй	-	-	171,567	171,567
Үнэлгээгүй	-	-	13,894,919	13,894,919
<b>Нийт дүн</b>	<b>761,465,618</b>	<b>3,871,989,691</b>	<b>1,357,821,671</b>	<b>5,991,276,980</b>

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотоод үнэлгээний зэрэглэл:

Мянган төгрөгөөр	Монголбанкны харилцах	Монголбанкны үнэт цаас	Бусад банкууд дахь харилцах, хадгаламж-3 сараас бага	Нийт дүн
AA- аас AA+ зэрэгтэй	-	-	74,075,463	74,075,463
A- аас A+ зэрэгтэй	-	-	254,620,194	254,620,194
BBB- ээс BBB+ зэрэгтэй	-	-	7,388,005	7,388,005
BB- ээс BB+ зэрэгтэй	-	-	5,590,559	5,590,559
B- ээс B+ зэрэгтэй	358,986,761	4,341,204,093	244,296,045	4,944,486,899
C ээс CCC+ зэрэгтэй	-	-	131,607	131,607
Үнэлгээгүй	-	-	16,096,216	16,096,216
<b>Нийт дүн</b>	<b>358,986,761</b>	<b>4,341,204,093</b>	<b>602,198,089</b>	<b>5,302,388,943</b>

## 8. Монголбанкинд заавал байлгах нөөц

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	2,214,651,757	1,652,362,155
Хасах: Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөцийн зээлжих эрсдэлийн сан	(18,151,215)	(17,152,298)
<b>Заавал байлгах нөөцийн цэвэр дүн</b>	<b>2,196,500,542</b>	<b>1,635,209,857</b>

Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн үлдэгдлийг ХӨ-өөр бүртгэх бөгөөд Банкны өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах боломжгүй заавал байлгах нөөцийн хүүгүй хадгаламж тул үүнийг мөнгөн гүйлгээний тайлан дахь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний зайлшгүй байлгах нөөцийн үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дундаж үлдэгдлийн төгрөгийн 13% (2024: 11.0%) болон валютын 18% (2024: 16.0%)-аас багагүй байна.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкны шаардсан 14 хоногийн дундаж нөөцийн үлдэгдлийн 1,792,158,298 мянган төгрөг (2024: 1,369,228,046 мянган төгрөг) нь монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн байсан ба гадаад валютын хувьд Монголбанкны харилцах дансанд 422,493,459 мянган төгрөг (2024: 283,134,109 мянган төгрөг)-ийг бүртгэсэн байна.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкны дотоод үнэлгээний системд үндэслэсэн Монголбанкны заавал байлгах нөөцийн зээлжилтийн чанар нь "В- зэргээс В+" зэрэгтэй байна. Банкны дотоод үнэлгээний систем болон ХБЭА-ын санг тусгайлсан эсвэл бүлэгт суурилан тооцоолдог эсэх талаар баримтлах бодлогыг Тодруулга 34-т тусгасан болно. ХБЭА-ын хэмжилтийн хувьд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкны заавал байлгах нөөцийг "шатлал 1"-д бүртгэсэн.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нийт дансны үнэ болон холбогдох ХБЭА-ын сангийн өөрчлөлтөд хийсэн дүн шинжилгээг доор харууллаа:

Мянган төгрөгөөр	2025 Шатлал 1	2024 Шатлал 1
<b>1-р сарын 1-нээрх нийт дансны дүн</b>	<b>1,652,362,155</b>	<b>1,103,720,018</b>
Тайлант жилийн цэвэр хөдөлгөөн	562,289,602	548,642,137
<b>12-р сарын 31-нээрх дансны дүн</b>	<b>2,214,651,757</b>	<b>1,652,362,155</b>
<b>1-р сарын 1-нээрх ХБЭА-ын сангийн дүн</b>	<b>17,152,298</b>	<b>12,764,762</b>
Тайлант жилийн цэвэр хөдөлгөөн (Тодруулга 27)	998,917	4,387,536
<b>12-р сарын 31-нээрх дансны үнэ</b>	<b>18,151,215</b>	<b>17,152,298</b>

## 9. Санхүүгийн хөрөнгө оруулалт

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
ХӨ-өөр хэмжигдэх өрийн үнэт цаас	310,238,967	600,182,758
БДОБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаас	363,785,866	339,993,364
ААБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаас	384,452,588	330,108,003
<b>Нийт өрийн хэлбэрээрх үнэт цаас</b>	<b>1,058,477,421</b>	<b>1,270,284,125</b>
БДОБҮЦ-ээр хэмжигдэх өмчийн үнэт цаас	6,263,389	4,509,664
<b>Нийт өмчийн хэлбэрээрх үнэт цаас</b>	<b>6,263,389</b>	<b>4,509,664</b>
<b>Нийт хөрөнгө оруулалт</b>	<b>1,064,740,810</b>	<b>1,274,793,789</b>

### Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт.

Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтыг Банк бизнес загвар болон мөнгөн урсгалын онцлог шинжид тулгуурлан ХӨ, БДОБҮЦ болон ААБҮЦ-ээр ангилж бүртгэдэг. Хэрэв өрийн үнэт цаас нь ААБҮЦ-ээр заавал тодорхойлогдоогүй бол түүнийг ЗҮТХТ-ийн дагуу гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа үед ХӨ-өөр бүртгэх ба нягтлан бодох бүртгэлийн зөрүүг бууруулах зорилгоор бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдээгүй үед хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Хэрэв өрийн үнэт цаас нь ААБҮЦ-ээр тодорхойлогдоогүй бол өрийн үнэт цаасыг ЗҮТХТ-ийн дагуу гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулах зорилгоор болон худалдан борлуулах зорилгоор эзэмшиж байгаа үед БДОБҮЦ-ээр бүртгэгдэнэ. Эдгээр хөрөнгүүдийн хүүний орлогыг үр ашигт хүүний аргачлалаар тодорхойлох ба ашиг, алдагдал бүртгэнэ. Үнэ цэнийн бууралтын санг хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварыг ашиглан тооцоолох ба тухайн тайлант жилийн ашиг, алдагдалд бүртгэдэг. Бусад бүх дансны үнэ цэнийн өөрчлөлтийг БДО-д хүлээн зөвшөөрнө. Хэрэв БДО-ын тайланд хүлээн зөвшөөрөгдөхгүй үед өмнө нь хуримтлагдан бүртгэгдсэн байсан ашиг, алдагдлыг БДО-ын тайлангаас ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилна.

ААБҮЦ-ээр бүртгэгдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хувьд ХӨ болон БДОБҮЦ-ийн шалгуурыг хангаагүй өрийн үнэт цаасууд байна. Банк нягтлан бодох бүртгэлийн олон янзын сууриар хүлээн зөвшөөрөгдсөн буюу хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн хоорондын нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах сонголтыг ашиглаж байгаа тохиолдолд анхны хүлээн зөвшөөрөлтөөр ААБҮЦ-ээр бүртгэгдэх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг дахин тодорхойлж болно.

Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтад Засгийн Газрын бондууд, Ипотекийн зээлээр баталгаажсан “Энгийн” ба “Давуу” эрхтэй үнэт цаас, Компанийн бондууд болон Нийслэл бондууд багтана.

Засгийн Газрын бондууд олон улсын зах зээлд бүртгэлтэй байдаг ба тухайн хөрөнгө оруулалтын бизнес загварт үндэслэн БДОБҮЦ эсвэл ХӨ-өөр хэмжигдэнэ.

Дотоодын зах зээлд бүртгэлтэй Нийслэл бондыг санхүүгийн хөрөнгийн бизнес загварт үндэслэн БДОБҮЦ-ээр хэмждэг.

Компанийн бондууд, биржийн болон биржийн бус үнэт цаасууд ХӨ-өөр хэмжигдэнэ.

Давуу эрхтэй бондонд Монголын Ипотекийн Корпорациас (“МИК”) гаргасан давуу эрхтэй “ИЗББ” болон Үнэт Цаасны Санхүүжилтийн корпорациас (“ҮЦСК”) гаргасан давуу эрхтэй бондууд багтана. Давуу эрхтэй “ИЗББ” нь Монголын Ипотекийн Корпорациас гаргасан хүү тооцдог, урт хугацаат үнэт цаас бөгөөд орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтэд зориулж арилжааны банкуудад олгосон ба Монголбанк болон Сангийн Яаманд ипотекийн зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт байдлаар худалддаг.

Энгийн эрхтэй бондонд МИК-аас гаргасан энгийн эрхтэй “ИЗББ” болон ҮЦСК-аас гаргасан энгийн эрхтэй бондууд багтана. Энгийн эрхтэй “ИЗББ” нь МИК-аас гаргасан хүү тооцдог, урт хугацаат үнэт цаас бөгөөд арилжааны банкууд хамгийн багадаа 3 жил эзэмших үүрэгтэй.

2025 онд хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасны бууралт нь Засгийн газрын бондын болон Компанийн бондуудын эргэн төлөлттэй холбоотой бол БДОБҮЦ болон ААБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаасны өсөлт ИЗББ болон Нийслэл бондын хөрөнгө оруулалттай холбоотой байна.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын ангилал болон хэмжилтийг доор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	ААБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаас	БДОБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаас	ХӨ-өөр хэмжигдэх өрийн үнэт цаас	Нийт дүн
Засгийн газрын бонд	-	95,611,365	283,501,325	379,112,690
Нийслэл бонд	-	275,645,238	-	275,645,238
Давуу эрхтэй бонд	161,293,038	-	4,247,742	165,540,780
Энгийн эрхтэй бонд	223,159,550	-	-	223,159,550
Компанийн бонд	-	-	24,691,508	24,691,508
<b>Нийт дансны дүн</b>	<b>384,452,588</b>	<b>371,256,603</b>	<b>312,440,575</b>	<b>1,068,149,766</b>
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	-	(7,470,737)	(2,201,608)	(9,672,345)
<b>Дансны үнэ (бодит үнэ цэнэ)</b>	<b>384,452,588</b>	<b>363,785,866</b>	<b>310,238,967</b>	<b>1,058,477,421</b>

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын ангилал болон хэмжилтийг доор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	ААБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаас	БДОБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаас	ХӨ-өөр хэмжигдэх өрийн үнэт цаас	Нийт дүн
Засгийн газрын бонд	-	116,498,559	476,353,207	592,851,766
Монголбанкны үнэт цаас	-	231,981,411	-	231,981,411
Давуу эрхтэй бонд	136,364,285	-	11,884,077	148,248,362
Энгийн эрхтэй бонд	193,743,718	-	-	193,743,718
Компанийн бонд	-	-	123,892,958	123,892,958
<b>Нийт дансны дүн</b>	<b>330,108,003</b>	<b>348,479,970</b>	<b>612,130,242</b>	<b>1,290,718,215</b>
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	-	(8,486,606)	(11,947,484)	(20,434,090)
<b>Дансны үнэ (бодит үнэ цэнэ)</b>	<b>330,108,003</b>	<b>339,993,364</b>	<b>600,182,758</b>	<b>1,270,284,125</b>

Зээлжих эрсдэлийн сангийн өөрчлөлт хөдөлгөөн болон БДОБҮЦ болон ХӨ-өөр хэмжигдэх өрийн хэрэглүүрийн нийт дансны дүнг дор харуулав.

Мянган төгрөгөөр	БДОБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаас	ХӨ-өөр хэмжигдэх өрийн үнэт цаас
<b>2025 оны 1 сарын 1-ний нийт дансны дүн</b>	<b>348,479,970</b>	<b>612,130,242</b>
Худалдан авалт/Нэмэгдсэн	305,340,959	68,296,190
Дуусгавар болсон/эргэн төлөгдсөн санхүүгийн хөрөнгө оруулалт	(299,571,106)	(385,411,009)
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	7,126,181	769,694
Гадаад валютын ханшийн зөрүү	7,638,562	16,655,458
Бодит үнэ цэнийн өсөлт	2,242,037	-
<b>2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>371,256,603</b>	<b>312,440,575</b>
<b>2025 оны 1 сарын 1-ний ХБЭА-ын сан</b>	<b>8,486,606</b>	<b>11,947,484</b>
Шинэ хөрөнгө оруулалтын худалдан авалт	7,488,905	4,319,755
ХБЭА-ын тооцоололд ашигласан үзүүлэлтүүдийн өөрчлөлт	(3,555,090)	(6,312,248)
Хугацаа дууссан/ эргэн төлөгдсөн	(4,949,684)	(7,753,383)
Тайлант жилийн цэвэр (буцаалт) (Тодруулга 27)	(1,015,869)	(9,745,876)
<b>2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>7,470,737</b>	<b>2,201,608</b>
<b>2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>363,785,866</b>	<b>310,238,967</b>

Мянган төгрөгөөр	БДОБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаас	ХӨ-өөр хэмжигдэх өрийн үнэт цаас
<b>2024 оны 1 сарын 1-ний нийт дансны дүн</b>	<b>78,595,711</b>	<b>1,198,743,104</b>
Худалдан авалт/Нэмэгдсэн	528,452,263	124,917,514
Дуусгавар болсон/эргэн төлөгдсөн санхүүгийн хөрөнгө оруулалт	(265,605,748)	(731,545,294)
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	1,069,087	20,208,878
Гадаад валютын ханшийн зөрүү	1,156,799	(193,960)
Бодит үнэ цэнийн өсөлт	4,811,858	-
<b>2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>348,479,970</b>	<b>612,130,242</b>
<b>2024 оны 1 сарын 1-ний ХБЭА-ын сан</b>	<b>1,505,227</b>	<b>12,940,857</b>
Шинэ хөрөнгө оруулалтын худалдан авалт	12,810,219	3,608,988
ХБЭА-ын тооцоололд ашигласан үзүүлэлтүүдийн өөрчлөлт	(985,314)	(2,645,310)
Хугацаа дууссан/ эргэн төлөгдсөн	(4,843,526)	(1,957,051)
Тайлант жилийн цэвэр (буцаалт)/зардал (Тодруулга 27)	6,981,379	(993,373)
<b>2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>8,486,606</b>	<b>11,947,484</b>
<b>2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>339,993,364</b>	<b>600,182,758</b>

Дараах хүснэгтэд зээлийн эрсдэлийн зэрэглэлд үндэслэсэн ХБЭА-ын санг хүлээн зөвшөөрсөн, БДОБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаасны зээлжилтийн эрсдэлийн шинжилгээг харууллаа. Бүх БДОБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаас нь шатлал 1-д ордог. Банкны ашигласан зээлийн эрсдэлийн үнэлгээний системийн тодорхойлолт болон хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн аргачлал, чанаргүйдлийн тодорхойлолт, БДОБҮЦ нь хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасанд хамаарах ЗЭМӨ-ийн талаар Тодруулга 34-өөс харна уу.

Мянган төгрөгөөр	2025 оны 12 сарын 31			2024 оны 12 сарын 31		
	Нийт дансны дүн	Зээлжих эрсдэлийн сан	Дансны үнэ (бодит үнэ цэнэ)	Нийт дансны дүн	Зээлжих эрсдэлийн сан	Дансны үнэ (бодит үнэ цэнэ)
<i>В- аас В+ зэрэгтэй</i>						
Засгийн газрын бонд	95,611,365	(611,914)	<b>94,999,451</b>	116,498,559	(2,160,537)	<b>114,338,022</b>
<i>Үнэлгээгүй</i>						
Нийслэл бонд	275,645,238	(6,858,823)	<b>268,786,415</b>	231,981,411	(6,326,069)	<b>225,655,342</b>
<b>Нийт</b>	<b>371,256,603</b>	<b>(7,470,737)</b>	<b>363,785,866</b>	<b>348,479,970</b>	<b>(8,486,606)</b>	<b>339,993,364</b>

Дараах хүснэгтэд зээлийн эрсдэлийн зэрэглэлд үндэслэсэн ХӨ-өөр хэмжигдэх өрийн үнэт цаасны зээлжилтийн чанарын шинжилгээг харуулсан. Бүх ХӨ-өөр хэмжигдэх өрийн үнэт цаас нь шатлал 1-д ордог. Банкны ашигласан зээлийн эрсдэлийн үнэлгээний системийн тодорхойлолт болон хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн аргачлал, чанаргүйдлийн тодорхойлолт, ХӨ-өөр хэмжигдэх өрийн үнэт цаасанд хамаарах ЗЭМӨ-ийн талаар Тодруулга 34-өөс харна уу.

Мянган төгрөгөөр	2025 оны 12 сарын 31			2024 оны 12 сарын 31		
	Нийт дансны дүн	Зээлжих эрсдэлийн сан	Дансны үнэ	Нийт дансны дүн	Зээлжих эрсдэлийн сан	Дансны үнэ
<i>В- с В+ зэрэгтэй</i>						
Засгийн газрын бонд	283,501,325	(1,691,721)	<b>281,809,604</b>	476,353,207	(8,763,959)	<b>467,589,248</b>
Компанийн бонд	-	-	-	85,776,122	(1,674,109)	<b>84,102,013</b>
<i>Үнэлгээгүй</i>						
Давуу эрхтэй бонд	4,247,742	(119,977)	<b>4,127,765</b>	11,884,077	(381,426)	<b>11,502,651</b>
Компанийн бонд	24,691,508	(389,910)	<b>24,301,598</b>	38,116,836	(1,127,990)	<b>36,988,846</b>
<b>Нийт</b>	<b>312,440,575</b>	<b>(2,201,608)</b>	<b>310,238,967</b>	<b>612,130,242</b>	<b>(11,947,484)</b>	<b>600,182,758</b>

### Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт

Бодит үнэ цэнээр хэмжигдэх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт нь Монголын хөрөнгийн бирж ("МХБ") болон Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй МИК Холдинг ХК ("МИК")-д оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлж байна.

### 10. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр

Дараах хүснэгтэд хөрөнгө, өр төлбөр гэж бүртгэгдсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн нэрлэсэн үнэ болон бодит үнэ цэнийг харуулсан. Нэрлэсэн үнэ нь нийт дүнгээрээ үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн тухайн үнэт цаасны дүн байх бөгөөд суурь хүү эсвэл хүүгийн индексээс шалтгаалан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээнд өөрчлөлт ордог. Нэрлэсэн үнэ нь жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах боловч зах зээлийн эрсдэл эсвэл зээлийн эрсдэлийн алийг нь ч илэрхийлэхгүй.

Мянган төгрөгөөр	Нэрлэсэн үнэ		Бодит үнэ цэнэ	
	Авлага	Өглөг	Хөрөнгө (бодит үнэ цэнэ)	Өр төлбөр (бодит үнэ цэнэ)
<b>Урт хугацаат үүсмэл санхүүгийн хэрэглүүр</b>	<b>3,187,934,380</b>	<b>3,093,859,474</b>	<b>84,371,923</b>	<b>19,497,207</b>
Хейджийн бүртгэлд хамрагдах хейджийн хэрэглүүр	1,617,412,305	1,579,943,146	31,286,006	12,839,207
Хейджийн бүртгэлд хамрагдахгүй үүсмэл хэрэглүүр	1,570,522,075	1,513,916,328	53,085,917	6,658,000
<b>Нийт богино хугацаат санхүүгийн хэрэглүүр</b>	<b>81,510,981</b>	<b>81,496,427</b>	<b>38,792</b>	<b>-</b>
<b>2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт бодит үнэ цэнээрх үүсмэл хэрэглүүр</b>	<b>3,269,445,361</b>	<b>3,175,355,901</b>	<b>84,410,715</b>	<b>19,497,207</b>

Мянган төгрөгөөр	Нэрлэсэн үнэ		Бодит үнэ цэнэ	
	Авлага	Өглөг	Хөрөнгө (бодит үнэ цэнэ)	Өр төлбөр (бодит үнэ цэнэ)
<b>Урт хугацаат үүсмэл санхүүгийн хэрэглүүр</b>	<b>2,484,621,329</b>	<b>2,446,585,032</b>	<b>29,158,228</b>	<b>-</b>
Хейджийн бүртгэлд хамрагдах хейджийн хэрэглүүр	1,273,019,863	1,261,749,950	6,835,418	-
Хейджийн бүртгэлд хамрагдахгүй үүсмэл хэрэглүүр	1,211,601,466	1,184,835,082	22,322,810	-
<b>Нийт богино хугацаат санхүүгийн хэрэглүүр</b>	<b>83,483,557</b>	<b>82,670,879</b>	<b>792,127</b>	<b>-</b>
<b>2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт бодит үнэ цэнээрх үүсмэл хэрэглүүр</b>	<b>2,568,104,886</b>	<b>2,529,255,911</b>	<b>29,950,355</b>	<b>-</b>

### Үүсмэл санхүүгийн хэрэглүүр.

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг (валютын своп хэлцэл багтсан) бодит үнэ цэнээр бүртгэдэг.

Бүх үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь эерэг байвал түүнийг хөрөнгөд, сөрөг бол өр төлбөр гэж бүртгэдэг. Үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлого болон тухайн жилийн ашиг, алдагдалд (үүсмэл хэрэглүүрээс үүссэн олзоос гарзыг хассан) тусгаж бүртгэдэг.

### Хейджийн бүртгэл.

Банк тодорхой деривативуудыг (валют хоорондын своп) хейджийн хэрэглүүр гэж тодорхойлдог бөгөөд тэдгээр нь хейджээр хамгаалагдсан зүйл гэж тодорхойлогдсон гадаадын Банк болон Банк бус санхүүгийн байгууллагуудаас авсан ам.долларын урт хугацааны зээлийн санхүүжилтийн мөнгөн гүйлгээний хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалах зорилготой юм.

Банк хейджийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолохдоо таамаглалын дериватив аргыг ашигладаг. Таамаглалын дериватив арга нь хейджийн эрсдэлд өртөхөд хамгийн тохиромжтой хейджийн хэрэглүүр болох нэрлэсэн деривативыг бий болгох явдал юм (хүүгийн своп эсвэл форвард хэлцэл нь энгийн нөхцөлтэй байх ба хейджийн харилцаа эхлэх үед бодит үнэ цэнэ тэг байна). Таамаглалын деривативын бодит үнэ цэнийг бодит хейджийн

хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй харьцуулах замаар хейджийн ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн цэвэр үнэ цэнийн төлөөлөл болгон ашигладаг.

Банкны тайлант хугацааны эцсээрх гадаад валютын форвард болон своп хэлцлээс үүссэн гадаад валютын авлага болон өглөгийн бодит үнэ цэнийг дараах хүснэгтэд үзүүлэв. Хүснэгтэнд холбогдох тайлант хугацааны эцсийн өдрийн дараа харилцагч талуудтай хийгдсэн хэлцлүүдийн төлбөр тооцооны дүн (болон төлбөр)-ийн цэвэршүүлээгүй нийт позицыг тусган харууллаа. Зах зээл дэх хүүний түвшний өөрчлөлт, гадаад валютын ханшийн өөрчлөлт, хөдөлгөөн болон гэрээний нөхцөл дэх бусад хувьсах өөрчлөлтөөс хамаарч үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь ашигтай (хөрөнгө) ашиггүй (өр төлбөр) байж болно. Үүсмэл санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн нийт бодит үнэ цэнэ нь цаг үргэлж их хэмжээгээр өөрчлөгдөж болдог.

Мянган төгрөгөөр	Авлага 2025	Өр төлбөр 2025	Авлага 2024	Өр төлбөр 2024
<b>Гадаад валютын форвард болон своп хэлцэл:</b>				
<b>тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ</b>				
- төлбөр тооцооны авлага (+)	1,960,465,124	1,267,716,295	2,523,563,899	-
- төлбөр тооцооны өглөг (-)	(1,876,054,409)	(1,287,213,502)	(2,493,613,544)	-
<b>Гадаад валютын форвард болон своп хэлцлийн цэвэр бодит үнэ цэнэ</b>	<b>84,410,715</b>	<b>(19,497,207)</b>	<b>29,950,355</b>	<b>-</b>

Банк үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн гэрээний эрсдэлд өртөх дүнг Банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын бүхий л хүрээнд хянадаг. Санхүүгийн байдал болон гүйцэтгэлд хейджийн бүртгэл хэрхэн нөлөөлөхийг Тодруулга 26 болон Тодруулга 34-өөс мөн доороос харна уу.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, хейджийн нягтлан бодох бүртгэлд хейджээр хамгаалагдсан зүйл гэж тодорхойлогдсон гадны банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаас авсан ам.долларын урт хугацаат зээлийн санхүүжилт нь 454,756 мянган ам.доллар (2024 оны 12 дугаар сарын 31: 372,201 мянган ам.доллар)-ын нэрлэсэн дүнтэй бөгөөд жилийн 3.0%-4.3%-ийн хүү дээр 6 сарын баталгаажсан овернайт санхүүжилтийн хүү (БОСХ)-г нэмсэн хувьсах хүү (2024 оны 12 дугаар сарын 31: жилийн 3.3%-4.3%-ийн хүү дээр 6 сарын БОСХ-г нэмсэн)-тэй байсан эсвэл жилийн 7.0%-7.1% тогтмол хүүтэй байсан (2024 оны 12 дугаар сарын 31: жилийн 4.1%-4.5%).

Дараах хүснэгтэнд хейджийн бүртгэлийг хангах хейджийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн мэдээллийн харууллаа.

Мөнгөн урсгалын хейдж Мянган төгрөгөөр	Хейджийн хэрэглүүр	Хейджийн эрсдэл	Хейджийн бүртгэлд хамрагдах хейджийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	Үр ашиггүй байдлын тооцоололд ашигласан хейджээр хамгаалагдсан зүйлсийн үнийн өөрчлөлт	Ашиг, алдагдлын тайлан руу ангилагдсан үр ашиггүй хейджийн дүн
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	Валют хоорондын хүүгийн своп хэлцэл	Валютын ханшийн эрсдэл	42,362,517	(36,055,612)	6,306,905
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	Валют хоорондын хүүгийн своп хэлцэл	Валютын ханшийн эрсдэл	4,049,539	(2,592,462)	1,457,077

Дараах хүснэгтэд хейджийн хэрэглүүрийн хугацааны ангиллыг дэлгэрэнгүй тусган харууллаа:

Мянган төгрөгөөр	3 сараас бага	3 - 6 сар	6 - 12 сар	1 - 5 жил	5 жилээс их
Төгрөгийн авлага	4,396,313	-	4,396,313	13,188,938	-
Төгрөгийн дундаж хүү	14.0%	-	14.0%	14.0%	-
Төгрөгийн өглөг	196,608,299	296,772,962	680,727,094	1,897,521,994	-
Төгрөгийн дундаж хүү	13.5%	12.7%	12.9%	12.6%	-
Ам.долларын авлага	211,147,818	308,942,496	708,783,830	1,937,078,673	-
Долларын дундаж хүү	5.7%	4.8%	5.0%	4.6%	-
Ам.долларын өглөг	4,445,825	-	4,445,825	13,337,475	-
Долларын дундаж хүү	6.1%	-	6.1%	6.1%	-

## 11. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
ХӨ-өөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дансны дүн	14,092,784,143	11,530,750,655
Хасах: Зээлжих эрсдэлийн сан	(838,733,828)	(735,127,618)
<b>ХӨ-өөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дансны дүн</b>	<b>13,254,050,315</b>	<b>10,795,623,037</b>
ААБҮЦ-ээр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	280,061,857	400,306,947
<b>Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа</b>	<b>13,534,112,172</b>	<b>11,195,929,984</b>

Банк харилцагчаас авах өрийг худалдан авах эсвэл шинээр зээл олгож мөнгө шилжүүлсэн тохиолдолд харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг бүртгэнэ. Бизнес загвар болон мөнгөн урсгалын шинж чанарт үндэслэн дараах хэмжилтийн аль нэгээр нь ангилна:

- (1) ХӨ: гэрээнд заасан мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор олгосон зээл бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь ЗҮТХТ-ийн дагуу байх, зээл нь ААБҮЦ-ээр заавал тодорхойлогдоогүй байх, болон
- (2) ААБҮЦ: Зээл нь ЗҮТХТ болон хорогдуулсан өртөг, БДОБҮЦ-ээр хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаагүй тохиолдолд ашиг, алдагдалаарх бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэнэ.

Үнэ цэнийн бууралтын санг ирээдүйд чиглэсэн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварт үндэслэн тогтоодог. Тодруулга 34-т хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтэд ашигласан өгөгдөл, таамаглал, тооцооллын аргачлал болон Банк хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллийг хэрхэн тодруулсан тайлбарыг тусгасан.

**Хорогдуулсан өртөг ("ХӨ")** нь санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасч, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, мөн үнийн аливаа нэмэгдэл буюу хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн дискаунтчилсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь тэнцэлд хамаарах хэсэгт дансны үнээр тусгасан болно.

**Үр ашигт хүүгийн аргачлал** нь хүүгийн орлого болон эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгахгаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн арга нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн эрсдэлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хорогдуулж санхүүгийн хэрэглүүрийн нийт дансны үнээс тооцдог хүүгийн хувь юм.

Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалыг хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтчлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал буюу хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Эдгээр урамшуулал, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоолдолд гэрээний талуудын хооронд өгч авалцах бүх шимтгэл, хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдаж авахад эсвэл шинээр олгоход үнэ цэнийн бууралттай ("POCI") санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед үр ашигт хүүний түвшинг зээлийн эрсдэлд тохируулахыг хэлнэ. Үүнд: анх хүлээн зөвшөөрөхдөө гэрээний төлбөрийн оронд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн тооцоолно.

**ХБЭА-ын сан.** Банк ХӨ болон БДОБҮЦ-ээр хэмжигдэх санхүүгийн өрийн хэрэглүүр болон зээл, санхүүгийн баталгаатай холбоотой ХБЭА-ыг ирээдүйн таамаглалын нөхцөл байдалд суурилан үнэлдэг. Банк ХБЭА-ыг хэмжиж, зээлжих эрсдэлийн хасагдуулгыг тайлант хугацаа бүрийн эцэст хүлээн зөвшөөрдөг. ХБЭА-ын хэмжилт нь:

- (1) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жинлэсэн дүн,
- (2) мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ
- (3) тайлант хугацаа бүрийн эцэст өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн нөхцөл байдлын таамаглалын талаар хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээлэлд үндэслэнэ.

ХӨ-өөрх өрийн хэрэглүүрийг санхүүгийн байдлын тайланд ХБЭА-ын санг хассан цэвэр дүнгээр тайлагнана. Зээл болон санхүүгийн баталгааны хувьд ХБЭА-ын санг санхүүгийн байдлын тайланд өр төлбөр гэж тусад нь хүлээн зөвшөөрдөг. БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн хувьд ХБЭА-ын санг хассан хорогдуулсан өртгийн өөрчлөлтийн дүн нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд дансны үнийн бусад өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн гарзыг хассан дүнгээр олз гэж тайлагнагдана.

Банк анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах зээлийн чанарын өөрчлөлтөд үндэслэсэн үнэ цэнийн бууралтын "3 шатлал" бүхий загварыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед ямар нэг үнэ цэнийн бууралтгүй зээлүүдийг "шатлал 1"-д ангилна. 1-р шатлалын зээлүүдийн ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сар эсвэл үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХБЭА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн дефолтоос үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлыг хэмжинэ. Хэрэв Банк анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн гэдгийг тогтоовол хөрөнгийг "шатлал 2"-т шилжүүлэн ангилах бөгөөд ХБЭА-ын нийт хугацааны хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжих ба хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзэж болно ("Нийт хугацааны ХБЭА").

Тодруулга 34-өөс Банк ЗЭМӨ-ийг хэрхэн тодорхойлсныг харна уу. Хэрэв Банк санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэ цэнэ буурсан гэж тодорхойлсон бол хөрөнгийг "шатлал 3"-руу шилжүүлэн ангилах ба ХБЭА-ыг нийт хугацааны турш дахь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалд үндэслэн тооцдог. Банкны эрсдэлийн үнэ цэнийн бууралттай хөрөнгө болон чанаргүйдлийн тодорхойлолтыг Тодруулга 34-т тайлбарласан. Худалдан авсан, шинээр гаргасан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА нь үргэлж хөрөнгийн нийт хугацааны турш дахь ХБЭА-тай ижил хэмжигдэнэ. ХБЭА-ын загварыг хэмжихэд ашиглагдсан мэдээлэл, таамаглал, тооцооллын аргууд болон ХБЭА-ын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллийг Банк хэрхэн ашигласан талаарх тайлбарыг Тодруулга 34-өөс харна уу.

Үүнээс гадна зээл болон ашиглагдаагүй байгаа зээлийн шугамыг хоёуланг нь багтаасан зээлийн карт гэх мэт санхүүгийн зарим хэрэглүүрүүдийн хувьд Банк хугацааны туршид хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тухайн хугацаа нь хамгийн ихдээ гэрээний хугацаатай адилхан болсон ч гэсэн зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр энэхүү алдагдлыг багасгах хүртэл тооцоолдог. Зээлийн эргэн төлөлтийг шаардах болон ашиглагдаагүй байгаа шугамын гэрээг цуцлах гэрээгээрх эрх нь гэрээний дагуу шаардах хугацаанд эрсдэлийн алдагдлын дүнд хязгаарлалт тавьдаггүйтэй холбоотой.

2025 онд ажилчдад олгосон зах зээлийн хүүнээс бага хүүтэй зээлтэй холбогдуулан 1,372,174 мянган төгрөг (2024: 4,120,258 мянган төгрөг)-ийн алдагдлыг тайлант жилийн ашиг, алдагдалд бүртгэсэн.

**Санхүүгийн хөрөнгө - данснаас хасах.** Банк элэгдэж дууссан, дахин ашиглах боломжгүй гэж дүгнэсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн данснаас хасдаг. Бүртгэлээс хасах нь данснаас хасагдсан үйл явдлыг илэрхийлнэ. Банк гэрээгээр хүлээгдэж буй төлбөрийг нөхөн төлөхийг оролдох үед хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа хэвээр байгаа санхүүгийн хөрөнгийг данснаас хасах боломжтой боловч эргэн төлөгдөх үндэслэл болохгүй.

ХӨ-өөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дансны үнэ болон зээлжих эрсдэлийн сангийн ангилалыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах хүснэгтээр харууллаа:

Мянган төгрөгөөр	2025 оны 12 сарын 31			2024 оны 12 сарын 31		
	Нийт дансны дүн	Зээлжих эрсдэлийн сан	Дансны дүн	Нийт дансны дүн	Зээлжих эрсдэлийн сан	Дансны дүн
Бизнесийн зээл	7,386,545,159	(527,507,560)	6,859,037,599	5,882,675,052	(475,743,698)	5,406,931,354
Хэрэглээний зээл	6,254,564,282	(281,683,110)	5,972,881,172	4,997,206,761	(166,603,827)	4,830,602,934
Хөдөө аж ахуйн зээл	451,674,702	(29,543,158)	422,131,544	650,868,842	(92,780,093)	558,088,749
<b>Нийт дүн</b>	<b>14,092,784,143</b>	<b>(838,733,828)</b>	<b>13,254,050,315</b>	<b>11,530,750,655</b>	<b>(735,127,618)</b>	<b>10,795,623,037</b>

Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дансны үлдэгдэл болон зээлжих эрсдэлийн сангийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг доорх хүснэгтээр харуулав:

Мянган төгрөгөөр	Зээлжих эрсдэлийн сан			Нийт дүн	Нийт дансны дүн			Нийт дүн
	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)		Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	
<b>БИЗНЕСИЙН ЗЭЭЛ</b>								
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар</b>	64,161,626	105,937,361	305,644,711	<b>475,743,698</b>	5,114,179,544	387,880,772	380,614,736	5,882,675,052
Шинээр олгосон болон худалдан авсан	101,857,823	-	-	<b>101,857,823</b>	12,541,064,917	-	-	12,541,064,917
Тайлант хугацаанд данснаас хассан	(91,449,967)	(46,815,816)	(77,355,450)	<b>(215,621,233)</b>	(10,537,245,807)	(405,228,875)	(118,744,797)	(11,061,219,479)
- Шилжилт/Шатлал 1-рүү	351,307	(7,497,697)	-	<b>(7,146,390)</b>	43,841,789	(43,841,789)	-	-
- Шилжилт/Шатлал 2-руу	(11,057,204)	144,420,543	(18,678,425)	<b>114,684,914</b>	(705,334,381)	729,154,054	(23,819,673)	-
- Шилжилт/Шатлал 3-руу	-	(43,986,117)	82,870,561	<b>38,884,444</b>	-	(149,363,389)	149,363,389	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	1,382,392	(1,119,227)	<b>263,165</b>	13,479,636	2,140,911	(1,633,587)	13,986,960
Загварын таамаглалын өөрчлөлт	737,606	5,933,066	12,121,461	<b>18,792,133</b>	-	-	-	-
<b>Тайлант хугацааны зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт</b>	<b>439,565</b>	<b>53,436,371</b>	<b>(2,161,080)</b>	<b>51,714,856</b>	<b>1,355,806,154</b>	<b>132,860,912</b>	<b>5,165,332</b>	<b>1,493,832,398</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>								
Данснаас хассан	-	-	(32,890)	<b>(32,890)</b>	-	-	(32,890)	(32,890)
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлтүүд	72,891	39	8,966	<b>81,896</b>	9,960,268	99,379	10,952	10,070,599
<b>2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар</b>	<b>64,674,082</b>	<b>159,373,771</b>	<b>303,459,707</b>	<b>527,507,560</b>	<b>6,479,945,966</b>	<b>520,841,063</b>	<b>385,758,130</b>	<b>7,386,545,159</b>

Мянган төгрөгөөр	Зээлжих эрсдэлийн сан			Нийт дансны дүн				
	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн
<b>БИЗНЕСИЙН ЗЭЭЛ</b>								
<b>2024 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар</b>	<b>46,683,209</b>	<b>119,562,466</b>	<b>297,410,326</b>	<b>463,656,001</b>	<b>3,298,019,708</b>	<b>939,882,914</b>	<b>378,289,212</b>	<b>4,616,191,834</b>
Шинээр олгосон болон худалдан авсан	114,143,734	-	-	<b>114,143,734</b>	10,433,758,318	-	-	10,433,758,318
Тайлант хугацаанд данснаас хассан	(52,305,013)	(40,062,426)	(74,899,138)	<b>(167,266,577)</b>	(8,253,056,956)	(802,939,418)	(115,762,178)	(9,171,758,552)
- Шилжилт/Шатлал 1-рүү	2,336,078	(21,556,027)	-	<b>(19,219,949)</b>	322,721,369	(322,721,369)	-	-
- Шилжилт/Шатлал 2-руу	(47,499,530)	73,657,308	(3,435,038)	<b>22,722,740</b>	(698,783,147)	704,043,533	(5,260,386)	-
- Шилжилт/Шатлал 3-руу	-	(48,212,373)	75,772,179	<b>27,559,806</b>	-	(126,256,235)	126,256,235	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	26,783	(851,180)	325,938	<b>(498,459)</b>	10,718,744	(4,071,846)	251,407	6,898,305
Загварын таамаглалын өөрчлөлт	759,881	23,399,725	13,628,745	<b>37,788,351</b>	-	-	-	-
<b>Тайлант хугацааны зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт</b>	<b>17,461,933</b>	<b>(13,624,973)</b>	<b>11,392,686</b>	<b>15,229,646</b>	<b>1,815,358,328</b>	<b>(551,945,335)</b>	<b>5,485,078</b>	<b>1,268,898,071</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>								
Данснаас хассан	-	-	(3,157,964)	(3,157,964)	-	-	(3,157,964)	<b>(3,157,964)</b>
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлтүүд	16,484	(132)	(337)	16,015	801,508	(56,807)	(1,590)	<b>743,111</b>
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар</b>	<b>64,161,626</b>	<b>105,937,361</b>	<b>305,644,711</b>	<b>475,743,698</b>	<b>5,114,179,544</b>	<b>387,880,772</b>	<b>380,614,736</b>	<b>5,882,675,052</b>

Мянган төгрөгөөр	Зээлжих эрсдэлийн сан			Нийт дансны дүн				
	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн
<b>ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ</b>								
<b>2024 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар</b>	<b>27,815,917</b>	<b>19,943,221</b>	<b>118,844,689</b>	<b>166,603,827</b>	<b>4,605,572,994</b>	<b>223,045,360</b>	<b>168,588,407</b>	<b>4,997,206,761</b>
Шинээр олгосон болон худалдан авсан	46,726,992	-	-	<b>46,726,992</b>	8,548,173,631	-	-	<b>8,548,173,631</b>
Тайлант хугацаанд данснаас хассан	(36,462,680)	(7,622,972)	(19,381,694)	<b>(63,467,346)</b>	(7,067,749,902)	(135,036,993)	(103,269,120)	<b>(7,306,056,015)</b>
- Шилжилт/Шатлал 1-рүү	94,304	(3,018,783)	-	(2,924,479)	16,741,118	(16,741,118)	-	-
- Шилжилт/Шатлал 2-рүү	(7,602,667)	22,378,333	(5,125,499)	9,650,167	(480,531,453)	488,625,425	(8,093,972)	-
- Шилжилт/Шатлал 3-рүү	-	(11,422,781)	126,522,333	115,099,552	-	(308,871,374)	308,871,374	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	68,522	791,580	<b>860,102</b>	17,908,120	302,876	2,197,559	<b>20,408,555</b>
Загварын таамаглалын өөрчлөлт	2,727,317	578,173	11,006,013	<b>14,311,503</b>	-	-	-	-
<b>Тайлант хугацааны зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт</b>	<b>5,483,266</b>	<b>960,492</b>	<b>113,812,733</b>	<b>120,256,491</b>	<b>1,034,541,514</b>	<b>28,278,816</b>	<b>199,705,841</b>	<b>1,262,526,171</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>								
Данснаас хассан	-	-	(5,178,136)	<b>(5,178,136)</b>	-	-	(5,178,136)	<b>(5,178,136)</b>
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлтүүд	33	6	889	<b>928</b>	6,216	2,186	1,084	<b>9,486</b>
<b>2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар</b>	<b>33,299,216</b>	<b>20,903,719</b>	<b>227,480,175</b>	<b>281,683,110</b>	<b>5,640,120,724</b>	<b>251,326,362</b>	<b>363,117,196</b>	<b>6,254,564,282</b>

Мянган төгрөгөөр	Зээлжих эрсдэлийн сан			Нийт дансны дүн				
	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн
<b>ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ</b>								
<b>2024 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар</b>	<b>26,418,039</b>	<b>27,270,842</b>	<b>95,825,559</b>	<b>149,514,440</b>	<b>3,847,359,872</b>	<b>234,274,953</b>	<b>125,467,324</b>	<b>4,207,102,149</b>
Шинээр олгосон болон худалдан авсан	41,882,642	-	-	<b>41,882,642</b>	7,544,929,561	-	-	7,544,929,561
Тайлант хугацаанд данснаас хассан	(39,486,235)	(9,320,730)	(13,665,115)	(62,472,080)	(6,606,180,571)	(110,700,759)	(39,185,277)	(6,756,066,607)
- Шилжилт/Шатлал 1-рүү	70,868	(1,128,472)	-	(1,057,604)	10,569,381	(10,569,381)	-	-
- Шилжилт/Шатлал 2-руу	(4,259,233)	8,734,005	(477,309)	3,997,463	(196,834,356)	197,819,751	(985,394)	-
- Шилжилт/Шатлал 3-руу	-	(6,545,285)	36,878,271	30,332,986	-	(87,888,955)	87,888,955	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	3,425	(57,574)	148,995	94,846	5,728,273	109,656	78,174	5,916,103
Загварын таамаглалын өөрчлөлт	3,186,402	990,434	4,809,615	8,986,451	-	-	-	-
<b>Тайлант хугацааны зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт</b>	<b>1,397,869</b>	<b>(7,327,622)</b>	<b>27,694,457</b>	<b>21,764,704</b>	<b>758,212,288</b>	<b>(11,229,689)</b>	<b>47,796,458</b>	<b>794,779,057</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>								
Данснаас хассан	-	-	(4,675,498)	(4,675,498)	-	-	(4,675,498)	<b>(4,675,498)</b>
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлтүүд	9	1	171	181	834	96	123	<b>1,053</b>
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар</b>	<b>27,815,917</b>	<b>19,943,221</b>	<b>118,844,689</b>	<b>166,603,827</b>	<b>4,605,572,994</b>	<b>223,045,360</b>	<b>168,588,407</b>	<b>4,997,206,761</b>

Мянган төгрөгөөр	Зээлжих эрсдэлийн сан				Нийт дансны дүн			
	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн
<b>ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗЭЭЛ</b>								
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар</b>	<b>4,736,183</b>	<b>79,893,706</b>	<b>8,150,204</b>	<b>92,780,093</b>	<b>281,831,008</b>	<b>360,017,007</b>	<b>9,020,827</b>	<b>650,868,842</b>
Шинээр олгосон болон худалдан авсан	3,905,280	-	-	3,905,280	417,284,338	-	-	417,284,338
Тайлант хугацаанд данснаас хассан	(6,086,758)	(72,315,359)	(3,145,686)	(81,547,803)	(334,896,666)	(259,905,026)	(5,803,757)	(600,605,449)
- Шилжилт/Шатлал 1-рүү	299	(3,372)	-	(3,073)	166,103	(166,103)	-	-
- Шилжилт/Шатлал 2-рүү	(1,309,237)	10,065,301	(109,456)	8,646,608	(122,590,141)	122,707,242	(117,101)	-
- Шилжилт/Шатлал 3-рүү	-	(2,097,135)	6,570,428	4,473,293	-	(12,752,103)	12,752,103	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	(9,126)	(19,695)	(28,821)	(4,615,724)	(11,168,870)	18,503	(15,766,091)
Загварын таамаглалын өөрчлөлт	50,268	427,732	946,519	1,424,519	-	-	-	-
<b>Тайлант хугацааны зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт</b>	<b>(3,440,148)</b>	<b>(63,931,959)</b>	<b>4,242,110</b>	<b>(63,129,997)</b>	<b>(44,652,090)</b>	<b>(161,284,860)</b>	<b>6,849,748</b>	<b>(199,087,202)</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>								
Данснаас хассан	-	-	(106,938)	(106,938)	-	-	(106,938)	(106,938)
<b>2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар</b>	<b>1,296,035</b>	<b>15,961,747</b>	<b>12,285,376</b>	<b>29,543,158</b>	<b>237,178,918</b>	<b>198,732,147</b>	<b>15,763,637</b>	<b>451,674,702</b>

Мянган төгрөгөөр	Зээлжих эрсдэлийн сан				Нийт дансны дүн			
	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (ЗЭМӨ-ийн нийт хугацааны ХБЭА)	Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралтын нийт хугацааны ХБЭА)	Нийт дүн
<b>ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗЭЭЛ</b>								
<b>2024 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар</b>	<b>3,023,251</b>	<b>30,498,301</b>	<b>5,757,901</b>	<b>39,279,453</b>	<b>463,469,872</b>	<b>191,438,168</b>	<b>7,799,486</b>	<b>662,707,526</b>
Шинээр олгосон болон худалдан авсан	5,937,276	-	-	5,937,276	<b>409,137,926</b>	-	-	<b>409,137,926</b>
Тайлант хугацаанд данснаас хассан	(4,480,419)	(12,555,002)	(750,730)	(17,786,151)	<b>(325,025,464)</b>	(102,828,940)	(2,444,647)	<b>(430,299,051)</b>
- Шилжилт/Шатлал 1-рүү	788,137	(4,228,766)	-	(3,440,629)	<b>25,988,232</b>	(25,988,232)	-	-
- Шилжилт/Шатлал 2-рүү	(2,566,227)	53,208,466	(504,455)	50,137,784	<b>(288,945,062)</b>	289,781,021	(835,959)	-
- Шилжилт/Шатлал 3-рүү	-	(193,919)	1,959,562	1,765,643	-	(4,464,566)	4,464,566	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	2,914	405	42,002	45,321	<b>(2,794,496)</b>	12,079,556	72,448	<b>9,357,508</b>
Загварын таамаглалын өөрчлөлт	2,031,251	13,164,221	1,680,991	16,876,463	-	-	-	-
<b>Тайлант хугацааны зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт</b>	<b>1,712,932</b>	<b>49,395,405</b>	<b>2,427,370</b>	<b>53,535,707</b>	<b>(181,638,864)</b>	<b>168,578,839</b>	<b>1,256,408</b>	<b>(11,803,617)</b>
Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:								
Данснаас хассан	-	-	(35,067)	(35,067)	-	-	(35,067)	(35,067)
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар</b>	<b>4,736,183</b>	<b>79,893,706</b>	<b>8,150,204</b>	<b>92,780,093</b>	<b>281,831,008</b>	<b>360,017,007</b>	<b>9,020,827</b>	<b>650,868,842</b>

Нийт зээлийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлжилтийн чанарыг харууллаа:

	2025 оны 12 дугаар сарын 31				2024 оны 12 дугаар сарын 31			
	Чанаргүйдэх магадлал	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл	Нийт дансны дүн	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл
0,00%-с <0,15% хүртэл	124,712,476	206,356,277	1,814,472	332,883,225	114,623,633	165,904,499	607,314	281,135,446
0,15%-с <0,25% хүртэл	40,789,304	12,912,522	563,848	54,265,674	-	6,904,270	-	6,904,270
0,25%-с <0,50% хүртэл	22,340,240	65,027,209	1,181,522	88,548,971	106,625,175	64,472,413	1,797,919	172,895,507
0,50%-с <0,75% хүртэл	128,168,727	145,264,089	13,232,224	286,665,040	67,350,432	76,649,342	4,500,078	148,499,852
0,75%-с <2,50% хүртэл	543,491,422	5,209,197,522	206,488,073	5,959,177,017	379,868,723	4,278,074,255	25,290,653	4,683,233,631
2,50%-с <10,0% хүртэл	5,619,456,993	-	13,683,391	5,633,140,384	4,443,402,193	-	249,446,582	4,692,848,775
10,0%-с <45,0% хүртэл	986,804	1,363,105	215,388	2,565,297	366,425	982,464	139,124	1,488,013
45,0%-с <65,8% хүртэл	-	-	-	-	1,942,963	12,585,751	49,338	14,578,052
<b>Нийт дүн Шатлал 1</b>	<b>6,479,945,966</b>	<b>5,640,120,724</b>	<b>237,178,918</b>	<b>12,357,245,608</b>	<b>5,114,179,544</b>	<b>4,605,572,994</b>	<b>281,831,008</b>	<b>10,001,583,546</b>

Чанаргүйдэх магадлал	2025 оны 12 дугаар сарын 31				2024 оны 12 дугаар сарын 31			
	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл	Нийт дансны дүн	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл	Нийт дансны дүн
0,00%-с <0,15% хүртэл	3,717,997	1,101,481	4,045,164	8,864,642	3,017,663	1,085,498	1,357,318	5,460,479
0,15%-с <0,25% хүртэл	3,355,003	179,048	1,307,549	4,841,600	-	66,200	595,130	661,330
0,25%-с <0,50% хүртэл	16,869	689,827	4,194,569	4,901,265	1,243,114	474,246	798,620	2,515,980
0,50%-с <0,75% хүртэл	1,751,060	1,841,888	12,953,113	16,546,061	4,488,712	600,063	7,132,544	12,221,319
0,75%-с <2,50% хүртэл	13,976,286	11,551,476	86,259,621	111,787,383	13,538,420	10,620,870	40,248,818	64,408,108
2,50%-с <10,0% хүртэл	116,600,860	81,920,134	83,749,423	282,270,417	87,054,845	47,089,227	306,597,244	440,741,316
10,0%-с <45,0% хүртэл	287,003,732	100,984,142	4,547,801	392,535,675	241,610,520	100,703,000	1,822,473	344,135,993
45,0%-с дээш	94,419,256	53,058,366	1,674,907	149,152,529	36,927,498	62,406,256	1,464,860	100,798,614
<b>Нийт дүн Шатлал 2</b>	<b>520,841,063</b>	<b>251,326,362</b>	<b>198,732,147</b>	<b>970,899,572</b>	<b>387,880,772</b>	<b>223,045,360</b>	<b>360,017,007</b>	<b>970,943,139</b>

Чанаргүйдэх хугацаа	2025 оны 12 дугаар сарын 31				2024 оны 12 дугаар сарын 31			
	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл	Нийт дансны дүн	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл	Нийт дансны дүн
12 хүртэлх сар	138,322,297	249,738,191	9,633,610	397,694,098	118,102,928	78,384,803	3,955,234	200,442,965
13-с 24 хүртэлх сар	45,033,326	43,343,867	2,675,429	91,052,622	124,518,704	25,839,545	2,724,786	153,083,035
25-с 36 хүртэлх сар	86,977,835	18,539,983	1,636,518	107,154,336	65,034,741	13,292,373	979,847	79,306,961
37-с 48 хүртэлх сар	56,541,275	9,539,577	605,074	66,685,926	30,503,884	7,967,110	129,056	38,600,050
49-с 60 хүртэлх сар	20,253,973	6,178,185	98,481	26,530,639	7,091,785	9,738,204	1,035,380	17,865,369
61-с 84 хүртэлх сар	11,879,701	25,036,920	956,999	37,873,620	8,086,736	27,684,108	37,292	35,808,136
84-с дээш сар	26,749,723	10,740,473	157,526	37,647,722	27,275,958	5,682,264	159,232	33,117,454
<b>Нийт дүн Шатлал 3</b>	<b>385,758,130</b>	<b>363,117,196</b>	<b>15,763,637</b>	<b>764,638,963</b>	<b>380,614,736</b>	<b>168,588,407</b>	<b>9,020,827</b>	<b>558,223,970</b>

Харилцагчдад олгосон зээлийн багцын эдийн засгийн эрсдэлийн төвлөрөл дараах байдалтай байна:

САЛБАР	2025 оны 12 дугаар сарын 31		2024 оны 12 дугаар сарын 31	
	Дүн	%	Дүн	%
Хувь хүмүүс	6,534,626,140	45%	5,397,513,707	45%
Худалдаа, арилжаа	2,846,407,336	20%	2,359,521,417	20%
Барилга	976,854,548	7%	850,230,672	7%
Хөдөө аж ахуй	885,788,417	6%	753,993,385	6%
Боловсруулах үйлдвэр	906,369,962	6%	678,191,021	6%
Уул уурхай	486,049,401	3%	345,894,108	3%
ЖДҮ	307,617,294	2%	428,627,920	4%
Тээвэр	278,809,778	2%	268,496,678	2%
Үл хөдлөх хөрөнгө	258,889,015	2%	192,970,603	2%
Цахилгаан эрчим хүчний үйлдвэр	243,341,910	2%	116,437,803	1%
Боловсрол	135,838,730	1%	103,175,639	1%
Бусад	512,253,469	4%	436,004,647	4%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>14,372,846,000</b>	<b>100%</b>	<b>11,931,057,602</b>	<b>100%</b>

Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн хувь хүнд олгосон зээлийн барьцаа хөрөнгийн мэдээллийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл	Нийт дүн
Зээлийн сайжруулалтаар баталгаажсан зээл:				
- Зээлийн сайжруулалт	-	3,985,443,074	-	3,985,443,074
Зээлийн барьцааны төрөл:				
- үл хөдлөх хөрөнгө	5,339,099,771	1,637,384,884	40,360,110	7,016,844,765
- бусад	795,410,207	65,103,627	400,426,834	1,260,940,668
- бэлэн мөнгө	3,498,745	490,733,258	-	494,232,003
- эргэлтэнд байгаа бараа	429,038,274	1,054,245	4,836	430,097,355
- машин	392,226,234	31,137,212	4,308,733	427,672,179
- тоног төхөөрөмж	168,398,250	1,563,749	3,755,478	173,717,477
- лиценз	89,593,906	-	-	89,593,906
<b>Нийт дүн</b>	<b>7,217,265,387</b>	<b>6,212,420,049</b>	<b>448,855,991</b>	<b>13,878,541,427</b>
Барьцаагүй зээл	169,279,772	42,144,233	2,818,711	214,242,716
<b>Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дансны үнэ</b>	<b>7,386,545,159</b>	<b>6,254,564,282</b>	<b>451,674,702</b>	<b>14,092,784,143</b>

Хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн хувь хүнд олгосон зээлийн барьцаа хөрөнгийн мэдээллийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл	Нийт дүн
Зээлийн сайжруулалтаар баталгаажсан зээл:				
- Зээлийн сайжруулалт	-	3,252,913,247	-	3,252,913,247
Зээлийн барьцааны төрөл:				
- үл хөдлөх хөрөнгө	4,367,973,532	1,213,830,926	39,832,378	5,621,636,836
- бусад	557,205,711	51,167,554	591,388,291	1,199,761,556
- бэлэн мөнгө	42,327	400,544,993	-	400,587,320
- машин	334,380,767	39,891,087	8,799,786	383,071,640
- эргэлтэнд байгаа бараа	300,697,175	728,702	12,264	301,438,141
- тоног төхөөрөмж	140,362,124	1,517,305	5,321,221	147,200,650
- лиценз	4,115,485	-	-	4,115,485
<b>Нийт дүн</b>	<b>5,704,777,121</b>	<b>4,960,593,814</b>	<b>645,353,940</b>	<b>11,310,724,875</b>
Барьцаагүй зээл	177,897,931	36,612,947	5,514,902	220,025,780
<b>Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дансны үнэ</b>	<b>5,882,675,052</b>	<b>4,997,206,761</b>	<b>650,868,842</b>	<b>11,530,750,655</b>

Зээлийн сайжруулалт нь ирээдүйн орлого олох цалин, тэтгэвэр, кредит карт зэрэг хэрэглээний зээлээс бүрдэнэ. Бусад барьцаанд голчлон мал болон авлагууд багтана. Дээрх тодруулга нь олгосон зээл болон барьцаа хөрөнгийн дансны үнийн бага хэсгийг л илэрхийлнэ. Үлдсэн хэсгийг барьцаагүй зээлийн ангилалд тодруулна. Зээлийн дансны үнийг барьцаанд авсан хөрөнгийн хөрвөх чадварт үндэслэн хуваарилсан.

ААБҮЦ-ээр бүртгэгдсэн хувь хүнд олгосон зээлийн барьцаа хөрөнгийн мэдээллийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл	Нийт дүн
Зээлийн барьцааны төрөл:				
- үл хөдлөх хөрөнгө	-	274,663,878	-	274,663,878
- Бусад	-	175,525	-	175,525
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>274,839,403</b>	<b>-</b>	<b>274,839,403</b>
Барьцаагүй зээл	-	5,222,454	-	5,222,454
<b>Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дансны үнэ</b>	<b>-</b>	<b>280,061,857</b>	<b>-</b>	<b>280,061,857</b>

ААБҮЦ-ээр хэмжигдсэн хувь хүнд олгосон зээлийн барьцаа хөрөнгийн мэдээллийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Хөдөө аж ахуйн зээл	Нийт дүн
Зээлийн барьцааны төрөл:				
- үл хөдлөх хөрөнгө	-	400,295,496	-	400,295,496
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>400,295,496</b>	<b>-</b>	<b>400,295,496</b>
Барьцаагүй зээл	-	11,451	-	11,451
<b>Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дансны үнэ</b>	<b>-</b>	<b>400,306,947</b>	<b>-</b>	<b>400,306,947</b>

Хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн болон үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгүүдийн зээлийн эрсдэлийг бууруулж буй барьцаа хөрөнгө болон зээлийн сайжруулалтын бусад хүчин зүйлсийг дараах байдлаар тусад нь толилуулсан (1) барьцаа хөрөнгө болон зээлийн сайжруулалтын бусад хүчин зүйлс нь хөрөнгийн дансны үнэтэй тэнцүү буюу их (илүү барьцаа бүхий хөрөнгө) мөн (2) барьцаа хөрөнгө болон зээлийн сайжруулалтын бусад хүчин зүйлс нь хөрөнгийн дансны үнээс бага (дутуу барьцаа бүхий хөрөнгө). Үнэ цэнэ буурсан хөрөнгүүд дэх барьцаа хөрөнгийн нөлөөг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доор харууллаа:

Мянган төгрөгөөр	Илүү барьцаа бүхий хөрөнгө		Дутуу барьцаа бүхий хөрөнгө	
	Хөрөнгийн дансны үнэ	Барьцаа хөрөнгийн үнэ	Хөрөнгийн дансны үнэ	Барьцаа хөрөнгийн үнэ
<b>2025 оны 12 дугаар сарын 31</b>				
Бизнесийн зээл	367,209,960	2,056,958,540	18,548,170	6,936,399
Хэрэглээний зээл	334,694,709	702,499,600	28,422,487	9,658,874
Хөдөө аж ахуйн зээл	15,571,918	117,095,586	191,719	120,065
<b>2024 оны 12 дугаар сарын 31</b>				
Бизнесийн зээл	356,175,777	1,947,002,915	24,438,959	13,572,031
Хэрэглээний зээл	142,772,823	386,102,207	25,815,585	7,053,124
Хөдөө аж ахуйн зээл	8,904,314	60,060,505	116,514	72,200

#### Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрч шилжүүлсэн санхүүгийн хөрөнгүүд

Банк тайлант жилийн хугацаанд тогтмол хүүтэй үл хөдлөх хөрөнгийн барьцаат зээлийн багцаас орж ирэх мөнгөн урсгалыг авах 100%-ийн эрхийг МИК-ийн эзэмшлийн тусгай зориулалтын компаниудад худалдаж, оронд нь Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг "ИЗББ"-ыг худалдан авсан. Банк санхүүгийн тайланд 374,803,800 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 94,650,500 мянган төгрөг)-ийн зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрч 37,480,700 мянган төгрөг болон 337,323,100 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 9,465,200 мянган төгрөг ба 85,185,300 мянган төгрөг)-ийн давуу эрхтэй болон энгийн ИЗББ-ыг санхүүгийн хөрөнгөөр тус тус хүлээн зөвшөөрсөн.

#### ААБҮЦ-ээр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Банк 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 280,061,857 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 400,306,947 мянган төгрөг)-ийн ипотекийн харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны багцыг эзэмшиж байгаа ба ААБҮЦ-ээр ангилагдсан байна.

## 12. Бусад хөрөнгө

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
<b>ХӨ-өөр хэмжигдэх бусад санхүүгийн хөрөнгө</b>		
Байгууллага болон Засгийн газрын байгууллагаас авах авлага*	87,135,218	67,346,196
Төлбөр тооцоо үйлчилгээний авлага	14,996,160	5,358,366
Факторингийн авлага	4,401,319	4,216,496
Хувь хүнээс авах авлага	2,287,076	5,382,191
Бусад санхүүгийн хөрөнгө	7,801,908	4,433,613
Хасах: Зээлжих эрсдэлийн сан	(39,040,123)	(38,166,893)
<b>Нийт ХӨ-өөр хэмжигдэх бусад санхүүгийн хөрөнгө</b>	<b>77,581,558</b>	<b>48,569,969</b>
<b>Бусад санхүүгийн бус хөрөнгө</b>		
Ажилчдын хойшлуулсан тэтгэмж**	75,450,314	60,105,570
Урьдчилж төлсөн зардал	35,081,203	28,990,556
Эргэлтийн бус хөрөнгийн урьдчилгаа төлбөр	43,980,969	13,801,936
Бусад урьдчилгаа төлбөр	7,504,393	15,708,671
Оффисын бараа материал, хангамжийн материал	10,355,812	13,789,154
Өмчлөх бусад хөрөнгө	3,110,715	3,315,979
<b>Нийт санхүүгийн бус хөрөнгө</b>	<b>175,483,406</b>	<b>135,711,866</b>
Хасах: Өмчлөх бусад хөрөнгийн сан	(3,110,715)	(3,315,979)
<b>Нийт бусад санхүүгийн бус хөрөнгө</b>	<b>172,372,691</b>	<b>132,395,887</b>
<b>Нийт бусад хөрөнгө</b>	<b>249,954,249</b>	<b>180,965,856</b>

\* Байгууллагаас авах авлагад Монгол Улсын Зам Тээврийн Хөгжлийн Яаманд олгосон 27,196,173 мянган төгрөг (2024 оны 12 дугаар сарын 31: 26,153,107 мянган төгрөг)-ийн баталгаатай холбогдуулан БНХАУ-ын Худалдаа, аж үйлдвэрийн банк (ICBC-C)-аас авсан эсрэг баталгааны авлага багтсан болно. Банк ICBC-ээс өгсөн баталгааг идэвхжүүлж чадаагүй тул шүүхэд нэхэмжлэл гаргасан. Энэ хэрэг нь БНХАУ-ын Дээд шүүхэд байгаа бөгөөд Банк авлагад 100%-ийн санг байгуулсан.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ICBC-ээс авах дээрх авлагыг "шатлал 3"-т, үлдсэн бусад хөрөнгийг "шатлал 1"-д ангилсан.

\*\* Банк ажилтнууддаа хөнгөлөлттэй зээл олгодог. Бодит үнэ цэнийн тохируулга нь ажилтнуудад олгосон хөнгөлөлттэй зээлийг анх олгоход тохируулагдах бодит үнэ цэнэ нь цалингийн урьдчилсан төлбөрт хамаарах ба зээлийн хугацааны туршид хорогдуулдаг.

Үнэ цэнийн бууралтын сангийн гарзын нэгтгэл дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
<b>Бусад авлагын үнэ цэнэ бууралтын сан</b>		
1 сарын 1-ний өдрийн байдлаар	<b>38,166,893</b>	<b>28,279,462</b>
Тайлант жилийн зардал	9,879,551	10,013,871
Буцаалт	(10,020,430)	(84,349)
Тайлант жилийн цэвэр (буцаалт)/зардал (Тодруулга 27)	<b>(140,879)</b>	<b>9,929,522</b>
Данснаас хассан	(117,553)	(107,440)
Гадаад валютын ханшийн зөрүү	1,131,662	65,349
<b>12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>39,040,123</b>	<b>38,166,893</b>
<b>Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан</b>		
1 сарын 1-ний өдрийн байдлаар	<b>3,315,979</b>	<b>4,612,381</b>
Тайлант жилийн цэвэр (буцаалт)/зардал	(205,264)	(1,296,402)
<b>12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>3,110,715</b>	<b>3,315,979</b>

## 13. Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Газар ба барилга	Компьютер тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил, тээврийн хэрэгсэл	Дуусаагүй барилга	Нийт дүн
<b>2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>					
<b>Өртөг/үнэлгээ</b>					
2025 оны 1 сарын 1-нээр	316,348,298	341,012,924	77,372,032	9,075,277	743,808,531
Нэмэгдсэн	2,352,837	28,343,271	4,870,557	19,496,509	55,063,174
Борлуулсан	(589,700)	(125,262)	(1,389,318)	-	(2,104,280)
Данснаас хассан	(19,915)	(24,371,680)	(1,693,490)	-	(26,085,085)
Дахин үнэлсэн	54,031,824	-	-	-	54,031,824
Ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилсны дагуу дахин үнэлгээний гарз	(4,799,955)	-	-	-	(4,799,955)
<b>2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>367,323,389</b>	<b>344,859,253</b>	<b>79,159,781</b>	<b>28,571,786</b>	<b>819,914,209</b>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>					
2025 оны 1 сарын 1-нээр	25,183,623	218,624,925	40,530,396	-	284,338,944
Тайлант жилийн зардал (Тодруулга 29)	7,652,389	46,800,811	7,120,608	-	61,573,808
Борлуулсан	(114,403)	(78,778)	(1,344,938)	-	(1,538,119)
Данснаас хассан	(7,072)	(24,206,905)	(1,429,131)	-	(25,643,108)
Хуримтлагдсан элэгдлийн буцаалт	(28,345,201)	-	-	-	(28,345,201)
<b>2025 оны 12 дугаар сарын 31-ний өдийн байдлаар</b>	<b>4,369,336</b>	<b>241,140,053</b>	<b>44,876,935</b>	<b>-</b>	<b>290,386,324</b>
<b>Дансны цэвэр дүн</b>	<b>362,954,053</b>	<b>103,719,200</b>	<b>34,282,846</b>	<b>28,571,786</b>	<b>529,527,885</b>
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>					
<b>Өртөг/үнэлгээ</b>					
2024 оны 1 сарын 1-нээр	311,880,082	304,323,002	71,282,306	9,743,623	697,229,013
Нэмэгдсэн	14,570	53,141,803	9,886,870	3,794,440	66,837,683
Шилжүүлсэн	4,462,786	-	-	(4,462,786)	-
Борлуулсан	-	(2,254,684)	(2,552,585)	-	(4,807,269)
Данснаас хассан	(9,140)	(14,197,197)	(1,244,559)	-	(15,450,896)
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>316,348,298</b>	<b>341,012,924</b>	<b>77,372,032</b>	<b>9,075,277</b>	<b>743,808,531</b>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>					
2024 оны 1 сарын 1-нээр	18,375,618	189,854,427	36,629,795	-	244,859,840
Тайлант жилийн зардал (Тодруулга 29)	6,811,795	45,019,023	7,422,192	-	59,253,010
Борлуулсан	-	(2,193,751)	(2,534,830)	-	(4,728,581)
Данснаас хассан	(3,790)	(14,054,774)	(986,761)	-	(15,045,325)
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний өдийн байдлаар</b>	<b>25,183,623</b>	<b>218,624,925</b>	<b>40,530,396</b>	<b>-</b>	<b>284,338,944</b>
<b>Дансны цэвэр дүн</b>	<b>291,164,675</b>	<b>122,387,999</b>	<b>36,841,636</b>	<b>9,075,277</b>	<b>459,469,587</b>

Барилгыг дор дурдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тусгадаг.

Банкны эзэмшиж буй барилгыг анх өртгөөр нь хэмжиж бүртгэх ба дахин үнэлэгдсэн тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн дансны үнэ нь бодит үнээс материаллаг зөрүүтэй эсэхийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлнэ. Дахин үнэлгээнээс нэмэгдсэн дансны үнээр бусад дэлгэрэнгүй орлогыг кредитлэн, өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлнэ. Ижил хөрөнгийн өмнө нь үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд өмнө нь хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулах ба бусад бүх бууралтыг тухайн жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийг борлуулах болон данснаас хасахад гарсан нэмэгдэл эсвэл хөрөнгийг Банк ашиглаж буй тохиолдолд өөрийн хөрөнгөнд бүртгэсэн барилга, тоног төхөөрөмжийн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан алдагдал буюу хуримтлагдсан ашигт шууд хааж бүртгэдэг. Сүүлийн тохиолдолд бодит зөрүүгийн хэрэгжсэн өсөлт нь хөрөнгийн дахин үнэлсэн дансны үнээс тооцсон элэгдэл болон хөрөнгийн анхны өртгөөс тооцсон элэгдлийн зөрүүтэй тэнцэнэ.

Банкны эзэмшиж буй тоног төхөөрөмжийг үнэ цэнэ бууралтын гарз болон элэгдлийг хассан дүнгээр бүртгэнэ.

**Үндсэн хөрөнгийн элэгдэл.** Дуусаагүй барилгад элэгдэл тооцдоггүй. Бусад үндсэн хөрөнгүүдийн элэгдлийг өртөг эсвэл дахин үнэлсэн дүнг доорх ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь хуваарилж тооцно:

	Ашиглалтын хугацаа (жилээр)
Барилга	30-67
Компьютер	3-10
Оффисын тавилга, тоног төхөөрөмж	10
Тээврийн хэрэгсэл	10
Ашиглах эрхтэй хөрөнгө	1-5
Зар сурталчилгаа, хаяг	2

**Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ.** 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдөр газар болон барилгуудыг албан ёсны хараат бус хөрөнгийн үнэлгээний компаниудаар дахин үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээ нь барилгын байршил, зориулалт, зах зээл дээрх ижил харицуулагдахуйц мэдээллийг үндэслэн зах зээлийн эсвэл өртгийн аргаар үнэлэгдсэн. Үр дүнд нь 82,377,024 мянган төгрөгийн олзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн.

Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийн дэлгэрэнгүйг Тодруулга 36-аас харна уу

Газар, барилгыг бодит үнэ цэнээр бүртгэдэг. Банкны үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүн нь ижил төрлийн үл хөдлөх хөрөнгийг үнэлж байсан туршлагатай, холбогдох мэргэжлийн мэргэшлийг эзэмшсэн, хараат бус үнэлгээчдийн хийсэн үнэлгээнд тулгуурладаг. Хамгийн сүүлд 2025 онд хараат бус үнэлгээчид үнэлгээг хийсэн. Барилгыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өртгийн загвараар хүлээн зөвшөөрсөн бол газар, барилгын дансны үнэ 188,883,619 мянган төгрөг (2024: 196,803,273 мянган төгрөг) байх байсан. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, Банк нийт 5,738,157 мянган төгрөг (2024: 1,072,349 мянган төгрөг)-ийн үндсэн хөрөнгийг худалдан авах гэрээний үүрэгтэй байсан.

## 14. Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31		2024 оны 12 дугаар сарын 31	
	Компьютер программ хангамж	Нийт дүн	Компьютер программ хангамж	Нийт дүн
<b>Өртгөөр</b>				
1 сарын 1-нээр	110,545,098	110,545,098	108,628,548	108,628,548
Нэмэгдсэн	17,387,258	17,387,258	7,823,535	7,823,535
Данснаас хассан	-	-	(5,906,985)	(5,906,985)
<b>12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>127,932,356</b>	<b>127,932,356</b>	<b>110,545,098</b>	<b>110,545,098</b>
<b>Хорогдуулалт</b>				
1 сарын 1-нээр	76,167,881	76,167,881	65,099,254	65,099,254
Тайлант жилийн зардал (Тодруулга 28)	14,181,521	14,181,521	14,947,797	14,947,797
Данснаас хассан	-	-	(3,879,170)	(3,879,170)
<b>12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>	<b>90,349,402</b>	<b>90,349,402</b>	<b>76,167,881</b>	<b>76,167,881</b>
<b>Дансны цэвэр дүн</b>	<b>37,582,954</b>	<b>37,582,954</b>	<b>34,377,217</b>	<b>34,377,217</b>

## 15. Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөр

Мянган төгрөгөөр	Ашиглах эрхтэй хөрөнгө	Түрээсийн өр төлбөр
<b>2025 оны 1-р сарын 1-ний дүн</b>	<b>14,096,706</b>	<b>15,219,265</b>
Нэмэгдсэн	9,366,014	9,290,089
Тайлант жилийн элэгдэл (Тодруулга 28)	(10,516,150)	-
Хүүгийн зардал (Тодруулга 24)	-	2,482,480
Түрээсийн төлбөр	-	(12,673,798)
<b>2025 оны 12 дугаар сарын 31-ний дүн</b>	<b>12,946,570</b>	<b>14,318,036</b>
<b>2024 оны 1-р сарын 1-нээр</b>	<b>12,115,097</b>	<b>13,036,341</b>
Нэмэгдсэн	11,815,987	11,620,498
Тайлант жилийн элэгдэл (Тодруулга 28)	(9,834,378)	-
Хүүгийн зардал (Тодруулга 24)	-	2,472,839
Түрээсийн төлбөр	-	(11,910,413)
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний дүн</b>	<b>14,096,706</b>	<b>15,219,265</b>

Түрээсийн өглөгийн төлбөр төлөгдөх хугацааны шинжилгээг Тодруулга 38-аас харна уу.

Банкны салбарууд оффисын зориулалтаар талбай түрээслэдэг ба түрээсийн гэрээ ихэвчлэн 1 жилээс 5 жилийн хугацаатай хийгддэг.

Түрээстэй холбоотой ашиг, алдагдлын тайланд тусгагдсан дүнг дараах хүснэгтэд харууллаа:

Мянган төгрөгөөр	2025	2024
Түрээсийн өр төлбөрт тооцсон хүүгийн зардал (Тодруулга 24)	2,482,480	2,472,839
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал (Тодруулга 28)	10,516,150	9,834,378
Богино хугацаат түрээсийн зардал (Тодруулга 28)	1,789,582	1,509,979
Индекс болон ханшаас хамааралгүй түрээсийн хувьсах төлбөр (Үйл ажиллагааны ашиглалтын зардал)	2,163,885	1,666,560
<b>Нийт дүн</b>	<b>16,952,097</b>	<b>15,483,756</b>

## 16. Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Банк санхүүгийн байгууллагын харилцах	36,523,999	13,803,786
Банк санхүүгийн байгууллагын хугацаатай хадгаламж	303,782,602	75,106,945
<b>Нийт дүн</b>	<b>340,306,601</b>	<b>88,910,731</b>

Бусад банкуудын байршуулсан хөрөнгийг харилцагч банкууд Банкинд мөнгө буюу бусад төрлийн хөрөнгө шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Үүсмэл бус өр төлбөрийг ХӨ-өөр бүртгэнэ.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гадаадын банкны байршуулсан хугацаатай хадгаламж жилийн 12.00%-13.70%-ийн хүүтэй, (2024: ам.долларын хадгаламж жилийн 4.40%-ийн хүүтэй, төгрөгийн хадгаламж жилийн 10.00%-ийн хүүтэй), анх тогтоосон хугацаа нь 12-91 хоног (2024: 11-90 хоног) байна.

## 17. Репо хэлцэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэлд Банк Монголбанктай байгуулсан 65,803,113 мянган төгрөг (2024: 87,791,865 мянган төгрөг)-ийн, жилийн 14.0%-ийн хүүтэй (2024: жилийн 12.0%-ийн хүүтэй), анх тогтоосон хугацаа нь 730 хоног (2024: 364-365 хоног)-ийн репо хэлцэл багтсан.

Репо хэлцэл нь Тодруулга 7-д дурдсан Монголбанкны үнэт цаасаар бүрэн баталгаажигдсан болно.

## 18. Харилцагчдын харилцах, хадгаламж

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
<b>Засгийн газар</b>		
- Харилцах данс	723,739,100	1,179,810,644
- Хугацаатай хадгаламж	755,276,703	90,822,552
<b>Хувийн сектор</b>		
- Харилцах данс	2,509,294,474	1,803,325,161
- Хугацаатай хадгаламж	677,289,847	664,011,259
- Барьцаат хадгаламж	69,462,470	50,276,668
<b>Иргэд</b>		
- Харилцах данс	2,346,060,474	2,206,710,152
- Хугацаагүй хадгаламж	2,180,731,852	2,167,802,132
- Хугацаатай хадгаламж	6,505,919,110	6,039,711,389
<b>Нийт дүн</b>	<b>15,767,774,030</b>	<b>14,202,469,957</b>

Харилцагчдын харилцах, хадгаламж нь хувь хүн, төрийн болон бизнесийн байгууллагын өмнө хүлээж буй банкны үүсмэл бус өр төлбөр бөгөөд ХӨ-өөр бүртгэлд тусгадаг.

## 19. Банкнаас гаргасан үнэт цаас

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Нийгмийн бонд	467,115,109	447,502,840
Ногоон бонд	181,491,317	207,766,401
Дотоодын ногоон бонд	107,051,827	103,348,053
Дотоодын жендэр бонд	32,314,521	-
<b>Нийт банкны гаргасан үнэт цаас</b>	<b>787,972,774</b>	<b>758,617,294</b>

Банкнаас гаргасан өрийн үнэт цаасуудад Банкнаас гаргасан бондууд багтсан бөгөөд ХӨ-өөр хэмжигдэнэ.

### Нийгмийн Бонд

Банк 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдөр 130,000 мянган ам.доллар хүртэлх дүн бүхий “Нийгмийн Бонд”-ыг олон улсад хаалттай хэлбэрээр гаргахаар Олон Улсын Санхүүжилтийн Корпорац (ОУСК)-тай санхүүжилтийн гэрээнүүдийг байгуулсан. Бондын эх үүсвэрээр Банк эрүүл мэнд, боловсрол, хүнс хөдөө аж ахуй, дэд бүтэц, орлогод нийцсэн орон сууц, бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчид, эмэгтэй бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа зэрэг нийгэмд эерэг нөлөө үзүүлэхүйц зээлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулах юм. Олон Улсын Санхүүжилтийн Корпорац (ОУСК) нь нийт 100,000 мянган ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн ба тус эх үүсвэрийн эхний хэсэг болох 60,000 мянган ам.доллар нь 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр, хоёрдугаар хэсэг болох 40,000 мянган ам.доллар нь мөн оны 12 дугаар сарын 19-ний өдөр тус тус олгогдсон. Нэмэлтээр, Францын Хөгжлийн Агентлагийн харьяа Пропарко банкнаас хоёрдугаар хэсэгт 30,000 мянган ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд Банк эх үүсвэрийг 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авсан.

### Ногоон бонд

Банк 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 5 жилийн хугацаатай 60,000 мянган ам.долларын Ногоон бондыг хаалттай хэлбэрээр гаргасан. Олон Улсын Санхүүжилтийн Корпорац (ОУСК), Нидерландын Хөгжлийн Санхүүжилтийн Компани (ХСК) болон Микровест Капитал Менежмент (МКМ) нь одоогийн бонд эзэмшигчид юм. Бондын орлого нь Банкны Ногоон Бондын Хамрах хүрээнд тодорхойлсон сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, ногоон барилга байгууламж, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах, усны менежмент ба ус цэвэршүүлэх, тогтвортой хөдөө аж ахуй, мал аж ахуй, ногоон тээврийг дэмжих зорилготой ногоон зээл, төслүүдийг санхүүжүүлэхэд зориулагдсан болно. Бондын төлбөрийг 2025 оны 4 дүгээр сараас эхлэн хагас жил тутамд төлж эхлэх бөгөөд 2028 оны 4 дүгээр сард төлөгдөж дуусна.

Банк 2025 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Азийн Хөгжлийн банктай 7.5 сая ам.долларын хувийн Ногоон бондын захиалгын болон Бодлогын эрхийн гэрээнд нэгдсэн. Энэхүү бонд нь Хаан банкны Ногоон бондын хүрээний дагуу ногоон дэд зээлүүдийг дэмжихэд зориулагдана. Бондыг дөрвөн тэнцүү хэсэгт хувааж, 2028 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр төлж дуусгана. 2025 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр санхүүжилтийг татан төвлөрүүлсэн.

### Дотоодын “Ногоон бондын хөтөлбөр”

Банкны 30,000 мянган ам.долларын дотоодын “Ногоон бондын хөтөлбөр”-ийн хүрээнд 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр санхүүжилтийн эхний хэсэг болох 17,000,000 мянган төгрөг (5,000 мянган ам.доллартой тэнцэх)-ийн бондыг амжилттай гаргасан. 2024 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Банк гадны стратегийн хөрөнгө оруулагчид болох Азийн хөгжлийн банк (АХБ) болон Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-тай Монголын хөрөнгийн бирж (МХБ) дээр хоёр дахь ээлжийн ам.долларын Ногоон бондын санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулсан. Банк нь бондын эх үүсвэрийг Банкны Ногоон Бондын Санхүүжилтийн Хүрээнд тодорхойлсны дагуу сэргээгдэх эрчим хүч болон байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, эрчим хүчний хэмнэлт, ногоон барилга байгууламж, хүрээлэн буй орчинд ээлтэй хөдөө аж ахуйн ногоон төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай юм. Бонд нь 3 жилийн хугацаатай. 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр МХБ-ээр дамжуулан ам.долларын Ногоон Бондыг стратегийн хөрөнгө оруулагчдад амжилттай худалдаж санхүүжилтийг татан төвлөрүүлсэн.

### Дотоодын Жендэр бонд

2025 оны 7 дугаар сард Банк Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан 30 тэрбум төгрөгийн Нийгмийн Бондыг гаргасан. Энэхүү бондын хугацаа гурван жил бөгөөд жилийн 16%-ийн тогтмол купон хүүтэй, жилд хоёр удаа төлөгдөнө. Энэхүү бонд нь зөвхөн Банкны Нийгмийн Бондны Хүрээтэй нийцсэн төслүүд болон үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулагдана. Үүнд эмэгтэй бизнес эрхлэгчид болон эмэгтэй удирдлагатай бизнесүүдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, жендэрийн тэгш байдлыг дэмжих зорилготой. Амжилттай гаргасны дараа Банк нийт орлогоо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр хүлээн авсан. Хоёрдогч зах зээлийн арилжаа мөн өдөр эхэлж, купоны хуримтлал эхэлсэн.

## 20. Зээлээр авсан санхүүжилт

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
<b>Гадаадын Банк санхүүгийн байгууллагуудаас зээлсэн эх үүсвэр</b>		
Нидерландын Хөгжлийн Санхүүжилтийн Компани (ХСК) болон ХСК-ийн хамтын санхүүжилтийн зээл	1,077,436,742	284,625,323
Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк	532,336,486	331,557,363
Олон Улсын Санхүүгийн Корпорац болон ОУСК-ийн хамтын санхүүжилтийн зээл	341,669,101	461,475,572
БлүОрчард Файнанс Лимитед	298,631,486	169,241,333
Азийн хөгжлийн банк	246,924,628	-
РиспонсАбилити Хөрөнгө оруулалт АГ	221,824,659	152,093,537
Симбиотикс хөрөнгийн менежмент	160,263,556	155,084,153
Германы хөрөнгө оруулалтын корпорац (Ди И Жи)	143,771,522	137,494,800
Австрийн Хөгжлийн Банк (ОеЕВ)	112,259,786	117,278,863
Инкофин микрофинанс фонд Си Ви (Incofin)	101,149,140	109,534,726
ДиДаблюЭм Хөрөнгийн менежмент	47,620,026	32,219,782
ЭйчЭс Холдингс Лимитед Компани	36,644,991	35,331,917
ЖиЭлСи Алтернатив Инвестментс	35,852,033	17,082,742
Банк Им Бистум Эссэн ЭйЖи	19,629,802	23,667,098
<b>Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан нийт зээлийн санхүүжилт</b>	<b>3,376,013,958</b>	<b>2,026,687,209</b>
<b>Өрийн бичиг</b>		
Симбиотикс	22,879,594	21,153,651
Глобал импакт инвестмент Эс Эй Ар Эл	3,531,147	10,660,877
Финетик Эс Си Эй, СИКАФ СИФ	-	5,220,821
<b>Нийт өрийн бичгийн дүн</b>	<b>26,410,741</b>	<b>37,035,349</b>

## Мянган төгрөгөөр

## Засгийн газраас санхүүжсэн эх үүсвэр

Монголбанк	224,579,417	326,386,024
Сангийн яам / Японы олон улсын хамтын ажиллагааны банк	34,764,396	33,682,335
Сангийн яам- Азийн Хөгжлийн Банк	31,497,687	34,205,872
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хөдөлмөрийн зах зээлийг дэмжих жижиг зээл	6,516,588	9,903,741
Засгийн газрын төслийн зээлүүд	2,126,778	1,929,630
Сангийн яам - бусад	132,936	176,705
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны оюутны хөгжлийн зээл	8,463	30,539
Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам	-	638,049
Бусад төслийн зээл	718,875	687,402
<b>Нийт зээлээр авсан засгийн газрын санхүүжилт</b>	<b>300,345,140</b>	<b>407,640,297</b>
Худалдааны санхүүжилт	205,309,164	14,047,397
<b>Нийт зээлээр авсан санхүүжилт</b>	<b>3,908,079,003</b>	<b>2,485,410,252</b>

Олон улсын санхүүгийн байгууллага болон Монгол Улсын төрийн байгууллагуудаас авсан зээл, өрийн бичгүүд нь зээлээр авсан санхүүжилтэнд багтана. Анхны хэмжилтийн дараа гаргасан өр болон бусад зээлсэн хөрөнгийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцож хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцоходоо гаргасан хөрөнгийн хөнгөлөлт, урамшуулал, мөн үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох зардлыг харгалзан тооцдог.

## Гадаадын санхүүгийн байгууллагуудаас зээлсэн эх үүсвэр

## 1. Нидерландын хөгжлийн банк (FMO)-ны хамтарсан санхүүжилт

Банк 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдөр Нидерландын хөгжлийн банк (FMO), Финландын хөгжлийн санхүүгийн байгууллага (FinnFund), болон Италийн хөгжлийн банк (CDP)-ууд хамтран оролцсон 200 сая ам.долларын дүн бүхий хамтарсан санхүүжилтийн гэрээг байгуулсан. Тус санхүүжилт нь барьцаагүй, А/В хамтарсан санхүүжилтийн хэлбэрээр, ам.доллар болон төгрөгийн хосолмол валютаар олгогдож байгаагаараа онцлог бөгөөд 5 жилийн хугацаатай 145 сая ам.доллар, 40 сая ам.долларын дүнтэй тэнцэх төгрөгийн эх үүсвэр болон 3 жилийн хугацаатай 15 сая ам.долларын эх үүсвэрээс тус тус бүрдэнэ. Энэхүү санхүүжилт нь 1.5 жилийн хугацаанд үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж, түүний дараагаар тэнцүү төлөлт хийх нөхцөлтэйгөөр, 2027 оны 12 дугаар сарын 10-ны өдөр болон 2029 оны 12 дугаар сард тус тус төлөлт хийгдэн, хугацаа нь дуусна. Энэхүү санхүүжилтийн эх үүсвэрээр шаардлага хангасан ногоон төсөл хөтөлбөрүүд, мөн залуу бизнес эрхлэгч, эмэгтэй бизнес эрхлэгчид, болон хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг жижиг, дунд бизнес эрхлэгчид, тэр дундаа ноос ноолуурын бизнес эрхлэгчдийг тусгайлан дэмжин санхүүжүүлэх юм.

Банк 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр ФинДев Канад компаниас хамтарсан санхүүжилтийн гэрээний хүрээнд нэмэлт 50 сая ам.долларын урт хугацааны санхүүжилт авсан. Энэхүү санхүүжилт 20 сарын хугацаанд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, түүний дараагаар зургаа тэнцүү хуваагдан төлөлт хийгдэн, 2029 оны 12 дугаар сарын 10-ны өдөр төлөгдөж дуусна.

## 2. Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)

Банк 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран 75 сая ам.долларын "Mongolian Green Economy Financing Facility" (MonGEFF) болон 70 сая ам.долларын "Women in Business" (WiB) хөтөлбөрийн хүрээнд нийт 145 сая ам.долларын дүн бүхий урт хугацаат санхүүжилтийн гэрээг байгуулсан. Энэхүү санхүүжилт нь байгаль орчинд ээлтэй ногоон зээлийг санхүүжүүлэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч/удирддаг эмэгтэйчүүдийг дэмжихэд зориулагдана.

Энэхүү хоёр зээл нь 3 жилийн хугацаатай, эхний 12 сарын хугацаанд үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж, түүний дараагаар хагас жил тутам хуваан тэнцүү төлөлт хийх нөхцөлтэй.

Банк тус санхүүжилтийн эхний хэсэг болох “Mongolian Green Economy Financing Facility” (MonGEFF)-ийн 37.5 сая ам.долларын болон “Women in Business” (WiB)-ийн 35 сая ам.долларыг 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр хүлээн авсан.

2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Банк нь “Хөдөө аж ахуйн санхүүгийн хэрэгсэл”-ийнхээ хүрээнд ЕСБХБ-тай нийт 20 сая ам.долларын зээлийн гэрээ хийсэн. Зээлийн зорилго нь хөдөө аж ахуйн үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэхийг дэмжих микро, жижиг, дунд бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийж, санхүүжилт үзүүлэхэд зориулагдана. Зээлийн хугацаа нь 3 жил бөгөөд үүнд 12 сарын хугацаанд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, түүний дараагаар хагас жил тутам тэнцүү хэмжээгээр үндсэн төлбөрийг төлөх хуваарьтай. Банк 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр эхний 10 сая ам.долларыг хүлээн авсан.

### 3. БлуОрчард Файнанс лимитэд

2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Банк нь BlueOrchard Finance Limited (BlueOrchard) компаниар удирдуулдаг BlueOrchard Microfinance Fund (BOMF)-тай 40 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ хийсэн. Санхүүжилтийн зорилго нь Монгол Улсад жижиг, дунд, микро бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд оршиж байна. Зээлийг нэг удаагийн төлбөрөөр төлөх ба 2028 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хугацаа дуусна. Банк төслийн санхүүжилтийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүлээн авсан.

### 4. Азийн Хөгжлийн банк (ADB)

2025 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Банк Азийн Хөгжлийн Банк (ADB)-тай нийт 100 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ хийсэн. Санхүүжилтийн зорилго нь Банкны хөдөө орон нутгийн жижиг, дунд, микро бизнесүүд (ЖДМБ), мөн хөдөө аж ахуйн аж ахуйн нэгжүүд болон фермер, малчдыг оролцуулсан хувь хүн төслийг дэмжихэд оршиж байна. Зээлийг хагас жилийн хугацаатай 9 тэнцүү хуваан төлөх ба 13 сарын хугацаанд үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж, 2030 оны 12 дугаар сарын 23-ны өдөр төлөгдөж дуусна. Банк 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр эхний хэсэг болох 70 сая ам.долларыг хүлээн авсан.

### 5. РеспонсАбилити Хөрөнгө оруулалт АГ

2025 оны 5 дугаар сарын 29-ны өдөр Банк нь РеспонсАбилити Хөрөнгө оруулалт АГ-ийн удирддаг РеспонсАбилити SICAV (Lux) Micro and SME Finance Debt Fund-тай 5 сая америк долларын зээлийн гэрээ байгуулсан. Санхүүжилтын зорилго нь Монгол Улсын микро, жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэхэд зориулагдана. Санхүүжилт нь 18 сарын хугацаанд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, түүний дараа нь тэнцүү хэмжээний эргэн төлөлтөөр төлөгдөж, 2028 оны 5 дугаар сарын 9-ний өдөр хугацаа дуусна. Банк санхүүжилтийн эх үүсвэрийг 2025 оны 6 дугаар сарын 3-ны өдөр хүлээн авсан.

2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Банк нь РеспонсАбилити Хөрөнгө оруулалт АГ-ийн удирддаг гурван хөрөнгө оруулалтын сан болох responsAbility SICAV (Lux) Financial Inclusion Fund, MultiConcept Fund Management S.A., responsAbility SICAV (Lux) Micro and SME Finance Leaders компаниудтай хамтарсан гэрээ байгуулсан. Ингэснээр нийт 5 сая ам.долларын дүйцэх төгрөгийн санхүүжилт авсан байна. Санхүүжилтийн зорилго нь Монгол Улсад микро, жижиг, дунд бизнесийг дэмжихэд оршино. Зээл 12 сарын сарын хугацаанд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, түүний дараагаар хагас жил тутам тэнцүү үндсэн төлбөрийг төлөх хуваарьт шилжиж, 2028 оны 6 дугаар сарын 27-ны өдөр хугацаа дуусна. Банк санхүүжилтээ 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авсан.

2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр Банк нь РеспонсАбилити Хөрөнгө оруулалт АГ-ийн удирдуулдаг SIFEM AG-тай 15 сая ам.долларын зээлийн хэлцэл байгуулсан. Энэхүү санхүүжилтээр ногоон зээл санхүүжүүлэх, Монгол Улсад эмэгтэйчүүдийн эзэмшдэг, эмэгтэйчүүд удирддаг жижиг, дунд бизнес болон микро бизнесүүдийг дэмжих, мөн эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжихэд ашиглагдана. Зээлийн хугацаа нь дөрвөн жил бөгөөд үүнд 18 сарын сарын хугацаанд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, үүний дараа жилд хоёр удаа тэнцүү төлбөр төлөх нөхцөлтэйгөөр төлөгдөж, 2029 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр дуусна. Банк зээлийн санхүүжилтээ 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хүлээн авсан.

2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Банк нь РеспонсАбилити Хөрөнгө оруулалт АГ-аар удирдуулдаг Global Climate Partnership Fund S.A., SICAV-SIF-аас 2024 оны 10 сарын 14-ний өдөр байгуулсан барьцаагүй санхүүжилт гэрээний дагуу 5 сая ам.долларыг 2025 оны 12 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан холбогдох нэмэлт хэлцлээр

хоёр дахь удаагийн санхүүжилтээ авсан. Зээлийн зорилго нь CO2 ялгаруулалт, эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих холбогдох ногоон төсөл, зээлүүдийг санхүүжүүлэхэд оршиж байна. Зээл нь 2 жилийн тэгшилсэн хугацаатай бөгөөд дараа нь хагас жил тутамд эргэн төлөх хуваарьтай бөгөөд 2030 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хугацаа дуусна.

#### 6. Симбиотикс

Банк 2024 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Симбиотикс хөрөнгө оруулалтын удирдлагын компанийн удирддаг ЭмЭсЭМИ Бондс Эс.Эй сантай 8,000 мянган ам.доллартай тэнцэх дүн бүхий төгрөгийн урт хугацаат зээлийн гэрээ байгуулсан. Зээлийн зориулалт нь Монгол Улсын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэхэд зарцуулагдана. Зээл нь хугацааны эцэст бөөн дүнгээр буюу 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдөр бүрэн төлөгдөж дуусах юм. Банк санхүүжилтийн эх үүсвэрийг 2024 оны 7 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авсан.

Банк 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Симбиотикс хөрөнгө оруулалтын удирдлагын компанийн ЭмЭсЭМИ Бондс Эс.Эй сантай 7,500 мянган ам.долларын урт хугацаат зээлийн гэрээ байгуулсан. Зээлийн зориулалт нь Монгол Улсын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин санхүүжүүлэхэд зарцуулагдана. Зээл нь хугацааны эцэст бөөн дүнгээр буюу 2027 оны 10 дугаар сарын 2-ны өдөр бүрэн төлөгдөж дуусах юм. Банк санхүүжилтийн эх үүсвэрийг 2024 оны 10 дугаар сарын 2-ны өдөр хүлээн авсан.

#### 7. Инкофин микрофинанс фонд Си Ви (Incofin)

2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Банк нь Инкофин микрофинанс фонд Си Ви-тэй 15 сая ам.доллартай зээлийн гэрээ байгуулсан. Зээлийн зорилго нь Монгол Улсад микро, жижиг, дунд бизнесүүдийг санхүүжүүлэхэд оршиж байна. Зээлийг санхүүжилт олгосноос хойш 36 ба 48 сарын дараа 2 тэнцүү хэсгээр төлж барагдуулах бөгөөд 2029 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хугацаа дуусна. Банк 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр санхүүжилтийг хүлээн авсан.

#### 8. ДиДаблюЭм

2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Банк нь ДиДаблюЭм Хөрөнгийн Менежмент ХХК-ийн удирддаг Cardano Impact Financial Inclusion Fund (I)-тэй 5 сая ам.долларын зээлийн хэлцэл байгуулсан. Зээлийн зорилго нь ногоон төслүүдийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал юм. Зээл нь нэг удаагийн төлөлтөөр 2028 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хугацаа дуусна. Банк нь санхүүжилтийг 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр хүлээн авсан.

2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Банк нь ДиДаблюЭм Хөрөнгийн Менежмент ХХК-ийн удирддаг Cardano Impact Financial Inclusion Fund (I)-тэй 5 сая ам.долларын зээлийн хэлцэл байгуулсан. Зээлийн зорилго нь Монгол Улсад жижиг, дунд, микро бизнесийг дэмжихэд оршино. Зээл нь хоёр тэнцүү төлөлтөөр, хөрөнгийг олгосноос хойш 18 болон 24 сарын дараа төлөгдөж, 2027 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хугацаа дуусна. Банк нь санхүүжилтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авсан.

#### 9. Франкфуртын Сургуулийн санхүүгийн үйлчилгээ

2025 оны 2 дугаар сарын 3-ны өдөр Банк нь Франкфуртын Сургуулийн Санхүүгийн үйлчилгээ Юу Кэй Лимитед Компанитай 5 сая ам.долларын зээлийн гэрээ байгуулсан. Зээлийн зорилго нь Монгол Улс дахь микро, жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэхэд оршино. Зээл нь нэг удаагийн төлбөртэй бөгөөд 2028 оны 2 дугаар сарын 21-ний өдөр хугацаа дуусна. Банк нь санхүүжилтийг 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авсан.

2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Банк нь Франкфуртын Сургуулийн Санхүүгийн үйлчилгээ Юу Кэй Лимитед Компанитай 5 сая ам.долларын зээлийн гэрээ байгуулсан. Зээлийн зорилго нь Монгол Улс дахь микро, жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэхэд оршино. Зээл нь нэг удаагийн төлбөртэй бөгөөд 2028 оны 5 дугаар сарын 16-ны өдөр хугацаа дуусна. Банк нь санхүүжилтийг 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авсан.

#### 10. Эргэн төлөлт

Тайлант хугацааны турш Банк нийт 172,947 мянган ам.долларын урт хугацаат зээл болон өрийн бичгийн эргэн төлөлтийг холбогдох санхүүжилтийн гэрээнүүдийн эргэн төлөгдөх хуваарийн дагуу бүрэн төлсөн.

### Худалдааны санхүүжилт

Тайлант хугацааны туршид нийт 33,685,846 мянган төгрөгийн эргэн төлөлтийг хийж, 223,595,923 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авсан байна. Бүх худалдааны санхүүжилт нь гадаад валютаар буюу ихэнх нь ам.доллараар илэрхийлэгдсэн. Худалдааны санхүүжилт нь жилийн суурь хүүний түвшин дээр 0.50%-5.00%-ийн нэмэгдэл тооцсон хүүгийн хувьтай ба 1 хүртэлх жилийн хугацаатай.

### Засгийн газраас санхүүжсэн эх үүсвэр

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн байдлаар Төрийн байгууллагаас авсан зээлийн хувьд дараах томоохон эргэн төлөлт хийгдэж, шинээр санхүүжилт орж ирсэн:

#### Монголбанк

##### *Ипотекийн зээлээр баталгаажсан санхүүжилт*

Банк Ипотекийн зээлээр баталгаажсан санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас жилийн 1%-2%-ийн хүүтэй санхүүжилт авч, энэ санхүүжилтээр харилцагчдад жилийн 3%-6%-ийн хүүтэй орон сууцны зээл олгодог. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк нийт 198,799,289 мянган төгрөг (2024: 248,667,437 мянган төгрөг)-ийн ипотекийн зээлийн нэмэлт санхүүжилтийг авсан.

##### *Алт-2 хөтөлбөр төслийн зээл*

Алт-2 хөтөлбөрийн төслийн зээлийг Монголбанкттай хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд 2020 оны 6 дугаар сард ерөнхий гэрээг байгуулсан. Урт хугацаат санхүүжилтийн төслийн зээлийн үлдэгдэл 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 379,719 мянган төгрөг байгаа бөгөөд 2025 онд төлөгдөж дууссан.

#### Сангийн яам / Японы олон улсын хамтын ажиллагааны банк

Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк (Жайка) хооронд байгуулсан зээлийн гэрээний 1-р хавсралтын дагуу Жайка олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр шатлалт зээлийн төсөл"-ийг санхүүжүүлэх зорилгоор 5,000,000 мянган иенийн зээл олгохоор болсон. Энэхүү гэрээний хүрээнд 2007 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Банк 93,282,870 мянган төгрөг, 3,200 мянган ам.долларын санхүүжилт авсан. Төгрөгийн зээлийн хувьд хүү нь арилжааны банкуудын өмнөх 12 сарын хугацаагүй хадгаламжийн дундаж хүүтэй тэнцүү, ам.долларын зээлийн хувьд хүү нь 6 сарын ЛИБОР хүү дээр 1%-ийн ахуйц ашиг нэмсэнтэй тэнцүү хэмжээгээр тогтоосон байдаг. 2025: оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 34,764,395 мянган төгрөг (2024: 33,682,335 мянган төгрөг) байгаа ба тус зээл 2035 онд төлөгдөж дуусна.

#### Сангийн яам - Азийн Хөгжлийн Банк

##### *Хөдөө аж ахуй, Хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төсөл (АХБ)*

2015 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын засгийн газар Азийн хөгжлийн банкттай "Хөдөө аж ахуйн болон хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт"-ийн 3287-МОН, 3288-МОН (СФ) тоот дамжуулан зээлдүүлэх гэрээнүүдийг байгуулсан. Энэхүү нэмэлт гэрээний хүрээнд Банк нь Сангийн яамтай 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдөр зээлийн гэрээг байгуулсан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл нь 15,151,516 мянган төгрөг (2024: 18,726,562 мянган төгрөг) ба жилийн хүү 4.5% болно.

##### Зээлийн батлан даалтын сан

Азийн хөгжлийн банкны "Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх" төслийн зээлийг хэрэгжүүлэх хүрээнд Банк нь Зээлийн батлан даалтын сантай "Батлан даалтын ерөнхий гэрээ"-г байгуулсан. Энэхүү төслийн зээлийн хүрээнд 3,632,181 мянган төгрөгийн батлан даалтын эх үүсвэр хүлээн авсан бөгөөд санхүүжилтийн зардал нь жилийн 5% байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл нь 14,863,162 мянган төгрөг (2024: 14,036,373 мянган төгрөг) байна.

##### Орлогыг дэмжих хөтөлбөр

<b>2024 оны 1 дүгээр сарын 31-ний дүн</b>	<b>1,054</b>	<b>200,000</b>
Тайлант жилд олгосон	54,985	13,527,148
Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл төлөгдсөн	(29,879)	(4,875,494)
<b>2024 оны 12 дугаар сарын 31-ний дүн</b>	<b>26,160</b>	<b>8,851,654</b>

		2025 оны 12 дугаар сарын 31							2024 оны 12 дугаар сарын 31						
	Чанаргүйдэх магадлал	Ашиглагдаагүй эээлийн шугам	Ашиглагдаагүй кредит карт	Санхүүгийн баталгаа	Гүйцэтгэлийн баталгаа	Импортын аккредитив	Факторингийн авлагын шугам	Нийт хүлээсэн үүргийн дүн	Ашиглагдаагүй эээлийн шугам	Ашиглагдаагүй кредит карт	Санхүүгийн баталгаа	Гүйцэтгэлийн баталгаа	Импортын аккредитив	Факторингийн авлагын шугам	Нийт хүлээсэн үүргийн дүн
Шатлал 1	0,00%-с <0,15% хүртэл	13,544,509	1,829,894	-	-	-	-	15,374,403	13,286,448	2,353,970	-	-	-	-	15,640,418
	0,15%-с <0,25% хүртэл	20,231,739	1,036,316	-	-	-	-	21,268,055	-	738,267	-	-	-	-	738,267
	0,25%-с <0,50% хүртэл	798,767	1,630,979	-	-	-	-	2,429,746	16,939,809	1,325,373	-	-	-	-	18,265,182
	0,50%-с <0,75% хүртэл	73,321,318	2,431,275	-	-	-	-	75,752,593	11,883,362	2,140,824	-	-	-	-	14,024,186
	0,75%-с <2,50% хүртэл	325,974,548	32,341,705	-	-	-	-	358,316,253	88,721,756	29,305,076	-	-	-	-	118,026,832
	2,50%-с <10,0% хүртэл	1,047,118,437	-	115,594,538	90,607,629	35,356,901	26,943,189	1,315,620,694	1,338,265,321	-	74,273,880	85,163,613	43,232,816	8,851,654	1,549,787,284
	10,0%-с <45,0% хүртэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Нийт Шатлал 1</b>	<b>1,480,989,318</b>	<b>39,270,169</b>	<b>115,594,538</b>	<b>90,607,629</b>	<b>35,356,901</b>	<b>26,943,189</b>	<b>1,788,761,744</b>	<b>1,469,096,696</b>	<b>35,863,510</b>	<b>74,273,880</b>	<b>85,163,613</b>	<b>43,232,816</b>	<b>8,851,654</b>	<b>1,716,482,169</b>	
Шатлал 2	0,00%-с <0,15% хүртэл	75,704	69,309	-	-	-	-	145,013	75,704	69,309	-	-	-	-	145,013
	0,15%-с <0,25% хүртэл	233,201	54,674	-	-	-	-	287,875	233,201	54,674	-	-	-	-	287,875
	0,25%-с <0,50% хүртэл	-	23,367	-	-	-	-	23,367	-	23,367	-	-	-	-	23,367
	0,50%-с <0,75% хүртэл	838,000	68,444	-	-	-	-	906,444	838,000	68,444	-	-	-	-	906,444
	0,75%-с <2,50% хүртэл	1,785,787	366,850	-	-	-	-	2,152,637	1,785,787	366,850	-	-	-	-	2,152,637
	2,50%-с <10,0% хүртэл	8,861,659	184,659	1,885,030	2,985,849	-	-	13,917,197	8,861,659	184,659	1,885,030	2,985,849	-	-	13,917,197
	10,0%-с <45,0% хүртэл	185,912	1,300	-	-	-	-	187,212	185,912	1,300	-	-	-	-	187,212
45,0% -с дээш	2,105	40,742	-	-	-	-	42,847	2,105	40,742	-	-	-	-	42,847	
<b>Нийт Шатлал 2</b>	<b>11,982,368</b>	<b>809,345</b>	<b>1,885,030</b>	<b>2,985,849</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>17,662,592</b>	<b>11,982,368</b>	<b>809,345</b>	<b>1,885,030</b>	<b>2,985,849</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>17,662,592</b>	

2025 оны 12 дугаар сарын 31								2024 оны 12 дугаар сарын 31						
Чанаргүйдлийн хугацаа	Ашиглагдаагүй зээлийн шугам	Ашиглагдаагүй кредит карт	Санхүүгийн баталгаа	Гүйцэтгэлийн баталгаа	Импортын аккредитив	Факторингийн авлагын шугам	Нийт хүлээсэн үүргийн дүн	Ашиглагдаагүй зээлийн шугам	Ашиглагдаагүй кредит карт	Санхүүгийн баталгаа	Гүйцэтгэлийн баталгаа	Импортын аккредитив	Факторингийн авлагын шугам	Нийт хүлээсэн үүргийн дүн
12 хүртэлх сар	715,467	30,154	-	-	-	-	745,621	691,099	34,628	-	-	-	-	725,727
13-24 сар	-	332	-	-	-	-	332	491,632	47,992	-	-	-	-	539,624
25-36 сар	-	-	-	-	-	-	-	461,565	19,696	-	-	-	-	481,261
37-48 сар	-	-	-	-	-	-	-	364	15,360	-	-	-	-	15,724
49-60 сар	-	-	-	-	-	-	-	-	12,149	-	-	-	-	12,149
61-84 сар	-	-	-	-	-	-	-	100,000	4,300	-	-	-	-	104,300
84-өөс дээш сар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Нийт Шатлал 3</b>	<b>715,467</b>	<b>30,486</b>					<b>745,953</b>	<b>1,744,660</b>	<b>134,125</b>					<b>1,878,785</b>

## Үүрэг

Үүрэг гэдэг нь Банкны зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм гэрээний үүргүүд нь тогтсон дуусгавар болох хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг хэрэгжээгүй байтал харилцагчаас тусгай шаардлага хангахыг шаардах тус үүргийнх нь хугацаа дууссан байж болох тул гэрээнд заасан нийт дүн ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

### Хадгаламжийн даатгалын корпорацтай үүссэн маргаан

2018 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр Хадгаламжийн даатгалын корпорац (ХДК) нь Монгол Улсын хөгжлийн Банкнаас Хаан Банкинд байршуулсан харилцах болон мөнгөн хадгаламжийн данснаас даатгалын хураамж болох 1,000,000 мянган төгрөгийг нэхэмжилсэн. Банк энэхүү нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бөгөөд 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдөр шүүхэд хариу тайлбар хүргүүлсэн. Мөн 2019 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Хадгаламжийн даатгалын корпорац нэхэмжлэлийн шаардлагаа 667,000 мянган төгрөгөөр нэмж нэхэмжилсэн бөгөөд нийт нэхэмжлэлийн дүн 1,667,000 мянган төгрөг болсон. Гэвч нэмэлт 667,000 мянган төгрөгийг Анхан шатны шүүх хэрэгсэхгүй болгосон. 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Хадгаламжийн даатгалын корпорац (ХДК) өөрийн нэхэмжлэлийн хэмжээг 2,246,863 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн бөгөөд шүүх талуудын нотлох баримт гаргах, хураах хүсэлтийг зөвшөөрсөн.

Банк 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус нэхэмжлэлд 100%-ийн нөөц санг хүлээн зөвшөөрсөн (2024: байхгүй).

### 34. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

ХААН Банк нь эрсдэлийн хүчирхэг соёл болон байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагыг банкны үйл ажиллагааны салшгүй хэсэг гэж үздэг бөгөөд банкны бизнес загвар, стратегийн зорилтууд болон тогтвортой байдлын бодлого, чиглэлүүдтэй уялдуулан Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлдэг. Түүнчлэн Банк нь Монгол улсын хууль, тогтоомж, зохицуулалтуудын шаардлагуудыг дагаж мөрдөхийн зэрэгцээ олон улсын шилдэг туршлага, стандартад нийцүүлэн эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулдаг.

ХААН Банк нь Хүлээн зөвшөөрөх Эрсдэлийн Мэдэгдэл (Risk Appetite Statement)-ийн хүрээнд банкны стратеги, зорилтуудад нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах, хянах болон тайлагнах замаар эрсдэлийг үр дүнтэй удирдахыг зорьж ажилладаг. Үүнд:

- Эрсдэл, өгөөжийн харьцааг оновчтой хадгалах;
- Эрсдэлийн удирдлагын үүрэг, хариуцлагуудыг оролцогч талуудад тодорхой хуваарилах;
- Эрсдэлийн хүчирхэг соёлыг нийт ажилтнуудад төлөвшүүлэх;
- Банкны материаллаг гэж үзсэн эрсдэлүүдийг тодорхойлох, үр дүнтэй удирдах;
- Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын (ERM) тогтолцоог олон улсын стандарт, удирдамж болон шилдэг туршлагад нийцүүлэн тогтмол хянаж, сайжруулах;

Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй үйл явц нь Банкны тогтвортой ашигт ажиллагааг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд ажилтан бүр өөрсдийн чиг үүргийн хүрээнд эрсдэлийг тодорхойлох, тайлагнах болон удирдах үүрэгтэй.

Банк нь байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын (ERM) тогтолцооны хүрээнд санхүүгийн эрсдэлүүд (зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл болон зах зээлийн эрсдэл, үүнд гадаад валютын эрсдэл, хүүгийн түвшний эрсдэл болон үнийн эрсдэл багтана) болон санхүүгийн бус эрсдэлүүд (үйл ажиллагааны эрсдэл, хууль эрх зүйн эрсдэл, комплаенсийн эрсдэл, мэдээллийн технологийн эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, стратегийн эрсдэл, хүний хувийн мэдээллийн эрсдэл, загварын эрсдэл, гуравдагч талын эрсдэл болон нэр хүндийн эрсдэл)-ийг тус тус удирдаж, хяналт тавин ажилладаг.

Хууль эрх зүйн болон Мэдээлэл Технологийн эрсдэлүүдээс бусад эрсдэлүүдийг хамгаалалтын хоёрдугаар шугамын чиг үүрэг бүхий газар нэгжүүд хянадаг. Санхүүгийн эрсдэл хариуцсан дэд захирал (СЭХДЗ), Байгууллагын эрсдэл, комплаенс хариуцсан дэд захирал (БЭХХДЗ) болон Аюулгүй байдлын захирал нь өөрсдийн хариуцсан чиглэлийн хүрээнд эрсдэлийг хариуцаж Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч (ЭХГЗО)-д шууд тайлагнадаг.

Хуулийн эрсдэлийг Гүйцэтгэх захирал хянадаг бөгөөд Мэдээллийн технологийн эрсдэлийг Мэдээлэл, технологи хариуцсан дэд захирал болон Технологи, Үйл ажиллагааны хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч хяналт тавьж ажилладаг. Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын (ERM) тогтолцооны хэрэгжилтийг Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хороо (БНЭУХ), Актив, Пассивын удирдлагын хороо (АПУХ), Зээлийн эрсдэлийн хороо, Комплаенс ба Хууль эрх зүйн эрсдэлийн хороо болон тодорхой эрсдэлийн төрөл хариуцсан дэд хороод дэмжин ажилладаг.

Банк нь Өөрийн хөрөнгө ба хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ICAAP/ILAAP, хамтад нь ICLAAP)-ыг нэвтрүүлэх зорилтыг анх 2020-2023 оны дунд хугацааны стратегидээ тодорхойлсон бөгөөд ICLAAP-г хэрэгжүүлэхтэй холбоотой зорилтуудыг 2024-2026 оны дунд хугацааны стратеги болон 2025 оны бизнес төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна. Эрсдэлийн удирдлагын тэргүүлэх чиглэлийн хүрээнд Өөрийн хөрөнгө ба хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явцын бодлогыг шинээр боловсруулж, 2024 онд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороогоор хянуулан, Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөр батлуулсан. Мөн Өөрийн хөрөнгө ба хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явцыг хэрэгжүүлэх журмыг шинээр боловсруулж, 2025 онд Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хороогоор батлуулсан. Түүнчлэн Банк нь ICLAAP-ын үйл явцыг өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй хэсэг болгон шигтгэн авч үзэх зорилгоор холбогдох үйл явцыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2025 онд Банк нь ICAAP болон ILAAP туршилтын тайлангуудыг боловсруулж, Монголбанкинд гурав дахь жилдээ хүргүүлсэн.

Банк нь тайлант жилд Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлогыг “ХААН Банкны Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлого” болгон шинэчлэн боловсруулж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан ба тус бодлогын хавсралтаар “Эрсдэлийн ангилал зүй” болон “Байгууллагын эрсдэлийн соёлын стратеги”-ийн баримт бичгүүдийг шинээр боловсруулж батлуулсан. Мөн “ХААН Банкны Дотоод хяналтын бодлого”-д нэмэлт өөрчлөлт оруулж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд бодлогын нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Өргөтгөсөн хамгаалалтын гурван шугам”-ын загварыг нэвтрүүлж, эрсдэлийн удирдлага болон хяналтын үүрэг, хариуцлагын хуваарилалтыг илүү нарийвчлан тодорхойлсон. Уламжлалт “Хамгаалалтын гурван шугам”-ын загварыг банкны бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн өргөтгөсөн бөгөөд хамгаалалтын нэгдүгээр шугамыг 1А (бизнес нэгжүүд болон тэдгээрийн дэмжих функц) болон 1В (тусгай эрсдэл, хяналтын функц) болгон өргөтгөж, эрсдэл хариуцагч болон хяналтын үүрэг хариуцлагыг илүү тодорхой болгосон.

Банк нь эрсдэлийг тодорхойлох, бүртгэх, үнэлэх, арга хэмжээ авах, хянах болон тайлагнах үйл явцыг автоматжуулах зорилгоор 2025 онд Дотоод процесс, эрсдэлийн хяналтын систем (IPRMS)-ийг шинээр нэвтрүүлсэн. Тус систем нь эрсдэлийн самбар (dashboard)-ын үйл явц болон эрсдэлийн хороодын шийдвэр гаргалтын үйл явцыг автоматжуулсан бөгөөд эрсдэлийн тайлагналын ил тод байдлыг нэмэгдүүлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулах юм.

ХААН Банк нь олон улсын эрсдэлийн удирдлагын чиг хандлага, шилдэг туршлага, цахим шилжилт, түүнчлэн Банкны бизнес загварын өөрчлөлт болон стратегитай уялдуулан шинэ төрлийн эрсдэлүүд болох Технологийн эрсдэл, Кибер эрсдэл, Стратегийн эрсдэл, Гуравдагч талын эрсдэл, Загварын эрсдэл, Уур амьсгалын нөлөөллийн эрсдэлүүдийг анхааран үзэж, байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хүрээнд үр дүнтэй удирдаж, хянах үе шаттай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд ногоон эдийн засгийг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний зорилтод хувь нэмэр оруулах бодлого, стратегийн зорилтуудын хүрээнд Банк нь 2024 онд Олон улсын Санхүүгийн Корпорацтай (“ОУСК”) Төслийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан. Үүний хүрээнд дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- i. уур амьсгалын стратеги болон өнөөгийн бэлэн байдлын оношилгоог хийж, олон улсын стандарттай нийцүүлэх зөвлөмж боловсруулах;
- ii. зээлийн багцын уур амьсгалын биет эрсдэлд хэрхэн өртөж байгааг үнэлэх;
- iii. санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох;
- iv. уур амьсгалын эрсдэлийн удирдлагын үйл явцыг Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын (ERM) тогтолцоонд нэгтгэх. Цаашид Банк нь ОУСК-ийн өгсөн зөвлөмжүүдэд үндэслэн уур амьсгалын шилжилтийн стратегийг тодорхойлж, дараагийн үе шатуудад холбогдох арга хэмжээ, бодлого болон үйл явцыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### 34.1 Эрсдэлийн удирдлагын бүтэц

ТУЗ нь Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог хянах үндсэн үүрэгтэй бөгөөд үүрэг хариуцлагаа ТУЗ-ийн Эрсдэлийн хороогоор дамжуулан хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороо ("ТУЗЭХ"). ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороо нь ТУЗ-д Банкны эрсдэлийн түвшинг хянахад дэмжлэг үзүүлдэг бөгөөд Банкны Дүрэм болон ТУЗЭХ-ны Дүрэмд заасан чиг үүргийн дагуу Банкны эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлж, үнэлэлт, дүгнэлт гаргаж ажилладаг. Банкны эрсдэлийн хороодоос танилцуулж буй сар бүрийн тайлан мэдээг хянаж, ТУЗ-өөс тогтоосон хүлээн зөвшөөрөх эрсдэл болон эрсдэлийн хязгаарын хэрэгжилтийг баталгаажуулдаг.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь ТУЗ-д Банкны санхүүгийн тайлангууд, тодруулгуудын болон мэдээллийн үнэн зөв байдал, хууль эрх зүйн болон зохицуулалтын нийцтэй байдал, эрсдэлийн удирдлагын болон дотоод хяналтын үр дүнтэй ба үр ашигтай байдал, дотоод аудитын чиг үүргийн гүйцэтгэл зэргийг баталгаажуулах, хяналт тавих үүргээ биелүүлэхэд нь туслах үүрэгтэй.

Удирдлагын хороо. Удирдлагын хороо нь Гүйцэтгэх удирдлагын 4 гишүүдээс бүрдэх бөгөөд сар бүр хуралдан холбогдох хууль, тогтоомжоор Банкны хүлээсэн үүрэг, зохицуулагч байгууллагын хууль ёсны шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор банкны бизнес төлөвлөгөө, үндсэн үйл ажиллагаа, банкны хороодын бүтэц, бүрэлдэхүүн, хэлэлцэх асуудлын шийдвэр гаргалт зэрэг шаардлагатай асуудлыг Монгол улсын нийгэм, эдийн засаг, улс төр, цаг үеийн нөхцөл байдал болон дотоод үйл ажиллагаатай уялдуулан хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гаргадаг.

Өргөтгөсөн удирдлагын хороо. Өргөтгөсөн удирдлагын хороо нь сар бүр 2 удаа хуралддаг бөгөөд холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудын хууль ёсны шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах зорилгоор цаг үеийн шинжтэй, банкны өдөр тутмын үйл ажиллагаанд тулгарч буй аливаа асуудлаар мэдээлэл солилцох үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус хороо нь Гүйцэтгэх захирал, Бизнес хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч, Технологи үйл ажиллагаа хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч, Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч, чиглэл хариуцсан дэд захирлууд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Ерөнхий аудитор, Аюулгүй байдлын захирал, Мэдээлэл Технологийн тасралтгүй ажиллагааны захирал, Цахим банкны захирал, ОНИБ-ны захирал зэрэг нийт 22 гишүүдээс бүрддэг.

Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хороо ("БНЭУХ"). БНЭУХ нь банкны нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлж, материаллаг эрсдэлийг үр дүнтэй удирдаж, хянах үйл явцыг бодлого, журмын хүрээнд хэрэгжүүлж, олон улсын сайн туршлага, стандарт, зөвлөмжид тасралтгүй нийцүүлэх замаар байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх зорилготой. БНЭУХ-г Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч удирддаг бөгөөд сард нэг удаа хуралддаг. БНЭУХ нь дараах дэд хороодтой байх бөгөөд тэдгээрийн чиг үүргийн хүрээнд өөрийн эрх, үүргээ шилжүүлж, тогтмол хяналт тавьж ажилладаг. Үүнд:

- Үйл ажиллагааны эрсдэлийн дэд хороо
- Аюулгүй байдлын эрсдэлийн дэд хороо
- Мэдээллийн технологийн эрсдэлийн дэд хороо

Актив пассивын удирдлагын хороо ("АПУХ"). АПУХ-ны зорилго нь Банкны тайлан тэнцлийн актив пассивын бүтцийг Банкны тогтвортой хөгжлийг хангахад тохиромжтой байдлаар тогтоох, актив пассивын боловсронгуй удирдлагаар ашигт ажиллагаа болон төлбөрийн чадварыг хангах мөн хөрвөх чадварын, валютын ханшийн, хүүгийн түвшний болон зах зээлийн бусад эрсдэлүүдийг удирдахад оршино. АПУХ нь банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн хороо бөгөөд ТУЗ-өөс баталсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинд актив, пассивын удирдлагыг хэрэгжүүлж ажилладаг. АПУХ нь банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэх боломжтой, холбогдох ажилтнуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгсөн үр ашигтай, зохистой удирдлагын системийг бүрдүүлэх, шаардлагатай нөөцөөр ханган ажилладаг. АПУХ-г Санхүү хариуцсан дэд захирал удирддаг.

Комплаенс, Хуулийн эрсдэлийн хороо ("КХЭХ"). КХЭХ нь банкны хэмжээнд комплаенс, хуулийн эрсдэлийг удирдах үйл явцад шаардлагатай мэдээ мэдээллийг тогтмол солилцох, комплаенс, хууль эрх зүйн болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах ажлын хүрээнд стратегийн шийдвэр гаргах, нэгдсэн удирдлагаар хангах, нийтлэг ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, хариуцсан чиглэлээр эрх бүхий зохицуулагч байгууллага, корреспондент банк болон гадаадын хөрөнгө оруулагчдын зүгээс тавих шаардлагыг хэлэлцэн шийдвэрлэх чиг үүрэгтэй байна.

### 34.2 Зээлийн эрсдэл

Банк зээлийн эрсдэлд өртөх бөгөөд энэ нь санхүүгийн хэрэглүүрийн аль нэг тал үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талдаа санхүүгийн хохирол учруулах явдал юм.

Банк зээл олгох болон бусад талуудтай хийсэн гүйлгээний үр дүнд зээлийн эрсдэлд өртөх нь бий. Энэ тохиолдолд санхүүгийн хөрөнгө болон балансын гадуурх зээлтэй холбоотой болзошгүй үүргийг бий болгодог.

Банкны зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээг санхүүгийн байдлын тайлангийн санхүүгийн хөрөнгийн дансны үнэд тусгадаг. Гаргасан санхүүгийн баталгаа, зээл сунгасны үүрэг, ашиглагдаагүй зээлийн шугам, экспорт/импортын аккредитивын хувьд зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээ нь болзошгүй үүргийн дүн байна.

**Зээлийн эрсдэлийн удирдлага.** Банк нь ТУЗ-өөс баталсан, Гүйцэтгэх удирдлагаас хэрэгжилтэд хяналт тавьдаг нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоонд тулгуурлан зээлийн эрсдэлийг удирддаг.

Энэхүү тогтолцоонд дараах үндсэн бүрэлдэхүүн багтана. Үүнд:

- Нарийвчлан тодорхойлсон зээлийн бодлого, журмууд болон шийдвэр гаргалтын эрх мэдэл;
- Зээлийн эрсдэлийн дотоод үнэлгээ болон скорингийн систем;
- Хараат бус зээлийн хяналт, мониторингийн чиг үүрэг;
- Зээлдэгч болон салбарын багцын хязгаарууд (лимитүүд);
- Тогтмол стресс тестийн шинжилгээ;
- Эрсдэл нэмэгдэж болзошгүй активыг эрт илрүүлэх систем;

Зээлийн эрсдэлийг багцын тогтмол хяналт, зээлдэгчийн санхүүгийн шинжилгээ хийх болон гэрээний нөхцөл, шаардлагын биелэлтийг шалгах замаар тогтмол хянадаг.

**Хязгаар (Лимит).** Банк нь нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдүүд буюу групп зээлдэгчид, салбар тус бүрээр эрсдэлийн хязгаарыг тогтоож, зээлийн эрсдэлийг зохих түвшинд ангилан удирддаг. Зээлдэгчийн болон салбарын эрсдэлийн хязгаарыг ТУЗ-өөс баталж, банкны эрсдэлийн засаглалын хүрээнд Зээлийн эрсдэлийн хороо нь хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажилладаг.

Банк нь томоохон харилцагч талууд, харилцан хамаарал бүхий групп зээлдэгчид болон салбаруудын төвлөрлийн эрсдэлийг тогтмол хянаж, удирддаг.

Хязгааруудыг зохицуулалтын шаардлага болон Банкны Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (RAS)-д нийцүүлэн тогтоосон байдаг. Лимитийн хэрэгжилтэд удирдлагын тогтмол тайлангаар хяналт тавьж, хязгаар хэтрэх эрсдэлтэй тохиолдолд шат дараатай мэдээллэж, зохих арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг. Батлагдсан хязгаарууд зөрчигдөж болзошгүй аливаа тохиолдлыг Гүйцэтгэх удирдлагад нэн даруй тайлагнаж, багцын хэмжээг бууруулах болон хяналтыг сайжруулах зэрэг холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

**Зээлийн эрсдэлийн хороо.** Банк нь Төв Банкны Зээлийн Эрсдэлийн Хороо /цаашид ТБЗЭХ гэх/ болон Салбарын түвшний зээлийн эрсдэлийн хороод гэсэн 2 түвшний зээлийн эрсдэлийн хороотой. Салбарын түвшний зээлийн эрсдэлийн хороодод ЖДББ-ны зээлийн эрсдэлийн хороо, УБИБ-ны Салбарын зээлийн эрсдэлийн хороо, ОНИБ-ны Салбарын зээлийн эрсдэлийн хороод багтдаг.

ТБЗЭХ нь сар бүрийн 2 болон 4 дэх долоо хоног бүр, бусад зээлийн эрсдэлийн хороод сард нэгээс доошгүй удаа хуралддаг.

ТБЗЭХ нь зээлийн үйл ажиллагаа, зээлийн эрсдэлтэй холбоотой журмыг хэлэлцэн баталж, зээлийн эрсдэлийн дотоод лимитийг тогтоодог. Түүнчлэн ТБЗЭХ нь нийт зээлийн багцын чанар, төвлөрлийн эрсдэл, зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ, эрт илрүүлэлтийн системийн хэрэгжилт, дотоод лимит, зээлдүүлэгч байгууллагуудын шаардлагын биелэлт тэдгээрийн гүйцэтгэлийг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гарган, хяналт тавьж ажилладаг. ТБЗЭХ-г Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч удирддаг.

Салбарын түвшний зээлийн эрсдэлийн хороод нь өөрийн харьяа салбар нэгжүүдийн багцын чанар, асуудалтай зээлийн талаар хэлэлцэж, бууруулах арга хэмжээ, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, тэдгээрийн биелэлтэд хяналт тавьж ажилладаг.

**Зээлийн хороод.** Банкны зээлийн хороодын бүтцийг зээлийн дүн, эрсдэлийн төлөвөөс хамаарч шат шатны түвшинд батлах эрхийг хуваарилах замаар зохион байгуулсан. Энэхүү шаталсан тогтолцоо нь зээлийн эрсдэлийн үр дүнтэй хяналт, шуурхай шийдвэр гаргалт болон зохистой хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Банк нь зээл батлах болон зээлийн эрсдэлийн тасралтгүй хяналт, мониторингийг хэрэгжүүлэх зорилгоор дараах зээлийн хороодтой. Үүнд:

Төв Банкны зээлийн хороо (ТБЗХ) нь доод шатны зээлийн хороодын эрхийн хэмжээнээс давсан бүх зээлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Түүнчлэн "ТУЗ-өөс зээлийн шийдвэрт хяналт тавих үйл ажиллагааны журам"-ын дагуу зээлдэгчийн эрсдэлийн түвшин болон зээлийн саналын хэмжээнээс хамаарч доод түвшний хороодын баталсан зээлийн шийдвэрүүдэд ТУЗ-өөс хяналт тавьдаг.

ТБЗХ нь дараах зээлийн хороодын эрхийн хэмжээг тогтоож, баталдаг:

- а. Төв Банкны зээлийн дэд хороо (ТБЗДХ),
- б. Жижиг, дунд бизнесийн банкны зээлийн хороо (ЖДББЗХ)
- в. Улаанбаатарын иргэдийн банкны харьяа салбарын зээлийн хороо (УБИБСЗХ)
- г. Орон нутгийн иргэдийн банкны харьяа салбарын зээлийн хороо (ОНИБСЗХ)
- д. Төв банкны ажилтны зээлийн хороо

Энэхүү шаталсан шийдвэр гаргалтын тогтолцоо нь эрсдэл өндөртэй болон өндөр дүнтэй зээлүүдэд илүү нарийвчилсан хяналт, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж, тэдгээрийг зохистой засаглал болон хяналтын хүрээнд шийдвэрлэх нөхцөлийг хангадаг.

**Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем.** Зээлийн эрсдэлийг хэмжих, санхүүгийн хэрэглүүрийн зээлжих зэрэглэлийг зээлийн эрсдэлийн хэмжээгээр ангилахын тулд Банк хоёр аргачлалыг ашигладаг - гадны олон улсын зээлжих зэрэглэлийн байгууллагууд (Стандарт & Пүүрс - "S&P", Фитч, Мүүдис)-ын тогтоосон эрсдэлийн үнэлгээ болон дотоод чанаргүйдлийн магадлал (ЧМ)-ын интервалыг ашигладаг. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар шатлалд ашигласан чанаргүйдлийн магадлалын интервалыг Тодруулга 11, Тодруулга 33-аас харна уу. Гадны зээлжих зэрэглэлийг дотооддоо тодорхойлсон ерөнхий зээлийн эрсдэлийг үнэлгээтэй хамтруулан чанаргүйдлийн магадлалыг тодорхойлсон интервалын хүрээг дараах хүснэгтэд харууллаа:

Ерөнхий зээлийн эрсдэлийн үнэлгээ	Гадны олон улсын зээлжих зэрэглэлийн байгууллагуудын холбогдох үнэлгээ (S&P)	Холбогдох ЧМ-ын интервал
Маш сайн	AAA зэрэгтэй	0.0200%
Маш сайн	AA- -с AA+ зэрэгтэй	0.0200% - 0.0237%
Маш сайн	A- -с A+ зэрэгтэй	0.0475% - 0.0593%
Сайн	BBB- -с BBB+ зэрэгтэй	0.1068% - 0.2492%
Сайн	BB- -с BB+ зэрэгтэй	0.3204% - 1.0324%
Хангалттай	B- -с B+ зэрэгтэй	0.9256% - 8.0218%
Дефолт	C -с CCC+ зэрэгтэй	100%
Тодорхойгүй	Зэрэглэл байхгүй	4.1770%

**Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад зээлийн сайжруулалт.** Барьцаа хөрөнгийн үнэлгээний дүн болон төрөл нь зээлдэгч болон харилцагч талын зээлийн эрсдэлийн үнэлгээ ба олгох зээлийн төрөл болон зориулалтаас хамаардаг. Барьцаалах боломжтой барьцаа хөрөнгийн үндсэн төрлүүдийг дор үзүүлэв. Үүнд:

- i. Байгууллага болон Жижиг, дунд бизнесийн зээлийн хувьд үл хөдлөх хөрөнгө, бараа материал, үйлдвэр ба тоног төхөөрөмж, машин механизм;
- ii. Хэрэглээний зээлийн хувьд автомашин, орлого болон үл хөдлөх хөрөнгө гэх мэт;
- iii. Орон сууц худалдан авах зээлийн хувьд орон сууцны үл хөдлөх хөрөнгийн барьцаа

Банкны Зээлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу цалингийн зээл болон тэтгэврийн зээлээс бусад бүх зээлийн хувьд барьцаа хөрөнгийн эрсдэл тооцсон үнэ ("RAP") нь тухайн зээлийн дүнгийн 100%-аас доошгүй байна. Зээлийн бүтээгдэхүүний тодорхой журамд өөрөөр заагаагүй бол барьцаа хөрөнгийн эрсдэл тооцсон үнэ нь зээлийн дүнгийн 100%-аас бага байж болно.

Банк нь аж ахуйн нэгжид зээл олгохдоо тухайн аж ахуйн нэгжийн толгой компаниас болон хязгаарлагдмал хувьцаат компанийн гол хувьцаа эзэмшигчдээс баталгаа, батлан даалт гаргуулж авдаг хэдий ч тухайн баталгаа, батлан даалтаас үүсэж болзошгүй үр өгөөжийг дээр дурдсан барьцаа хөрөнгийн үнэлгээнд тусгаагүй болно.

Банк нь барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнд тогтмол хяналт тавьж ажилладаг ба харилцагчтай байгуулсан гэрээний дагуу шаардлагатай үед нэмэлт барьцаа хөрөнгө гаргуулахаар хүсэлт тавьдаг.

Банкны зээлийн дотоод үнэлгээний систем, жилийн эцсийн шатлалын ангилалд үндэслэсэн зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээг Тодруулга 7, 8, 9, 10, 12-оос харна уу.

**Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт:** ХБЭА нь ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын өнөөгийн үнэ цэнэ (өөрөөр хэлбэл: зээлийн үргэлжлэх хугацаанд зээл дефолт болоход жигнэсэн дундаж алдагдал) юм. ХБЭА нь нэг хүчин зүйлээс шууд хамааралтай бус хэд хэдэн боломжит хувилбаруудаас хамаарч тооцоологддог. Банкны ХБЭА-ын тооцоолол дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: Чанаргүйдлийн магадлал ("ЧМ"), Чанаргүйдэлд өртөх дүн ("ЧӨД"), Алдагдалд хүргэх чанаргүйдэл ("АХЧ") болон Хөнгөлөлтийн хувь.

ЧӨД гэдэг нь зээл дефолт болох үеийн үлдэгдэл бөгөөд тайлант хугацаанаас хойших зээлийн үлдэгдлийг таамаглахдаа зээлийн эргэн төлөлт буюу үндсэн зээлийн болон хүүгийн төлөлт, нэмж олгож болзошгүй зээлийн дүнг харгалзан авч үздэг. Хүлээж болзошгүй үүргийн дефолт болох үеийн зээлийн үлдэгдлийг тооцоолохдоо зээл хөрвүүлэлтийн коэффициент ("ЗХК") ашигладаг. ЗХК нь хүлээж болзошгүй үүрэг зээл хөрвүүлэлтийн магадлалын коэффициент бөгөөд энэ нь тогтоосон хугацаанд хүлээсэн үүргийн дүнг тайлан тэнцэлд тусгах магадлалыг харуулдаг.

ЧМ нь өгөгдсөн хугацааны туршид дефолт болох магадлалын тооцоолол юм. АХЧ нь зээл дефолт болсон тохиолдолд түүнээс хүлээж болзошгүй алдагдлын тооцоолол юм. АХЧ нь гэрээний дагуух төлөх ёстой мөнгөн дүн болон зээлдүүлэгч тухайн зээлээс төлүүлж чадах мөнгөн дүн хоёрын зөрүү юм. Харилцагчаас төлүүлж чадах мөнгөн дүнд барьцаа хөрөнгө орно. АХЧ нь ихэвчлэн ЧӨД-д эзлэх хувиар илэрхийлэгддэг. Хүлээгдэж буй алдагдлыг тайлант хугацааны эцэст өнөөгийн үнэ цэнээр хорогдуулна. Хөнгөлөлтийн хувь нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн аргачлал ("ҮАХА") юм.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцооллыг зээлийн нийт хугацааны туршид загварчилсан. Нийт хугацааны туршид гэдэг нь өрийн хэрэглүүрийн гэрээний үлдсэн хугацаа ба гэрээнээсээ өмнө төлөгдөх магадлалыг тохируулдаг. Зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааны гэрээний хувьд тухайн аж ахуйн нэгж зээлийн хугацааг сунгах гэрээний үүрэгтэй гэрээт хугацаа юм. Нийт хугацааг гэрээний дагуу хүлээгдэж буй үлдэгдэл хугацаагаар тодорхойлдог бол хувь хүнд олгосон зээлийн картын хувьд нийт хугацаа нь гэрээний дагуух картын хугацаа бөгөөд энэ нь хамгийн ихдээ 2 хүртэлх жилтэй тэнцүү байна.

Нийт хугацааны ХБЭА нь зээлийн дуусах хугацааны турш болзошгүй бүх дефолт тохиолдлоос үүсэх алдагдал юм. 12 сарын ХБЭА нь зээлийн дуусах хүртэлх хугацааны ХБЭА-ын нэг хэсэг бөгөөд тайлант хугацаанаас хойших 12 сарын хугацаанд үүсэж болзошгүй зээлийн алдагдал юм. Хэрэв зээлийн дуусах хугацаа нь 12 сараас бага байвал хүлээж болзошгүй зээлийн алдагдлыг дуусах хугацаа хүртэл тооцоолно.

Санхүүгийн тайланд толилуулсан ХБЭА-ын тооцоолол нь дотоодын зохицуулагч байгууллагад зориулсан урт хугацааны өгөгдлийг ашиглах бус сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан. Тооцоолол нь ирээдүйн таамаглалыг агуулсан буюу зээлийн эрсдэлд нөлөөлдөг гол макро хувьсагчуудын ирээдүйд болох таамаглал тусгагдсан.

Монголбанкны тайлангийн зорилгоор ХБЭА-ын тооцоололд өөр аргачлал ашигладаг. 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкны аргачлалын дагуу ХБЭА нь 522,597,849 мянган төгрөг (2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 440,820,124 мянган төгрөг) байна.

**Чанаргүйдлийн тодорхойлолт.** ЧМ-ыг хэмжихийн тулд Банк дараах шалгууруудын нэг буюу хэд хэдэн шалгуурыг хангасан нөхцөл байдлыг чанаргүйдэл гэж тодорхойлдог:

- Зээлдэгч гэрээний дагуу төлөх төлбөрөө 90 хоногоос дээш хугацаагаар хугацаа хэтрүүлсэн;
- Зээлдэгч бусад банкинд гэрээний дагуу төлөх төлбөрөө 90 хоногоос дээш хугацаагаар хугацаа хэтрүүлсэн зээлтэй;
- Банк зээлийн чанар муудсаны улмаас зээлдэгчийн өр төлбөрийн бүхэлд нь эсвэл хэсэгчлэн алдагдалтай худалдсан;
- Зээлдэгч нь доорх төлбөр төлөх боломжгүй гэсэн шалгуурыг хангасан:
  - o Банк зээлийн гэрээний бүтцэд өөрчлөлт оруулахаас өөр аргагүй болсон;
  - o Зээлдэгч нас барсан;

- Зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон;
- Зээлийн хугацаанд барьцаа хөрөнгийн үнэгүйдэл;
- Зээлдэгчийн эргэлтийн хөрөнгө буурсан эсвэл томоохон үйлчлүүлэгчээ алдах;
- Зээлдэгч дампуурах магадлалтай болсон;
- Банкны зүгээс зээлдэгчийг зээлийн төлбөрийн үүргээ биелүүлэх боломжгүй гэж үзэх бусад нөхцөл байдал;
- Зээл нь ЗЭМӨ (Тодруулга 4)-ийн аль нэг нөхцөлийг хангасан ба тус зээлдэгчийн өөр нэг зээл чанаргүй болсон.

Тодруулгын зорилгоор, Банкны чанаргүйдлийн тодорхойлолт болон зээлийн үнэ цэнэ бууралтын тодорхойлолт хооронд ямар нэгэн зөрүүгүй бөгөөд дээр дурдсан чанаргүйдлийн тодорхойлолт нь Банкны санхүүгийн бүх хөрөнгөнд мөрдөгдөнө.

Санхүүгийн хөрөнгө нь зургаан сар дараалан чанаргүйдлийн тодорхойлолтод заасан нөхцөлүүд арилсан тохиолдолд чанаргүйдлийн байдлаас гарч болно.

Зээл анх олгогдсоноос хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн ("ЗЭМӨ") эсэх үнэлгээ нь зээл нэг бүрчлэн хийгддэг. Банкны Зээлийн Эрсдэлийн Газар зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн (Тодруулга 4) эсэх нөхцөлүүдийн тохиромжтой байдлыг тогтмол хугацаатай хянаж байдаг. Зээл анх олгогдсоноос хойш эрсдэл илэрхий өссөн эсэх шалгууруудын нэг болох хугацаа хэтэрсэн хоног нь 30-аас дээш хоног байх нөхцөл өөрчлөгдөөгүй болно.

Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцоолол нь харилцагчийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өссөн эсэхэд тулгуурладаг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцооллын загвар нь 3 шатлалтай байдаг. Санхүүгийн хэрэглүүр нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үед ямар нэг үнэ цэнийн бууралтгүй байдаг ба түүний зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш их хэмжээгээр нэмэгдээгүй бөгөөд 12 сарын ХБЭА (шатлал 1)-д үндэслэн эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг тооцдог. Хэрвээ зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн нь тогтоогдсон тохиолдолд 2-р шатлалд орж, нийт хугацааны ХБЭА-д үндэслэн эрсдэлийн алдагдлыг тооцоолно. 2-р шатлалд орсон зээлүүд нь үнэ цэнэ буураагүй санхүүгийн хэрэглүүр болно. Санхүүгийн хэрэглүүр нь үнэ цэнэ буурсан тохиолдолд 3-р шатлалд хуваарилагдаж, дуусах хугацаа хүртэлх ХБЭА-ыг тооцоолдог. Хүүгийн орлогыг тооцоходоо 3-р шатлалд орсон зээлүүдийн хүүгийн орлогыг зээлийн эрсдэлийн сангаас цэвэршүүлсэн дүнд тооцоолдог.

Хэрэв зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг үнэлдэг шалгуурууд нь тухайн зээлд дахин илрээгүй бол 1-р шатлалд шилжинэ. Банк чанарын үзүүлэлтээр 2-р шатлалд шилжсэн зээлүүдийг тогтмол хянадаг. Банк үзүүлэлтүүд нь хэвээр эсвэл өөрчлөгдсөн эсэхийг хянадаг.

Үнэ цэнэ буурсан зээл олгосон ба худалдан авсан санхүүгийн хөрөнгүүдийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь үргэлж нийт хугацааны турш тооцоологддог. Иймд Банк эдгээр зээлийн хувьд зөвхөн нийт хугацааны ХБЭА-ын зөрүүг бүртгэдэг.

ХБЭА-ын тооцоолол нь хоёр үнэлгээний аргаас бүрддэг. Үүнд: (1) тусгай үнэлгээ; (2) бүлгийн үнэлгээ: зээлийн багцын нэг ижил төрлийн сегментүүдийн хувьд ХБЭА-ын тооцоололд ижил зээлийн эрсдэлийн параметр (жишээ нь: ЧМ, АХЧ)-ийг ашигладаг.

Банк дараах төрлийн зээлүүдийг тусгай үнэлгээний аргаар үнэлдэг:

- i. 2,000,000 мянган төгрөгөөс дээш үлдэгдэлтэй, 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн, гэрээний бүтцэд өөрчлөлт оруулсан зээл;
- ii. Дотоод үнэлгээний "Анхаарах зээлийн жагсаалт" орсон тохиолдолд.

Зээлийн үнэ цэнэ бууралтын бодит нотлох баримт илэрсэн тохиолдолд ХБЭА-ыг тооцно. Зээлийн үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо нь санхүүгийн хүндрэл, гэрээний үүргээ биелүүлээгүй болон хугацаа хэтэрсэн, гэрээний бүтцийн өөрчлөлт, барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралт зэрэг юм.

Хүлээгдэж буй алдагдлын тооцоо, боломжит хувилбарыг тодорхой үнэлгээний аргаар үнэлж, хувилбар бүрийн магадлалыг харгалзан ХБЭА-ыг тооцно.

Банк дараах төрлийн зээлүүдэд багцын үнэлгээ хийдэг. Үүнд: Зээлдэгчийн мэдээлэл байхгүй үед хэрэглээний болон ЖДҮ-ийн зээл олгосон. Энэ арга нь зээлдэгчийн тусгайлсан мэдээлэл, тухайлбал, алдагдлын талаарх түүхэн

мэдээлэл, байршил болон бусад урьдчилан таамаглах мэдээлэл зэрэгт үндэслэн зээлийн санг нэгэн төрлийн сегмент болгон ангилдаг. Банк нь мөн байгууллагын харилцагчдад олгосон зээл, банк хоорондын зээл, хэрэглээний зээл, ЖДҮ-д олгосон зээлийн үнэлгээг багцаар хийдэг.

Тусгайлсан ХБЭА-ын үнэлгээг үр дүн бүрийн магадлалын эсрэг олон төрлийн боломжит үр дүнгийн зээлийн алдагдлын тооцооллыг жинлэх замаар гүйцэтгэдэг. Банк үнэлгээнд хамрагдсан зээл бүрийн хувьд 2-3 боломжит үр дүнг тодорхойлдог бөгөөд тэдгээрийн нэг хувилбарын магадлал нь маш бага байсан ч зээлийн алдагдалд нөлөөлнө. Тусгай үнэлгээ нь үндсэндээ Байгууллагын банкны газар болон Зээлийн эрсдэлийн газар, Тусгай активын газрын туршлагатай ажилтнууд, шинжээчдийн дүгнэлтэд суурилдаг. Тооцоолол болон бодит алдагдлын зөрүүг багасгахын тулд шинжээчид тогтмол дүгнэлт хийн шалгаж үздэг.

Бүлгийн үнэлгээний аргаар бүлгийн алдагдлын санг тооцоолохдоо зээл бүрийг үе шат бүрд хуваарилдаг. Банкны зээлийн эрсдэлийн нийтлэг шинж чанарт үндэслэн тодорхойлогдсон сегментүүдээр эрсдэлээ шинжилдэг. Банк зээлүүдийг ижил төрлийн эрсдэлийн шинж чанартайгаар нь ялган бүлэглэж тооцоолдог. Ижил төрлийн эрсдэлийн шинж чанартай зээл гэдэг нь харилцагчийн ангилал (бизнесийн, хэрэглээний болон хөдөө аж ахуйн гэх мэт) бүтээгдэхүүний төрөл, зээлийн эрсдэлийн зэрэглэл, анх хүлээн зөвшөөрөгдсөн огноо, дуусах хугацаа, барьцаа хөрөнгийн чанар, зээлийн үнэ (ЗҮ) харьцаа юм. Бүлэг болгон өөр өөр ЧМ болон АХЧ зэрэг эрсдэлийн параметруудтэй байна. Зээлийн эрсдэлийн газар нь зээлүүдийг бүлэглэх нь зохистой байгаа эсэхийг тогтмол хянаж байдаг.

ХБЭА нь ЧӨД, ЧМ, АХЧ зэрэг эрсдэлийн параметруудийн үржвэр бөгөөд тухайн санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүүгээр дискаунт хийж өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдэнэ. Эрсдэлийн параметр (ЧӨД, ЧМ, АХЧ)-ийг ирэх нэг жилийн таамаглалын тооцооллыг зээл нэг бүрийн эсвэл бүлгэлсэн зээлүүдийн хувьд гаргаж тооцоолдог. Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгийг хамтад нь үржүүлж, зээл төлөгдөх магадлалыг тохируулна (өөрөөр хэлбэл, чанаргүйдлийн өмнөх сард төлсөн эсвэл төлөгдөөгүй). ХБЭА нь зээл бүрийн ирээдүйн алдагдлыг тооцоолол ба тайлант огноо руу дискаунт хийсэн алдагдлуудын нийлбэр юм. ХБЭА-ын тооцоололд ашиглагдаж буй дискаунт хүү нь үр ашигт хүү эсвэл ойролцоо тооцоолсон хүү байна.

**Зээлийн эрсдэлийн параметруудийг тооцоолох үндсэн зарчим.** ЧӨД-үүд нь хүлээгдэж буй төлбөрийн хуваарьт тулгуурлан тодорхойлогддог бөгөөд энэ нь бүтээгдэхүүний төрлөөс хамаарна. ЧӨД нь зээлдэгчийн хүлээсэн үүргийнхээ дагуу ирэх 12 сар эсвэл нийт хугацааны туршид төлөх ёстой зээлийн эргэн төлөлтөд тулгуурладаг. Үүнийг мөн зээлдэгчийн төлөхөөр хүлээгдэж буй илүү төлбөрт тохируулдаг. Зээлдэгч нь зээлийн хуваарьт зааснаас өмнө зээлээ урьдчилан төлөх магадлалтай дүнгээр зээлийн эргэн төлөлтийн хуваарьт тохируулга хийдэг. Эргэн төлөлт, дахин санхүүжилтийн таамаглалыг мөн тооцоололд оруулдаг. Эргэлтийн бүтээгдэхүүнүүдийн хувьд ЧӨД нь одоогийн үлдэгдлийг авч, зээлийн хөрвүүлэлтийн коэффициент ашиглан үлдсэн хугацаан дахь хүлээгдэж буй зээл олголтыг нэмж тооцоолдог. Эдгээр таамаглалууд нь бүтээгдэхүүний төрөл, одоогийн зээлийн эрхийн хэрэглээ болон зээлдэгчийн онцлог зан төлөвөөс хамаарч ялгаатай байж болно.

ХБЭА-ыг тооцоход хоёр төрлийн ЧМ ашигладаг ба эдгээр нь 12 сар ба нийт хугацааны ЧМ юм. 12 сарын ЧМ-ын үнэлгээ нь хамгийн сүүлийн үеийн өгөгдөлд суурилсан. Нийт хугацааны ЧМ нь санхүүгийн хэрэглүүрийн үлдсэн хугацааны туршид дефолт болох магадлал ба энэ нь санхүүгийн хэрэглүүрийн 12 сар болон дефолт болох магадлалын нийлбэр байна. Банк шилжих хөдөлгөөнт матрицийн статистик аргагүйг ашиглан нийт хугацааны ЧМ-ыг харилцагчийн ангилал болон хугацаа хэтэрсэн хоногт тулгуурлан тооцоолдог. Тухайлбал, шилжих хөдөлгөөний матрицад суурилсан 12 сарын ЧМ-ыг экстраполяци хийж, түүхэн дефолт өгөгдөлд суурилсан нийт хугацааны ЧМ муруйг сайжруулах гэх мэт.

АХЧ нь төлөгдөөгүй эрсдэлээс үүдэн гарах алдагдлын хэмжээг буюу Банкны хүлээлтийг илэрхийлнэ. АХЧ нь харилцагч талын /counterparty/ төрөл, нэхэмжлэлийн төрөл, барьцаа хөрөнгө зэргээс хамаарч өөр өөр байдаг. 12 сар ба нийт хугацааны АХЧ нь зээл дефолт болсны дараа хүлээгдэж буй эргэн төлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг авч үздэг.

АХЧ хэмжилтийг гурван боломжит аргад хувааж болно:

- Барьцаа хөрөнгийн онцлог шинж чанарт үндэслэсэн АХЧ хэмжилт;
- Эргэн төлөлтийн статистик мэдээлэлд тулгуурласан бүлэгт суурилсан АХЧ тооцоолол;
- Өөр өөр хүчин зүйлс, хувилбараас хамааран дангаар нь тодорхойлсон АХЧ.

Банк үл хөдлөх хөрөнгө, бэлэн мөнгө, хөрвөх чадвартай үнэт цаасаар баталгаажсан зээлийн барьцаа хөрөнгийн төсөөлж буй үнэ, борлуулалтын түүхэн хөнгөлөлт болон бусад хүчин зүйлс зэрэгт үндэслэн АХЧ-ийг тооцдог. АХЧ-ийг хамгийн сүүлийн үеийн эргэн төлөлтийн статистик мэдээлэлд үндэслэн байгууллагын болон хэрэглээний бүх зээлүүдэд бүлгийн түвшинд тооцоолдог.

**Санхүүгийн баталгаа болон зээлийн үүргийн ХБЭА-ын хэмжилт.** Эдгээр хэрэглүүрийн ХБЭА-ын хэмжилт нь дээр дурдсантай ижил тооцоологдох боловч дефолт болох үеийн зээлийн үлдэгдэл АХЧ-ийн тооцооллын хувьд ялгаатай байна. АХЧ нь зээл хөрвүүлэлтийн коэффициент ("ЗХК") болон үүргийн дүнгээс хамаарна. Зээл хөрвүүлэлтийн коэффициент нь олгогдоогүй зээлийн үүрэг, зээлийн карт, санхүүгийн баталгааны түүхэн статистик тооцоололд тулгуурладаг. Овердрафтын зээл хөрвүүлэлтийн коэффициент нь 100% гэж тодорхойлогддог, учир нь харилцагч ямар ч үед дээд хэмжээгээр нь ашиглах боломжтой байдаг.

**ХБЭА-ын тооцоололд орсон ирээдүйн мэдээлэл.** Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт болон ХБЭА-ыг тооцоолоход шударга болон дэмжигдэхүйц ирээдүйд үндэслэсэн мэдээллийг оролцуулдаг. Банк зээлийн эрсдэл болон ХБЭА-ыг боловсруулахад хамааралтай гол эдийн засгийн хувьсагч хэмжигдэхүүнүүдийг тодорхойлсон байдаг. Эдийн засгийн гол хувьсагч хэмжигдэхүүнүүдийг ("эдийн засгийн суурь хувилбар") улирал тутам Банкны Хөрөнгийн Удирдлагын газраас гаргаж, таван жилд хүлээгдэж буй макро эдийн засгийн хөгжлийн хамгийн оновчтой тооцоог гаргаж өгдөг. Таван жилийн дараа "дундаж урвуу хандлагыг" ашигладаг бөгөөд энэ нь эдийн засгийн урт хугацааны дундаж түвшин (жишээ нь, ажилгүйдлийн түвшин) эсвэл урт хугацааны дундаж өсөлтийн хувь (жишээлбэл, ДНБ) руу буцах хандлагатай байдаг. Чанаргүйдлийн магадлал (ЧМ), Чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД) болон Алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ)-д нөлөөлөх холбогдох эдийн засгийн хувьсагчдыг нөлөөг тодорхойлохын тулд статистик регрессийн шинжилгээ хийн эдгээр хувьсагчдын өөрчлөлт нь өмнө хэрхэн АХЧ болон ЧӨД-ийн бүрэлдэхүүнд нөлөөлж байсныг тодорхойлно.

Сүүлийн жилүүдэд өвөлжилт хүндэрч байгаа тул малын хорогдол нэмэгдэх төлөвтэй байгаа ба ингэснээр малчдын зээлийн багцын зээлийн эрсдэл нэмэгдэнэ. Банк малчдын зээлээ төлөх чадварт ихээхэн сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар малчдын зээлийн хэтийн төлөвийг тусад нь тооцсон.

Эдийн засгийн суурь хувилбараас гадна Банкны Зээлийн Эрсдэлийн газар нь бусад боломжит хувилбаруудыг магадлалын хувь хэмжээтэй өгдөг. Бусад хувилбаруудын шугаман бус байдлыг харуулахын тулд үндсэн томоохон бүтээгдэхүүнүүдийн тус бүрийн шинжилгээнд үндэслэдэг. Хувилбаруудын хэмжээний хувьд тайлант жил бүр дахин үнэлэгддэг ба статистик шинжилгээ ба шинжээчдийн зээлийн дүгнэлтийг хослуулан тодорхойлдог ба ингэхдээ сонгогдсон хувилбар бүрийг илтгэх боломжит үр дүнг харгалзан үздэг. Зээлийн мэдэхүйц өсөлтийн хэмжээг тооцоолохын тулд ЧМ-ын нийт хугацааг холбогдох хувилбарын хувь хэмжээнд үржүүлнэ, ингэхдээ чанар болон back-stop индикаторуудыг оролцуулна. Энэ нь санхүүгийн хэрэглүүрийг бүхэлдээ 1-р шатлал, 2-р шатлал эсвэл 3-р шатлалд орох эсэхийг тодорхойлж 12 сар эсвэл нийт хугацааны ЧМ бүртгэх эсэхийг тодорхойлно. Энэхүү үнэлгээний дараа Банк 12 сарын магадлалаар жинлэсэн ХБЭА-ыг бүртгэх (1-р шатлал) эсвэл магадлалаар жинлэгдсэн нийт хугацааны ХБЭА-ыг бүртгэнэ (2,3-р шатлал). Энэ магадлалаар жинлэсэн ХБЭА-ыг холбогдох ХБЭА-ын загвар хувилбар тус бүрээр гүйцэтгэж зохих хувилбарын жигнэгчээр үржүүлснээр тодорхойлогдоно.

Эдийн засгийн урьдчилсан таамаглалын хувьд тэдгээр тохиолдлын биелэх магадлал, төсөөлөл нь маш тодорхойгүй байдаг тул бодит үр дүн нь төлөвлөснөөс эрс ялгаатай байж болно. Банк эдгээр таамаглалуудыг боломжит үр дүнгийн хамгийн сайн тооцоолол гэж үзсэн ба өөр өөр бүлгүүдийн шугаман бус ба тэгш бус байдлын сонгогдсон хувилбарууд нь боломжит хувилбаруудыг хамгийн сайн боломжит байдлаар төлөөлдөг болохыг тогтоосон.

Банк эрсдэлийн тооцоолол болон бодит алдагдал хоёрын хоорондын зөрүүг бага байлгах үүднээс тооцооллын загварыг болон таамаглалыг тогтмол хугацаанд хянадаг. Тухайн хяналтыг жилдээ хамгийн багадаа нэг удаа хийж гүйцэтгэдэг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцооллын загварын хяналтын үр дүнг банкны удирдлагуудад хүргүүлдэг ба хэлэлцүүлгээс гарсан үр дүнд үндэслэн загвар болон тооцоололд шаардлагатай шинэчлэлүүдийг хийдэг.

### 34.3 Зах зээлийн эрсдэл

Банк зах зээлийн эрсдэлд өртөх боломжтой бөгөөд энэхүү эрсдэлд а) валютын ханш, б) хүүгийн түвшин, в) өмчийн хэрэглүүр болон г) санхүүгийн хэрэглүүрүүд (үүнд үүсмэл санхүүгийн хэрэглүүр орно)-ийн нээлттэй позицоос үүсэх эрсдэлүүд ордог ба эдгээр нь зах зээлийн ерөнхий болон тусгай өөрчлөлт, хөдөлгөөнд өртдөг. Банкны удирдлага нь хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшин, түүний хязгаарыг тогтоодог ба хэрэгжилтийг өдөр тутам хянаж ажилладаг. Гэсэн хэдий ч энэ нь зах зээлийн ач холбогдол бүхий үйл явдлуудын үед хязгаараас давсан алдагдлаас сэргийлж чадахгүй юм.

Банк хамгийн их эрсдэлийн арга (VaR), статик хугацааны зөрүүний шинжилгээ, мэдрэмтгий байдлын шинжилгээг ашиглан зах зээлийн эрсдэлээ хэмжин удирддаг бөгөөд АПУХ-оос стоп лосс лимит, позицгийн лимит, мөнгөн гүйлгээний хейджийн зорилгоор хийх бодит бус нөхцөлтэй үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн мөнгөн урсгалын лимит, банкууд ба харилцагчидтай хийх арилжааны лимит болон зээлээс бусад активын нийт лимитийг тогтоон мөрдүүлж ажиллаж байна.

Түүнчлэн Банк өөрийн эрсдэл даах чадварыг үнэлэх, цаашлаад том хэмжээний гэнэтийн өөрчлөлтөөс учирч болзошгүй алдагдлыг тэсвэрлэх, хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө ба төлбөрийн чадвартай эсэхийг тодорхойлох, хүндрэлийг даван туулах шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор улирал тутам стресс тестийн шинжилгээг хийдэг. Банк олон улсад өргөн ашиглагддаг шилдэг туршлага, стандартад нийцүүлэн зах зээлийн эрсдэлийг хэмжих загвар, аргачлал, лимит тогтоох үйл явц болон эрсдэл бууруулах арга хэрэгслүүдийг тасралтгүй хөгжүүлж, хэрэгжүүлж ажилладаг.

### 34.4. Гадаад валютын ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдэлийг гадаад валютын ханшийн эрсдэл гэнэ. Банк гадаад валютын ханшийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Монголбанкнаас банкуудад гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг тэдгээрийн эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор тогтоосон тухайн нэг болон нийт гадаад валютын нээлттэй позицгийн хязгаарлалуудыг хангаж ажиллаж байна. Мөн дотооддоо гадаад валютын нээлттэй позицоос тодорхой хугацаанд алдаж болох алдагдлын хэмжээг тодорхой магадлалтайгаар тодорхойлдог. Хамгийн их эрсдэлийн аргаар ханшийн эрсдэлээ хэмжиж удирдаж ажилладаг. Банкны ашиглаж буй VaR аргачлал нь 99%-ийн итгэлцлийн түвшинд хэрэв одоогийн позиц нэг өдөр өөрчлөгдөхгүй хэвээр байхад болзошгүй алдагдлын хэмжээ нь хэтэрч илүү гарахгүй байх 1 өдрийн хугацааг ашигладаг ба эдгээр хувьсагчуудыг зах зээлийн өгөгдлийн 250 өдрийн хөдөлгөөнийг ажигласны үндсэн дээр тодорхойлдог. Эдгээр загварууд нь зах зээлийн хэвийн нөхцөлд эрсдэлийн хүчин зүйлсийн өөрчлөлтүүд нь хэвийн тархалттай байна гэж үздэг. Зах зээлд тогтворгүй байдал үүссэн тохиолдолд гадаад валютын эрсдэлийг илүү нарийвчлалтайгаар тооцох хэрэгцээ шаардлага өндөр байдаг. Иймд, Банк дотоод программ хангамжинд үнэлгээний загварууд болон буцаан шалгах аргачлалуудыг өргөтгөх, удирдлагын мэдээллийн системийн чанарыг сайжруулах зэрэг томоохон хөгжүүлэлтүүдийг хийсэн. Банк энэхүү хөгжүүлэлтүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан ханшийн эрсдэлийн VaR тайланг (2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 83,409 мянган төгрөг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 61,193 мянган төгрөг) бэлтгэж, АПУХ-оос тогтоосон лимитийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

Банк мөн харилцагч байгууллагуудтай хийх арилжааны лимитийг тогтоож тогтмол хяналт тавин ажилладаг. Түүнчлэн гадаад валютын захын тогтворгүй үед банкны хүндрэлтэй үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахын зэрэгцээ гадаад валютын ханшийн эрсдэлийн стресс тестийг улирал бүр хийж, үр дүнг АПУХ-нд танилцуулан ажиллаж байна.

Тайлант хугацааны эцэст Банкны гадаад валютын ханшийн эрсдэлийн хураангуйг доорх хүснэгтээр харуулав:

Мянган төг	2025 оны 12 дугаар сарын 31				2024 оны 12 дугаар сарын 31			
	Мөнгөөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	Мөнгөөр илэрхийлэгдэх санхүүгийн өр төлбөр	Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	Цэвэр дүн	Мөнгөөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	Мөнгөөр илэрхийлэгдэх санхүүгийн өр төлбөр	Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	Цэвэр дүн
Төгрөг	19,888,496,442	(14,764,076,551)	(3,049,648,787)	2,074,771,104	17,585,041,274	(13,332,720,559)	(2,373,560,045)	1,878,760,670
Ам.доллар	2,741,377,394	(5,867,200,870)	3,165,112,513	39,289,037	1,714,825,917	(4,132,817,896)	2,403,493,725	(14,498,254)
Евро	28,385,728	(18,382,669)	(9,838,792)	164,267	27,887,405	(22,868,096)	105,969	5,125,278
Юань	239,211,739	(352,201,719)	(5,862,170)	(118,852,150)	190,030,834	(202,291,121)	16,163	(12,244,124)
Бусад	163,369,921	(37,397,584)	(5,673,304)	120,299,033	109,556,295	(85,813,748)	(105,457)	23,637,090
<b>Нийт дүн</b>	<b>23,060,841,224</b>	<b>(21,039,259,393)</b>	<b>94,089,460</b>	<b>2,115,671,291</b>	<b>19,627,341,725</b>	<b>(17,776,511,420)</b>	<b>29,950,355</b>	<b>1,880,780,660</b>

Бусад бүх хувьсах хүчин зүйлс тогтмол үед Банкны бүртгэлийн валюттай холбоотой тайлант хугацааны эцсийн ханшийн боломжит өөрчлөлт Банкны ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөнд үзүүлэх мэдрэмтгий байдлыг доорх хүснэгтэд тусгав:

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Ам.доллар 15%-аар чангарахад (2024: 15%-аар чангарахад)	5,893,356	(2,174,738)
Ам.доллар 15%-аар сулрахад (2024: 15%-аар сулрахад)	(5,893,356)	2,174,738
Евро 15%-аар чангарахад (2024: 15%-аар чангарахад)	24,640	768,792
Евро 15%-аар сулрахад (2024: 15%-аар сулрахад)	(24,640)	(768,792)
Юань 15%-аар чангарахад (2024: 15%-аар чангарахад)	(17,827,823)	(1,836,619)
Юань 15%-аар сулрахад (2024: 15%-аар сулрахад)	17,827,823	1,836,619
Бусад валют 15%-аар чангарахад (2024: 15%-аар чангарахад)	18,044,854	3,545,564
Бусад валют 15%-аар сулрахад (2024: 15%-аар сулрахад)	(18,044,854)	(3,545,564)

### 34.5. Хүүгийн түвшний эрсдэл

Банкны санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээ нь зах зээлийн хүүний түвшний хэлбэлзлийн нөлөөнд өртдөг. Ийм хэлбэлзлийн үр дүнд хүүгийн ахиуц ашгийн хэмжээ нэмэгдэх магадлалтай боловч гэнэтийн өөрчлөлт үүсэх тохиолдолд алдагдал өсөх эсвэл эсрэгээрээ буурах ч боломжтой.

Банк нь банкны арилжааны бүртгэл болон банкны бүртгэлийн позициос хүлээж болзошгүй хүүгийн түвшний эрсдэлүүдийг хэмжиж удирддаг. Зах зээл дэх хүүний түвшний өөрчлөлт нь богино хугацаанд банкны цэвэр хүүгийн орлогод шууд нөлөөлдөг бол урт хугацаанд өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнэд нөлөөлдөг. Банк хүүгийн эрсдэлийг хамгийн бага байлгах үүднээс Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос боловсруулсан аргачлал, түүнд тодорхойлсон хүүний түвшний стандарт болон шокийн сценари хувилбаруудыг ашиглан эрсдэлээ хэмжиж, сөрөг нөлөөллийг хязгаарладаг. Энэхүү аргачлалын хүрээнд мөрдөгдөх дотоод лимитийг АПУХ баталдаг. Үүнд:

- Арилжааны бүртгэлийн хүүгийн түвшний эрсдэлийг удирдахын тулд хөрвөх чадвараар тохируулсан хамгийн их эрсдэлийн аргыг ашиглан позицийн ба стоп лосс зэрэг хязгаарлалуудыг тавьдаг.
- Банкны бүртгэлийн хүүгийн түвшний эрсдэлийг удирдахын тулд орлогын ба эдийн засгийн өртгийн хандлагуудыг ашиглаж хүлээн зөвшөөрсөн хязгаарлалтын хүрээнд сар тутам хяналт тавьдаг.

Түүнчлэн Банк олон улсын санхүүгийн байгууллагуудаас тогтоосон хүүгийн эрсдэлийн дахин үнэлгээний зөрүүний харьцаа үзүүлэлтүүдийг хангаж ажиллахын зэрэгцээ хүүгийн стресс тестийг улирал бүр хийн үр дүнг шийдвэр гаргах зорилгоор АПУХ-нд тайлагнадаг.

Доорх хүснэгтэд Банкны хүүгийн түвшний эрсдэлийн өртөх байдлыг хураангуйлан үзүүлэв. Энэхүү хүснэгтэд банкны хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийн дүнг хүүнд өөрчлөлт орох хугацаа эсвэл дуусгавар болох хугацааны аль өмнөх хугацаагаар нь ангилан үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Хугацаагүй болон 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	1 жилээс их	Хүүгүй	Нийт дүн
<b>2025 оны 12 дугаар сарын 31</b>						
Нийт санхүүгийн хөрөнгө	5,396,249,464	2,919,681,181	2,890,967,311	8,141,251,953	3,803,365,422	<b>23,151,515,331</b>
Нийт санхүүгийн өр төлбөр	4,337,278,842	7,325,100,854	3,380,407,043	2,234,463,637	3,762,009,018	<b>21,039,259,394</b>
<b>2025 оны 12 дугаар сарын 31-нээр хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү</b>						
	1,058,970,622	(4,405,419,674)	(489,439,732)	5,906,788,316	41,356,404	<b>2,112,255,937</b>
<b>2024 оны 12 дугаар сарын 31</b>						
Нийт санхүүгийн хөрөнгө	5,034,593,647	2,432,343,512	2,501,935,366	6,860,961,145	2,831,968,078	<b>19,661,801,748</b>
Нийт санхүүгийн өр төлбөр	5,797,650,637	4,988,133,070	2,288,895,898	955,342,776	3,746,489,038	<b>17,776,511,419</b>
<b>2024 оны 12 дугаар сарын 31-нээр хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү</b>						
	(763,056,990)	(2,555,789,558)	213,039,468	5,905,618,369	(914,520,960)	<b>1,885,290,329</b>

Хэрэв 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хүүгийн түвшинг 100 суурь оноогоор бага, бусад бүх хувьсагчдыг тогтмол байна гэж үзвэл (2024: 100 суурь оноогоор бага) тухайн жилийн ашиг 19,946,167 мянган төгрөг (2024: 24,471,388 мянган төгрөгөөр их)-өөр их байхаар байна, шалтгаан нь хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү эерэг байгаатай холбоотой. Өөрийн хөрөнгө 6,040,483 мянган төгрөг (2024: 8,461,831 мянган төгрөг)-өөр их байхаар байна, шалтгаан нь бодит үнэ цэнээр хэмжигдэх бусад дэлгэрэнгүй орлого (БДОБҮЦ)-д бүртгэгдэх тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өсөлттэй холбоотой байна.

Хэрэв хүүгийн түвшинг 100 суурь оноогоор их (2024: 100 суурь оноогоор их), бусад бүх хувьсагчдыг тогтмол байна гэж үзвэл тухайн жилийн ашиг 19,946,167 мянган төгрөг (2024: 24,471,388 мянган төгрөгөөр их)-өөр бага байхаар байна, шалтгаан нь хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү эерэг байгаатай холбоотой. Өөрийн хөрөнгө 4,792,428 мянган төгрөг (2024: 6,830,104 мянган төгрөг)-өөр бага байхаар байна, шалтгаан нь бодит үнэ цэнээр хэмжигдэх бусад дэлгэрэнгүй орлого (БДОБҮЦ)-д бүртгэгдэх тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралттай холбоотой байна.

Банк өөрийн санхүүгийн хэрэглүүрийн хүүгийн түвшинд тогтмол хяналт тавьдаг. Доорх хүснэгтэнд эрх бүхий албан тушаалтнуудын хянасан тайлангуудад үндэслэн холбогдох тайлант хугацааны хүүгийн түвшнийг хураангуйлан үзүүлэв.

Үнэт цаасны хувьд хүүгийн хувь нь тайлант хугацааны зах зээлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дуусгавар болох хугацаа хүртэлх өгөөжийн хувийг хэлнэ:

Жилийн хувь	2025					2024				
	Төг	Ам.дол	Евро	Юань	Бусад	Төг	Ам.дол	Евро	Юань	Бусад
<b>Хөрөнгө</b>										
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10.94%	2.58%	0%	0%	0%	9.36%	2.18%	0%	0%	0%
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах хадгаламж	15.50%	-	-	-	-	-	-	-	-	-
Өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	11.30%	7.51%	-	-	-	11.35%	6.54%	-	-	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16.48%	8.62%	9.11%	10.00%	-	15.82%	8.50%	9.88%	-	-
<b>Өр төлбөр</b>										
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	13.63%	0%	0%	0%	0%	9.84%	2.25%	0%	0%	0%
Репоз хэлцэл	14.00%	-	-	-	-	12.83%	-	-	-	-
Харилцагчдын харилцах, хадгаламж										
- харилцах	0.76%	0.83%	0%	0.62%	0.01%	0.67%	0.65%	0%	0.83%	0.16%
- хугацаагүй хадгаламж	5.74%	1.00%	-	0.60%	-	6.58%	1.00%	-	0.70%	-
- хугацаатай хадгаламж	13.01%	3.81%	3.00%	2.99%	2.99%	12.83%	3.53%	-	2.17%	-
Гаргасан өрийн хэрэглүүр	16.00%	7.46%	-	-	-	16.00%	8.18%	-	-	-
Зээлээр авсан санхүүжилт	7.70%	7.31%	-	5.00%	-	3.87%	8.15%	-	-	-
Түрээсийн өр төлбөр	17.13%	-	-	-	-	17.14%	-	-	-	-

Дээрх хүснэгтийн "-" тэмдэг нь Банкинд холбогдох валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө эсвэл өр төлбөр байхгүйг илтгэнэ.

### 34.6. Хөрвөх чадварын эрсдэл

Банкны хувьд хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагад өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд шаардагдах хөрвөх чадвартай хөрөнгийн түвшинг бүрдүүлэх, олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, санхүүжилтийн болзошгүй үүргийн удирдлага болон хөрвөх чадварын харьцааг холбогдох бодлого зохицуулалтын шаардлагын дагуу хяналт тавин ажилладаг. Харин хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ хэвийн болон стресстэй нөхцөл байдалд биелүүлэхэд хүндрэл гарах үед үүсэх эрсдэлийг хэлнэ. Энэхүү эрсдэлийг удирдахын тулд удирдлага харилцагчийн харилцах, хадгаламжаас гадна олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрийг татахын зэрэгцээ хөрөнгийн удирдлагадаа хөрвөх чадварын эрсдэлийг авч үзэн, банкны мөнгөн урсгал болон хөрвөх чадварт өдөр тутамд хяналт тавьж ажилладаг. Үүнд ирээдүйн мөнгөн урсгалын болон шаардлагатай үед нэмэлт санхүүжилт авах зорилгоор ашиглах боломжтой өндөр зэрэглэлийн барьцааны үнэлгээг оролцуулна. Түүнчлэн, Банк хөрвөх чадварын аливаа сөрөг хандлагыг тодорхойлж, нэмэгдэж буй эрсдэл ба эмзэг байдлыг бууруулахын тулд өөрийн дотоод шалгуурт үндэслэн хөрвөх чадварын эрт анхааруулах үзүүлэлтүүдийг тодорхойлдог. Эдгээр үзүүлэлтүүд нь болзошгүй хямрал эсвэл стрессийн үйл явдлыг цаг тухайд нь таних боломж олгон банкинд шуурхай үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломжийг олгодог.

Банк нь Монголбанкнаас шаарддаг түвшнээс илүү хэмжээний хөрвөх чадвар бүхий хөрөнгөтэй байдаг. Үүнээс гадна Банк хоёр долоо хоногийн дунджид суурилсан нийт харилцагчаас татан төвлөрүүлсэн төгрөгийн харилцах, хадгаламжийн 13%, валютын 18%-тай тэнцэх бэлэн мөнгийг Монголбанкн дахь дансандаа заавал байлгах нөөц хэлбэрээр байршуулж байх ёстой байдаг.

Дараах хүснэгтэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааг тэдгээрийн аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүрэгт үндэслэн харууллаа. Гэсэн хэдий ч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлтэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдөлд үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

2025 оны 12 дугаар сарын 31	Хугацаагүй	3-аас доош сар	3 - 6 сар	6 сараас 1 жил	1 - 5 жил	5 -с дээш жил	Нийт дүн
<i>Мянган төгрөгөөр</i>							
<b>Хөрөнгө</b>							
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,219,790,300	4,995,609,990	-	-	-	-	6,215,400,290
Монголбанкинд заавал байлгах нөөц	2,196,500,542	-	-	-	-	-	2,196,500,542
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах хадгаламж	-	144,685	130,543	-	-	-	275,228
Өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	-	56,353,572	82,931,099	65,395,815	797,444,568	1,051,447,753	2,053,572,807
Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	6,263,389	-	-	-	-	-	6,263,389
Своп ба форвард хэлцлийн нийт дүн:							
- Орох мөнгөн урсгал	-	294,523,235	206,077,534	461,496,345	1,079,805,065	-	2,041,902,179
- Гаргах мөнгөн урсгал	-	(281,065,618)	(195,418,668)	(435,985,228)	(1,045,021,950)	-	(1,957,491,464)
ХӨ-өөр бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	1,898,681,233	2,073,914,241	3,440,863,015	7,426,637,390	1,850,693,866	16,690,789,745
ААБҮЦ-ээр бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	5,044,448	5,018,304	10,293,979	86,704,707	289,304,989	396,366,427
Бусад санхүүгийн хөрөнгө	-	77,581,558	-	-	-	-	77,581,558
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>3,422,554,231</b>	<b>7,046,873,103</b>	<b>2,172,653,053</b>	<b>3,542,063,926</b>	<b>8,345,569,780</b>	<b>3,191,446,608</b>	<b>27,721,160,701</b>
<b>Өр төлбөр</b>							
Бусад банк ба санхүүгийн байгууллагын харилцах хадгаламж	36,523,999	307,772,119	-	-	-	-	344,296,118
Репо хэлцэл	-	2,388,909	67,316,089	-	-	-	69,704,998
Харилцагчдын харилцах, хадгаламж	7,850,577,227	2,290,357,305	2,339,469,060	3,349,682,150	408,362,000	-	16,238,447,742
Своп ба форвард хэлцлийн нийт дүн:							
- Орох мөнгөн урсгал	-	(15,274,704)	(105,493,438)	(259,368,426)	(898,337,321)	-	(1,278,473,889)
- Гаргах мөнгөн урсгал	-	15,304,003	107,054,017	263,502,915	912,110,161	-	1,297,971,096
Гаргасан өрийн хэрэглүүр	-	77,325,694	132,936,811	207,110,333	448,222,984	-	865,595,822
Зээлээр авсан санхүүжилт	14,068,253	258,168,761	485,668,959	799,498,424	2,675,032,296	227,873,693	4,460,310,386
Түрээсийн өр төлбөр	-	2,467,227	2,288,040	3,896,006	5,666,763	-	14,318,036
Бусад санхүүгийн өр төлбөр	-	135,508,629	-	-	-	-	135,508,629
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>7,901,169,479</b>	<b>3,074,017,943</b>	<b>3,029,239,538</b>	<b>4,364,321,402</b>	<b>3,551,056,883</b>	<b>227,873,693</b>	<b>22,147,678,938</b>
Ашиглагдаагүй зээлийн шугам	1,493,687,154	-	-	-	-	-	1,493,687,154
Санхүүгийн баталгаа	93,593,478	-	-	-	-	-	93,593,478
Гүйцэтгэлийн баталгаа	117,479,568	-	-	-	-	-	117,479,568
Аккредитив	35,356,900	-	-	-	-	-	35,356,900
Ашиглагдаагүй кредит карт	40,110,000	-	-	-	-	-	40,110,000
Факторингийн авлагын шугам	26,943,189	-	-	-	-	-	26,943,189
<b>Нийт балансын гадуурх зүйлс</b>	<b>1,807,170,289</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1,807,170,289</b>
<b>Нийт санхүүгийн өр төлбөр болон балансын гадуурх өр төлбөр</b>	<b>9,708,339,768</b>	<b>3,074,017,943</b>	<b>3,029,239,538</b>	<b>4,364,321,402</b>	<b>3,551,056,883</b>	<b>227,873,693</b>	<b>23,954,849,227</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>(6,285,785,537)</b>	<b>3,972,855,160</b>	<b>(856,586,485)</b>	<b>(822,257,476)</b>	<b>4,794,512,897</b>	<b>2,963,572,915</b>	<b>3,766,311,474</b>
<b>Нийт цэвэр зөрүү</b>	<b>(6,285,785,537)</b>	<b>(2,312,930,377)</b>	<b>(3,169,516,862)</b>	<b>(3,991,774,338)</b>	<b>802,738,559</b>	<b>3,766,311,474</b>	<b>-</b>

2024 оны 12 дугаар сарын 31 Мянган төгрөгөөр	Хугацаагүй	3-аас доош сар	3 - 6 сар	6 сараас 1 жил	1 - 5 жил	5 -с дээш жил	Нийт дүн
<b>Хөрөнгө</b>							
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	891,284,165	4,599,229,551	-	-	-	-	5,490,513,716
Монголбанкинд заавал байлгах нөөц	1,635,209,857	-	-	-	-	-	1,635,209,857
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах хадгаламж	-	2,047,572	1,635,058	3,222,683	525,954	-	7,431,267
Өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	-	54,677,780	89,189,989	154,902,893	975,774,738	873,295,800	2,147,841,200
Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	4,509,664	-	-	-	-	-	4,509,664
Своп ба форвард хэлцлийн нийт дүн:							
- Орох мөнгөн урсгал	-	262,230,535	160,112,095	347,774,319	1,818,449,284	-	2,588,566,233
- Гаргах мөнгөн урсгал	-	(260,512,815)	(152,468,924)	(346,131,251)	(1,799,502,885)	-	(2,558,615,875)
ХӨ-өөр бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	1,747,102,567	1,748,594,250	2,865,493,697	5,921,387,754	1,327,753,923	13,610,332,191
ААБҮЦ-ээр бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	8,123,236	7,800,456	15,884,009	131,007,348	416,730,168	579,545,217
Бусад санхүүгийн хөрөнгө	-	48,569,969	-	-	-	-	48,569,969
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>2,531,003,686</b>	<b>6,461,468,395</b>	<b>1,854,862,924</b>	<b>3,041,146,350</b>	<b>7,047,642,193</b>	<b>2,617,779,891</b>	<b>23,553,903,439</b>
<b>Өр төлбөр</b>							
Бусад банк ба санхүүгийн байгууллагын харилцах хадгаламж	13,803,785	75,126,441	-	-	-	-	88,930,226
Репо хэлцэл	-	2,778,171	60,232,865	31,642,571	-	-	94,653,607
Харилцагчдын харилцах, хадгаламж	7,421,923,711	2,587,320,932	1,699,717,819	2,420,245,217	438,523,332	-	14,567,731,011
Гаргасан өрийн хэрэглүүр	-	22,228,644	50,600,659	59,420,166	751,935,535	-	884,185,004
Зээлээр авсан санхүүжилт	13,528,687	199,519,111	205,755,763	380,176,642	1,756,946,574	347,072,484	2,902,999,261
Түрээсийн өглөг	-	2,467,083	2,411,221	4,210,624	6,130,337	-	15,219,265
Бусад санхүүгийн өр төлбөр	-	138,092,056	-	-	-	-	138,092,056
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>7,449,256,183</b>	<b>3,027,532,438</b>	<b>2,018,718,327</b>	<b>2,895,695,220</b>	<b>2,953,535,778</b>	<b>347,072,484</b>	<b>18,691,810,430</b>
Ашиглагдаагүй зээлийн шугам	1,476,885,258	-	-	-	-	-	1,476,885,258
Санхүүгийн баталгаа	76,814,247	-	-	-	-	-	76,814,247
Гүйцэтгэлийн баталгаа	85,163,613	-	-	-	-	-	85,163,613
Аккредитив	43,232,815	-	-	-	-	-	43,232,815
Ашиглагдаагүй кредит карт	36,315,445	-	-	-	-	-	36,315,445
Факторингийн авлагын шугам	8,851,655	-	-	-	-	-	8,851,655
<b>Нийт балансын гадуурх зүйлс</b>	<b>1,727,263,033</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1,727,263,033</b>
<b>Нийт санхүүгийн өр төлбөр болон балансын гадуурх өр төлбөр</b>	<b>9,176,519,216</b>	<b>3,027,532,438</b>	<b>2,018,718,327</b>	<b>2,895,695,220</b>	<b>2,953,535,778</b>	<b>347,072,484</b>	<b>20,419,073,463</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>(6,645,515,530)</b>	<b>3,433,935,957</b>	<b>(163,855,403)</b>	<b>145,451,130</b>	<b>4,094,106,415</b>	<b>2,270,707,407</b>	<b>3,134,829,976</b>
<b>Нийт цэвэр зөрүү</b>	<b>(6,645,515,530)</b>	<b>(3,211,579,573)</b>	<b>(3,375,434,976)</b>	<b>(3,229,983,846)</b>	<b>864,122,569</b>	<b>3,134,829,976</b>	<b>-</b>

Банк төлбөрийн чадвараа удирдахын тулд өр төлбөрийн гэрээний хорогдуулаагүй хугацаанд үндэслэж дээрх эргэн төлөгдөх хугацааны шинжилгээг ашигладаггүй. Үүний оронд Банк хүлээгдэж буй дуусгавар болох хугацаа болон хүлээгдэж буй хугацаан дахь төлбөрийн чадварын зөрүүг дараах байдлаар хянадаг:

Мянган төгрөгөөр	Хугацаагүй болон 1 сараас доош	1-6 сар	6-12 сар	12 сараас 5 жил	5 жилээс дээш	Нийт дүн
<b>2025 оны 12 дугаар сарын 31</b>						
Санхүүгийн хөрөнгө	9,000,302,195	2,781,554,636	2,906,366,524	6,625,933,618	1,837,358,358	<b>23,151,515,331</b>
Санхүүгийн өр төлбөр	5,745,297,464	4,958,527,652	4,219,062,666	4,824,339,190	1,292,032,421	<b>21,039,259,394</b>
<b>Хүлээгдэж буй хугацаан дахь төлбөрийн чадварын цэвэр зөрүү</b>	<b>3,255,004,731</b>	<b>(2,176,973,016)</b>	<b>(1,312,696,142)</b>	<b>1,801,594,427</b>	<b>545,325,938</b>	<b>2,112,255,937</b>
<b>Нийт цэвэр зөрүү</b>	<b>3,255,004,731</b>	<b>1,078,031,715</b>	<b>(234,664,427)</b>	<b>1,566,930,000</b>	<b>2,112,255,937</b>	<b>-</b>
<b>2024 оны 12 дугаар сарын 31</b>						
Санхүүгийн хөрөнгө	7,675,082,748	2,406,336,605	2,493,695,631	5,593,875,690	1,492,811,074	<b>19,661,801,748</b>
Санхүүгийн өр төлбөр	5,524,689,966	3,768,804,599	2,865,664,374	4,790,004,317	827,348,163	<b>17,776,511,419</b>
<b>Хүлээгдэж буй хугацаан дахь төлбөрийн чадварын цэвэр зөрүү</b>	<b>2,150,392,782</b>	<b>(1,362,467,994)</b>	<b>(371,968,743)</b>	<b>803,871,373</b>	<b>665,462,911</b>	<b>1,885,290,329</b>
<b>Нийт цэвэр зөрүү</b>	<b>2,150,392,782</b>	<b>787,924,788</b>	<b>415,956,045</b>	<b>1,219,827,418</b>	<b>1,885,290,329</b>	<b>-</b>

Хөрөнгө, өр төлбөрийн дуусгавар болох хугацаа болон хүүгийн түвшний нийцтэй байдал болон хяналтанд буй үл нийцэл нь Банкны удирдлагын үндсэн суурь болдог. Банкны хувьд бизнесийн гүйлгээнүүдийн төрөл нь олон, хугацаа нь тодорхойгүй байдаг тул эдгээр нь үргэлж нийцтэй байх явдал бага юм. Хөрөнгө, өр төлбөрийн нийцээгүй позицтой байх нь ашигт ажиллагааг нэмэгдүүлэх ч эсрэгээрээ алдагдлын эрсдэлийг өсгөдөг. Банк хүү, валютын ханшийн өөрчлөлтөд өртөх эрсдэлийг бууруулах, төлбөрийн чадварыг үнэлэхэд хөрөнгө, өр төлбөрийн дуусгавар болох хугацаа болон хүүтэй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөгдөх өртгөөр нөхөх чадвар чухал хүчин зүйлс болдог.

Харилцагчийн харилцах, хадгаламжийн ихэнх хэсэг нь эрэлттэй ангилалд байгаа боловч, харилцах хадгаламжийн дансуудын тоо болон төрөлжүүлэлт, мөн Банкны өнгөрсөн туршлагаас үзэхэд эдгээр харилцагчийн дансууд нь банкны урт хугацааны тогтвортой эх үүсвэр болж байгаа гэдэгт Банк итгэлтэй байна.

Зээлээр авсан санхүүжилт болох 3,376,013,958 мянган төгрөг (2024: 2,026,687,209 мянган төгрөг) болон өрийн бичиг болох 26,410,741 мянган төгрөг (2024: 37,035,349 мянган төгрөг) нь зээлийн гэрээний үүргийг хүлээнэ. Энэ нь хэрвээ дээрх нөхцөлүүд зөрчигдөж уг зөрчил нь гэрээ зөрчсөн тохиолдол гэж үзвэл, мөн тогтоосон хугацаанд залруулаагүй, эсвэл зээлдүүлэгчид чөлөөлөөгүй тохиолдолд зээлдүүлэгчид үлдэгдэл төлбөрийг нэн даруй төлөхийг зарлах боломжтой болох эрсдлийг банкныг оруулж байна. Ингэснээр эдгээр өр төлбөрийг шаардсан даруйд төлөх нөхцөл үүсч болзошгүй юм. Мөн зээлээр авсан санхүүжилт болох 3,376,013,958 мянган төгрөг (2024: 2,026,687,209 мянган төгрөг) болон өрийн бичиг болох 26,410,741 мянган төгрөг (2024: 37,035,349 мянган төгрөг) нь харилцан зөрчлийн заалтуудыг агуулдаг, ба энэ нь зээл олгогчдод бусад санхүүжилтийн гэрээнд зөрчил гарсан тохиолдолд үлдэгдэл төлбөрөө нэн даруй төлөх шаардлагатай болохыг мэдэгдэх эрхийг олгож байгаа бөгөөд энэ өр төлбөрийг мөн даруй төлөх эрсдлийг үүсгэж байгаа юм. Банк 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хувьд эдгээр үүргээ биелүүлсэн. Тиймээс эдгээр санхүүжилтийн зээлүүдийг гэрээний хугацаанд үндэслэн доорх хугацааны шинжилгээг харуулсан. Банк санхүүгийн гэрээнд заасан бүх санхүүгийн болон санхүүгийн бус үүргийг байнга хянадаг. Санхүүгийн гэрээний нөхцөлүүдийг, үүнд капиталын хангалт, зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл болон хөрвөх чадварын харьцааг багтаан эрсдэл болон санхүүгийн өгөгдөл, тайлагналын багийн бэлтгэсэн тайлагнал болон албан ёсны хяналтыг тогтмол үнэлдэг. Үр дүнг удирдлагад тогтмол тайлагнана. Санхүүгийн бус гэрээний үүргийг хариуцсан нэгжүүд хянадаг бөгөөд шаардлагатай гэрчилгээ, тайлангуудыг гэрээний үүргийн дагуу зээл олгогчдод гаргаж өгдөг.

### 34.7. Үйл ажиллагааны эрсдэл

Банк дотоод үйл явц, ажилчид болон системийн зохисгүй, доголдолтой үйл ажиллагаа болон гадаад үйл явдлаас үүсэх алдагдлыг үйл ажиллагааны эрсдэл гэж тодорхойлдог. Үйл ажиллагааны эрсдэл нь дараах дэд ангиллуудыг хамарна:

- Дотоод залилан,
- Гадаад залилан,
- Хөдөлмөрийн харилцаа ба ажлын байрны аюулгүй байдал,
- Харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ болон бизнесийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл,
- Биет хөрөнгийн эвдрэл,
- Бизнесийн тасалдал ба системийн доголдол,
- Гүйцэтгэл, нэвтрүүлэлт болон процессын удирдлагын алдаа дутагдал;

Хамгаалалтын нэгдүгээр шугам (1A) нь бизнесийн нэгжүүд болон тэдгээрийн дэмжих чиг үүрэг бүхий функцууд буюу салбар, тооцооны төв, Төв Банкны газар, нэгжүүдийг хамрах бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаандаа үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах болон хянах үүрэгтэй байна.

Хамгаалалтын нэгдүгээр шугам (1B) буюу тусгай чиг үүрэг бүхий хяналтын нэгжүүд нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам, арга аргачлалын хүрээнд тодорхойлсон эрсдэл, асуудлыг зохистой зорилтот түвшинд удирдаж ажиллахад хамгаалалтын 1A шугамд дэмжлэг үзүүлэх, хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тухайлсан заавар, арга аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй байна.

Хамгаалалтын хоёрдугаар шугам буюу Үйл ажиллагааны эрсдэлийн газар нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог хариуцах бөгөөд холбогдох бодлого журам, арга, аргачлалуудыг боловсруулж, хамгаалалтын нэгдүгээр шугамын нэгжүүдэд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх болон бууруулахад дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Мөн Үйл ажиллагааны эрсдэлийн газар нь санхүүгийн бус эрсдэлийн нэгтгэл тайланг хагас жил тутам Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулдаг. Тус хороод нь тайланг хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргадаг. Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хороонд дараах дэд хороод харьяалагдах бөгөөд банкны бүх түвшинд үйл ажиллагааны эрсдэлийг нарийвчлан удирдаж хянадаг. Үүнд:

- Үйл ажиллагааны эрсдэлийн дэд хороо
- Салбарын эрсдэлийн хороо

Хамгаалалтын гуравдугаар шугам болох Дотоод аудит нь хамгаалалтын нэг болон хоёрдугаар шугамын үйл ажиллагаанд хараат бус хяналт, баталгаажуулалт хийдэг.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг GRC (Governance, Risk and Compliance) систем дэмждэг бөгөөд энэ нь эрсдэлийн мэдээллийн ил тод байдлыг хангаж, тогтмол тайлагнах боломжийг бүрдүүлдэг. GRC системийг сайжруулах зорилгоор тусгай ажлын хэсэг байгуулагдан нийлүүлэгч байгууллагатай хамтран системийн шинэчлэл, сайжруулалтыг хийсэн.

Залилангийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналтыг сайжруулах, залилангийн тохиолдлыг тайлагнах болон илрүүлэх, түүнчлэн засаж залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явцыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Банк нь Залилангийн удирдлагын бодлого болон Залилангийн удирдлагын журамд нийцүүлэн Залилангийн удирдлагын стратегийг жил бүр боловсруулж, хэрэгжүүлдэг. Тус стратегийг Төлөөлөн Удирдах Зөвлөл баталдаг.

#### 34.8. Комплаенс болон Хууль эрх зүйн эрсдэл

Банкны ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох журам, тогтоомжийг дагаж мөрдөн Банкны мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр зэрэг бодлого, журмыг батлах замаар комплаенсийн эрсдэлийн удирдлагад онцгой анхаарал хандуулан ажилладаг.

Комплаенсийн эрсдэл гэдэг нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хуулийн зохицуулалтын шаардлага, холбогдох олон улсын стандарт, олон улсын санхүүгийн байгууллага болон корреспондент банкуудтай байгуулсан гэрээнээс үүдэлтэй гэрээний үүргийг дагаж мөрдөөгүйгээс үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй холбоотой хууль тогтоомж, журам хамаарна. Банк нь бодлого, журам, систем, дотоод хяналтын хөтөлбөрийн хүрээнд холбогдох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хэмжих, бууруулах, тайлагнах зорилгоор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Хуулийн эрсдэл гэдэгт хууль, эрх зүйн орчны өөрчлөлт болон банкнаас хууль, журам, заавар, гэрээний нөхцөлийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс үүдэн маргаан үүсэх, хуулийн хариуцлагад өртөх нөхцөл байдлыг хэлэх бөгөөд зохицуулалтын хяналт шалгалтаас үүсэх торгууль, акт, шийтгэл болон бусад өр төлбөрийг хамрах ба үүгээр хязгаарлагдахгүй.

#### 34.9. Мэдээллийн технологийн эрсдэл

Банк нь Мэдээллийн технологийн эрсдэлийг үр дүнтэй удирдах зорилгоор Мэдээллийн технологийн эрсдэлийн дэд хороотой бөгөөд тус хороо нь банкны систем, мэдээллийн технологийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээ авах үүрэгтэй.

#### 34.10. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

ХААН Банк нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хангаж ажиллахдаа олон улсын шилдэг түршлага, арга хэрэгсэл, стандартуудыг мөрдлөг болгодог ба эрсдэлийн удирдлагад оролцогч талуудын үүрэг хариуцлагыг “Хамгаалалтын гурван шугам” загварын дагуу хэрэгжүүлдэг. Дээрх загварын дагуу мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, шинжилгээ хийх, үнэлэх, арга хэмжээ авах болон тайлагнах үйл явцуудад олон улсын ISO/IEC 27005 стандартыг мөрдлөг болгон ажилладаг бөгөөд мэдээллийн хөрөнгийн сул талыг ашиглан түүний нууцлал, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдал алдагдсанаар учрах хохирол болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг Аюулгүй байдлын эрсдэлийн дэд хороогоор тогтмол хянан хэлэлцдэг.

### 35. Санхүүгийн хөрөнгүүд болон Санхүүгийн өр төлбөрүүдийн цэвэршүүлэлт

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар цэвэршүүлэх, цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай болон түүнтэй адил зохицуулалт хийгдэхээр байгаа санхүүгийн хэрэглүүрүүд дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Санхүүгийн байдлын тайланд цэвэршүүлэхээс өмнөх нийт дүн	Санхүүгийн байдлын тайланд цэвэршүүлсэн нийт дүн	Санхүүгийн байдлын тайланд цэвэршүүлсний дараах цэвэр дүн	Санхүүгийн хэрэглүүр барьцаа	Цэвэр дүн
<b>ХӨРӨНГӨ</b>					
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>					
- Монгол банкны үнэт цаас	3,871,989,691	-	3,871,989,691	(67,000,000)	3,804,989,691
<b>Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</b>	84,628,712	(217,997)	84,410,715	-	84,410,715
<b>МАСТЕР БОЛОН ИЖИЛ ТӨРЛИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ ЦЭВЭРШҮҮЛЭХ НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>3,956,618,403</b>	<b>(217,997)</b>	<b>3,956,400,406</b>	<b>(67,000,000)</b>	<b>3,889,400,406</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>					
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	19,715,204	(217,997)	19,497,207	-	19,497,207
Репо хэлцэл	65,803,113	-	65,803,113	(65,803,113)	-
<b>МАСТЕР БОЛОН ИЖИЛ ТӨРЛИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ ЦЭВЭРШҮҮЛЭХ НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>85,518,317</b>	<b>(217,997)</b>	<b>85,300,320</b>	<b>(65,803,113)</b>	<b>19,497,207</b>

2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар цэвэршүүлэх, цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай болон түүнтэй адил зохицуулалт хийгдэхээр байгаа санхүүгийн хэрэглүүрүүд дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Санхүүгийн байдлын тайланд цэвэршүүлэхээс өмнөх нийт дүн	Санхүүгийн байдлын тайланд цэвэршүүлсэн нийт дүн	Санхүүгийн байдлын тайланд цэвэршүүлсний дараах цэвэр дүн	Санхүүгийн хэрэглүүр барьцаа	Цэвэр дүн
<b>ХӨРӨНГӨ</b>					
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>					
- Монгол банкны үнэт цаас	4,341,204,093	-	4,341,204,093	(84,840,000)	4,256,364,093
<b>Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</b>	47,162,872	(17,212,517)	29,950,355	-	29,950,355
<b>МАСТЕР БОЛОН ИЖИЛ ТӨРЛИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ ЦЭВЭРШҮҮЛЭХ НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>4,388,366,965</b>	<b>(17,212,517)</b>	<b>4,371,154,448</b>	<b>(84,840,000)</b>	<b>4,286,314,448</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>					
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	17,212,517	(17,212,517)	-	-	-
Репо хэлцэл	87,791,865	-	87,791,865	(84,840,000)	2,951,865
<b>МАСТЕР БОЛОН ИЖИЛ ТӨРЛИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ ЦЭВЭРШҮҮЛЭХ НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>105,004,382</b>	<b>(17,212,517)</b>	<b>87,791,865</b>	<b>(84,840,000)</b>	<b>2,951,865</b>

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн дүнг санхүүгийн тайланд зөвхөн хууль ёсны эрх байгаа тохиолдолд цэвэршүүлсэн дүнгээр тайлагнадаг. Үүнд цэвэршүүлсэн дүнгээр тайлагнах эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нэгэн зэрэг барагдуулах зарчим үйлчилнэ. Ийм төлбөр тооцоо хийх эрх нь (a) ирээдүйн үйл явдлаас шалтгаалахгүй байх ёстой бөгөөд (б) дараах бүх нөхцөл байдалд хууль ёсны дагуу хэрэгжих ёстой: (i) бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед, (ii) гэрээний үүрэг зөрчигдөх үед болон (iii) төлбөрийн чадваргүй болсон эсвэл дампуурсан тохиолдолд.

Банк гэрээний үүрэг зөрчигдсөн тохиолдолд хэрэгжүүлэх төлбөр тооцооны цэвэршүүлэх ерөнхий гэрээ болон түүнтэй адилтгах зохицуулалтыг тусгасан гэрээг харилцагч санхүүгийн байгууллагуудтай байгуулдаг. Мөн холбогдох хууль тогтоомж болон журмаар тухайн санхүүгийн байгууллагад төлөх ёстой, ижил валютаар илэрхийлэгдсэн арилжааны авлага, өглөгийг цэвэршүүлэн тооцохыг зөвшөөрдөг. Мөн Банк гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд харилцагч санхүүгийн байгууллага Банкны өглөгийг маржин барьцааны хадгаламжаар барагдуулах зохицуулалтын хүрээнд нээлттэй деравитив хөрөнгийн позицын барьцаанд маржин хадгаламж байршуулдаг.

### 36. Бодит үнэ цэнийн тодруулга

Бодит үнэ цэнийн хэмжилтийг бодит үнэ цэнийн шатлал тус бүрт үнэлэх ба эдгээр түвшин нь: (1) ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно, (2) хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийн үнэлгээг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ, (3) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийн үнэлгээг тодорхойлно. Удирдлага санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшинг ангилдаг. Хэрэв бодит үнэ цэнийг тодорхойлоход шууд ашиглаж болох өгөгдөлд ихээхэн тодруулга хийгдсэний дараа ашиглаж байгаа бол тухайн хэмжилт нь 3-р түвшинд хийгдэж байна гэсэн үг. Үнэлгээний өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн тодорхойлолттой бүхэлд нь уялдуулан авч үзэн үнэлдэг.

**(а) Бодит үнэ цэнийн давтагдах хэмжилт**

Бодит үнэ цэнийн давтагдах хэмжилт нь нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу тайлангийн үе бүрийн эцэст санхүүгийн байдлын тайланд заасан эсвэл зөвшөөрөгдсөн хэмжилт юм. Бодит үнэ цэнийн давтагдах хэмжилтийг ангилсан бодит үнэ цэнийн шатлалын түвшин дараах байдалтай байна. Үүнд:

Мянган төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31				2024 оны 12 дугаар сарын 31			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт дүн	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт дүн
<b>БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР БҮРТГЭГДСЭН ХӨРӨНГӨ</b>								
<b>САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ</b>								
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт								
- Бодит үнэ цэнээр үнэлэгдсэн үнэт цаас	363,785,866	-	-	<b>363,785,866</b>	339,993,364	-	-	<b>339,993,364</b>
- Давуу эрхтэй ИЗББ, бодит үнэ цэнээр	-	161,293,038	-	<b>161,293,038</b>	-	-	136,364,285	<b>136,364,285</b>
- Энгийн эрхтэй ИЗББ, ҮЦСК бодит үнэ цэнээр	-	223,159,550	-	<b>223,159,550</b>	-	-	193,743,718	<b>193,743,718</b>
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт								
- Байгууллагын хувьцаа	4,475,054	-	1,788,335	<b>6,263,389</b>	4,509,664	-	-	<b>4,509,664</b>
Бодит үнэ цэнээр ашиг, алдагдалд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	-	280,061,857	-	<b>280,061,857</b>	-	400,306,947	-	<b>400,306,947</b>
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	-	84,410,715	-	<b>84,410,715</b>	-	29,950,355	-	<b>29,950,355</b>
<b>САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ</b>								
